



**БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН**

БАГА БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ

Монгол хэл. I-V анги

Улаанбаатар
2019

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР АНГИ

Танилцуулга	6
НЭГ. Унших чадвар	21
ХОЁР. Бичих чадвар	27
ГУРАВ. Сонсох чадвар	30
ДӨРӨВ. Хэл зүй, үгийн сан	34

ХОЁРДУГААР АНГИ

Танилцуулга	36
НЭГ. Унших чадвар	36
ХОЁР. Бичих чадвар	49
ГУРАВ. Сонсох-ярих чадвар	58
ДӨРӨВ. Хэл зүй, үгийн сан	64

ГУРАВДУГААР АНГИ

Танилцуулга	68
НЭГ. Унших чадвар	68
ХОЁР. Бичих чадвар	81
ГУРАВ. Сонсох-ярих чадвар	97
ДӨРӨВ. Хэл зүй, үгийн сан	101

ДӨРӨВДҮГЭЭР АНГИ

Танилцуулга	104
НЭГ. Унших чадвар	104
ХОЁР. Бичих чадвар	113
ГУРАВ. Сонсох-ярих-чадвар	131
ДӨРӨВ. Хэл зүй, үгийн сан	135

ТАВДУГААР АНГИ

Танилцуулга	137
НЭГ. Унших чадвар	137
ХОЁР. Бичих чадвар	145
ГУРАВ. Сонсох-ярих чадвар	157
ДӨРӨВ. Хэл зүй, үгийн сан	161



БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРТЫН ТУШАА.1

2019 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Суралцахуйн удирдамж батлах тухай

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” А/491 дүгээр тушаал, “Хөтөлбөр батлах тухай” А/492 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бага боловсролын монгол хэл, математик, хүн ба орчин, хүн ба нийгэм, хүн ба байгаль, дүрслэх урлаг технологи, хөгжим, биеийн тамир, англи хэлний сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжийг нэгдүгээр; суурь боловсролын монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, математик, мэдээллийн технологи, физик биологи, хими, газар зүй, түүх, нийгэм судлал, дүрслэх урлаг, хөгжим, дизайн, технологи, биеийн тамир, англи хэл, орос хэлний сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжийг хоёрдугаар; бүрэн дунд боловсролын заавал судлах, сонгон судлах монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, математик, мэдээллийн технологи, физик, биологи, хими, газар зүй, нийгэм судлал, англи хэл, орос хэлний болон заавал судлах монголын түүх, биеийн тамир, дизайн зураг зүй, технологи, сонгон судлах түүх, дизайн, технологийн сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын нэг, хоёр, гуравдугаар хавсралтаар батлагдсан суралцахуйн удирдамжийг нийслэлийн Боловсролын газар, аймгийн Боловсрол, Соёл, Урлагийн газруудад хүргүүлж, холбогдох мэдээллийг байгууллагын цахим хаяг /mier.mn/-т байршуулахыг Боловсролын хөтөлбөрийн секторын эрхлэгч /А.Энхтогтох/-д даалгасугай.

ЗАХИРАЛ



П.ЛХАГВАСҮРЭН

ХТА2990

ӨМНӨХ ҮГ

Суралцахуйн удирдамж, түүний зориулалт

Суралцахуйн удирдамж нь сургалтын хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг суралцахуй болон багшлахуйгаар хэрэгжүүлэх үйл ажиллагааг үлгэрчлэн төлөвлөсөн баримт бичиг юм.

Суралцахуйн удирдамж нь сургалтын хөтөлбөрийг жилээр болон нэгж, ээлжит хичээлээр зохистой төлөвлөх, суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа, хичээлийн арга зүйн санааг хөгжүүлэх, үнэлгээг үр дүнтэй зохион байгуулах хөтөч болно.

Суралцахуйн удирдамж нь арга зүйн зөвлөмж төдий бус, өнөөгийн боловсролын хөгжлийн чиг хандлага, үзэл санаанд суурилсан шинэлэг арга зүйг тусгасан тул суралцахуй, багшлахуйд тулгамдаж буй бэрхшээл, сорилтыг даван туулахад дэмжлэг үзүүлнэ.

Багш суралцахуйн удирдамжийг сайтар ойлгож, мөрдөн хэрэгжүүлэх нь хичээлийг үр өгөөжтэй зохион байгуулах, суралцахуйн үйл ажиллагааг бүтээлчээр дэмжих, багшлах ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Суралцахуйн удирдамжийг багш нар бэлэнчлэн хуулбарлаж хэрэглэх биш, өөрсдийн туршлага, ур чадвараар баяжуулан хөгжүүлэхийн сацуу сурагчдынхаа ялгаатай байдал мэдлэг, чадвар, хандлагад тохируулан уян хатан, нээлттэйгээр хэрэгжүүлэх боломжтой юм.

Суралцахуйн удирдамжийн бүтэц

Суралцахуйн удирдамж нь суралцахуйн зорилт, суралцахуйн үйл ажиллагаа, багшид зөвлөмж, хэрэглэгдэхүүн гэсэн үндсэн бүтэцтэй.

Суралцахуйн зорилт нь сурагчийн эзэмших мэдлэг, чадвар, чадамжийн илэрхийлэл. Өөрөөр хэлбэл; тухайлсан үйл ажиллагааны үр дүнд сурагчийн эзэмших мэдлэг, чадвар юм.

Суралцахуйн үйл ажиллагаа: Багш төвтэй сургалтын арга зүйг биш, сурагчийн бүтээлч сэтгэлгээ, идэвх, оролцоо, бие даасан байдлыг хүндэтгэн дэмжсэн, мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх, шинжлэн судлах, эрэл хайгуул хийх зэрэг сурагч төвтэй сургалтын арга технологид суурилсан үйл ажиллагааг тусгасан.

Суралцахуйн зорилт бүрээр сэдэлжих, мэдлэг бүтээх сорил туршилт, дадлага ажил, даалгавар гүйцэтгэх арга, аргачлал, үр дүнгээ үнэлэх, ганцаарчлан болон багаар ажиллах арга зүйн шийдлийг зөвлөсөн болно. Мөн багш суралцахуйг дэмжих, туслах үүрэг, хариуцлагаа ухамсарлах, багийн үйл ажиллагааг хөгжүүлэх, сурсан зүйл нь хүүхэд бүрт “үр өгөөжтэй” байхад санаа тавих, хүүхэд бүрийн суралцах ялгаатай байдлыг харгалзан хичээл зохион байгуулахад анхаарах зүйлийг зөвлөмжилсөн.

Хэрэглэгдэхүүн: Энэ хэсэгт суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хэрэглэх сурах бичиг, гарын авлага, цахим болон бусад эх сурвалж, дадлага, туршилт, аялал, төсөлт хичээл, хамтын хичээлийн хэрэглэгдэхүүнийг сонгон ашиглахыг санал болгосон.

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжийг бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин тус бүрээр боловсруулсан тул сургууль, багш нар судлагдахуунуудын хөндлөн ба босоо залгамж холбоог сайтар судлан хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Боловсролын хүрээлэн


НЭГДҮГЭЭР АНГИ

Танилцуулга

Нэгдүгээр ангийн монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамж нь дараах хоёр хэсгээс бүрдэнэ.

1. Үсэг бичигт эхлэн суралцах (цагаан толгойн бэлтгэл ба цагаан толгойн үе)
2. Цагаан толгойн дараах үе

Нэгдүгээр ангийн монгол хэлний сургалтын агуулга нь цагаан толгойн бэлтгэл, цагаан толгой үе, цагаан толгойн дараах үе гэсэн гурван хэсгээс бүрддэг бөгөөд эдгээр агуулга нэгдүгээр ангийн монгол хэлний хичээлийн нийт цагийн гуравны хоёр хэсгийг эзэлдэг. Цагаан толгойн бэлтгэлийн үед хүүхдийн хэл яриа, гарын жижиг булчинг хөгжүүлэхэд илүү анхаардаг бол цагаан толгойн үеийн зорилго бол сурагчдад авиа үсэг таниулж, уншиж, бичих анхан шатны чадвар эзэмшүүлэхэд оршино.



Монгол хэлний авиа, үсгийг авианы задлаг, нийлэг аргаар таниулж ирсэн уламжлалтай. Энэ нь эхийг өгүүлбэр, өгүүлбэрийг үг, үгийг үе, үеийг авиа болгон задлах анхны хүртлэг, төсөөлөлтэй болгодог ба энэ цаашдаа шинэ авиатай танилцах тусам төсөөлөл нь ойлголт, ойлголт нь мэдлэг болон тогтож, улмаар хэлний авиаг сонсох, хэлэх, үг, өгүүлбэрийг унших, бичих чадвар нь дадал хэвшил болон тогтоход ач холбогдолтой байдаг. Цагаан толгойн үеийн гол онцлог бол сурагчид хичээл бүрээр шинэ авиа үсэгтэй танилцаж, шинэ үг хэллэг унших бичихэд суралцаж байдаг онцлогтой.

Авиа, үсгийг задлаг аргаар таниулдаг бол уншиж, бичихийг нийлэг аргаар сургаж ирсэн уламжлалтай. Авианы задлаг хийх үйл ажиллагааг багш дагуулан хийх бол нийлэг хийхэд сурагчдын үсэг, үе холбон уншиж, бичих идэвхтэй үйл ажиллагаа чухал. Авиа, үсэгтэй таниулах, уншуулж, бичүүлж сургахыг бие биеэс нь хэт салангид явуулж болохгүй, шинэ авиа, үсэг бүрийг таниулахад хамтад нь хэрэгжүүлдэг онцлог үйл ажиллагаа болно.

ҮСЭГ, БИЧИГТ ЭХЛЭН СУРАЛЦАХ ҮЕ

0.1. СОНСОХ-ЯРИХ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
0.1а. Бусдын уншсан үлгэр, өгүүллэгийг сонсож, асуултад хариулах	- Бусдын уншиж байгаа эхийг анхааралтай сонсох - Ойлгомжгүй болон сонирхсон зүйлээ асуух - Асуултын хариултын талаар өөрийн санал бодлоо найз нөхөдтэйгөө хуваалцах	- Нас сэтгэхүйд тохирсон сонсгох үлгэр, өгүүллэг
0.1б. Сурах бичиг дэх зургийн дагуу үлгэр өгүүллэгийг ярих	- Зургаас үйл явдлын дарааллыг ажиглах - Ажигласан үйл явдлаа хэн нэгэнд ярьж өгөх - Бусдын ярьсныг сонсож санаагаа баяжуулах	- Сурах бичгийн цуврал зураг

0.2. УНШИХ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
0.2а. Үгийн бүтцээс богино, урт, хос эгшиг үсгийг ялган таних, нэрлэх, зөв унших (а, аа, ай, э, ээ, эй, и, ий, ы, о, оо, ой, ө, өө, у, уу, уй, ү, үү, үй)	I. Эгшиг авиатай танилцах 1. Зураг ажиглаж, зургийн дагуу эх зохиомжлон ярилцах, Жишээ нь: “И” авиа таниулах үед “Хоёр ишиг” үлгэрийн зураг харж багшийн асуултад хариулна. Асуулт: - Ишиг ямар амьтны төл вэ? - Хэдэн ишиг байна? - Хоёр ишиг юу хийж байна? - Хоёулаа усанд унахгүй гарч чадах уу? - Ямар үед хоёул усанд унах вэ? - Ямар үед хоёул усанд унахгүй вэ? 2. Сурагчдын яриа, хариултаас нэг “ишиг” гэсэн үг орсон нэг өгүүлбэрийг сонгоно. Жишээ нь: “Ишиг хөөрхөн амьтан”. “Ишиг мөргөлдөх дуртай”. Хоёр ишиг гүүрээр зөрж гарсан гэх мэт 3. Сонгосон өгүүлбэрийг үгээр задалж, үгсийг нэг нэг дүрс, бүдүүвчээр төлөөлүүлж байрлуулна. Жишээ нь: Хоёр ишиг мөргөлдөв. 4. Сонгосон үгийг багш эхлээд бүтнээр нь, дараа нь үеэр зааглан хэлэхийг сонсож, дагаж хэлнэ. Тухайн үгийг авиагаар задалж, шинэ авиаг хэлэхэд багшийн ам, уруул, хэл яаж оролцож байгааг ажиглана, дуурайж хэлнэ. Өөрийн болон бусад сурагчийн хэлэхийг ажиглаж, ярилцана. Багшийн асуултад хариулна. Жишээ нь: а,э авиаг хэлэхээс ямар ялгаатай байна вэ? II. Эгшиг үсэгтэй танилцах 5. Шинээр үзсэн авиаг тэмдэглэдэг дармал үсгийг ажиглаж том жижиг үсгийн ижил ба ялгаатай талыг ярилцана. 6. Шинээр танилцсан үсэг юутай төсөөтэйг ярилцаж, дүрсийг нь шагай, утас, савх зэргээр бүтээлгэнэ. Жишээ нь: “И и” үсэг “И и” үсэг муруй замын тэмдэг, эвхдэг метр гэх мэт. 7. Үсгийн нэр ба дуудлагын ялгааг ярилцана.	- Эгшиг авиа таниулахад ашиглаж болох үлгэр, зохиол - Эгшиг авиаг хэлэхэд амны хайрцаг, уруул, хэл яаж оролцож байгааг харуулсан зураг - Ярилцлагад ашиглах зурагт үзүүлэн - Эгшгээс бүтсэн үгийг харуулсан зурагт үзүүлэн - Том жижиг дармал эгшиг үсгүүд - Ханын хүснэгт, үеийн хүснэгт

	8. Шинээр үзсэн эгшиг үсэг, үеийг нүдлэн тогтоож, унших дасгал хийнэ. а. Богино ба урт эгшгийг ялгаж унших б. Богино, урт, хос эгшгийг ялгаж унших 9. Шинэ үсэг бүхий үе, үг, зурагт холбоо үг, зурагт өгүүлбэрийг сурах бичиг зэргээс уншина.	- Шагай, савх зэрэг хэрэглэгдэхүүн - Уншлагад зориулсан тарааж өгөх материал
0.26. Дармал ба бичмэл “м, с, х, р, в, л, н, ш” үсгийг таних, нэрлэх, задгай ба битүү үеийг нүдлэх, үг, холбоо үгийг үелж зөв унших	Саадгүй хэлэгддэг эдгээр гийгүүлэгч авиатай танилцах үйл ажиллагааг “м” гийгүүлэгчээр үлгэрлэн үзүүлэв. I. Саадгүй хэлэгддэг гийгүүлэгч авиатай танилцах 1. Эх зохиож ярилцах, холбогдох үлгэр, өгүүллэг сонсох. Жишээ нь: “М” гийгүүлэгч авиа таниулах гэж байгаа бол “Наадам” сэдвээр яриагаа эхэлж, нум сумны зураг үзүүлж, ярилцана. Асуулт: -Зурагт юуны тухай харуулсан байна? -Нум сумыг яаж хэрэглэдэг вэ? -Аль нь нум, аль нь сум бэ? гэх мэт. 2. Өгүүлбэр зохиож хэлэх. Жишээ нь: Манай ахад нум сум байгаа. Наадмаар нум сум харвадаг. 3. Сурагчид нэг өгүүлбэр сонгон, үгээр задалж, үгсийг нэг нэг дүрсээр төлөөлүүлж байрлуулна. Жишээ нь: Наадмаар нум сум харвадаг. 4. Үгийг үеэр таслан хэлэхийг сонсох. Жишээ нь: Багш өгүүлбэрээс “сум” гэсэн үгийг сонгож хэлэхийг сурагчид сонсох, хэлэх 5. Үгийг авиагаар задалж, шинэ авианы хэлэгдэх онцлогийг ажиглах, ярилцана. Жишээ нь: Үгийн төгсгөлд сонсогдож байгаа “м” ялган сонсох, зөв дуудахыг ажиглаж, ярилцана. с-у-м. Шинэ авиаг давтан хэлж, уруул, хэл зэрэг өгүүлэх эрхтний оролцоог ажиглах, ярилцана. Асуулт: -Бидний өмнө үзсэн а, э, и, о, ө, у, ү авиаг хэлэхээс ямар ялгаатай байна вэ? -Уруул, хэл, амны хайрцаг ямар байдалтай байна вэ? (Сурагчдад бие биеийн хэлэхийг ажиглах боломж олгож болно.) II. Нэгдүгээр шатны гийгүүлэгч үсэгтэй танилцах 6. Шинээр үзсэн авиаг тэмдэглэдэг дармал том, жижиг үсгийг ажиглаж, ижил ба ялгаатай талыг ярилцана. 7. Багшийн шинэ үсгийг уншихыг сонсож, давтан хэлнэ. Үсгийн нэр ба дуудлага ижил эсэхийг анхаарч ярилцана. 8. Шинээр танилцсан үсэг юутай төсөөтэйг ярилцаж, дүрсийг шагай, утас, савх зэргээр бүтээлгэнэ. Жишээ нь: “Мм” үсэг муруй замын тэмдэг, эвхдэг метр гэх мэт. 9. Шинээр үзсэн үсгээр үг бүтээж унших, шинэ үсэг, үеийг нүдлэн тогтоож, унших дасгал хийнэ а. Битүү үе бүтээж унших: ам, им, эм б. Задгай үе бүтээж унших: маам, мээм, амуу 10. Шинэ үсэг бүхий үе, үг, зурагт холбоо үг, зурагт өгүүлбэрийг сурах бичиг зэргээс уншина.	- Саадгүй хэлэгддэг гийгүүлэгч авиа таниулахад ашиглаж болох эхүүд, үлгэр, зохиол - Ярилцлагад ашиглах зурагт үзүүлэн - Эгшгээс бүтсэн үгийг харуулсан зурагт үзүүлэн - А4 цаасан дээр бэлтгэсэн том жижиг дармал эгшиг үсэг - Ханын хүснэгт, үеийн хүснэгт - Үсэг бүтээх шагай, савх зэрэг хэрэглэгдэхүүн (математикийн хичээлд ашигладаг тооллын хэрэглэгдэхүүн) - Уншлагад зориулсан тарааж өгөх материал

0.2в. Дармал ба бичмэл б, г, д, т, ц, ч, з, ж (ь) үсгийг таних, нэрлэх, задгай ба битүү үеийг нүдлэх, 1-2 үетэй үгийг шууд, урт үг, холбоо үгийг үелж, зөв унших	Саадтай хэлэгддэг гийгүүлэгч авиатай танилцах үйл ажиллагааг “д” гийгүүлэгч таниулахаар үлгэрлэн харуулав. I. Саадтай хэлэгддэг гийгүүлэгч авиатай танилцах - Эх зохиож ярилцах, холбогдох үлгэр, өгүүлэл сонсох Жишээ нь: “д” гийгүүлэгч авиа таниулах гэж байгаа бол Цасангаа ба долоон одойн тухай үлгэрийг товч ярилцана. Асуулт: - Зурагт хэн, хэн (юу, юу) байна? - Одойнуудын нэрийг хэлэх хүүхэд байна уу? - Охины нэрийг мэдэх үү? Хэн хэлэх вэ? - Цонхоор юу харагдаж байна? гэх мэт. - Өгүүлбэр зохиож хэлэх. Жишээ нь: Тэнгэрт од гарсан байна. Охин долоон одойн гэрт унтсан гэх мэт. - Сурагчид нэг өгүүлбэр сонгон, үгээр задалж, тус бүрийг нэг дүрсээр төлөөлүүлж байрлуулна. Жишээ нь: Тэнгэрт од гарсан байна. Сонгосон үгийг хэлэх, үеэр таслан хэлэхийг сонсох. Жишээ нь: Багш өгүүлбэрээс “од” гэсэн үгийг сонгож хэлэхийг сурагчид сонсох, давтан хэлнэ. - Үгийг авиагаар задалж, шинэ авианы хэлэгдэх онцлогийг ажиглах, ярилцах. Жишээ нь: Үгийн төгсгөлд сонсогдож байгаа “д” авиаг ялган сонсох, зөв дуудахыг ажиглаж, ярилцана. о-д. - Шинэ авиаг давтан хэлж, уруул, хэл зэрэг өгүүлэх эрхтний оролцоог ажиглаж, багшийн асуултад хариулна. Асуулт: - Өмнө үзсэн м, с, р, ш, зэрэг авиаг хэлэхээс ямар ялгаатай байна? - Уруул, хэл, амны хайрцаг ямар байдалтай байна вэ? (Сурагчдад бие биеийн хэлэхийг ажиглах боломж олгож болно.) II. Хоёрдугаар шатны гийгүүлэгч үсэгтэй танилцах - Шинээр үзсэн авиаг тэмдэглэдэг дармал том, жижиг үсгийг ажиглаж, ижил ба ялгаатай талыг ярилцана. Жишээ нь: “Д д” үсэг - Багшийн шинэ үсгийг уншихыг сонсож, давтан хэлнэ. Үсгийн нэр ба дуудлага ижил эсэхийг анхаарч ярилцана. - Шинээр танилцсан үсэг юутай төсөөтэйг ярилцаж, үсгийг шагай, утас, савх зэргээр бүтээлгэнэ. Жишээ нь: “Д д” үсэг хоёр хөл дээрээ хагас сууж байгаа хүнтэй төстэй гэх мэт. - Шинээр үзсэн үсгээр үг бүтээж уншина. - Битүү үе бүтээж унших: од, эд, мод, шүд, нүд, хад, хадаас ... - Задгай үе бүтээж унших: дах, дэх, дус, дүн - Шинээр үзсэн үсэг бүхий үе, үг, холбоо үг, өгүүлбэрийг сурах бичиг зэргээс уншина.	- Саадтай хэлэгддэг гийгүүлэгч авиа таниулахад ашиглаж болох үлгэр, зохиол - А4 цаасан дээр бэлтгэсэн том жижиг дармал эгшиг үсэг - Ханын хүснэгт, үеийн хүснэгт - Үсэг бүтээх шагай, савх зэрэг тооллын хэрэглэгдэхүүн) - Уншлагад зориулсан тарааж өгөх материал
0.2г. Зөөлний тэмдгийг ялган таних, нэрлэх, зөөлөрсөн гийгүүлэгч бүхий үсгийг зөв унших	- Зураг ажиглаж, зургийн талаар ярилцана. - Багшийн харуулсан дараах хос зургуудыг нэрлэж, дуудлагын ялгааг ажиглаж, харьцуулна. Жишээ нь: бах - бахь, тах - тахь, уул - ууль, тав - тавь	

	3. Зураг бүрийн дор нэрийг нь бичсэн үгсийг байрлуулж, бичлэгийн ялгааг ажиглуулж, харьцуулж ярилцана. Жишээ нь: бах - бахь, тах - тахь, уул - ууль, тав - тавь гэх мэт 4. Багшийн шинээр таниулж байгаа үсгийг зөөлний тэмдэг гэдгийг хэлж, бусад үсгийн адил тусгай дуудлагагүй, харин өмнөх гийгүүлэгчийг зөөлрүүлдэг болохыг тайлбарлахыг сонсоно. 5. Хос үсгийг дахин уншуулж хэлний аль хэсэг яаж өөрчлөгдөж байгааг ажиглаж, ярилцана. 6. Сурах бичиг, тарааж өгөх материалаас гийгүүлэгч зөөлөрсөн болон зөөлрөөгүй гийгүүлэгч бүхий хос үгсийг унших дасгал хийнэ. 7. Шинээр үзсэн зөөлний тэмдэг бүхий үгийг хэлэхэд өгүүлэх эрхтний оролцоо, ялангуяа хэлний оролцоо ямар байгааг ярилцана. 8. Шинээр танилцсан зөөлний тэмдэг үсэг орсон үг олж хэлнэ. 9. Сурах бичиг, тарааж өгөх материалаас үг, холбоо үг, өгүүлбэр, эхийг унших дадлага хийнэ. Зөөлний тэмдгийг үгэнд утга ялгаж байгаа үүргийн талаас харьцуулан ойлгуулна. Үүнд: ам – амь Эдгээр үсгийг холбоо үг өгүүлбэрт оруулан утгын ялгааг ярилцана. Өөрөө хэлбэл зөөлөрсөн ба зөөлрөөгүй гийгүүлэгчтэй авианы бүрхүүл ижилхэн үсгийг сонгон харьцуулах аргаар заана. Үгийн утгыг тодорхой ойлгуулахын тулд холбоо үг, өгүүлбэрт оруулж хэлэх, хүүхдээр ийм маягаар өгүүлбэр зохиолгож болно. Жишээ нь: <table> <tr> <td>хүний амь</td> <td>хүний ам</td> </tr> <tr> <td>морь барь</td> <td>хийж бар / бар арслан</td> </tr> <tr> <td>гэртээ харь</td> <td>намайг хар / хар өнгө</td> </tr> <tr> <td>номоо тавь</td> <td>хадаасны тав гэх мэт.</td> </tr> </table>	хүний амь	хүний ам	морь барь	хийж бар / бар арслан	гэртээ харь	намайг хар / хар өнгө	номоо тавь	хадаасны тав гэх мэт.	- Зурагт ба бичмэл үзүүлэн - Үсгийн сан, Үеийн хүснэгт - Үеийн карт - Савх, шагай, утас - Үлгэр, өгүүллэгийн бичлэг
хүний амь	хүний ам									
морь барь	хийж бар / бар арслан									
гэртээ харь	намайг хар / хар өнгө									
номоо тавь	хадаасны тав гэх мэт.									
0.2д. “я, е, ё, ю” болон “к, п, ф, щ” үсгийг ялган таних, нэрлэх, эдгээр үсэг бүхий үг, холбоо үг, хялбар эхийг унших, 2-3 үетэй үгийг шууд унших	Үет үсэг болон гадаад онцгой 4 гийгүүлэгч үсгийг таниулахыг “ё”- үсгээр үлгэрлэн харуулав. 1. Зураг ажиглаж, зургийн талаар ярилцана. 2. Багшийн харуулсан үг, зургийн хажууд бичсэн тулгуур үг унших оролдлого хийнэ. Жишээ нь: яргуй, ерөөл, ёл, юүдэн 3. Уншсан үгээс танил биш үсгийг олж, юутай төсөөтэй болохыг ярилцана. 4. Багш уг шинээр үзсэн үсгийн нэрийг хэлж, дуудлагыг таниулна. Сурагчид зөв дуудах дасгал хийнэ. Шинэ үсгийг хэлэхэд өгүүлэх эрхтний оролцоо ямар байгааг ярилцана. 5. Шинээр танилцсан үсэг орсон үг олж хэлэх 6. Сурах бичиг, тарааж өгөх материалаас үг, холбоо үг, өгүүлбэр, эхийг унших дадлага хийнэ.	- Зурагт ба бичмэл үзүүлэн - Үсгийн сан, Үеийн хүснэгт - Үеийн карт - Савх, шагай, утас - Үлгэр, өгүүллэгийн бичлэг								
0.2е. Хатуугийн тэмдгийг ялган таних, нэрлэх, унших	1. Зураг ажиглаж, зургийн талаар ярилцана. Жишээ нь: “Манжин” үлгэрийн зургийг тавьж “Татъя, татъя, хүчилье, хүчилье ямар том манжин бэ” гэж бичсэн байж болно. 2. Багшийн харуулсан зургууд ба тайлбарыг уншина. Жишээ нь: зуръя, будъя, бодъя, татъя									

	3. Эдгээр үгийн дунд үзээгүй ямар үсэг байгааг сурагчдаар олуулна. 4. Багшийн шинээр таниулж байгаа үсгийг хатуугийн тэмдэг гэдгийг хэлж, бусад үсгийн адил тусгай дуудлагагүй гэж тайлбарлахыг сонсоно. 5. Энэ үсгийг орхиод уншихад үгийн утга өөр болж байгаа эсэхийг шалгаж ярилцаж болно. Үүнийг зөөлөрсөн гийгүүлэгчтэй харьцуулж болно. Жишээ нь: тавь гэдгийг зөөлний тэмдгийг уншихгүй бол тавь биш тав болно. Гэтэл хатуугийн тэмдгийг орхиод уншихад үгийн утга хэвээр байна гэх мэтээр ярилцана. 6. Сурах бичиг, тарааж өгөх материалаас хатуугийн тэмдэг орсон үг, өгүүлбэр үг, холбоо үг, өгүүлбэр, эхийг унших дадлага хийнэ. Тайлбар: Хатуу ба зөөлний тэмдэг нь хоёулаа нэгдүгээр биеийн шийдэн хүсэх утгатай "я, е, ё" нөхцөлийг өмнөх гийгүүлэгчээс нь салгаж тусгаарлах үүргийг гүйцэтгэдэг. 7. Зөөлний тэмдэг тусгаарлах болон зөөлрүүлэх үүргээр орсон үгийг хатуугийн тэмдэг бүхий үгтэй харьцуулан унших дасгал хийнэ. Жишээ нь: таръя-тарья уръя-урья баръя-барья 8. Дараа нь зөвхөн зөөлний тэмдэг зөвхөн тусгаарлах үүргээр орсон үсгийг уншуулна. Жишээ нь: үзье, хүчилье, өгье, хүсье гэх мэт.	- Зурагт ба бичмэл үзүүлэн - Үсгийн сан - Үеийн хүснэгт - Үеийн карт - Савх, шагай, утас - Үлгэр, өгүүллэгийн бичлэг
--	---	---

Багшийн анхаарах зүйл:

Нэг. Авианы задлаг, нийлэг аргаар авиа, үсэг таниулах

Авианы арга, үсгийн арга, үеийн арга, үгийн арга нь хүн төрөлхтний бичиг үсэгт сургадаг үндсэн аргууд бөгөөд улс үндэстэн бүрийн хэлний онцлогоос хамааран аль нэгийг нь зонхилж, эсвэл аль алийг нь хослуулан хэрэглэдэг байна. Монголчууд эрт дээр үеэс бичиг үсэгт сургахдаа үеийн болон бүтэн үгийн аргыг голлон хэрэглэж ирсэн бол кирилл шинэ бичигт шилжсэн үеэс авианы задлаг, нийлэг аргыг авиа, үсэг таниулах гол арга гэж үзсээр ирсэн байна. Иймд уншуулж сургахдаа үеийн аргыг голлох бөгөөд үеийн арга нь өөрөө авианы задлаг, нийлэг аргын нэг элемент болдог. Авианы задлаг-нийлэг арга нь нэг талаас хэл бол систем, нөгөө талаас уншиж, бичиж сурах үйл ч бас систем гэдгийг харуулж байдагт мөн чанар нь оршино. Гийгүүлэгчийг авианы задлаг, нийлэг аргаар таниулах үйлийг алхамчлан танилцуулбал:

Нэг. Задлаг хийх алхам:

- 1.1. Сэдэвт зураг ашиглан ярилцах
- 1.2. Эхээс өгүүлбэрийг ялгах
- 1.3. Өгүүлбэрийг үгээр задлах
- 1.4. Үгийг үе болгон задлах
- 1.5. Үгийг авиагаар задалж, авиаг хэлж, сонсох замаар ажиглан "судлах"
- 1.6. Шинэ авиаг тэмдэглэсэн дармал үсгийг таниулах

Хоёр. Нийлэг хийх алхам:

- 2.1. Шинэ үсгээр үг, үе бүтээх, үг, өгүүлбэр унших
- 2.2. Сурах бичгээс үе, үг, өгүүлбэр, эх унших
- 2.3. Бичмэл үсэгтэй танилцуулах
- 2.4. Үсгийн зурлага, үсэг, үг, холбоо үг, өгүүлбэр бичих

1. Хэлний авиаг ялгаж сонсох, зөв дуудаж сургах

Эгшиг авиаг сонсох, зөв дуудаж сургах. Эгшиг авиа нь гийгүүлэгчийг бодвол хэлэхэд амархан, уушгинаас гарсан хийн урсгал саадгүй гардаг, дан дуунаас бүтдэг, дангаараа үе бүтээдэг тул эгшиг авиаг задлаг ойлгуулахад хялбар байдаг.

Эгшиг авиа нь үе, үеийн орой болж, гийгүүлэгч авиаг эгшигжүүлэн холбож үе бүтээдэг. Үндсэн долоон богино эгшгийг авианы задлаг нийлээ аргаар, харин урт, хос эгшгийг харьцуулан жиших аргаар таниулна. Эгшиг авиаг таниулах үе бол багшийн хамгийн хариуцлагатай мөч билээ. Хэлний авиаг сонсож, хэлж болдог, харин тэдгээрийг үсгүүдийг уншиж, бичдэг гэдгийг ойлгуулах хэрэгтэй. Эгшиг авиа таниулахдаа тухайн авиа үгийн нэгдүгээр үед байгаа үгийг сонгох хэрэгтэй. Энэ нь монгол хэлний өргөлтөт үеийн эгшиг нь дараа дараагийн үеэс ямагт тод сонсогддог онцлогтой холбоотой. Харин нэгдүгээр үеэс хойших эгшиг нь үед харьцангуй бүдэг, балархай сонсогддог. Эгшгийг уужим “а”-аас эхлэн уйтан “ү” эгшиг хүртэл дараалан заах боловч “а, э, и” эгшгийг “и” үсгээс өмнө заах тул зөвхөн богино, урт эгшгийн дуудлага ба бичлэгийг харьцуулан заана. Харин “и” үсэг таниулсны дараа хос эгшиг эхлэн заах бөгөөд өмнө сурсан богино, ба урт “а, э” эгшигтэй харьцуулан “ай, эй” хос эгшиг таниулна. Улмаар “и” эгшгийн дараа таниулах дөрвөн эгшиг үсгийг богино ба урт, хос эгшгийг хамтад нь таниулна. “И” үсэг таниулах явцад урт “ий”-г таниулахдаа хагас и буюу “й” үсэг таниулах бөгөөд мөн эр үгийн “ы” үсгийг таниулдаг. Ийм учраас “ий”, “ы” үсгийн эр, эм үгэнд ялган бичдэг учрыг нарийн тайлбарлах шаардлагагүй, харин үсгийн дүрс, бичлэг нь ялгаатай ч адилхан “и” гэсэн уншдагийг хэлж, дадлагажуулах хэрэгтэй.

Гийгүүлэгч авиаг сонсох, зөв дуудаж сургах. Өгүүлэхийн талаас авч үзвэл, гийгүүлэгч авиаг хэлэхэд уушгинаас гарсан хийн урсгал мөгөөрсөн хоолойгоор дамжин, төвөнхөд орж, ам хамрын хөндийгөөр гадагш гарахдаа ямар нэгэн саад хашлагатай тохиолдож анир үүсгэнэ. Гийгүүлэгчийг сонсгол зүйн болон өгүүлэхийн талаас нь сонсголонт, шуугиант гэж хоёр ангилдаг. Сонсголонт гийгүүлэгч авиаг өгүүлэхэд хийн урсгалын замд саад бага тохиолдох тул өгүүлэх эрхтний булчингийн үйл ажиллагааны хүчдэл бага шаардана. Сонсголонт гийгүүлэгчийг өгүүлэхэд дууны хөөч доргин чичирч, зонхилон дуу давамгайлж бүтэх бөгөөд ялангуяа хийн урсгал хамрын хөндийгөөр саадгүй урсан гардаг. “М,н” авиа нь ямар ч тохиолдолд дуугаа тогтвортой хадгалж чаддаг. Сонсголонт гийгүүлэгч авиаг үндсэн өнгөөр нь удаан дуудаж болно. Харин хамжих, хамжин шүргэх гийгүүлэгчийг удаан хэлж болдоггүй. Жишээ нь “ж, ч” авиаг удаан дуудаж болохгүй. Тэрхүү хашлага, саадын их багын хэмжээнээс болж зарим нь бага хүчдэл шаарддаг бол зарим нь их хүчдэл шаарддаг. Энэ онцлогийг харгалзан гийгүүлэгч авиа, үсгийг заахдаа эхлээд уушгинаас гарах хийн урсгалын замд тохиолдох саад багатай “м, с, х, в, р, л, н, ш” гийгүүлэгчийг эхлэн зааж дараа нь хийн урсгалын замд саад ихтэй хэлэгддэг “д, т, г, б, ц, ч, з, ж” гийгүүлэгч авиаг таниулна. Аль ч гийгүүлэгч үгийн төгсгөлд байхдаа дуудлага нь хамгийн цэвэр, тод сонсогддог тул энэ онцлогийг тооцож авиа, таниулах үгийг сонгодог. Монгол хэлний задгай үеийн богино эгшиг уртаар дуудагдах тэмүүлэлтэй байдаг тул задгай үеийг уншуулсны дараа заавал “нар, нэр, нас” гэх мэтээр битүү үе болгон уншуулж бичүүлнэ.

Гийгүүлэгч авиаг таниулахад эгшгээс ялгарах нэг онцлог бол тэдгээрийг хэлэхэд ямар саад тохиолдож байгааг ажиглуулах нь чухал. Эгшгийг хэлэхэд уушгинаас гарсан хий нь ам, хамрын хөндийгөөр гарахад ямар нэг саад тохиолддоггүй бол гийгүүлэгч авиаг хэлэхэд ямар нэг саад тохиолддог. Гийгүүлэгч авиаг авианы задлаг аргаар хүүхдэд зааж ойлгуулах бөгөөд дараах онцлогийг багш мэдсэн байх шаардлагатай.

1. Монгол хэлэнд үгийн эцэст гийгүүлэгч авиа эгшиггүй орох тохиолдол элбэг байна. Ийм гийгүүлэгч авиаг хүүхэд хэлж сурсан, ярианы аппарат нь хэвшил болсон байдаг. Ихэвчлэн ам, сам, муур, хав гэх мэт гийгүүлэгчээр төгссөн үг эхлэн уншуулж сургадаг онцлогтой.
2. Гийгүүлэгч авианы зөв дуудлага нь гийгүүлэгчийн өмнө хойно орсон эгшиг авианаас хол байгаа байрлал дээр илүү тод цэвэр сонстож, дуудагддаг байна. Жишээ нь: Элс гэхэд “с” гэж хэлэгдэж сонстохоос биш “эс” гэж хэзээ ч сонстож хэлэгдэхгүй байх жишээтэй байна.

Монгол хэлэнд хэлний гүн үгийн “г” хэлний үзүүрийн “н”-ээр төгссөн бага, хана, оно гэх мэт хэдэн үгээс өөр тийм задгай үеэр төгссөн үг маш ховор юм. Энэ бүхнээс үзэхэд монгол хэлний гийгүүлэгч авиаг үгийн эцэст орсон тохиолдлоос нь задлан ойлгуулах нь илүү тохиромжтой, олон талын ач холбогдолтой байна. Ийм учраас гийгүүлэгч авиаг эхлэн үгийн эцэст байгаа тохиолдлоос нь ялгаж заагаад дараа нь үгийн эцэст, дунд, эхэнд оруулж дасгал ажиллуулж бататгана. Жишээ нь: амм-мма, самар, алим, мөөг, хэрэм гэх мэт. Удаан хэлэгддэг гийгүүлэгчээс “ш, с, р, л, н” авиаг хэлэхэд хэлний үзүүр, “в,м” хоёр гийгүүлэгч авиаг хэлэхэд уруул, “м,н” авианд хамар илүү идэвхтэй оролцдог болохыг мэдүүлнэ.

Мөн с-ш, р-л, м-н авиаг сольж дууддаг хүүхэд байдаг учраас багш энэ авиаг хурц тод хэлж заах хэрэгтэй.

Удаан хэлэгддэг гийгүүлэгчээс “н” үсэг хэлний угийн ба үзүүрийн хоёр авиаг тэмдэглэдэг. Үүнийг заахад нарийн дэс дараа чухал. Монгол хэлний авиа таниулахад гардаг хэд хэдэн бэрхшээл байдаг. Тухайлбал:

- Нутгийн аялгуутай холбогдон бий болдог. Тухайлбал, баруун аймагт хэлний угийн “н” авиаг хэлний үзүүрийн “н” тэй ижилхэн хэлдэг тул (Жишээ нь: ...арван(а) дөрвөн(ө) он(о), номын(о) сан(а) хэлний угийн “н” авиаг таниулахад, хэлний г гийгүүлэгчийг хоолойн “э”-тэй ижилхэн дуудаг нутагт (багш – багаш) хэлний “э” авиа таниулахад бэрхшээлтэй байдаг.

Цага яга хэд байна? Өөл нүүх ногаан өнгө гэх мэт.

Хүүхдийн хэл ярианы хөгжил харилцан адилгүй. Зарим авиаг, тухайлбал “р, с, ш, ж, з, ц, ч” зэрэг авиаг зөв хэлж чаддаггүй хүүхэд байдаг. Жишээ нь “р” гийгүүлэгчийг “л”-ээр сольж хэлдэг, эвсэл хэлж чаддаггүй хүүхэд байгаа бол “р” авиаг хэлж сургахад өгүүлэх эрхтнийг идэвхжүүлэх, өгүүлэх эрхтнийг зөв байршуулж “р” авианы тавилтыг зөв болгох, дуудлагыг зүгшрүүлэх дасгал зааж, хэвшүүлэх ажил тусгайлан хийж болно. Мөн хэл зүгшүүлэх үг хэллэг хэлүүлэх ч үр дүнтэй дасгалын нэг болно.

II. Цагаан толгойн үсэг таниулах

Эгшиг үсэг таниулах. Эдгээрийг бусад үсгээс түрүүлэн заадаг нь монгол бичгийг зааж ирсэн уламжлал төдийгүй авиаг үгийн бүтцээс ялган сонсох, хэлэх, тогтооход хялбар, авианы дуудлага ба үсгийн нэр адилхан байдаг тул унших бичихийн суурь болдог. Энэ нь эгшигийг хамгийн уужим агуу дуудагдах “а” эгшгээс уруул цорвойж, хамгийн уйтан дуудагддаг “ү” эгшиг хүртэл дараалуулсан тул сурагчид эгшиг авиаг маш хялбархан цээжилж тогтоодог. Энэ нь өгүүлэх эрхтний ажиллагааны зохицолд тун сайн нийлэмжтэй төдийгүй цаашид гийгүүлэгч авиатай холболт хийх аргад хялбар суралцдаг байна. Харин үсгээ нүдэлж байгаа эсэхэд багш анхаарах хэрэгтэй. Эгшиг үсгийг таниулахдаа эхлээд богино, дараа нь урт ба хос эгшигийг богино эгшигтэй болон өөр хооронд нь харьцуулан жиших аргаар үсэг таниулж бичлэгийн ялгааг ойлгуулна. Тухайлбал, “а-аа-ай, э-ээ-эй, и-ий-ы, о-оо-ой, у, уу, уй, ө-өө, ү-үү-үй”

Урт “ий” авиа үсэг таниулах хэсэгт “й”, “ы” хоёр үсгийг таниулдаг. Гэхдээ энэ хоёр үсгийг эр, эм үгэнд ялган бичдэг учрыг нарийн тайлбарлах шаардлагагүй, харин үсгийн дүрс, бичлэг нь ялгаатай ч адилхан “и” гэсэн уншдагийг хэлж, дадлагажуулах хэрэгтэй.

Улмаар “ав-аав-айв, ус-уус, үс-үүс, хур- хуур, дэл- дээл” гэх мэтээр үсгийг, мөн “үс-үүс-үйс” гэх мэтээр жишин уншуулж, бичүүлнэ.

Урт ба хос эгшиг монгол хэлэнд бие дааж, дангаараа үг байх тохиолдлыг сонгон авч, бусад үгтэй холбон утгыг тайлбарлах замаар уншуулж бичүүлэх хэрэгтэй. Жишээ нь: оо саван, гарын үү, сүү уу, модны өө, бүү ай, гэх мэт. Өгүүлбэр зохиолгох нь үгийн утгыг мэдэхэд ач холбогдолтой. Хос эгшиг нь хоёр авианы нийлэмж бөгөөд “й” үсэг үзээгүй байхад “а, э” эгшиг үсгийг заах тул эхлээд зөвхөн богино, урт эгшиг таниулж, “й” үсэг үзсэний дараа “ай, эй” гэж хос эгшиг үсэг уншуулна. Харин “о, у, ө, ү” дөрвөн эгшиг үсгийг урт, хос эгшигийг хамтад нь заана.

Гийгүүлэгч үсэг таниулах. Гийгүүлэгч үсгийг гурван хэсэг болгон таниулахаар сургалтын хөтөлбөрт тусгасан. Эхний шатанд уушгинаас гарах хийн урсгалын замд тохиолдох саад багатай, удаан хэлэгддэг, “Мм, Сс, Хх, Вв, Рр, Лл, Нн, Шш” зэрэг гийгүүлэгч, дараа нь саад ихтэй, түргэн хэлэгддэг “Дд, Тт, Гг, Бб, Цц, Чч, Зз, Жж” гийгүүлэгч болон зөөлний тэмдэг, гуравдугаар шатанд гадаад үгэнд ихэвчлэн бичдэг “п,к,ф,ц” үсэг болон хатуугийн тэмдгийг таниулна. Нэг, хоёрдугаар шатны гийгүүлэгчийг тус тусад нь бүлэг болгон таниулах бөгөөд эдгээрийг үгийн төгсгөлөөс авианы задлаг нийлэг аргаар таниулна. Гийгүүлэгч үсгийг ямагт нэр үгийг сонгож, таниулдаг.

а. Саадгүй хэлэгддэг гийгүүлэгч. Эхний шатанд уушгинаас гарах хийн урсгалын замд тохиолдох саад багатай, удаан хэлэгддэг, “Мм, Сс, Хх, Вв, Рр, Лл, Нн, Шш” зэрэг гийгүүлэгчийг таниулах бөгөөд эхний гурван гийгүүлэгчийг буюу “м,с,р” үсгийг нягт нямбай таниулснаар унших бичих суурь зөв тавигддаг.

Иймд энэ үед багш анхаарлаа илүү төвлөрүүлэх шаардлагатай. Эгшиг авиаг удаан дуудаж сурсан сурагчдад хэлж сурахад нь хялбар байх талыг бодолцож, үндсэн өнгөөр нь удаан дуудах бололцоотой, ямарч үед дуугаа хадгалдаг, дуурхаг “М” гийгүүлэгч авиаг эхлэн оруулсан билээ. “М” авиа нь сонсголт, дуутай, уруулын, хамжих, хамаршсан, утга ялгах талаасаа туйлын тод. Үгийн эхэн, дунд, адагт хаана ч тохиолдоно.

Нэгдүгээр шатны гийгүүлэгч үзэх явцад хүүхэд бүрд үг холбон үг унших, уншсан нүдлэн тогтоох эхлэл тавигдсан байх ёстой.

Эхний 5 гийгүүлэгчийг үзэх хугацаанд багш яаралгүй тогтуун ажиллаж, хүүхэд нэг бүрт унших анхны дадлага олгох ёстой. Энэ үед л хүүхэд уншлагад сурахгүй бол цаашид хоцрох магадлал өндөр байдгийг багш нар хатуу анхаарах хэрэгтэй. Нэгдүгээр шатны гийгүүлэгчээс “н” авиа, үсгийг таниулахад нэлээд онцлогтой. Учир нь “н” үсгээр хэлний үзүүрээр болон угаар хэлэгддэг хоёр өөр авиаг тэмдэглэдэг тул бага насны хүүхдэд зэрэгцүүлэн заахад төвөгтэй байдаг. Сүүлийн үед зарим багш нар “н”, “г” гийгүүлэгчийг бусад гийгүүлэгчийн адилаар зааж байгаа нь ажиглагддаг. Гэтэл энэ мэдлэг сул, нөгөө талаас бүтээлч биш ажиллаж байгааг харуулж байна. Гийгүүлэгч таниулах энэ шатанд “н” үсэг нь хоёр өөр авиаг тэмдэглэж, өөр өөрөөр дуудагддаг нарийн учиртай. Үүнийг сайн ойлгуулаагүйгээс хүүхэд ихээхэн бэрхшээлтэй тулгардаг байна. “Н” үсэг нь хоёр авиа тэмдэглэдэг тул эхлээд хэлний үгийн “н” авиаг таниулж, “он, сан, хан” гэх мэтээр уншиж сурсны дараа хэлний үзүүрийн “н” авиаг дахин таниулж, “оно, сана, хана” гэх мэтээр уншуулж сургах хэрэгтэй. Н үсгийн хоёр дуудлагыг заах явцад хэлний үзүүрийн “н” ардаа эгшиг үсэгтэй, хэлний үгийн “н” ардаа эгшиггүй бичигддэг болохыг ойлгуулна.

сан-сана,	он-оно,	хонх-хонох,	саван-савна,	хаван-хавна,
хаан-хаана,	орон-орно,	эрэн-эрнэ,	эн-энэ	

Ийм үсгийг харьцуулан уншуулснаар шууд уншдаг, жишээ үг хэлж чаддаг болгоно.

б. Саадтай хэлэгддэг гийгүүлэгч. Хоёрдугаар шатанд нэгдүгээр шатны гийгүүлэгчтэй адилхан удаанаар хэлж болдоггүй д, б, г, т, ц, ч, з, ж гийгүүлэгч болон хатуугийн тэмдэг үсгийг тэмдэг үсгийг таниулна. Эдгээр гийгүүлэгчийг удаан хэлж болдоггүй, хурдан огцом хэлэгддэг онцлогтой бөгөөд хамжин тэсрэх «т, д, г, б», хамжин шүргэх «ж, з, ц, ч» авиаг түргэн хэлэгддэг гийгүүлэгч авиа гэдэг. Эдгээр авиаг үгээс ялган заах цэвэр зөв дуудах, холбон уншихад элдэв бэрхшээл тохиолддог.

Эдгээр гийгүүлэгч авиаг огцом тод хэлэхгүй, жаахан удаан хэлбэл “тэ, дэ, чэ, цэ” гэх мэт үе болон хэлэгддэг холбон унших үед «тээр, дэун, чэоно» гэх мэтээр уншихад хүргэдэг тул аль болох зөв, тод дуудахыг эрхэмлэх хэрэгтэй. Эдгээр авиаг дуудахдаа хойно, өмнө нь ямар нэг авиа хэлэлгүй, «ард, хүрз, навч, бут, уеж, арц, гэх мэт үгэнд хэлэгдэж байгаа шигээр хэлэх нь зохистой. Түргэн хэлэгддэг гийгүүлэгчид нь “ц-ч, з-ч, т-д, г-х, б-в” гэх мэтээр хос хосоор авианы дуудлагын хувьд төстэй учир эхлэн сурч байгаа хүүхэд хооронд нь сольж хэлэх, унших тохиолдол гардаг. Хоёрдугаар шатны гийгүүлэгчээс “г” үсэг хэлний ба хоолойн хоёр авиа тэмдэглэдэг бөгөөд хоолойн “г” нь га, го, гу үе, хэлний “г” нь гэ, ги, гө, гү үе үүсгэдэг онцлогтой. Монгол хэлэнд ихэнх гийгүүлэгч үгийн эцэст гийгүүлэгчийн дараа эгшиггүй ордог ч «г» авианы хувьд ийм тохиолдол байдаггүй онцлогтой.

Ийм учраас “г” авиа, үсгийг эхлээд “цаг, баг, туг” гэх мэт үгээс таниулж, дараа нь задгай үеийг уншуулах “баг-бага, тараг-тарга, араг-арга” гэх мэт хос үгс уншуулж, өгүүлбэр зохиолгох, тохирох зурагт харгалзуулах зэргээр ялгааг ойлгуулж болно. Харин “б” гийгүүлэгчээр төгссөн үг монгол хэлэнд огт байдаггүй тул үгийн эхнээс таниулдаг төдийгүй том жижиг, дармал бичмэл дөрвөн үсгийн дүрс нь өөр хүүхдэд нэлээд бэрхшээлтэй байдаг.

Хоёр. Үсгийн аргаар шинэ үсэг таниулах

Үсгийн аргаар Я-ийн төрлийн үсэг, онцгой дөрвөн гийгүүлэгч, хатуу, зөөлний тэмдэг үсгийг таниулдаг. Үсгийн аргаар заана гэдэг нь авианы задлаг хийлгүй, таниулах гэж байгаа үсгийг шууд нэрлэн хэлж, дуудлагыг нь таниулж, уншуулах арга юм.

а. Я-ийн төрлийн үсэг таниулах. Үет үсэг буюу “я, е, ё, ю” дөрвөн үсэг нь хэлний дундуурх “j” гийгүүлэгчийн дараа а, о, э (ө), у (ү) эгшиг орсон нийлцийг тэмдэглэсэн үсэг тул үет үсэг гэдэг. Энэ дөрвөн үсэг нь хэдийгээр тус тусдаа өөр дүрс, дуудлагатай үсэг боловч угтаа “j” гэсэн нэг л авиалбарын тухай ойлголт юм.

я=j + а, е=j + э, ё=j + ө, ё=j + о ю=j + у, ю=j + ү

Зарим багш үүнийг мэдэхгүйгээс болж авианы задлаг нийлэг аргаар таниулах гэж оролддог нь буруу юм. Эдгээр үсгээс “я, ё” үсгийг үгийн эхэнд дангаараа задгай үе болох байрнаас, тухайлбал, ямаа, ялаа, ёроол, ёотон гэх мэтээс таниулж болно.

Харин “е, ю” хоёр үсэг нь тус бүр хоёр дуудлагатай нь хоёр өөр үгээс таниулна. Тухайлбал, “ю” үсгийн “j+ү” авианы нийлцийг “юүдэн юүлүүр” гэсэн үгээс, “j+у” авианы нийлцийг “юм, юу” гэсэн үгээс таниулахад тохиромжтой. Харин нэг “е” үсгийн хувьд “j+э” нийлцийг “евэн, ер, евэн, “j+ө” авианы нийлцийг “ерөөл, ерөнхий, ес, ерөөл” зэрэг үгээс таниулна. Гэхдээ хүүхдэд ийм хоёр авиа тэмдэглэдэг гэсэн онолын тайлбар өгөх шаардлагагүй.

б. Онцгой дөрвөн гийгүүлэгч. Харин гадаад үгэнд ихэвчлэн бичигддэг “п, к, ф, щ” үсгийг цагаан толгойн төгсгөлд үздэг. “П” авиа нь “пагдгар, пар пар, пас пүс, пал пүл” гэх мэтээр үгийн эхэнд, авиа дуурайх үгэнд цөөнгүй хэрэглэгддэг, харин үгийн төгсгөлд ордоггүй. Харин гадаад хэлнээс орж ирсэн “Пагма, паалан, пуужин” гэх мэт цөөн үгийн эхэнд хэлэгдэж, бичигддэг. Ийм учраас багш өргөн хэрэглээнд хэрэглэгддэг “марк, кино, фото, парк, пүүз, кино, фтортой оо гэх мэт хүүхдийн өдөр тутмын амьдралд тохиолддог үсгийг уншуулж бичүүлэх замаар сургана. Энэ дөрвөн үсгийг я-ийн төрлийн дөрвөн үсэгтэй адилхан үсгийн аргаар таниулж ирсэн уламжлалтай.

в. Тэмдэг үсэг таниулах. Цагаан толгойн үсэгт ямар ч авиа тэмдэглэгддэггүй хатуугийн тэмдэг “ь”, зөөлний тэмдэг “ъ” гэсэн нэртэй хоёр үсэг байдаг. Тэдгээрийг тэмдэг үсэг гэж нэрлэнэ. Авиа тэмдэглэхгүй учраас тэмдэг үсгийг мөн үсгийн аргаар таниулна. Хатуу ба зөөлний тэмдэг нь хоёулаа нэгдүгээр биеийн шийдэн хүсэх утгатай “я, е, ё” нөхцөлийг өмнөх гийгүүлэгчээс нь салгаж тусгаарлах үүргийг гүйцэтгэдэг. Жишээ нь: явь, харъя, орё, хууля, үзье, өгье, хүсье эр эм үгэнд ялгаатай хэрэглэгддэг. Эдгээрийг заахдаа дүрэмчлэн ярьж ойлгуулах бус зөв хэвшүүлэн уншуулж сургахыг голчилно. Харин үүнээс бусад тохиолдолд зөөлний тэмдэг нь өмнөх гийгүүлэгчийг зөөлрүүлэх өөр нэг үүрэгтэй. Өөрөөр хэлбэл зөөлний тэмдэг нь эр үгэнд зөөлөрснийг, эм үгэнд тусгаарлах үүрэгтэй. Зөөлөрснийг тэмдэглэсэн жишээ нь: хор-хорь, ам-амь, тав-тавь; Тусгаарлах үүрэгтэй хэрэглэсэн жишээ: үзье, хэлье, өгье, үүрье гэх мэт. Зөөлний тэмдгийг үгэнд утга ялгаж байгаа үүргийн талаас харьцуулан ойлгуулна. Үүнд:

ам – амь тав – тавь хар – харь бар – барь

Эдгээр үсгийг холбоо үг өгүүлбэрт оруулан утгын ялгааг ярилцана. Өөрөө хэлбэл зөөлөрсөн ба зөөлрөөгүй гийгүүлэгчтэй авианы бүрхүүл ижилхэн үсгийг сонгон харьцуулах аргаар заана. Үгийн утгыг тодорхой ойлгуулахын тулд холбоо үг, өгүүлбэрт оруулж хэлэх, хүүхдээр ийм маягаар өгүүлбэр зохиолгож болно. Жишээ нь:

хүний амь	хүний ам
морь барь	хийж бар / бар арслан
гэртээ харь	намайг хар / хар өнгө
номоо тавь	хадаасны тав гэх мэт.

Ангид шинээр үсэг үзэх бүрд зөвхөн сурах бичгээс унших даалгавар өгөхөөс гадна гэртээ байгаа сонин сэтгүүл, номын гарчиг зэргээс үзсэн үсгээ олох, унших зэрэг даалгавар өгч болно. Эгшиг үсгүүдийг нүдлэхэд нь тус болох тоглоом тоглуулж болно. Шинээр үсэг үзэж нүдэлж байгаа үед үсгийн зарим хэсгийг цухуйж байгаагаар харуулж, ямар үсэг байж болохыг төсөөлж бодуулах, батлуулах, батлах гэж оролдох нь шинээр үзсэн үсгээ бүрэн нүдэлж тогтоох, зарим үсгийн ижил ба ялгаатай байдлыг ухаарч авахад тустай. Үүнийг өөр өөр үсэг дээр хийхдээ хуудас цаасны цаанаас үсгийг сонирхолтой байх болно.

Гурав. Цагаан толгойн үед уншихад сургах

Сурагчдад авиа, үсгийг эхлэн таниулсан цагаас эхлэн үг, өгүүлбэр уншуулна. Сайн уншихын тулд үгэнд байгаа бүх үсгийг уншиж сурсан байхаас гадна үгийг зөв унших, үелэн унших, өгүүлбэр ба эхийг зөв уншуулахад багш анхаарах хэрэгтэй. Нэг үетэй хялбар үгийг аль болох бүтэн үгээр нүдлүүлэн уншуулах бол урт, хүнд хэцүү үгийг үелэн уншуулна. Гэхдээ заавал бүх үеэр таслуулах гэх шаардлагагүй. Жишээ нь: “уралдууллаа” гэсэн үгийг заавал у-рал-дуул-лаа гэж дөрвөн үе болгохын оронд уралдууллаа” гэж хоёр хэсэг болгон уншуулж болно. Хүүхэд сайн уншиж сураагүй байхад үсэг үсгээр, эсвэл үе үеэр салгаж хэл, үсэглээд унш гэх хэлэх нь зохисгүй. Харин өгүүлбэр, эхийг уншуулахад их, бага зогсолтыг хийж сургах хэрэгтэй. Унших явцад таслал байвал бага зэрэг, өгүүлбэр төгсөж цэг тавьсан байвал харьцангуй удаан зогсолт хийж сургана.

Үг нь авиануудын нэгдэл учраас тухайн үгийг бүтээж байгаа авианууд (үсгүүд) хэллэгийн урсгалд эгшин зуур холбогддог хуультай. Ийм учраас авианууд нэг нэгдээ харилцан нөлөөлдөг. Үсгээ бүрэн таньж нүдэлсэн ч зарим сурагч уншиж чаддаггүй шалтгаан нь авианы ийм огцом нарийн холбоог гаргах чадахгүй байгаагаар холбоотой. Өөрөөр хэлбэл үг хэллэгийн урсгалд авиануудын эхлэл, төгсгөл тус тусдаа хэлэгддэггүй харин түрүүчийн авианы төгсгөл дээр дараагийн авианы эхлэл давхцаж байдагтай холбоотой. Иймд “ма” гэж уншихад хоёр үсгээ мэдэж байгаа ч уншиж байгаа нь авиануудын төгсгөл ба эхлэлийн давхцалыг хийж чадахгүй байгаа хэрэг. Энэ холбоосыг хийж, ма гэдгийг уншуулахын тулд хоёр уруулаа нийлүүлэн “м” авиаг хэлэхэд бэлтгээд, араас нь “а” авиаг шууд хэлэх зэргээр эдгээр задгай үеийг уншуулж сургах нь зохистой. Ийм учраас уншуулж сургахдаа үсгүүдийн холбоос буюу нэг авиаг нөгөө авиатай, нэг үеийг нөгөө үетэй огцом холбож сургахад анхаарах хэрэгтэй.

Сурагчид бүтэн үгээр уншиж сурах хүртэл энэхүү огцом холбоог шалмаг тогтоож чаддаг дадал олгох хэрэгтэй. Уншуулж сургахад гардаг нэг бэрхшээл бол сурагчид үсгийг нэрлэж хэлэх боловч холбон уншиж чаддаггүй. Энэ тохиолдолд эхний авианы төгсгөлийг хэлэхэд бэлтгээд, өөрөөр хэлбэл эхний авианы хэлэх байдлаас дараагийн авиаг залгуулан шууд хэлж сургах нь хэрэгтэй. Жишээ нь: САМ гэхэд

Нэгдүгээр шатны гийгүүлэгчийг таниулах явцад багш дараах чадвар эзэмшүүлэхэд анхаарах хэрэгтэй.

- Хүүхэд бүр үзсэн үсэг бүрийг нүдэлж тогтоох, зөв уншиж сурах
- Үеийг маш сайн нүдэлж, үсэглэхгүй шууд уншиж сурах
- Үе холбон үг бүтээн унших уншсан зүйлийн утгыг ойлгох. Жишээ нь: Са+мар, Са+раа, Со+сор 2 сүү уув гэх мэт.

Хүүхэд үг өгүүлбэр уншиж сурахад далд байгаа үсгийг олох, тохирох үеийг холбох зэрэг дасгалыг өдөр бүр хийх нь үр дүнтэй. Даалгаврыг сурагчдад өгөхдөө “Алимны ард нэг үсэг нуугдсан байна. Түүнийг олъя” гэх мэтээр хэлэхэд хүүхдэд сонирхолтой. (Жишээ 2)

Үе унших дасгалыг хичээл бүр дээр 2-3 минут хийж хэвших нь үг бүтээн уншихыг хялбар дөхөм болгодог. Үеийн хүснэгт ашиглахаас гадна харгалзаа үүсгэх даалгаврыг хүүхдүүд дуртай хийдэг.

Жишээ нь:

ху	ваа
са	руу
хо	рээ
сэ	воо

Үгийн сүлжээ бөглөх, үсгээс үг бүтээж унших даалгавар өгч болно. Жишээ нь: хоёр авиа тэмдэглэдэг “н,г” гийгүүлэгчийг заахдаа нэлээд анхаарах шаардлагатай. Тухайлбал, хэлний үгийн “н” авиа, үсгийг таниулсны дараа хэлний үзүүрийн авиаг таниулж, дараа нь харьцуулан утга ялган уншуулж сургана. Уншлагад сургах хэд хэдэн аргаас танилцуулж байна.

Өөртөө унших. Бусад хүний сонсоход зориулж биш, зөвхөн өөртөө зориулж унших хэлбэрийг хэлнэ. Нэг, хоёрдугаар ангид сурагчид ихэвчлэн амандаа үглэн “чанга” уншдаг нь ойлгохын тулд зөвхөн “өөртөө” зориулан уншиж байгаа хэрэг гэдгийг багш нар ойлгох хэрэгтэй. Энэ нь бага насны хүүхдийн өөрийн уншсаныг сонсож байж ойлгодог онцлогтой нь холбоотой. Харин дараагийн шатанд буюу гурав, дөрөвдүгээр ангиас эхлэн сурагчид “харааны уншлага”-д суралцаж эхэлдэг.

Бусдад унших. Бусдын сонсож ойлгоход зориулан чанга дуугаар уншихыг бусдад унших гэнэ. Бусдад унших уншлагыг өөртөө унших “чанга” уншлагатай андуурч болохгүй. Зорилгын хувьд ялгаатай. Энэ уншлага нь нэг талаас уншихдаа сонсож байгаа хүний анхаарлыг татаж, сэтгэлд нь хүртэл унших чадварыг харуулдаг бол нөгөө талаас сонсож байгаа хүн нь хүний уншсаныг ойлгох чадварыг шаарддаг. Бусдад унших нь уран уншлагад сургах эхний алхам болно. Уншиж сурах цагаан толгойн үеэс сурагчид үг, өгүүлбэрийг алдаа мадаггүй, тод хэлж уншихад суралцах бол анги ахих тусам үг, өгүүлбэрийн утгын өргөлт гаргах, их, бага зогсолт хийх, уншлагын хурд, өнгө аялыг тохируулан уран унших чадварт суралцдаг. Зөв, ухамсартай уншлага нь уран уншлагын бэлтгэл болдог. Цагаан толгойн уншлагаас эхлэн уншлагын дараах дөрвөн чадварыг жигд эзэмшүүлэхийг ахмад арга зүйчид зөвлөсөн байдаг.

Үсэгт карт. Ийм карт нь шинээр үсэг үзээд нийлэг хийж уншуулахад гол хэрэглэгдэхүүн болно. Шинээр үзсэн үсгээр үг бүтээж уншихад төдийгүй хүүхдүүд чөлөөт цагаараа үг бүтээн тоглох боломж бүрдэнэ. Ахмад багш нар шинэ үсэг таниулаад, түүнийг үсгийн кассет хийдэг, нийлэг хийж уншуулахдаа хэрчмэл үсгээр үг бүтээж уншуулдаг байсан бөгөөд энэ уншиж сурах гол алхам гэж үздэг байсан.

Хүүхдүүд багшийн бичсэн үг, үзүүлэн, сурах бичгээс уншихаас гадна гартая ийм маягаар бэлтгэсэн “үсэг” барьж үгбүтээн унших сонирхол маш их байдаг. Өөрсдийн болон найз нарынхаа бүтээсэн үгийг унших дуртай. Багш хэд хэдэн хүүхдийн дунд ийм хэрэглэгдэхүүн (карт) байхаар тооцон гарын доорх материалаар бэлтгэж болно.

Жишээ нь: утасны цэнэглэгч карт, хуванцар савны бөглөө мэт ижил хэмжээтэй зүйл дээр үсэг бичээд нааж болно. Картын нэг талд үсэг, боломжтой бол нөгөө талд нь холбогдох зураг байвал үсгээ мартсан хүүхэд үсгийг уншихад дөхөм байна. Том жижиг гийгүүлэгч тус бүр 2-3 ширхэг, эгшиг үсэг 4-5 ширхэг, тэмдэг үсэг тус бүр 2 байхад болно. Ийм багц хэрэглэгдэхүүн нэг ангид 5-6 байхад сурагчдыг баг болгон суулгаж, нэг нэгийг өгч болно. Харин багш өөрөө арай том хэмжээтэйг хийж зургийн ард байрлуулбал үсгийг самбарт тогтооход хялбар, хүүхдэд харагдах боломжтой болно. Хэрэв үе нүдлүүлнэ гэвэл үсгийн оронд үе бичиж болно.

0.3. БИЧИХ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
0.3а. Үсэг бүтээдэг зурлагуудыг дэвтрийн шугамаар баримжаалан дэгийн дагуу бичих	- Самбар дээр хос шугамд багш тухайн зурлага хаанаас нь эхэлж, ямар шугамд хэрхэн тааруулан бичих журмыг тайлбарлаж, бичиж үзүүлэхийг анхаарч сонсоно. - Багшийн бичиж байгааг дуурайн агаарт дүрсэлж үзүүлнэ. Зарим сурагчийг хүсэлтээр нь самбарт бичүүлж болно - Сурагчид зурлагаа дэвтэр дээрээ бичнэ.	- Зөв сууж бичих, үзгээ зөв барихыг харуулсан зурагт үзүүлэн - Бичмэл үсгийн зурлага харуулсан зурагт үзүүлэн, ТӨМ
0.3б. Богино, урт, хос эгшиг үсгийг дэгийн дагуу бичих (а, аа, ай, э, ээ, эй, и, ий, ы, о, оо, ой, ө, өө, у, уу, уй, ү, үү, үй)	<i>Эгшиг үсэг бичиж сурах</i> 1. Багшийн үлгэрлэн бичсэн үсгийг ажиглаж, ямар ямар зурлагаас бүтсэнийг яриулна. 2. Самбар дээр хос шугамд багш тухайн үсгийн зурлага хаанаас нь эхэлж, ямар шугамд хэрхэн тааруулан бичих журмыг тайлбарлаж, бичиж үзүүлэхийг анхаарч сонсоно. 3. Багшийн бичиж байгааг дуурайн агаарт дүрсэлж үзүүлнэ. Зарим сурагчийг хүсэлтээр нь самбарт бичүүлж болно 4. Сурагчид шинэ үсгээ дэвтэр дээрээ бичнэ.	- Эгшиг үсэг бичих дарааллыг харуулсан зурагт үзүүлэн. - Зөв сууж бичих, үзгээ зөв барихыг харуулсан зурагт үзүүлэн - Бичмэл үсгийн зурлага харуулсан зурагт үзүүлэн, ТӨМ
0.3в. Том, жижиг “м, с, х, р, в, л, н, ш” үсгийг дэгийн дагуу бичих, зөв холбон бичих	<i>Нэгдүгээр шатны гийгүүлэгч үсгийг бичиж сурах</i> 1. Багшийн үлгэрлэн бичсэн үсгийг ажиглаж, ямар ямар зурлагаас бүтсэнийг яриулна. 2. Самбар дээр хос шугамд багш тухайн үсгийн зурлага хаанаас нь эхэлж, ямар шугамд хэрхэн тааруулан бичих журмыг тайлбарлаж, бичиж үзүүлэхийг анхаарч сонсоно. 3. Багшийн бичиж байгааг дуурайн агаарт дүрсэлж үзүүлнэ. Зарим сурагчийг хүсэлтээр нь самбарт бичүүлж болно. 4. Сурагчид шинэ үсгээ дэвтэр дээрээ бичнэ.	- Нэгдүгээр шатны гийгүүлэгч үсэг бичих дарааллыг харуулсан зурагт үзүүлэн - Зөв сууж бичих, үзгээ зөв барихыг харуулсан зурагт үзүүлэн - Бичмэл үсгийн зурлага харуулсан зурагт үзүүлэн, ТӨМ - Үсгүүдийг холбон бичихийг харуулсан үзүүлэн
0.3г. Том, жижиг “б, г, д, т, ц, ч, з, ж” үсэг болон зөөлний тэмдгийг дэгийн дагуу бичих, зөв холбон бичих	<i>Хоёрдугаар шатны гийгүүлэгч үсгийг бичиж сурах</i> 1. Багшийн үлгэрлэн бичсэн үсгийг ажиглаж, ямар ямар зурлагаас бүтсэнийг яриулна. 2. Самбар дээр хос шугамд багш тухайн үсгийн зурлага хаанаас нь эхэлж, ямар шугамд хэрхэн тааруулан бичих журмыг тайлбарлаж, бичиж үзүүлэхийг анхаарч сонсоно. 3. Багшийн бичиж байгааг дуурайн агаарт дүрсэлж үзүүлнэ. Зарим сурагчийг хүсэлтээр нь самбарт бичүүлж болно. 4. Сурагчид шинэ үсгээ дэвтэр дээрээ бичнэ.	- Хоёрдугаар шатны гийгүүлэгч үсэг бичих дарааллыг харуулсан зурагт үзүүлэн - Зөв сууж бичих, үзгээ зөв барихыг харуулсан зурагт үзүүлэн - Бичмэл үсгийн зурлага харуулсан зурагт үзүүлэн, ТӨМ - Үсгүүдийг холбон бичихийг харуулсан үзүүлэн

0.3д. Том, жижиг “я, е, ё, ю” болон “к, п, ф, щ” үсэг, хатуугийн тэмдгийг дэгийн дагуу бичих, үг, холбоо үг, өгүүлбэрийг бичих	<i>Я-ийн төрлийн эгшиг, онцгой гийгүүлэгч үсэг бичиж сурах</i> 1. Багшийн шинээр үзсэн үсгийг самбарт бичихийг ажиглаж, бичмэл үсэгтэй танилцана. 2. Багш үсэг бичихдээ хос шугамын хаанаас нь эхэлж, ямар шугамд хэрхэн тааруулан бичиж байгааг ажиглаж, тайлбарыг анхаарч сонсоно. Багшийн бичиж байгааг дуурайн агаарт дүрсэлж үзүүлнэ. 3. Сурагчид шинэ үсэг, үеийг дэвтэр дээрээ бичнэ.	- Я-ийн төрлийн 4 үсэг, онцгой 4 гийгүүлэгч үсэг бичих дарааллыг харуулсан зурагт үзүүлэн - Зөв сууж бичих, үзгээ зөв барихыг харуулсан зурагт үзүүлэн - Бичмэл үсгийн зурлага харуулсан зурагт үзүүлэн, ТӨМ
0.3е. Хуулж бичихдээ урт үгийг үеэр, богино үгийг бүтнээр нүдэлж бичих	1. Хуулж бичих өгүүлбэрийг бүтнээр нь уншина. (Багш самбарт 3-4 үгтэй өгүүлбэр бичиж өгнө.) 2. Багшийн өгсөн хугацаанд өгүүлбэрийг хэд хэдэн удаа уншиж, үгсийн бичлэгийг нүдэлнэ. 3-аас дээш үетэй үгийг багшийн үелэн хэлэхийг давтан хэлж тогтооно. Жишээ нь: хо-роо-лол, ө-гүүл-бэр гэх мэт. 3. Багш самбарт бичсэнээ арилгаж, сурагчид бичнэ.	- Нэгдүгээр шатны гийгүүлэгч үсэг бичих дарааллыг харуулсан зурагт үзүүлэн - Зөв сууж бичих, үзгээ зөв барихыг харуулсан зурагт үзүүлэн - Бичмэл үсгийн зурлага харуулсан зурагт үзүүлэн, ТӨМ - Үсгүүдийг холбон бичихийг харуулсан үзүүлэн

Цагаан толгойн үед бичихэд сургах

Цагаан толгойн үеийн нэг онцлог бол шинэ үсэгтэй танилцаж өдөр тутам бичих үйл хийдэг. Бичмэлээс хуулан бичих нь үндсэндээ үлгэр жишээ бичлэгийг дуурайн бичих үйл явц болно. Цагаан толгойн бэлтгэлийн үед эзэмшсэн зурлагуудыг ашиглан шинээр үзсэн үсгийг бичиж сурна. Ихэнх багш нар сурагчдын дэвтэр шинээр бичих үсгийг бичиж өгдөг бол зарим багш хичээнгүй бичгийн дэвтэр ашиглах нь бий. Цагаан толгойн үсгийг хос шугамд бичих нь эхлэн сурч буй хүүхдэд үсгийн эхлэх, үргэлжлэх, төгсөх баримжааг авахад тустай байна. Үсгийн өндөр нам, ташууг зөв гарган бичихэд ийм шугам чухал үүрэгтэй байдаг. Хос шугамд жижиг үсэг нь 4мм, том үсэг нь 7,5-8мм орчим байна. Ийнхүү цагаан толгойн үсэг бичүүлж сургах дараар аргыг багш нар түгээмэл хэрэглэдэг. Үүнд:

Тооллын /тактын/ арга: Эхний үед үсгийн зурлагын тоогоор тоолж бичүүлнэ. Дараа нь үеийн тоогоор бичүүлж болно. Энэ аргыг хэрэглэснээр ангийн сурагчдын бичгийн хурд жигд болно. Хэт хурдан элемент муутай бичдэг хүүхдийн бичлэгийг тогтоох, удаан бичдэг хүүхдийн бичих хурдыг нэмэгдүүлнэ. Мөн дэгийн дагуу сайхан бичдэг болоход хүүхдийн гарын хөдөлгөөнийг зөв зохицуулахад тусална. Энэ аргыг нэг цагийн хичээл дээр удаан хугацаагаар хэрэглэх нь үр дүнгүй, өөр аргатай хослуулан явуулах нь зохимжтой.

Баримжааллын арга: Үсгийн дүрсийг сурагчдад харуулаад хэлбэрийг нь хүүхдэд нүдлүүлэн ярилцах, дэвтэрт бичүүлэхийн өмнө агаарт бичих хөдөлгөөн хийх, хөдөлгөөнөө сурагчдаар дуурайлгах, самбар, эсвэл том цаасан дээр үсэг бичээд дээгүүр нь дагуулан бичүүлэх зэргээр тухайн үсгийн эхлэл, үргэлжлэх байдал, төгсгөл, мөн бичих дарааллыг гарт нь баримжаа болгох дасгал хийлгэсний эцэст бичүүлнэ гэсэн үг.

Эхлэн бичүүлж сургахад бичмэл үсэг тус бүрийг бүтээх зурлага, үсгийн дүрс хэлбэрийг хэрхэн бичих, бусад үсэгтэй холбох, үсгийн налуу ташууг яаж зөв гаргах аргуудыг анхнаас нь хүүхдэд зөв зааж бичих дадал эзэмшүүлснээр хичээнгүй сайхан бичиж сурах эхлэл тавигдана. Багш шинээр үсэг бичүүлэхийн өмнө үлгэр жишээ бичлэгийг сурагчдад үзүүлж, үсгийн зурлага тус бүрийг хаанаас эхэлж, ямар шугамд тааруулж бичих журмыг багш самбарт бичиж үзүүлнэ. Үүний тулд самбарт хос шугам зурж бэлтгэсэн байх хэрэгтэй.

Дараа нь эдгээрийг нийлүүлэн үсэг болгон бичих жишээг багш мөн самбарт бичиж үзүүлнэ.

Үүнийг алхамчлан тайлбарлавал:

1. Багш эхлээд бичмэл үсэг, мөн үсгийн зурлагыг үлгэрлэн бичиж, сурагчдад үзүүлж, бичмэл үсэгтэй танилцуулна.
2. Үсгийн зурлага хаанаас нь эхэлж, ямар шугамд хэрхэн тааруулан бичих журмыг багш, самбарт бичиж үзүүлнэ. Ийм учраас багш самбарт хос шугам татан бэлтгэсэн байх шаардлагатай. Багш үүнийг харуулж тайлбарлахдаа самбарыг биеэрээ халхлахгүй зогсож, хаанаас эхлэн ямар шугамаар бичиж, хаана дуусгахыг харуулахын зэрэгцээ тайлбарлан ярьж байж бичнэ. Мөн заримдаа агаарт дүрсэлж ч үзүүлнэ.
3. Эдгээр зурлагыг нэгтгэн үсэг болгон бичихийг үлгэрлэн үзүүлнэ. Сурагчид шинэ үсгээ дэвтэр дээрээ бичнэ.
4. Мөн тэр үсгийг үг, өгүүлбэрт оруулж бичих, үүнд багш самбар дээр үг бичихдээ үсгүүдийг хооронд нь яаж холбох, хоёр үгийн хооронд ямар хэмжээтэй зай үлдээх зэргийг сурагчдад бүрэн ойлгуулсны дараа бичүүлнэ. Тэгээд уншиж ярилцсаны дараа сурагчид дэвтэртээ яаралгүй сайхан бичнэ.

Бага ангийн сурагчдыг цагаан толгойн сургалтын үеэс л алдаагүй, зөв бичиж сурах эхлэлийг тавьдаг. Үсэг үзсэн өдрөөс эхлэн тухайн үсэг бүрийн зурлага, элемент бичвэрийн шаардлагыг зөв бичүүлж хэвшүүлэхийн тулд сурагч бүртэй ганцаарчлан, хэсэгчлэн ажиллах нэг цагийн хичээлийн үр өгөөжийг жигд байлгах зэрэг нь сурагч бүрийг амжилттай сургахын үндэс болдог. Хичээнгүй сайхан бичүүлж сургахдаа дараах асуудлыг анхаарах хэрэгтэй болдог. Тухайлбал:

1. Үсгийн элементийг зөв дарааллаар бичиж сургах

Энэ үед хүүхдэд үсгийн зурлагыг хаанаас эхэлж хаана төгсгөх, үсэг бүрт ямар зурлагууд орж байгааг мэдэж түүнийг яаж зөв бичүүлж хэвшүүлэхэд маш сайн анхаарах хэрэгтэй болдог. Жишээ нь: үсгийн дэгээ эхлэлтэй зурлагыг дээш шулуун татаж шулуун зураасаар холбон дэгээ төгсгөл хийж байгаагаар бичих. Үүнд сурагчид дунд талын хөндлөн зураасыг долгионтуулж хийх хандлага ажиглагддаг. Бас төгсгөлийг хэт хол зайтай бичих зэргээр алдаатай бичдэг.

- Хоёр тийш харж нийлсэн хагас дугуй зурлага. Энэ нь 2 хагас дугуйг яг ижил байхаар бичиж сургах
- Шулуун зурлагуудыг өндөр нам, хоорондох зайг яг ижил жигд хийж бичих. Хүүхдүүд дээд талын нурууг долгионтуулж бичээд байдаг гэх мэтчилэн үсэг бүрийн элементийг зөв бичүүлж сургахад маш нарийн анхаарах шаардлага байдаг.

2. Үсгийн налалтыг зөв гаргаж сургах

Үсгийн налууг 65 градус буюу дэвтрийн налуу шугамд баримжаалан бичих, хуудас цаасан дээр тусгайлан татаж бэлтгэсэн налуу шугамыг тавьж гэрэлтүүлэн бичих зэргээр бичүүлж хэвшүүлж болдог. Багш хүүхдүүдийн дэвтрийг үзэх явцдаа үсэг бүрийн налалт ямар байгааг шугам татаж шалган үзэж болно.

Хоёр дахь үгэнд шугамууд харилцан зэрэгцэж ойролцоо байгаа нь үсгийн налалт жигд, үсэг хоорондын зай ч зөв болж байгааг харуулна.

3. Үсгийн өндөр, намыг тааруулж бичих

Бага ангийн сурагчдын хувьд элементийн дэвтрийн хол, ойр шугамыг баримжаалан үсгийн өндөр намыг бичих ба цаашид ч жижиг, том үсгийн хэмжээг жигд байлгахад анхаарах. Хичээнгүй бичгийн стандартад зааснаар жижиг үсэг 3 мм, том үсгийн өндөр 7 мм орчим байхаар бичүүлдэг. Одоо ч бага ангид томоор бичүүлэх хэрэгтэй байдаг. Энэ нь үсэг бүрийн элементийг зөв гаргахад чухал нөлөөтэй ба бичгийн хэлбэрийг жигд сайхан харагдуулдаг. Аажимдаа хүүхдүүдийн бичиг жижгэрдэг учир бага ангид нь томоор бичүүлж байхад зүгээр санагддаг.

4. Үсгийн холбоосыг зөв хийлгэх

Үсгийн хоорондох холбоосыг үсэг холбон бичиж эхлэх үеэс зөв хийлгэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, авиа, үсэг таниулахдаа ямар үсэг, яаж холбогдож бичдэгийг маш сайн анхаарч хийлгэх хэрэгтэй байдаг. Анхнаасаа үсгийн холболтыг буруу хийсэн хүүхэд том болсон үедээ дараа, дараагийн үед засахад хүндрэлтэй болж ерөнхийдөө буруу холболттой бичдэг болдгийг багш бүр анхаарвал зохино. Тухайлбал: Өмнөө жижиг холбоос хийж бичдэг м, л, я үсгүүд, а, э, о үсгүүдийн холболтыг зөв хийхэд маш сайн анхаарах.

М-үсгийн холболтыг буруу хийвэл и үсэгтэй адил болж харагддаг. Ийм байдлаар харагдах бөгөөд сүүлийн холболтод нэг зүйл дутуу байгаа нь элементийг өөр болгож харагдуулна. а, о үсгүүдийг дээгүүр доогуур гэх мэтчилэн хэдэн янзаар холболт хийдэг.

Энэ нь элементээр сайхан бичүүлэх шаардлагад нийцэхгүй хүүхдүүдээс өөрөөр бичээд байдаг.

5. Үсэг, үг хоорондын зайг зөв авах

Үгийн хоорондох зайг чигчий хуруугаар баримжаалан бичүүлж сургадаг туршлага байдаг. Зарим хүүхдүүд үгийн хоорондох зайг хэт ойр, эсвэл хэт хол хооронд нь бүтэн үг бичихээр зай үлдээх буюу дэвтрийн нэг шугаманд 2-3 үг бичээд дүүргэх байдал ажиглагддаг. Энэ нь бичвэр үзэмжгүй харагдах, мөн дэвтэр нь амархан дүүрч олон дэвтэр хэрэглэх болдог ба дэвтрээ зөв ашиглаж чадахгүй байна гэсэн үг юм. Үсэг хоорондын зай нь 2 мм буюу ойролцоогоор 2 үсгийн хооронд дахин нэг үсэг бичих хэмжээтэй зай үлдээх нь зохистой. Бичихдээ үгийг үсгээр, өгүүлбэрийг үг, үеэр таслан, олон дахин харж бичих, үзгийг олон дахин дэвтрээс салгадаг зэрэг нь сайхан бичиж сурахад бэрхшээл учруулдгаас гадна бичиж байгаа зүйлийн утгыг ойлгохгүйд хүргэдэг. Ийм учраас эхний “а” үсгийг бичүүлэхдээ л зурлагын тоогоор хоёр дахин харахгүй, нэг удаа сайн хараад бичихийг шаардах хэрэгтэй. Энэ нь сурагчдад том, жижиг “а” үсэг бүтнээр нүдлэгдэн тогтож, хаа ч байсан таньдаг болно. Хэрэв “а” үсгийг зурлагын тоогоор хоёр удаа харж бичсэн бол үсгийг нүдлэн тогтоож чадахгүйд хүрнэ. Түүнчлэн эхний гийгүүлэгч таниулсан үед “ам, ах” гэх мэт хоёр үгийг нэг удаа хараад бичих, цаашид “сам, сар, нар” гэх мэт гурван үсэгтэй үгийг нэг удаа хараад бичих, улмаар хоёр богино үгээс бүтсэн өгүүлбэрийг нэг удаа сайн харж тогтоогоод бичдэг болгоход аажмаар дасгах хэрэгтэй. Энэ нь яваандаа хэд хэдэн үгтэй өгүүлбэрийг ч хараад, сонсоод бичдэг дадал олгохыг зорих хэрэгтэй.

Сурагчдыг шинэ үсэг, үе, үг, өгүүлбэр бичиж байгаа үед хурдан бичихийг шаардаж болохгүй. Их бага ямар боловч бичих ажлыг хийлгэж гүйцсэний дараа өөрсдөөр нь уншуулж хянуулах ба бүгд ижил зүйлийг бичсэн тохиолдолд нэг сурагчаар уншуулж, бусад бичсэнээ түүнтэй тохируулан шалгаж болдог. Нэгдүгээр улиралд нэг хичээлд хоёр мөрөөс илүү бичүүлэх шаардлагагүй. Дундаж бичдэг хүүхдийн хувьд энэ хоёр мөрийг бичихэд бараг 5-10 орчим зарцуулах болно. Гэрийн даалгаварт ч их зүйл бичүүлэх шаардлагагүй. Зарим багш сурагчдад нүүр нүүрээр нь бичих даалгавар өгдөг нь сайхан бичиж сургахаас илүү бэрхшээх, бушуухан дуусгахын тулд хааш яаш бичихэд хүргэдэг. Гэрийн даалгавар хэтэрхий их байвал хүүхэд удаан сууж ядраад, сонирхол нь буурч алдаатай, муухай бичихэд хүрдэг. Бичих даалгаврыг бага хэмжээтэй өгч, харин түүнийг маш зөв, нямбай цэвэр бичүүлэх нь чухал. Сурагчдын бичих чадвар нэмэгдэх тусам бичих зүйлийн хэмжээг аажмаар (1 мөрөөр) нэмэгдүүлэх хэрэгтэй. Сурагчдын бичих чадвар харилцан адилгүй тул бичих дадал хурдан эзэмшиж байгаа болон хоцорч байгаа сурагчидтай ялгаатай ажиллах хэрэгтэй. Өөр нэг анхаарах асуудал бол солгой гараар бичдэг хүүхэдтэй ялгаатай ажиллах хэрэг гарна. Дэвтэр тавих, үзэг барихаас эхлээд бусад хүүхдээс ялгаатай байна.

0.4. ХЭЛ ЗҮЙ, ҮГСИЙН САН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
0.4а. Өгсөн үгээс эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсгийг таньж нэрлэх	- Шинээр авиа үсэгтэй танилцах бүрд эгшиг авиа, эгшиг үсэг, гийгүүлэгч авиа, гийгүүлэгч үсэг, тэмдэг үсэг гэх мэтээр багшийн хэлэхийг анхаарч тогтооно. - Сурах бичигт үсгүүдийг ямар өнгөөр тэмдэглэсэн байгааг ажиглаж “а” эгшиг үсэг”, “б” гийгүүлэгч үсэг,”ь” хатуугийн тэмдэг үсэг” гэх мэтээр хэлж сурна.	- Сурах бичиг - Эгшиг, гийгүүлэгчийг өнгөөр ялган тэмдэглэсэн үгийн үзүүлэн, тарааж өгөх материал
0.4б. Хуулж болон цээжээр бичихдээ хүний нэр ба өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих	- Эхээс том үсгээр бичсэн үгсийг ажиглаж, яагаад том үсгээр эхэлж байгааг өөрийн ойлголтоор тайлбарлах - Хүний нэр болон өгүүлбэр эхлэхдээ томоор бичдэг дүрмийг ярилцах - Хуулж болон цээжээр бичихдээ том үсгийн дүрмийг баримтлан бичих - Бичсэнээ хянах	- Хүний нэр болон өгүүлбэрийн эхлэлийг нөхөж бичих хэрэглэгдэхүүн

0.4в. Өгүүлбэрийг хаана?, хэзээ? гэсэн асуултаар дэлгэрүүлэх	- Уншсан өгүүлбэрээс хаана? хэзээ? гэсэн асуултад хариулагдах үгсийг түүж бүлэглэх - Бүлэглэсэн үгэндээ асуулт тавих. - Хэн? хаана? яав?, хэн? хэзээ? яав? - гэх мэт асуултын бүтцээр өгүүлбэр зохиох, өгүүлбэр дэх үгэнд асуулт тавих - Өгүүлбэрийг асуултад хариулагдах үгсээр дэлгэрүүлэн бичих	- Өгсөн бүтцийн дагуу өгүүлбэр зохиох загвар үзүүлэн - Асуултад тохирох үгийг нөхөж бичих тарааж өгөх материал
---	--	---

Цагаан толгойн өмнөх үед “үг, өгүүлбэр” гэсэн сурагчдад “а” авиа, үсэг таниулахаас эхлэн “авиа, үсэг”, “эгшиг”, “эгшиг авиа”, “эгшиг үсэг”, “богино эгшиг”, “урт эгшиг”, “хос эгшиг” гэсэн үг хэллэг шинээр хэрэглэх хэрэгцээ бий болно. Үүнтэй холбоотойгоор эгшиг авиатай холбогдох багшийн тайлбарыг сурагчид ойлгоход бэрхшээлтэй тул багш эдгээрийг нэг дор бүгдийг нь хэрэглэхгүй, нэг нэгээр хэлж, дасгах нь илүү үр дүнтэй. Мөн сурах бичигт эх, өгүүлбэр, үгийг задалсан бүдүүвч, тэмдэглэгээг анхааралтай таниулах шаардлагатай.

ЦАГААН ТОЛГОЙН ДАРААХ ҮЕ

НЭГ. УНШИХ ЧАДВАР

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1.1а. Өгүүлбэр, эхээс танил биш үгийг олж, утгыг нь таамаглах	- Эх, өгүүлбэрийг уншихад тааралдсан танил биш үг хэллэгийг олж, доогуур нь зурах, тодруулагчаар тэмдэглэх - Уг үгийн утгыг эхийн хам бүтцээс таамаглах, асуух - Жишээ нь: “Ажил хийвэл ам тосодно” хэлцийг уншсаны дараа “ам тосодно” гэсэн хоёр үг нийлээд идэх хоолтой болно гэсэн утгатай болохыг мэдэх - Багшийн үгийн тайлбар уншихыг анхаарч сонсох - Тухайн үгийн эхэд хамаарах утгаар өгүүлбэр зохиож хэлэх, тохирох зурагт харгалзуулах - Тухайн үгийг мэддэг үгтэйгээ харьцуулж, адил төстэй хэсгүүд байгаа эсэхийг нягталж үгийн утгыг ойлгон унших	- Ойролцоо бичлэг, дуудлагатай үгсийн утгыг ялгах
1.1б. Сурах бичгийн эх, зурагт эх, богино хэмжээтэй хялбар эхийг уншиж агуулгыг ерөнхийд нь ойлгосноо харуулах	Уран зохиолын эх унших 1. Эхийг уншихын өмнө зураг ба гарчгаас юуны тухай унших гэж байгаагаа таамаглаж, ярилцах 2. Багшийн болон бусад сурагчийн уншихыг анхаарч сонсох, асуулт асуух 3. Эхийг хамтарч унших 4. Эхийг бие дааж унших 5. Эхэд юуны тухай уншсанаа эргүүлж ярих 6. Уншсан эхийг уншиж ойлгосноо харуулах - Асуултын дагуу ярих - Асуултад хариулах - Агуулгыг зургаар харуулах - Асуултын зөв хариултыг олж сонгох - Эхийн агуулгыг харуулсан зургийг зөв дараалалд оруулах Хэрэглээний эх унших - Гудамж талбай, байгууллагын гадна хаяг, хүнсний бүтээгдэхүүн баглаа боодол, шошго дээр томоор бичсэн нэр хаягийг унших, уншихыг эрмэлзэх (заавал учрыг ойлгох гэх албагүй) - Сурах бичиг, дэвтрийн хаяг, ном, сэтгүүлийн нэр, зохиогчийн нэр зэргийг олж унших	- Богино хэмжээтэй хялбар эх, үлгэр, өгүүллэг, шүлэг хэрэглээний эхүүд (нэр хаяг) - Зурагт эх, хялбаршуулсан, богино хэмжээтэй

1.1в. Уншсан эхийн үйл явдлыг асуултын дагуу тоочин ярих (эхлээд? дараа нь, эцэст нь?)	Эхийн үйл явдлын дарааллыг асуултын дагуу тоочин ярихдаа: 1. Эхийг хэд хэдэн удаа уншиж, хэн? юу?, юуг?, яав?, яасан? гэсэн асуултад хариу олно. 2. Уншихдаа үйл явдлын дарааллыг тэмдэглэн уншина. - Эхлээд ямар үйл явдал болов? - Дараа нь ямар үйл явдал болов? - Тэгээд яасан бэ? Яаж өрнөв? - Төгсгөлд нь ямар үйл явдал болов? 3. Эхийн агуулгыг ярихдаа “эхлээд, дараа нь, тэгээд, эцэст нь” гэх мэт үг хэрэглэн үйл явдлын дарааллаар ярина.	
1.1г. Уншсан эхийн баатрын хийсэн зүйлийг тоочих 1.1е. Зохиолын баатруудын гадаад байдлыг төсөөлж ярих	1. Уншсан эхээс гол баатруудыг нэрлэх 2. Яагаад гол баатар гэж үзэж байна вэ? гэсэн асуултад хариулах 3. Эхэд гол баатрын юу юу хийснийг тоочин, тэдгээрийн аль нь сайн, аль нь муу үйл болохыг жишээгээр ярина. 4. Гол баатар эдгээр сайн, муу үйлийг яагаад, юунаас болж хийх болсон шалтгааныг багшийн асуултын дагуу ярилцана. 5. Эхээс гол баатрын гадаад байдлыг дүрсэлсэн хэсгийг олж, бие дааж болон хамтарч унших 6. Гол баатрын гадаад байдлаас юуг нь онцолж дүрсэлснийг олж ярилцана. (хувцаслалт, үг яриа, нүүр царай гэх мэт) 7. Гол баатрын дүрсэлсэн хэсгийг бусдад уншиж өгөх 8. Дүрсэлсэн хэсгийг дэвтэртээ хуулж бичих	- 6 настай хүүхдэд зориулсан үлгэр, өгүүллэг - Холбогдох зураг
1.1д. Цээжилсэн хэл зүгшрүүлэх үг, бэлгэ дэмбэрлийн үг, шүлгийг бусдын өмнө тод чанга дуугаар унших	Сурах бичиг, тарааж өгөх материал дахь шүлэг, оньсого, бэлгэ дэмбэрлийн үг, зүйр цэцэн үг зэргийг уншиж цээжлэхдээ: 1. Багш, бусад сурагчийн уншихыг сонсоно. 2. Юуны тухай өгүүлж байгааг асуултын дагуу ярилцана. 3. Танил биш үгийг утгыг ярилцана. 4. Эхийг бие дааж хэд хэдэн удаа уншина. 5. Бусдад чангаар уншиж өгнө. 6. Цээжлэн тогтоох дасгал хийнэ. 7. Цээжилснээ бусад хүний өмнө уншиж харуулна.	- Сурах бичиг, тарааж өгөх материал дахь шүлэг, оньсого, бэлгэ дэмбэрлийн үг, зүйр цэцэн үг
Багшийн анхаарах зүйл: Сурахад тохиолддог хамгийн том саадыг ойлгомжгүй буюу танил биш үг хэллэг гэж үзсэн байдаг. Танил биш үгийн утгыг сурагчдад ойлгуулах хоёр үндсэн арга байдаг. 1. Үзүүлэн таниулах 2. Тайлбарлан таниулах хоёр үндсэн арга Энэ хоёр аргаас нэгдүгээр ангид үзүүлэн таниулах арга маш чухал тул тухайн зүйлийг биет байдлаар, эсвэл бодит үзүүлэн, макет, зураг, видео бичлэг үзүүлэх нь үр дүнтэй. Жишээ нь: “Хонь хонь буугаарай Холбоо дүүрэн хоньтой болоорой” гэсэн бэлгэдэл үгийг уншуулахдаа хотын хүүхэд холбоотой хонины зураг, бичлэг үзүүлбэл утгыг нь шууд ойлгоно.  		

Гэтэл хөдөөгийн хүүхэд замын гэрэл дохио, явган хүний гарц, цагаан шугамын тухай уншуулахад зургийг нь үзүүлэх нь үр дүнтэй.

Тайлбарлан таниулах хэд хэдэн арга байдаг. Тухайлбал:

1. Ойролцоо утгатай үгийг ашиглах арга: Жишээ нь: бах-мэлхий, хөвөөх-живэх
2. Өгүүлбэр, холбоо үгийн бүтцээс ойлгуулах арга:

Жишээ нь: хонины холбоо, хонь холбох- Би хонио холбов. шуудан холбоо- Холбооны газраас сонин авав. Үгэн тоглоом тоглуулах арга:

Жишээ нь: Эхний үе нь үсний хэрэгсэл

Дараах үе нь араатны нэр

Нийлүүлж уншвал

Ангид байдаг эд хогшил (самбар)

Эхэнд бичсэн “С” үсгийг

Эндүүрч бичээд “Х” болгочихсон чинь

Хоолны хэрэгслээ болиод

Ховдог шувууны нэр болчихлоо (сэрээ- хэрээ)

Сурагчдад унших даалгавар өгсөн бол танил биш, ойлгомжгүй үг хэллэг таарвал доогуур нь зурах, тодруулагч хэрэглэх, асуултын тэмдэг тавих гэх мэтээр тэмдэглэхийг зөвлөж болно. Ангийн сурагчдаар ижил тэмдэглэгээ хэрэглэхийг зөвлөж болно. Нэг унших эхэд хэт олон хүнд үг хэллэг байхаас сэргийлэх хэрэгтэй. Багш ийм үгийг урьдчилан судалж, холбогдох зураг, товч тайлбар зэргийг бэлтгэсэн байвал зохино. Ялангуяа сурагчдыг шинэ үгийн утгыг бүрэн ойлготол нь өгүүлбэр зохиож хэлүүлэх нь үр дүнд хүргэдэг.

1. Чангаар дуудаж унших, багш унших явцыг анхааралтай ажиглаж, үг орхиж унших, буруу унших, будилах, эргэлзэж тээнэгэлзэх зэрэг байдал гарвал тухай бүр тусална. Энэ үед багш тайлбар толь бичгээс тухайн үгийг харж, тайлбарлаж өгнө. Хэрэв толь бичиг ашиглах нь нэгдүгээр ангид арай тохиромжгүй гэж үзвэл уншиж байгаа эхэд холбогдох зургийг урьдчилан бэлтгэсэн харуулж, тайлбарлаж болно.
2. Уг үгийг олж, тайлбарыг уншиж өгөх нь хүүхдэд бас нэг мэдлэг болж өгнө. Эсвэл багш тухайн сэдэвт зориулан зураг бэлтгэхийн зэрэгцээ хажууд нь товч тайлбарыг энгийн байдлаар тайлбарлан бичиж болно. Тухайлбал:
3. Сурагч дахин дээрх алдаа гаргахгүй бол цааш нь үргэлжлүүлэн уншуулна. Хэрэв дээрх алдаа гарвал үгийн утгыг дээрх маягаар тодруулна.
4. Чангаар дуудан унших нь бусдад уншихтай хэлбэрийн төстэй хэдий ч зорилго нь ялгаатай.

Нэр, хаяг унших. Сурагчдыг сурах бичгийн хүрээнд танил эх уншуулахын зэрэгцээ орчин тойрондоо байгаа янз бүрийн бичвэр уншихыг дэмжих хэрэгтэй. Мөн тоглоомын дүрэм, заавар, бараа бүтээгдэхүүний шошго дээр бичсэн нэр, сургуульдаа ирж, буцах замд тааралдах дэлгүүр, номын сан, цайны газар, эмийн сан зэрэг байгууллагын гадна нэр хаяг, рекламн самбар дээр зар, телевизийн нэвтрүүлгийн нэр зэргийг унших үйл ажиллагааг дэмжсэн даалгавар өгч болно. Гэхдээ эдгээрийн утгыг сайн ойлгох шаардлагагүй, зөвхөн уншиж байх нь чухал юм. Жишээ нь:



Ангид унших таатай орчныг бүрдүүлэх хэрэгтэй. Унших чадвар төлөвшил нь ярих сонсох, бичих чадварт нөлөөлж байдаг тул сайн уншигч болгон төлөвшүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Унших үйлийг удирдах. Багш унших үйл ажиллагааг удирдахдаа эхийг хэсэглэн уншуулж, үйл явдлыг нь нягтлан ярилцаж, дараа нь юу болохыг таамаглах боломж олгоход анхаарах бол уншсаны дараа эхийн агуулгыг тодруулах асуулт асуух, уншаад юу ойлгосноо дахин ярих, ойлгосноо дахин уншиж шалгах, жижиг бүлгээр асуулт хариулт зохиох, эхийн санааг дүгнэн ярилцах, зургаар болон бичгээр тайлбарлах, жүжигчилсэн тоглолт хийх зэрэг үйл ажиллагааг хийлгэж болно. Эцэст нь эхийг уншсанаар юуг ойлгож авсан тухайг нь яриулж, эхийн санаатай холбоотой хичээлээс гадуур уншлагын сэдэв сонгож өгөх нь сурагчдын унших дур хүслийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Зөв уншлага. Зөв уншлага гэдэг бол алдаагүй (үгийн үе, үсэг сольж, гээлгүй), амьсгал тохируулан, бичгийн хэлний үндсэн хэв журмын дагуу уншихыг хэлнэ. Зөв унших суурь нь цагаан толгойн сургалтын үеэс эхлэн тавигдаж, анги ахих тусам улам өргөжнө. Ийм учраас сурагчдыг багаас нь аль болох шулуун шударга, хурц тод хэлж уншуулахыг хичээх хэрэгтэй. Хэрэв сурагч түгдэрч байвал тухайн үгэнд үгийн задлаг хийж унших дадалтай болгох хэрэгтэй. Зөв уншиж сурахад танил биш, шинээр танилцсан үгийн утгыг ойлгуулах явдал чухал байдаг. Ажиглалтаас үзэхэд муу уншдаг хүүхэд уншиж байгаа зүйлээ төдийлэн сайн ойлгодоггүй байна. Зөв уншлага нь голдуу бусдад уншихаар илэрхийлэгддэг. Сурагчдын уншлагыг ажиглахад

- а. Үгийн төгсгөлийг буруу унших
- б. Ойролцоо дуудлагатай үсгийг сольж унших
- в. Урт, хос, богино эгшгийг буруу унших зэрэг дутагдал ихээхэн гардаг.

Иймээс хүүхэд бүрд унших боломж олгож, ийм үйлийг хэвшил болгохын тулд дараах асуудлыг анхаарах хэрэгтэй. Үүнд:

1. Үсэг, үгийг зөв хэлж дуудах
2. Үсэг, үе орхихгүй гүйцэд унших
3. Үсэг, үе, үгийг давтан хэлэхгүй байх
4. Үсэг, үеийг сольж уншихгүй байх
5. Үсэг, үе нэмж уншихгүй байх
6. Өгүүлбэр уншихдаа өргөлтийг зөв хэлэх
7. Их, бага зогсолтыг зөв хийх
8. Дууны өнгийг тохируулан унших

Зөв уншиж сургахын тулд багш тухайн үсэг үзэхэд шинээр унших үгсийн утгыг ойлгуулахад анхаарч холбогдох үзүүлэн таниулах бэлтгэх хэрэгтэй. Хэрэв зургаан настай хүүхдэд ойлгомжгүй байвал бодитоор эсвэл зургаар үзүүлэхээр бэлтгэх бол хялбар үгийг хичээлийн явцад, заримыг нь уншлагын дараа товч тайлбарлаж болно.

Хурдан уншлага. Сурагчид аажмаар уншлагын хурдыг тохируулан унших дадалтай болдог. Сурагчдын унших хурд ангиас ангид нэмэгдэнэ. Сурагчид сэдвийг хэт хурдан, эсвэл хэт удаан унших нь утгыг ойлгоход нь саад болдог. Ер нь уншлагын хурдыг хүний ярианы хурдтай ойролцоо байхыг зохистой гэж үздэг. Хүний унших хурд нэмэгдэх тусам мэдээлэл авах боломж нэмэгдэх тул аль болох бага хугацаанд их мэдээлэл авч чадахаар уншиж сургахад чиглүүлэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, нэгж хугацаанд унших хурдыг ахиулна гэсэн үг болно. Зарим сурагч хэт хурдан уншихад анхаарч, уншиж байгаа зүйлээ ойлгодоггүй бол зарим нь хэт удаан уншсанаас зохиолын агуулгыг ойлгодоггүй. Улиралд 2-3 удаа танил ба танил бус сэдвээр уншлага хийлгэж, унших хурд нь хэрхэн төлөвшиж байгаад дүгнэлт хийх зүйтэй.

Хүүхдийн хурдан уншлагад сургахад олон арга байдаг. Зарим багш шүлэг цээжлүүлж уншуулсны дараа сурагчид өөр сэдэв уншихдаа шүлэг уншсан хурдаар уншихыг эрмэлздэг.

Мөн уншсан сэдвээс аль нэг үгийг хурдан олох (Жишээ нь: Уншсан эхээс нэг өгүүлбэрийг аль нэг үгийг бичилгүй, зай үлдээх, цэгээр тэмдэглэх гэх мэтээр уншуулж, дутуу үгийг олох даалгавар өгөх гэх мэт), багшийн асуултад тохирох хэсгийг олох (Багш уншихын өмнө асуултыг бэлтгэж, унших явцдаа асуултын хариуг олох гэх мэт) зэрэг дасгал ач холбогдолтой.

Ухамсартай уншлага. Унших явцдаа утгыг бүрэн ойлгож авахыг ухамсартай уншлага гэдэг. Үүний тулд зөвхөн үгсийн утгыг төдийгүй өгүүлбэр, цогцолборуудын санааг саадгүй ойлгож байвал зохино. Сэдвийнхээ үндсэн агуулгыг ойлгож байна гэдэг бол өгүүлбэр болон цогцолборын гол санааг ялган салгаж, тэдгээрийн хоорондын учир шалтгааныг тогтоож чаддаг байхыг хэлнэ. Зарим сурагч хэт түргэн уншдаг ч ойлгосон зүйлгүй хоцордог нь ухамсартай уншиж сураагүйтэй холбоотой. Сурагчид эхнээс нь үг үгээр нь биш, аль болох утгаат хэсгээр нь зааглан, улмаар бүтэн өгүүлбэрээр нь уншиж сургах хэрэгтэй. Бүтээлчээр утгаачлан уншиж сурсан хүн нэг харахдаа хэд хэдэн үгийг (4-5) нэгэн зэрэг уншиж чаддаг байна. Ийнхүү хэд хэдэн үгийг гүйлгэн харах явцад цааш нь тийм үг байх ёстой гэдгийг таамаглан унших чадвартай болдог байна.

Сайн уншигч болж төлөвшихөд уншсанаа ойлгож тогтоох явдал чухал. Ийм учраас сурагчдаар тодорхой сэдэв уншуулсны дараа асуулт асууж хариулт авах, зураг зуруулах, яриулах, үйл хөдлөл нэрлэсэн үгийг дарааллаар нь байрлуулах, зурагт харгалзуулах, тохирох хариултыг олох гэх мэт олон аргаар хэрхэн ойлгосныг илрүүлж болно. Нэгдүгээр ангийн сурагчид нэг уншаад ойлгоход бэрхшээлтэй тул багш эхлэн үлгэрлэн унших, дараа нь хамтын уншлага хийх, бие дааж унших гэх мэтээр хэд хэдэн унших боломж олгох хэрэгтэй.

Бусдад уншуулахдаа хүүхдийг ганц нэгээр нь биш хосоор, багаар, анги нийтээр нь уншуулах нь тэдний айдсаас холдуулна.Эхний үед багш болон сайн уншигч сурагчийг дагуулан уншуулах, бичлэг сонсгон дагуулан уншуулах зэргээр аль болох тод чангаар уншуулж зүгшрүүлэх хэрэгтэй.

Уран тод унших. Уран уншлага нь бусдад уншиж байгаа сэдвийн агуулгыг гүн гүнзгий ойлгуулах, сурагчдын сэтгэл хөдлөл, гоо зүйн хүмүүжил төлөвшилд чухал нөлөөтэй. Уран уншлага бол ухамсартай уншлагатай нягт холбоотой. Хэрэв сурагчид уншсан зүйлийнхээ утгыг сайн ойлгоогүй бол утга төгөлдөр, уран уншиж чадахгүй. Утга төгөлдөр сайн уншихгүй бол ойлгоход бас хэцүү. Ухамсартай уншлага нь уран уншлагын бэлтгэл болдог бол зөв унших нь уншиж буй зүйлээ сайтар ойлгоход тусалдаг харилцан холбоотой үйл ажиллагаа юм. Уран уншихад утгын өргөлт гаргах, их, бага зогсолт гаргах, уншлагын хурд, өнгө аялга зэрэг чухал үүрэгтэй байдаг. Уран тод уншуулж сургахын тулд эхлээд үг, өгүүлбэрийг тод уншиж сургах, аажимдаа урнаар уншуулж сургах хэрэгтэй. Уран уншлагыг дараах хэлбэрээр хийж болно

Тухайлбал: шүлэг, магтаалыг анги нийтээр болон сурагчид ганц ганцаар уншиж болно. Ийнхүү уншихад шүлгийн утга санааг сонсож байгаа хүмүүст хэрхэн хүргэх талаар бодож төлөвлөх хэрэгтэй. Тухайлбал: ямар байдалтай унших, ямар хөдөлгөөн хийх, дууны өнгө, аялга хэмнэл ямар байх гэх мэт.

Шүлгийг цээжилж, бусдын өмнө уншиж сурах. Шүлгийн үг хэллэг хүүхдэд амархан тогтоогддог. Багш шүлгийн уран яруу хэллэгийг сурагчдад сайн ойлгуулж чадвал хүүхэд шүлгийг амтархан унших болно. Шүлгийг өөрийн үгээр ярих боломжгүй тул шүлэгтэй багш болгоомжтой хандахгүй бол шүлгийн утга санааг сурагчид ойлгохгүйд хүрч, улмаар шүлэг унших сонирхолгүй болно. Шүлгийг уншуулахдаа багш зохиолчийн дүрсэлсэн байгаль, юмс, үзэгдэлийн дүрслэлийг ойлгуулж, шүлэгчийн дотоод сэтгэлийг мэдрүүлэхэд оршино. Шүлгийг уншуулахын өмнө бэлтгэх яриа хийсний дараа шүлгийн анхны уншилтыг багш өөрөө хийж үзүүлнэ. Багш үнэхээр уран тод, сайхан, үлгэр жишээчээр унших нь сурагчдын уншлагын дадал чадвар эзэмшихэд туслаад зогсохгүй, шүлгийн гүн гүнзгий уран дүрслэлийг ойлгоход тусална. Шүлгийн утга санааг ойлгуулах, түүнийг нь гүнзгийрүүлэхэд гол зорилго оршино. Шүлэг уншуулах төгсгөлийн ажиллагаа бол уран уншуулах ажил байдаг. Шүлгийн ерөнхий утга санаа, үйл байдлын дараалал, үг бүртэй танилцан хэд хэдэн удаа уншсаны үр дүн нь уран унших үндсэн нөхцөл болдог. Иймээс шүлгийг уран тод уншуулах нь шууд гүйцэтгэх ажил биш, уншлагын бусад ажилтай хосолсон бэлтгэл шаардана. Үлгэр, өгүүллэгийн баатрыг төлөөлөн унших хэлбэр байж болох бөгөөд сонгосон үлгэр, зохиолын баатрыг сурагчдад оноон өгч тэднийг төлөөлөн эхээс уншуулж болно. Хэрэв үүгээр дүрийн тоглолт хийхээр бол, жишээ нь: “Долоон ногоон өндөгтэй доголлон шаазгайн үлгэр”-ээр дүрийн тоглолт хийхэд үнэг, шаазгай, хулганын дүрд оногдсон хүүхдүүд тэдгээрийн хэлдэг үгийг цээжилсэн, түүнийг уран тод хэлж сурсан байна.Нэг хүн зохиолын бүх баатрыг төлөөлөн уншиж болно.

Энэ тохиолдолд тухайн хүн баатар бүрийн онцлогийг гарган уншихыг хичээнэ. Жишээ нь: дээрх үлгэрийг нэг хүн уншихаар бол үнэгний зальжин, дээрэнгүй байдал, шаазгайн аймхай байдал, хулганын аргатай, ухаантай байдлыг харуулахаар дуу хоолойн өнгийг гарган уншвал нэн сайн болно.Уран зохиолын уншлагад багш олон арга хэрэглэдэг. Эдгээрээс зарим аргыг тайлбарлаж байна.

Үлгэрлэн унших уншлага. Багш шаардлагатай үед зарим зохиолыг бүхлээр нь буюу хэсэглэн үлгэр жишээ уншлага хийж үзүүлэх нь сурагчдын унших хүсэл эрмэлзлийг төрүүлэх, үгийн урлагийн сайхныг мэдрэх, цаашид уран зохиолд шимтэн дурлахад нь их ач холбогдолтой байдаг. Үлгэрлэх уншлага бол эх зохиолын үйл явдлыг сурагчдын ой тойнд ортол дүрсэн үзүүлэх нэг арга болдог. Багш тухайн эхийг үлгэрлэн уншихаар төлөвлөсөн бол унших бэлтгэлийг сайтар хийж, дахин дахин уншиж, гол санааг гаргахын тулд ямар үгийг хаана хэрхэн унших, түүний хөг аялга, утгын өргөлт, цэг таслал, удаан түргэнийг хэрхэн тохируулахад ихэд анхаарч, уншлагын бүхий л шаардлагыг хангасан байх шаардлагатай.

Уншихын өмнө түгээмэл хэрэглэгддэггүй үг хэллэгийг тайлбарлаж өгөх хэрэгтэй. Зарим үед үлгэрлэх уншлагыг маш сайн уншдаг сурагчаар хийлгэж болно.

Давтан унших уншлага. Энэ уншлагын гол зорилго бол сурагчдын унших дадал, чадварыг хөгжүүлэхэд оршино. Давтах уншлагад олон сурагчийг хамруулах шаардлагатай тул эх зохиолыг хэсэглэн хэд хэдэн сурагчаар уншуулах хэрэгтэй. Сурагчид өмнө уншсаныг давтан уншиж байгаа тул өмнө гаргасан алдааг дутагдалыг нь гаргуулахгүй байхад багш анхаарна.

Давтан унших явцад сурагчийн гаргасан алдаа, оноог бусад сурагчаар ажиглуулж, тухай бүр хэлэлцүүлж байх нь өөрийн болоод бусдын уншлагыг харьцуулан сайнаас нь суралцаж, муугаас сэргийлэх боломжийг сурагчдад олгодог сайн талтай.

Төлөөлөн унших уншлага. Энэ нь зохиолч ба зохиолын баатруудыг сурагчид төлөөлөн амьдруулж уншихыг хэлнэ. Уншлагын явцад сурагчид зохиолын үйл явдал, дүрслэгдэж байгаа хүн, юмсын харилцаанаас сурагчид тус тусын төлөөлж байгаа баатрын зан чанар, дүр байдал, хүсэл зорилгыг танин мэдэхэд тус болохын зэрэгцээ зохиолыг унших урмыг сэргээж, сонирхлыг татдагаараа онцлогтой.

Хамтын уншлага. Бага ангийн сурагчид унших дадал сайн эзэмшиж сураагүй байдаг тул энэ аргыг үе үе хичээлд ашиглах нь үр дүнтэй. Энэ нь ангийн бүх сурагч хамтарч дуу нийлүүлэн зэрэг уншихыг хэлнэ. Энэ уншлага нь зохиолыг хамт олноороо цээжлэх, улмаар уран унших бэлтгэл болохын зэрэгцээ хийх, хэлэхэд төвөгтэй хүндэвтэр үгийг зөв дуудаж сурахад ач холбогдолтой.

Сурагчдад сонгон унших боломж олгох хэрэгтэй. Хот хөдөөгийн аль ч сургуулийн номын сангаас гадна ангийн номын сантай болсон байгаа. Энэ нь хүүхдийн уншлагыг дэмжих чухал орчин болно. Уншлагад сурах бичгээс гадна ангийн номын санд байгаа үлгэр зохиолыг ашиглаж болно.

Мөн багт тусгайлан бэлтгэсэн зохиолоос сонгон тарааж өгөх материал бэлтгэн уншуулж болно. Ийнхүү эх зохиол сонгохдоо зургаан настай хүүхдийн танин мэдэхүй, хөгжлийн онцлогт тохирсон байх дараах шаардлагыг байнга анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Эхийн хэмжээ хэт том биш, үг хэллэг нь энгийн хялбар байх
- Эхийн агуулгыг тодруулах зураг дүрслэлтэй байх
- Эхийн агуулга, санаа нь шууд ойлгогдохоор байх
- Эх нь голдуу энгийн өгүүлбэрээс бүтсэн байх
- Эхэд шилжсэн утгатай үг хэллэг хэрэглээгүй байх

Үлгэрийн уншлага. Хүүхэд багаасаа л үлгэрийг маш дуртай сонсож, үлгэрийн кино үзэж, дахин дахин яриулж, уншуулж байх хүсэлтэй байдаг. Ийм учраас нэгдүгээр ангийн сурагчдын унших номд үлгэр цөөнгүй оруулдаг.

Хүүхдүүд үлгэрийг маш амархан ойлгож, өөрийн хайртай баатрыг амархан "илрүүлж" таньж олдог. Ихэвчлэн адегуусан амьтны үлгэрийг уншиж задлал хийж ярилцахдаа үлгэрт гарч байгаа амьтдын үйл хөдлөл, дүр байдлыг тодорхойлж болно. Жишээ нь: Шаазгайн өндгийг хуурч, айлган сүрдүүлж байгаа үнэг бол зальтай, аргатай амьтан. Харин шаазгай бол аймхай, гэнэн амьтан. Хулгана бол ухаантай, сэргэлэн амьтан гэх мэтээр дүгнэлт хийлгэж болно. Амьтдын тухай үлгэр уншсаны дараа амьтдаар хүнээр төлөөлүүлсэн гэдгийг онцгойлон ярих шаардлагагүй. Зургаан настай хүүхэд нарийн учрыг ойлгохгүй тул төөрөлдөхөд хүрнэ. Зургаан настай хүүхдийн хувьд амьтдыг хүнтэй адилхан ярьж хөөрдөг гэдэг ойлголтоосоо бараг салаагүй байдаг. Ийм учраас зургаан насыг "үлгэрийн нас" гэх нь бий.

Харьцангуй том хэмжээтэй үлгэр, зохиол уншихаар сонговол бага багаар уншуулахаар хэсэглэж, тус бүрийг уншсаны дараа асуулт асууж, цаашид юу болохыг таамаглан ярилцаад уншуулна. Үүнийг дараах үлгэрээр жишээлэн үзүүлээ. Энэ үлгэрийг дөрвөн хэсэг болгон уншуулахыг зохистой бөгөөд эхний хэсгийн уншсаны дараа цаашид юу болох талаар таамаглал дэвшүүлэн өгсөн асуултын дагуу ярилцана. Дараагийн хэсгийг уншсаны дараа уншихын өмнө төсөөлөн бодож байснаа харьцуулан бодох, үүнийгээ бусад сурагчдад ярьж илэрхийлэх боломж олгох хэрэгтэй. Үүнийг багш асуултаар удирдана. Энэ мэтээр дөрвөн хэсэг тус бүрийг таамаглал дэвшүүлэн уншуулснаар нэг талаар сурагчдын сэтгэн бодох чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ үлгэрийн утга агуулгыг бүрэн дүүрэн ойлгуулах зорилготой үйл ажиллагаа болно.

	- Асуултын оронд тохирох үгийг нөхөн бичиж өгүүлбэрийг гүйцээн бичих - Загварын дагуу өгүүлбэр зохиож бичих - Зурагт тохирсон өгүүлбэр зохиож бичих - Асуултад өгүүлбэрээр хариулж бичих - Зураг харж эх зохиож бичих Асуултын жишээ: - Зураг дээр юу юу байна? - Хэдэн хүүхэд байна? Нэр өгөөрэй. - Болд юу хийж байна? - Баяр юу хийж байна? - Ананд юу хийж байна? - Үүр хийсний дараа юу болох вэ? гэх мэтээр асуултад хариулж бичүүлнэ. Өгүүлбэрүүд нийлж зургийн утга санааг гаргахаар бичүүлнэ.	
1.2е. Өөрийгөө 4-5 өгүүлбэрээр танилцуулж бичих	Хамтарч зохион бичих Багш урьдчилан бэлтгэсэн зургийг сурагчдаар ажиглуулна. Зургийг ажиглаж, дарааллыг өөрийн хувилбараар хэлэхэд бэлэн болсон сурагчдыг гараа өргөхийг анхааруулна. Хэд хэдэн сурагчаар дарааллыг хэлүүлж, санал нийлж байгаа эсэх талаар ярилцана. Багш асуулт асууж, сурагчид хариулна. Сурагчдаар аль болох бүтэн өгүүлбэрээр хариулт авахыг эрмэлзэх хэрэгтэй. Зургийг дарааллаар нь байрлуулна. Ярилцах асуултын жишээ: - Хэдэн зураг байна вэ? - Хүүд ямар явдал тохиолдов? - Яагаад энэ зургийг эхнийх гэж бодов? - Дараа нь юу болсон бэ? Эх зохиож бичихийг дараах үйл ажиллагаагаар удирдана. 1. Юу бичихээ бодох, санаагаа зурах, бичих 2. Яаж бичихээ төлөвлөх 3. Санаагаа цаасан дээр буулган бичиж, ноороглох 4. Бичсэнээ бусдад уншиж, зөвөлгөөг нь сонсох 5. Бусдын санааг тусган дахин бичих 6. Алдааг шалгах, сайжруулах 7. Дахин сийрүүлж бичих.	- Үйл явдал бүхий цуврал зураг ашиглах

Эх, өгүүлбэрийг дэгийн дагуу бичих. Зургаан настай хүүхдийн хурууны жижиг булчингийн хөгжил маш сул байдаг тул их бичих, хичээнгүй гоё бичихийг шаардах нь хүүхдэд бэрхшээл үүсгэдэг. Харин цагаан толгойн бэлтгэл үеэс зураг зурж будах, товч товчлох, гутал үдэх, шүр хэлхэх зэргээр энэ булчинг хөгжүүлэх дасгал хийх нь сайн бичиж сурахад ихээхэн нөлөөтэй. Хүүхэд бүрийн бичих хурд, үсгийн холбоос, үг хоорондын зай, том жижиг үсгийн харьцаа, хэмжээ, хичээнгүй, сайхан бичиж байгаа эсэхийг багш ажиглаж, туслах хэрэгтэй. Үүний тулд дараах аргаас хэрэглэж үзээрэй.

1. **Тодруулан бичих арга:** Багш сурагчийн дэвтэрт үсэг, үг, өгүүлбэрийг балын харандаагаар бичиж, дээгүүр нь дагуулан бичүүлж болно. Зарим багш нар тусгайлан бичсэн бичвэр дээр калькан цаас тавьж, мөн тодруулан бичүүлдэг туршлага байдаг.
2. **Дуурайн бичих:** Үлгэр жишээ бичлэг харан дуурайж бичүүлдэг.

3. Төрөлжүүлэн бүлэглэх арга: Үсгийн зурлагын ижил төстэй байдлаар төрөлжүүлж хөнгөнөөс хүндрүүлэх замаар ялган хуваагаад бичиг сайжруулах дасгал хийлгэх арга юм.

4. Баримжаалан бичих арга: Дэвтэрт бичүүлэхийн өмнө агаарт бичих хөдөлгөөн хийлгэсний эцэст бичүүлнэ гэсэн үг.

Цэвэр, нямбай бичих үйлийг удирдахдаа сурагчдад зөв суух, дэвтрээ зөв байрлуулах, үзгээ зөв барьж бичих дадал эзэмшүүлэхэд байнга анхаарах хэрэгтэй. Үг, өгүүлбэрийг бичихэд үсгийн холбоосыг зөв бичиж сургахад анхаарна. Ялангуяа, эгшгийн дараа “л” үсгийг бичихдээ дараагийн үсэгт шууд залгахгүй, тусгайлан эхлэлтэй бичдэгийг онцгой анхаарах хэрэгтэй.

Зөв бичүүлж сургах. Сурагчдыг зөв бичиж сургахад тэдний сонсох ба харах эрхтэн, гар хурууны зөв хөдөлгөөн, зөв суулт зэрэг нь чухал ач холбогдолтой. Буруу ойлгосон, эсвэл буруу бичиж сурсных нь дараа засах нь шинээр заахаас хэд дахин илүү төвөгтэй хэцүү байдаг.

Өгүүлбэр зохиож сургах. Зураг харуулж, асуултын дагуу өгүүлбэр зохиолгож сургана. Жишээ нь: Энэ юу вэ? Нохой яадаг вэ? гэх мэтээр асууж эхлээд хоёр үгтэй, дараа нь 3-4 үгтэй өгүүлбэр зохиолж хэлүүлнэ.

- Өгүүлбэрт дутуу үгийг нөхөж бичих
- Өгүүлбэр дэлгэрүүлж бичих
- Асуултад хариулт бичих
- Өгсөн үгсээр өгүүлбэр зохиож бичих
- Үгэнд тохирох залгавар залгаж, өгүүлбэр бичих

Багшийн самбарт бичсэн үг, өгүүлбэрийг уншиж, хэдэн үг байгаа, үгс нь ямар ямар үеэс бүтсэн, хэдэн үсэгтэй үгс байгаа талаар ярилцан бичлэгийг ажиглана. Хэрэв өгүүлбэр бол эхлэл төгсгөлийг бас анхааруулна. Сурагчдад хэсэг хугацаанд ажиглах даалгавар өгсөний дараа бичсэнээ арилгах, эсвэл цаасаар дээрээс нь дараад уг өгүүлбэр, үгийг хэлж өгч бичүүлнэ. Ийм цээж авиа, үсэг таниулах үеэс хийж болох бөгөөд эхний үед зөвхөн эгшгээс бүтсэн үг бичүүлэх бол гийгүүлэгч авиа, үсэг таниулахаас эхлэн задгай үе, нэг үетэй үгээс эхлэн сурагчдын сайн мэдэх, богино цөөн үгээс бүтсэн өгүүлбэр бичүүлэх нь тохиромжтой.

Өгүүлбэрийг томоор бичих. Нэгдүгээр ангид цагаан толгойн бэлтгэл үеэс эхлэн сурагчид өгүүлбэр үгээс бүтдэгийг мэддэг болсон байгаа. Улмаар сурагчид зураг хараад өгүүлбэр зохион хэлэх, хялбар бүтэцтэй өгүүлбэр зохион бичих чадвар эзэмшсэн байгаа. Хамгийн гол чадвар бол өгүүлбэр дэх үгс хоорондоо холбоотойг мэдэж, асуултаар энэ холбоог олж сургана. Гэхдээ энэ ажил нэг удаа хийгээд сурах чадвар биш тул өдөр тутмын хичээл дээр байнга хийж байх шаардлагатай. Харин өгүүлбэрийг томоор бичүүлж сургах нь харьцангуй хялбар. Гэхдээ өгүүлбэр мөн биш эсэхийг таньж сургахын тул эхийг дараах байдлаар өгч, өгүүлбэрээр зааглан том үсэг ба цэг, асуултын тэмдэг нөхөж бичүүлэх даалгавар өгч болно. Жишээ нь: “өвөл болов зузаан цас орлоо. хүүхдүүд цасаар өвгөн хийлээ.” Үүнийг “Өвөл болов. Зузаан цас орлоо. Хүүхдүүд цасаар өвгөн хийлээ.” гэж бичүүлнэ гэсэн үг. Харахад хялбар мэт боловч өгүүлбэр дэх үгсийн холбоо, утга санаа төгс болж байгаа эсэхийг мэдэх шаардлагатай гэсэн үг болно.

Нэгдүгээр ангийн сурагчид заавал төгс сайн эх зохиож чадахгүй ч санаагаа 3-4 өгүүлбэрээр илэрхийлэн бичих арга барил эзэмшсэн байх нь чухал. Гэхдээ нэгдүгээр ангид энэ бүхэнд төгс сургахыг зорихгүй ч зохион бичих аргын зарим ангийн үйлдэлд сургах хэрэгтэй.

Энэ хэсэгт дараах хоёр алхмыг багтаан үзэв. Эх зохиож бичих сэдвийг сонгох, бичих зүйлээ төлөвлөх үйлийг багш удирдахдаа:

Бичихийн өмнө загварт эхтэй танилцаж, хэрхэн бичих талаар дадлага хийх. Тэд тухайн загвар бичлэгийн захын тэмдэглэгээ болон бүтэц, илэрхийлсэн байдал зэргийг тодорхойлж, энэ нь тэд дуурайн бичихэд нь хэрэгтэй.

Жишээ нь: Багш эхлээд хүн бүрийг өөрт тохиолдсон явдлаасаа бодож байгаад нэг зураг зурах даалгавар өгнө. Сурагчдыг зурж будах хангалттай хугацаа өгнө. Сурагчдыг зурж дууссаны дараа “Одоо зургаа сайн ажиглаад орхисон зүйл байвал нэмж зурахыг анхааруулна. Багш сурагчдад заавал ижилхэн сэдвээр зурахыг шаардахгүй байх нь зохистой. Хүүхэд бүр өөрийн хүсэл, мэдрэмж, төсөөллөөр зураг зурах боломжийг олгох хэрэгтэй.

Төлөвлөлт хийх. Багш зохиож бичих янз бүрийн бичих төлөвлөлтийн хэд хэдэн загвар үзүүлнэ. Жишээ нь: оюуны зураглал, гарчиг- төлөвлөгөө зохиох, толгой өгүүлбэр, оюуны шуурга болон өөр өөр хэв маягаар бичихэд төлөвлөлт хийх ялгаатай саналыг зөвлөмжилнө. Жишээ нь: Хэрэв тоочимж хэв маягаар бичих бол хоёр багана үүсгэж, бичих зүйлийн эсрэг шинж буюу тухайлбал, өөрт нь эерэг, сайхан мэдрэмж төрүүлж байгаа шинжийг нэг талд, сөрөг мэдрэмж төрүүлж байгаа шинжийг нөгөө талд нь бичүүлж болно.

(шинжийг шүүмж ба үр дүн) Харин хүүрнэмж бичих бол цаг хугацааны дараалал буюу бүтцийн бүдүүвч гаргах гэх мэт. (Багш сурагчдын гүйцэтгэлд хяналт тавьж, ялгаатай дэмжлэг үзүүлнэ.

Сурагчдыг хосоор ажиллуулж, хийсэн төлөвлөлтөө харилцан үзэж, сайжруулах үйлийг удирдана. Энэ ажлын хүрээнд сурагчдад төлөвлөлтийг сайжруулах санааг нэмэх, уялдаа холбоотой хэсгийг сумаар зурах, тоогоор тэмдэглэх, нэг эгнээнд оруулах зэргээр тохирох хэлбэрээр тэмдэглэлж бичих дарааллыг тогтооход сургана. (Багш сурагчдын гүйцэтгэлд хяналт тавьж, ялгаатай дэмжлэг үзүүлнэ.

Багш нь эхлэн бичих үед өмнө хийсэн төлөвлөлтийг хэрхэн ашиглахыг тайлбарлана. Тухайлбал, санааг хөгжүүлэх, дэмжлэг болох хэсгийг нэмэх, үргэлжлүүлэх бичих, догол мөр хэрэглэх, догол мөрүүдийг холбох, эхлэл ба төгсгөлийг үр дүнтэй холбох гэх мэт. Сурагчид бичихэд ашиглах схем тэмдэглэгээ болон ноороглон бичих үед амжилтын шалгуур, шалгах хуудас зэргийг урьдчилан мэдсэн байх нь чухал тул ангийн хана, самбарт томоор бичиж байрлуулсан байвал зохино. Жишээ нь: үг, өгүүлбэр, нөхцөлийг хасах бол

Эдгээрийг нэмэх бол

Эдгээрийг сольж, өөрчлөх бол гэсэн тэмдэглэгээ хийж сургана.

Сурагчдын хамтын ажиллагаанд сургасан үйл ажиллагааг багш зохион байгуулах хэрэгтэй. Хүүхэд бүр өөрийн бичсэнийг бусад нөхдөдөө унших боломж олгож, харин багш яаран дүгнэлт гаргахын оронд сурагчдын санал бодлыг сонсож, түүнд хариулт өгч сургах дараах үйлээр удирдаж болно.

1. Бусад хүүхдийн зохиож бичсэнээ уншихыг сонсох
2. Санал хэлэх, асуулт асуух
3. Зохиогчийн асуултад хариулах
4. Хувь хүний болон бүлгийн саналд хүндэтгэлтэй хандах

Сурагчдын гаргасан төлөвлөгөөг үндэслэн эхний удаад ноороглон бичүүлсний дараа сайжруулах боломж олгоно. Хүүхдүүд эхийн бүтцэд сонгосон үг бүр, найруулж бичсэн өгүүлбэр бүр чухал үүрэгтэй ойлгох хэрэгтэй. Сурагчдаар эхний ноорогт бичсэн үгийн тоог гаргана.

Эхийг эхний удаа ноороглон бичих Тухайлбал, сурагчид тухайн загвар эхийг ажигласны дараа өөрсдөө “дуурайн” эх зохиож ноороглон бичих. Энэ нь эцэслэн бичиж, багшид үзүүлэхээс өмнө өөрчлөлт хийх боломжтой, сайжруулах үе шат буюу сурагчдын бичлэгийн эхний төсөл.

Жишээ нь: Нэг сурагчийн бичсэн бичлэгийн нэг ижил хэсгийг үлгэр жишээ болгон бүх сурагчид тарааж өгсөн байна. Сурагчид тэрхүү бичлэгийг бүх боломжтой хувилбараар засаж сайжруулах дадлага хийж, санал болгосон өөрчлөлтийг хэлэлцэх

Эх зохиож ноороглон бичих үйлийг багш удирдахдаа:

1. Сурагчдын бичих явцад асуусан үгийг нь самбарт бичиж, үгийн нөөцийг бичиж өгч болно. Үүнийгээ “Үгийн нөөц” гэж нэрлэж болно.
2. Сурагчдыг бичиж дууссаны дараа сурагчдыг хос хосоор нь баг болгож, бичсэнээ бие биедээ унших боломж олгоно.
3. Дараа нь зураг ба бичсэн эхийг харьцуулан үзэж, хэн нэг нь зурагт байгаа зүйл эхэд дутуу байх зэргээр тодруулах, нэмж бичих боломж олгоно. Энэ нь сурагчид хоорондоо ярилцах, бие биеэсээ суралцах, хамтран ажиллах, нэг нэгийнхээ санааг дэмжих үйлийн бодит орчин болно.

Сурагчдад зургаасаа сэдэвлэн эх зохиож бичих даалгавар өгнө. Сурагчдын зохиох эх нь 2-3 өгүүлбэрээс бүтсэн байхад болно. Сурагчдыг бичих үед бүх үгийг заавал зөв бичихийг шаардах хэрэггүй, хамгийн гол нь санаагаа гаргаж бичих, утгын холбоотой өгүүлбэр зохион бичүүлэхэд чиглэнэ.

ГУРАВ. СОНСОХ - ЯРИХ ЧАДВАР

Энэ үед сурагчдын авианы дуудлага засах үйл ажиллагаа явуулж болно. Мөн санаа бодлоо оновчтой илэрхийлэн ярих, бусдын яриаг сонсох арга техникт сургах явдал чухал юм. Үүний тулд бүлэг хэсгээр ажиллуулах, дүрд тоглуулахын зэрэгцээ өөрийн хийсэн бүтээлийн тухай анги нийтийн өмнө зогсож ярих, “илтгэл тавих” зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах хэрэгтэй.

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1.3а. Өгсөн зургийг ажиглаж үйл явдлыг тод, чанга, ойлгомжтой ярих	- Өгсөн зургаас үйл явдлын дарааллыг тодорхойлох - Зургаас ажигласан үйл явдлаа хэн нэгэнд тод, чанга, ойлгомжтой ярьж өгөх - Бусдын ярьсныг нь сонсож санаагаа болон үйл хөдлөлийг баяжуулах	- Үйл явдалтай зураг
1.3б. Бусдын яриа, асуулт, зааврыг анхааралтай сонсож, ойлгосноо харуулах 1.3в. Үлгэр, хүүхэлдэйн киноны баатрын үг хэл, үйл хөдлөлийг дуурайж тоглох	<i>Бусдын яриаг анхааралтай сонсож, оновчтой хариулах</i> - Сэдвийн холбоотой асуултад хариулах - Үлгэр, богино өгүүллэгийн утгыг ойлгож сонсох - Асуултын дагуу ярих, ярилцах - Ойлгосноо найз нөхдөдөө ярих - Найз, нөхдөөсөө асуух асуулт бэлтгэх - Найз нөхдийнхөө хариултыг сонсох <i>Тод, чанга, ойлгомжтой ярих дасгал хийх</i> - Багшийн удирдлагын дор харилцан ярианд идэвхтэй оролцох - Ардын аман зохиол, уран зохиолоос оновчтой үг хэллэгийг дуурайж ярих - Цээжилж тогтоосон шүлгийг тод уншиж сурах - Зурагт дүрслэгдсэн зүйлийг нэрлэх, үйл явдлыг дарааллаар нь ярих <i>Харсан сонссоноо тогтоох, тэмдэглэх, ярих</i> - Болсон явдлыг бусдын асуулт, дэмжлэгтэйгээр мэдээлэн ярих, учир шалтгааныг өөрийн хэмжээнд тайлбарлах - Үзсэн үзвэр, оролцсон үйл ажиллагааны талаар эргэн бодох, зурж, бичих зэргээр тэмдэглэл хийх - Сурагчдын өмнө зогсож байгаад тэмдэглэлээ харан ярих <i>Юунд дуртайгаа үндэслэлтэй хэлэх</i> - Үзсэн кино, уншсан ном, сонссон зүйлээс сурч мэдсэн зүйлийг ярихдаа эх сурвалжийг хэлж сурах. Жишээ нь: Би аавын уншиж өгсөн “Норовын намтар”-аас хичээлийн хэрэглэлээ гамтай хэрэглэхгүй бол ном дэвтэр, үзэг, харандаа, баллуур, цүнх нь гомддог гэдгийг мэдсэн гэх мэт. - <i>Болсон явдал, уншсан ном, сонссон, үзэж харсан зүйлээс төрсөн сэтгэгдлээ тодорхой жишээгээр хэлэх.</i> Жишээ нь: Би ээжтэйгээ хамт “Алтан загасны үлгэр” уншсан. Ээж бид хоёр ээлжлэн уншсан. Би алтан загасны үгийг уншсан. Загас их хөөрхөн, тусч амьтан гэдгийг мэдсэн. Харин шуналтай эмгэнд дургүй их хүрсэн. Хэрэв ... гэх зэргээр өөрийн болгож тодорхой ярих <i>Ээлж дараагаар ярих</i> - Жижиг бүлгээр ажиллахдаа, ээлж дараагаар ярих дүрмийг баримтлан ажиллах - Бусдын яриаг таслахгүй сонсох, сонсох үедээ анхаарал татсан зүйлийг товч тэмдэглэх	- Сонсох үлгэр богино өгүүллэг
Багшийн анхаарах зүйл: Багш хүүхдийн үгийн нөөцийг нэмэгдүүлэхэд анхаарахын зэрэгцээ дараах асуудлыг анхаарлаасаа гаргаж болохгүй. Тухайлбал: • Ярихдаа үгийг үндсэн утгаар нь зөв хэрэглэж байгаа эсэх (Надад цүнх бий гэх мэт) • Зарим үгийн утгыг тайлбарлах (цүнх- хичээлийн хэрэглэл хийдэг сав гэх мэт)		

- Ярихдаа идэвхтэй хэрэглэгддэг эсрэг утгатай үгийг зөв хэрэглэх (Тэнгэр бүрхэг / цэлмэг байна гэх мэт)
- Бусадтай ярилцах, танилцах, уучлал гуйх, талархах, асуулт асуух, хариулахдаа бүтэн өгүүлбэр хэрэглэж сурах
- Зөв бүтэцтэй өгүүлбэр хэрэглэх

Үгийг зөв дуудах. Хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх нэг чиглэл бол монгол утга зохиолын хэлний хэм хэмжээг эзэмшүүлэхэд оршино. Ийм учраас уншуулж бичүүлж сургах үеэс хэлний авиаг зөв дуудах, авиан зөв тавилтын дасгал хийлгэх хэрэгтэй. Тухайлбал, түргэн хэллэг, дайралцаан, амьсгал уртасгах хэллэг, жороо үг гэх мэт үгэн тоглоомоор тоглох нь хэлний авиаг зөв цэвэр хэлж сурахад тустай.

“Хэл зүгшрүүлэх үг” буюу түргэн хэллэг нь хэлд орж буй үеэс нь эхлээд хүүхдийг зөв цэвэр дууддаг, ярьдаг болгоход зориулагдсан, бага насны хүүхдийн хэлэхэд төвөгтэй, барагтай л бол сольж хэлчих гээд байдаг “р”, “л”, эхнээс нь зөв дуудуулж сургахгүй бол бөөрөнхий хэлтэй болчихож болзошгүй “б”, “м” зэрэг уруулын авиаг хэлж сургахад зориулагдан зохиогдсон байна. Гэхдээ түргэн хэллэгийг хүүхдээр хэлүүлэх дүрэм журам бас байна. Энэ нь эхлээд “Хүрэл илүүр”, “болор соруул” гэх мэт цөөн (хоёр) үгийг тус тусад нь хэлүүлж, түүнийгээ олон дахин давтуулж сургасны дараа “хүрэл илүүр, болор соруул” гэж дахин хоёр үг нэмэх, улмаар

“Орсон бороонд
Норсон бор морь
Олмоороо олойртоно”

гэх мэтээр гэх зэргээр хүүхдийн насны байдалд тохируулан өсөх хэрээр нь үгийн тоог нь нэмж хэлүүлдэг байна. Ийм түргэн хэллэг хэлж сургахын өмнө танил биш үгийн утгыг мэдүүлэхэд анхаарч үзүүлэн таниулах ашиглах хэрэгтэй. Орчин үеийн хот, хөдөөгийн хүүхдийн аль нь ч “илүүр”, “соруул”-ыг нэг их сайн мэдэхгүй. Учир нь эдгээр зүйл хэрэглээнээс бараг гарсан байна. Хотын хүүхдүүд “олом” гэдгийг сайн мэдэхгүй бол хөдөөгийн хүүхдэд танил үг байна.

Зөв ярихад зөвхөн авиа, үгийг зөв цэвэр дуудахаас гадна үг бүрийг зөв, тод хэлж, амьсгалаа зөв хуваарилан түгдрэлгүй ярих шаардлагатай.

Ийнхүү түгдрэлгүй ярьж сурахад амьсгал уртасгах хэллэг чухал бөгөөд “Сайн эрийн гучин хоёр цагаан лонх”, “Хорин таван хул”, “Есөн мөнгөн бумба” тоолох гэх зэрэг тоглоом наадам байдаг байна.

Дэн дэн хул	Дон дон хул
Дэрсэн хул	Тосон хул
Ян ян хул	Бөн бөн хул
Ясан хул	Бөөрөнхий хул

Түргэн хэллэг нь үгийг зөв дуудуулах, амьсгаа задлах үгэнд өгүүлбэрийг зөв сайхан ярих зорилготой бол жороо үг нь шүлэг зохиох, үгсийг тодорхой айзам хэмжээнд багтаан журамлан хэлүүлж сургадаг. Жишээлбэл:

Хааны хар морь

Морины мухар тэрэг

Тэрэгний тэр болдог

Болдгийн бор начин

Начны найман төлөг

Төлгийн төвгөр уул

Уулын ахар чулуу

Чулууны шонхор хээр . . .

гэх зэргээр өмнөх мөрийн эцсийн үгийг дараа мөрийн эхэнд хэлүүлээд гурван өргөлт буюу үгийг нэг мөрд багтаан айзам тааруулан зохиох “зөхээс маягийн шүлэг” юм. Харин ихэнх тохиолдолд утгыг харгалзадгүй бололтой.¹

Дайралцаан бол хүүхдүүд хоорондоо хурдан сэтгэх чадвар, шүлэглэх авьяасаа сорилцон цэц булаалдахад зориулагдсан уран хошин харилцаа шүлэг юм. Дайралцаан нь хүүхдүүдийн дунд харилцан шүлэг хэлж мэтгэлцдэг тоглоом наадмын чанартай учраас драмын элемент бүхий жүжгийн хэлбэртэй юм. Дайралцаан нэгэнт хоёр хүүхдийн хоорондын уран үг, сэтгэх чадварын өрсөлдөөн болдог байна. Жишээ нь:

-Зээ хүү минь тийм үү дээ

Дайралцвал дайралцъя

Даалин хутгаа тавилцъя

Хэлэлцвэл хэлэлцье

Хэт хутгаа тавилцъя.

¹ Д.Оюунбадрах

-Зээ хүү минь тийм үү дээ
Зурман тааны нүхэнд нь
Зургаан салаа байна уу даа
Зулзган чиний цээжинд нь
Зургаан шүлэг байна уу даа
Алаг дааганы нүхэнд нь
Арван салаа байна уу даа
Аанаа чиний цээжинд нь
Арван шүлэг байна уу даа

-Зээ хүү минь тийм үү дээ
Арван тавны сарыг
Ар дээр гартал хэлэлцье.
Адуу үхэр хоёрыг
Бэлчээрт гартал хэлэлцье.
Хорин тавны сарыг
Хойд дээр гартал хэлэлцье
Хонь ямаа хоёрыг
Бэлчээрт гартал хэлэлцье

гэх зэргээр нөгөөгийнхөө урнаар шүлэглэх чадварыг сорин хэлэхэд нөгөө нь хариуд нь түүнийг няцаан шүлэглэдэг.

Зарим авиаг хүүхдүүд сайн хэлж чадахгүй бол малъ амьтан, эд юмс, үзэгдлийн гаргадаг дуу чимээг дуурайж хэлэх сургах тоглоом тоглуулж болно. Жишээ нь:

Хувилбар 1: Сурагчдыг хэдэн хэсэг болгон, бүрээ, морин хуур, бөмбөр, цан зэрэг хөгжмийн зургийг нэг нэгээр өгнө. Багшийн дохиогоор багууд ээлжлэн тус тусын хөгжмийг дуурайн дуугарна. Бүрээ- бүү, бүү, морин хуур- дүү, дүү, бөмбөр- түн түн, цанцин цин гэх мэтээр хамтарч хэлнэ. Энэ нь хүүхдийн авианы дуудлагыг сайжруулахад тустай.

Хувилбар 2: Сурагчдыг хэдэн хэсэг болгон, мэлхий, нохой, муур, хулгана зэрэг амьтдын зураг өгнө. Багшийн дохиогоор багууд ээлжлэн тус тусын багт оногдсон амьтныг дуурайн дуугарна. Мэлхий вааг вааг, нохой- хөв хөв, арр арр, муур- мяу,мяу, хулгана- жив, сурагчдыг баг бо жив жив гэх мэтээр хамтарч хэлнэ. Энэ нь хүүхдийн авианы дуудлагыг сайжруулахад тустай.

Сурагчдын дунд зарим авиаг сайн хэлж чаддаггүй хүүхдийг зориудаар тухайн багт оруулах хэрэгтэй. Жишээ нь: “р” авиаг буруу хэлдэг сурагчийг “арр, арр” гэж архирах нохой болох багт оруулна гэсэн үг. Гэхдээ үүнийг тоглоом тоглож байгаа байдлаар зохион байгуулах хэрэгтэй.

Тод, чанга, ойлгомжтой ярих. Хүүхдийн хэл яриа нь зөв, ойлгомжтой байвал зохино. Зөв байна гэдэг нь хүүхэд орчин тойрноо зөв ухаарч, мэдэрч сонирхсон, ажигласан, мөрөөдсөнөө яриандаа илэрхийлэхийг хэлнэ. Хэл сэтгэхүй хоёр салшгүй холбоотой байдаг болохоор хүүхэд сайн мэдэх амьдрал, үзсэн харсан зүйл, тоглоом зэрэг бодит үзэгдэл, юмсыг мэдэж байгаа хэмжээгээр л үгийн баялаг нь нэмэгдэж байдаг.

Ийм учраас багш нар хүүхдийн хэл ярианы чадварыг хөгжүүлэх бүтээлч арга зүйгээс суралцаж өөрсдийн туршлагаа баяжуулах хэрэгтэй.

Зөв бүтэцтэй өгүүлбэрээр ярих. Хэлний зүйн дүрмийг хүүхдүүд сургуульд сурдаг бөгөөд хэлд орсон цагаасаа орчноосоо хэл зүйн хувьд алдаагүй ярих дадлага эзэмшиж байдаг. Гэхдээ сургуульд орохдоо энэ чадвар төдийлэн хангалттай биш байдаг. Нэртэй сурган хүмүүжүүлэгчид хүүхдийг аль болох зөв ярианд сургахыг онцлон тэмдэглэсэн байдаг. Багш, эцэг эхчүүд хүүхдийн ярианд гарч байгаа алдааг бага гэхгүй тухай бүр засаж өгч байх хэрэгтэй. Жишээ нь: хот суурин газрыг хүүхдүүд “ямааны хүүхэд, ааруул хийх”, тэмээ хашхирч байна” гэх мэтээр ярих нь бий.

Бусдын яриаг сонсож ойлгох, санаагаа тодорхой илэрхийлэхэд сургах. Мэдэж байгаа зүйл, үзэж харсан, сонсоноо хэрхэн ойлгож байгаагаа эрэмбэ дараатай ярьж сурах нь хүрээлэн байгаа орчноо хэр зэрэг зөв ухаарч байгааг мэдэх чухал хэрэглүүр болдог. Гэртээ юу хийсэн, ямар үйл явдал болсон тухай ангидаа, ангидаа юу сурсан тухайгаа эцэг эхдээ хүүхдүүд ярьдаг. Хүүхэд өдөр тутмын ярих үйл ажиллагааны явцад хэл ярианы чадвар эзэмшиж, үгийн нөөц нь нэмэгдэн баяжиж байдаг.

Хүүхдийг зөв ярианд сургах нь нэг өдөр хийгээд сургадаг ажил биш тул алгуур аажим хугацаанд дэс дараалан хийх шаардлага гардаг. Нэг удаагийн хичээл дээр бүх хүүхдийг багш яриулах боломжгүй тул багш цөөн хэдхэн ярих хүсэлтэй “идэвхтэй” хүүхдээр өдөр бүр яриулах биш, анги нийтийг хамарч хүүхэд бүрд ярих бололцоо олгох хэрэгтэй. Орчин үед энэ асуудлыг шийдэх нэг арга бол сурагчдыг баг хэсэг болгон ажиллуулах явдал бөгөөд харин багш тухайн өдөр хэн хэний яриаг голлон анхаарч ажиллахаа урьдчилан төлөвлөх хэрэгтэй. Хүүхэд бүрийн ярианы чадвар харилцан адилгүй байдаг тул энэ чадвар харьцангуй сул хөгжсөн хүүхдэд илүү анхаарал хандуулж ажиллах хэрэгтэй. Гэхдээ сайн ярьдаг сурагчийг бас орхиж болохгүй бөгөөд яриаг сайжруулах үйл ажиллагаа хийвэл зохино.

Ярианд сургахдаа хүүхдийн мэдлэг, туршлагыг сайн судалж асуултыг зөв, ойлгомжтой тавьж сурахаас их хамаарна.

Үүний тулд багш:

- Хүүхдүүд юуны тухай ярьж чадах вэ?

- Тэдний ярианы чадварыг хөгүүлэх ямар ямар арга байна вэ? гэдгийг сайн бодох хэрэгтэй. Ярианд сургах сэдвийг сонгохдоо хүүхдийн орчин, тухайлбал, гэр орон, сургууль, найз нөхдийн хүрээнд болсон явдал, тэдний сэтгэлд үлдсэн, сонирхлыг нь татсан асуудлыг судалж, ярилцах нь үр дүнтэй.

Үлгэр ярих нь хүүхдэд хамгийн сонирхолтой яриа байдаг. Ялангуяа үлгэрийн зураг нь зөв ярихад туслах гол хэрэгслэгдэхүүн болдог. Жишээ нь: том ном, бяцхан ном бэлтгэн уншуулж болно. Том ном нь хамтарч уншихад тохиромжтой хэрэгслэгдэхүүн бол бяцхан ном нь бие дааж уншихад тохиромжтой. Ийнхүү уншсан үлгэрээ зургийг нь харж ярихад аль болох үлгэрийн үг хэллэгээс ашиглахыг зөвлөөрэй.

Харилцан ярианы арга. Тодорхой асуултын дагуу нийт сурагчтай ярилцах хэлбэр. Энэ үед багшийн ярианы чадвар чухал бөгөөд багш хүүхдийг дэс дараатай, тодорхой зорилготой ярьж сургахад хүүхдийг жолоодохын зэрэгцээ харилцан ярианы үед хүүхэд анхаарлаа төвлөрүүлэх, бусдын яриаг анхааралтай бүрэн сонсож сурах, бусдадаа сонсогдохоор тод, чанга, өөртөө итгэлтэй ярьж сурахад туслах үүрэгтэй. Харилцан ярианы гол агуулга нь хүүхдийн амьдрал ахуйд ойр, хүмүүжил төлөвшилд эерэг нөлөө үзүүлэхээр байвал зохино. Харилцан ярианы үед багшийн асуулт маш чухал. Хүүхдэд асуулт маш оновчтой, тодорхой зорилготой байвал хүүхдээс оновчтой хариулт авч чадна.

ДӨРӨВ. ХЭЛ ЗҮЙ, ҮГИЙН САН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1.4а. Эгшиг ба гийгүүлэгч, тэмдэг үсгийг ялган таних	Цагаан толгойн үсгийг дарааллаар нь цээжлэн тогтоох дасгал, тоглоомыг дараахаас сонгон тоглуулж болно. Үүнд: 1. Цагаан толгойн үсгийг дарааллаар нь цээжээр хэлэх 2. Цагаан толгойн үсгийг эмх замбараагүй байрлуулж, дарааллаар нь зөв байрлуулах 3. Цагаан толгойн үсгээс заримыг нь орхин байрлуулж, дутуу үсгийг олж зөв байрлуулах 4. Сурагчид цагаан толгойн үсгийн дарааллаар жагсах (нэрийн эхний үсгээр) гэх мэт 5. Уншиж, бичихдээ эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсгийг ялган таньж, зөв хэрэглэх. Жишээ нь: “а” эгшиг, “м” гийгүүлэгч, урт “аа” гэх мэт.	- Цагаан толгойн үсэг бичсэн тарааж өгөх материал
1.4б. Эх, өгүүлбэр дэх үсгийг хэн? юу? яав? гэсэн асуултаар ялгах	Өгүүлбэр уншиж, өгүүлбэрээс хэн? юу? яав? гэсэн асуултад хариулагдах таньж олох дасгалыг дараах алхмаар гүйцэтгүүлнэ. 1. Эхлээд өгүүлбэрээс зөвхөн хүнийг нэрлэсэн үгийг олж асуулт тавиулна. Жишээ нь: - Хэн манжин тарьсан бэ? - Өвгөн хэнийг дуудсан бэ? - Эмгэн хэнийг дуудсан бэ? 2. Дараа нь амьтныг нэрлэсэн үгийг олж, асуулт тавиулна. - Охин юуг дуудсан бэ? - Нохой юуг дуудсан бэ? 3. Өгүүлбэрээс юмыг нэрлэсэн үгийг олж асуулт тавиулна. - Өвгөн юу (г) тарьсан бэ? - Юу маш сайхан ургасан бэ? - Тэнгэрт юу мандсан бэ?	

	4. Өгүүлбэрээс үйл хөдлөл нэрлэсэн үгийг олж асуулт тавиулна. - Өвгөн яасан бэ? - Эмгэн яасан бэ? - Охин яасан бэ?	
1.4в. Өгүүлбэрийг 1-2 асуултаар дэлгэрүүлэх	- Өгүүлбэр дэх үгсийг хэн? юу? яав? гэсэн асуултаар бүлэглэх - Өгүүлбэрт хэн? юу? яав? гэсэн асуултад хариулагдах үгсийг нөхөж бичих - Өгүүлбэрийг хаана? хэзээ? гэсэн асуултаар дэлгэрүүлэх - Асуултад тохирох үгийг хэд хэдэн үгийн дундаас сонгох	- Асуултад тохирох үгийг нөхөж бичих тарааж өгөх материал
1.4г. Өгүүлбэрт цэг, таслал, асуултын тэмдгийг зөв хэрэглэх	- Уншсан өгүүлбэрээс хаана?, хэзээ? гэсэн асуултад хариулагдах үгсийг түүж бүлэглэх - Хэн? хаана? яав? хэн? хэзээ? яав? - гэх мэт асуултын бүтцээр өгүүлбэр зохиох, өгүүлбэр дэх үгэнд асуулт тавих - Өгүүлбэрийг асуултад хариулагдах үгсээр дэлгэрүүлэн бичих	- Өгсөн бүтцийн дагуу өгүүлбэр зохиох загвар үзүүлэн

Багшийн анхаарах зүйл:

Үгсийн аймгийн тухай ойголтыг асуултын тусламжтайгаар эхэлж ойлгуулна. Хэн?, юу?, яав? гэсэн асуултаар дамжуулан жинхэнэ нэр, үйл үгийн тухай олголт өгнө. Гэхдээ жинхэнэ нэр, үйл үг гэсэн нэр томъёо хэрэглэхгүй. Харин үйлийг хэн хийсэн?, Дорж ямар үйл хийсэн бэ? гэх мэт асуултаар ойлгуулна.

Юу?	Ямар?	Яасан бэ?
зараа	өргөст зараа	Өргөст зараа явж байна.
цох	эрээн цох	Эрээн цох модонд авирлаа.
үнэг	зальт үнэг	
тоншуул	алаг тоншуул	
нугас		
.....		

Өгүүлбэр дэх үгийн холбоо болон өгүүлбэрийг асуултаар дэлгэрүүлэх нэг дасгалыг үлгэрлэн үзүүлж байна. Эхлээд зараа, цох юу? гэсэн асуултад хариулагдах хоёр үгийг хэрхэн дэлгэрүүлэх асуулт тавьж, өгүүлбэр болгосныг ажиглуулна. Дараа нь үнэг, тоншуул гэсэн холбоо үгээр өгүүлбэр зохиож, дараа нь нугас гэсэн үгийг холбоо үг ба өгүүлбэрт оруулна. Эцэст нь сурагчид өөрсдөө үг олж энэ маягаар дэлгэрүүлнэ. Зургаан настай хүүхдийн хувьд хийсвэр утгатай үг, үгийн шилжсэн утга, хэлц үгийн утгыг бүрэн ухаарч утгатай ойлгох хэмжээнд хүрээгүй байдаг. Учир нь юмс үзэгдлийн гадаад шинжийг анзаарч, дотоод далд шинж, шалтгаан үр дагаврын холбоог таних логик сэтгэлгээ сул хөгжсөн байдаг. Ийм учраас “Соёмбо бол монголын ард түмний бэлгэдэл мөн”, “Шүүдрийн усыг түүж, ээждээ аяга цай чанаж өгвөл ээжийнхээ ачийг хариулдаг”, “Хүнд яах гэж нэг ам, хоёр чих заяадаг вэ? гэх үг хэллэг, өгүүлбэрийн утгыг төдийлэн ойлгохгүй. Нэгдүгээр ангийн сурагчид үгийг үндсэн утгаар нь сайн мэдэх боловч шилжсэн болон далд утгыг төдийлэн мэддэггүй, түүнийг ухаарах нас нь ч болоогүй байдаг тул хэлцийг багш яриа болон уншлагад нэг их хэрэглэх шаардлагагүй. Харин багш эдгээрийг цээжлэх даалгавар өгвөл цаад утгыг нь сайн ойлгоогүй байж цээжилж тогтоосон байдаг.

ХОЁРДУГААР АНГИ

Танилцуулга

Энэхүү суралцахуйн удирдамж нь хоёрдугаар ангийн монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөлт юм. Унших, бичих, сонсох-ярих чадварын хүрээнд сурагчдын эзэмших чадвар буюу суралцахуйн зорилтуудыг заах хичээлийн дагуу үлгэрчилсэн байдлаар эрэмбэлэн байрлуулсан бөгөөд багш тухайн орон нутаг, сургууль, ангийн сурагчдын онцлогт тохируулан суралцахуйн зорилтуудын дарааллыг өөрчлөх боломж нээлттэй. Суралцахуйн зорилтдоо хүрэх аргачлалын хувилбарыг суралцах үйл ажиллагаа, хэрэглэгдэхүүн, багшид өгөх санамж хэсгүүдэд санал болгон зөвлөсөн болно.

НЭГ. УНШИХ ЧАДВАР

Унших чадварыг эзэмшүүлэхийн тулд уншихын чанар гэгддэг шаардлагуудыг харгалзахыг зөвлөж байна. Хоёрдугаар ангийн сурагчдын унших чадварт тавигдах шаардлага: унших хурдаа нэмж, бусдад ойлгогдохоор зөв, унших. Ямар ч төрлийн эхийг уншихдаа өөртөө уншиж, эхийн агуулгыг ойлгож байна уу? гэх зэргээр үнэлэхэд анхаарна.

Унших чадвар нь уншлагын дөрвөн чанар буюу зөв, хурдан, ойлгох, уран унших зорилгыг өөртөө агуулдаг.

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
2.1а. Танил биш үгийг сурах бичгийн тайлбараас цагаан толгойн үсгийн дарааллаар олж сонгох, утгыг мэдэх	Утга нь танил биш үгийн утгыг ойлгон уншихдаа: - Уншсан эхээс утгыг нь ойлгохгүй байгаа үгийг олж зурж тэмдэглэнэ. - Танил биш үгийн утгыг илэрхийлэхдээ эхийн хам бүтцээс холбон таамаглана. - Утгыг мэдэхгүй үгээ сурах бичгийн тайлбар толиос цагаан толгойн үсгийн дарааллаар олно. - Толь бичиг ашиглан тайлбарлахдаа аль утга нь илүү оновчтой байгаа, мөн өөр ямар үгээр илэрхийлж болох талаар санал бодлоо бусадтай хуваалцана. (өөрийн үгээр тайлбарлах) ярилцах - Бусдын тайлбарыг анхааралтай сонсоно. Бүтээлч үйл ажиллагаа - Шинээр мэдсэн үгээрээ өгүүлбэр зохион хэлэх, бичих - Зураг хараад өгүүлбэр зохиох Жишээлбэл: Аав <u>сур</u> элдэх үү? Ээж тохош оёно. сур-эмээлийн сур, бугуйлын сур сур-шир арьсыг урт зүсэж элдсэн нь гэх мэт. Морины хазаар, жолоог сураар хийдэг. Би өвөөдөө сур элдэхэд нь туслав. Сурыг бод малын арьс ширээр хийдэг. Бөхчүүд гутлаа сураар боосон байдаг. Бөхчүүд сур дэрлэж унтдаг.	- “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь” (Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, УБ., 2008) - “Монгол хэлний өвөрмөц хэлцийн толь” (Б. Уянга нарын УБ., 2011) гэх мэт төрөл бүрийн толь бичиг - “Монгол хэлний товч тайлбар толь” (Я.Цэвэл, УБ., 2013, 2 дугаар хэвлэл) - “Сурагчийн толь” 2018 он /бага ангийн сурагчдад зориулав/ - tsevel.toli.query.mn

Багшийн анхаарах зүйл:

Аливаа эхийг ойлгож унших суурь чадвар бол мэдэхгүй үгийн утгыг ойлгох түүнийгээ тайлбарлаж сурах явдал юм. Сурагч нэгдүгээр ангидаа мэдэхгүй үгээ таних чадвар суусан эсэх дээр багш анхаарч ажиллана. Хоёрдугаар ангид мэдэхгүй үгээ олж, тэмдэглэн түүнийгээ сурах бичгийн тайлбар толиос цагаан толгойн үсгийн дарааллаар олж чадаж байна уу гэдэг нь чухал.

Сурагчид үгийн утгыг өөрийн үгээр тайлбарлан ярьж, бичихдээ тухайн зүйлийг зөвхөн ухагдахуунаар ойлгон тайлбарлаж байна уу эсвэл хэлбэр, бүтэц, шинж чанар, эд зүйл, юунд хэрэглэдэг гэх мэтээр сэтгэхүй, сэрэл, хүртэхүйн нарийн үйлдэл хийж тайлбарлаж байна уу гэдэгт анхаарлаа хандуулан, үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлэхийг санал болгож байна. Зарим сурагчид үгийн утгыг зөвхөн ухагдахуунаар нь ойлгосон байдаг бол зарим сурагчид мөн чанараар нь ойлгож дэлгэрэнгүй тайлбарладаг. Иймд багш нар үгийн утгыг зөвхөн ухагдахуунаар нь ойлгон тайлбарлаж байгаа сурагчдын суралцахуйг дэмжин ажиллах хэрэгтэй. Хөдөө орон нутгийн хүүхдүүд буюу малд ойр өссөн тэдний хувьд сурьыг юугаар хийдэг, юунд хэрэглэдэг талаар мэдлэгтэй байдаг учир энэ үгийн утгыг тайлбарлахад хүндрэлтэй биш юм. Гэтэл хот буюу суурин газар өссөн хүүхдэд сур гэдэг үгийн утгыг тайлбарлахад бэрхшээл учирч болох юм. Мөн зарим сурагчдад гэрлэн дохио, цахилгаан шат, гэрлэн дохио гэх мэт үгийн утгыг нарийн тайлбарлахад хүндрэлтэй байж болох юм. Иймд хүүхэд нэг бүрт хүрч ажиллахын тулд тухайн сурагчдын өссөн орчин, орон нутгийн онцлог, түүх, соёлыг харгалзан үзэж, арга зүйгээ төлөвлөх шаардлагатай болох нь харагдаж байна.

Үгийн утгыг тайлбарлахад шинэ үгийн утгыг үзүүлэх (show), хэлж тайлбарлах (use language) гэсэн үндсэн хоёр арга байдаг.

• **Үзүүлэх (show)**

Үгийн сангийн жинхэнэ утгыг үзүүлэх (ostensive) арга Жишээлбэл: сур, ногт, бурантаг, чөдөр зэргийг шууд үзүүлэх

- Зургаар үзүүлэх (pictures) арга
- Тайлбарлах (use language)
- Ойролцоо утга (synonyms) –ыг ашиглах арга

Жишээлбэл: мэлмий-нүд, хоршоо-дэлгүүр, хөвөх- живэх

- Өгүүлбэрээр ойлгуулах (illustrate sentences) арга. Жишээлбэл: Аав сураар эмээлийн ганзага хийв.
- Үгэн тоглоомын (word game) арга. Жишээлбэл: Үгийн сүлжээ бөглөх, үгийн утгыг таах оньсого гэх мэт.
- Дуу чимээгээр таниулах (Audio presentation) арга. Янз бүрийн дуу, чимээний бичлэгийг ашиглаж болно. Жишээ нь: морь янцгаах, ямаа, хонь майлах, ингэ буйлах гэх мэт.

Дээрх аргуудыг тухайн нөхцөл байдалд тохируулан бүтээлчээр ашиглахыг санал болгож байна.

Хэдий чинээ сайн үгийн сантай байна, хэлийг төдий чинээ сайн эзэмших баялаг материалтай байна гэсэн үг. Хэлнээс үгийн санг хасвал цаана нь юу ч үлдэхгүй. Иймд хоёрдугаар ангийн сурагчдын үгийн баялгийг нэмэгдүүлэх, уламжлалт ёс заншил, соёлоос суралцахад үгийн утгыг тайлбарлах үйл чухал бөгөөд энэ нь монгол хэлний сургалтын чухал хэсэг болох нь харагдаж байна. Мөн багш өөрөө хичээл, сургалтын явцад хэлж байгаа үг бүрээ бодож боловруулж хэлэх, мөн өөрийн үгийн сангаа байнга арвижуулахын тулд санаачилгатай ажиллах хэрэгтэй.

2.16. Уншсан шүлэг, өгүүллэг, үлгэр, зүйр цэцэн үг, хэл зүгшрүүлэх үг зэрэг эхийг уншиж, агуулгыг ерөнхийд нь ойлгосноо харуулах	1. Шүлэг, өгүүллэг, үлгэрийг уншихдаа: - Уншсан эхээ ерөнхийд нь ойлгож уншина. - Эхээс утгыг нь ойлгохгүй үгийг ялган тэмдэглэнэ. - Мэдэхгүй үгээ толиос тайлбар хийнэ. - Юуны тухай уншсанаа өөрийн үгээр эргэн ярина. - Эхийн агуулгыг харуулсан зургийг үйл явдлын зөв дараалалд оруулна. - Эхээс юуг ойлгосноо бусдад өөрийн үгээр ойлгомжтой ярина. - Шүлгийн утгыг ойлгож, авиа үсгийг тод хэлж, хэмнэлтэй уншина. - Шүлгийн утгаас юуг ойлгосноо бусдад ойлгомжтой ярина. - Бусдын уншихыг анхааралтай сонсож асуулт асууна. - Бусдын яриаг сонсоод юу ойлгосноо хэлнэ. 2. Зүйр цэцэн үгийг уншихдаа: - Утгыг ойлгож, зөв тод уншина.	- Хүний сайн сайхан зан чанар, хүмүүжлийн болон монгол зан заншил ахуйтай холбоотой богино хэмжээтэй эх, өгүүллэг, үлгэр, шүлэг - Зүйр цэцэн үг, хэл зүгшрүүлэх үг, ертөнцийн гурав, - Байгаль, хүний үйл ажиллагаа, мал, амьтан, жигүүртний оньсого - Бие даан ажиллах даалгаврын сан - Ц.Дамдинсүрэнгийн “Цэцэн хурга” өгүүллэг
--	--	---

	- Утгыг ойлгосноо бусдад өөрийн үгээр тайлбарлана. 3. Хэл зүгшрүүлэх үгийг уншихдаа: - Авиа үсгийг зөв дуудаж, тод чанга хурдан хэлнэ. - “л, р” “с, ш” “д, т” “ц, ч” “з, ж” авиа үсгүүдийг зөв тод ялган хэлнэ.	
--	---	--

Багшийн анхаарах зүйл:

Ойлгох чадвар гэдэг нь эхийн агуулгыг бүтээлчээр уншиж ойлгох, ойлгосноо ухаарч хэрэглэх, хувиргах, бүтээлчээр эргэцүүлэх, дахин боловсруулах зэрэг үйлээр тодорхойлогдоно. Ойлгоцын 4 загварыг дараах хүснэгтээр харуулав.

Глобал ойлголт	Тайлбарласан ойлголт	Хувийн ойлголт	Бүтээлч ойлголт
Сэдэв агуулгыг ойлгоход бэлтгэж ерөнхийлөн ойлгох	Утга санааг хэлэлцэх, уялдаа холбоог илрүүлэх, санаа болон мэдээллийг бусад хамааралгүй зүйлтэй нэгтгэх	Өмнө олж авсан туршлага мэдлэгийн хүрээндээ шинэ мэдлэгийг оруулан холбож ойлгох	Агуулгаас хальж түүнийг задлан шинжлэх, хэрэглээ, үнэ цэн, ач холбогдол зэргийг тооцон авч үзэх

Үүнээс ойлгохын суурь чадвар нь ерөнхийлөн ойлгох гэж үзэж болно.²

Онъсого нь юмсын төстэй, эсвэл ялгаатай талыг ажиглан мэдсэний үндсэн дээр тухайн зүйлийн нэрийг нууцалсан шүлэглэсэн хэлбэртэй байдаг. Онъсого нь сурагчдын унших чадварыг дээшлүүлэхээс гадна эргэцүүлэн бодох болон оюун ухааныг хөгжүүлэх дасгал болдог байна. Онъсого таах дараалал: Хар морь

Ногоон ногттой (тэр юу вэ?)

Эхний алхам: Өнгө нь хар юм байна. Ногттой адил зүйл нь ногоон өнгөтэй юм байна.

Дөхүүлэх асуулт: Хүний өмсдөг хувцсанд хар өнгөтэй мөртлөө морьтой төстэй зүйл юу байж болох вэ? Онъсого таах үйлийн алхам нь төсөөлөх чадвартай салшгүй холбоотой учраас таахгүй тохиолдолд дөхүүлэх асуултаар чиглүүлэх хэрэгтэй.

Дараах онъсогог таагаад, хариуг үгийн сүлжээнд тохируулан бичээрэй.

Эр ганц хүү


Эрдэнийн зүйлээр бөөлжинө.

Тэр юу вэ?

Монгол газрын молтогчин

Модон дээгүүр дүүлэгчин.

Тэр юу вэ?



Ертөнцийн гурвыг цээжлүүлэхдээ эхлээд ертөнцийн гурвын үгүүдийг тус тусад нь өгөөд бүтээлгэх. Жишээлбэл:

явдал	хурдан.	Тэнгэрийн
салхитай	“Ертөнцийн гурав”	Саруул
үүл		Ухаантны
морины	санах	Сайн

Сурагчид ертөнцийн гурвыг шууд уншиж цээжилснээс бүтээгээд, дараа цээжлэх илүү үр дүнтэй байдаг.

“Эхийн агуулгыг ойлгох” чадварын хүрээнд эхийн агуулгыг ерөнхийд нь ойлгох гэсэн суралцахуйн зорилтыг дэвшүүлсэн байна. Энэ нь сурагчдын унших чадвартай холбоотой юм. Учир нь энэ ангийн сурагчдын хувьд түгдрэлгүй унших буюу шууд унших чадварт суралцаж байгаа үе учраас эхийн агуулгыг ерөнхийд нь дүрслэл талаас ойлгодог байна. Иймд хоёрдугаар ангийн сурагчдын уншаад ойлгох чадварыг нэмэгдүүлэхийн тулд хурдаа нэмж зөв унших, уншихдаа ойлгож унших чадварыг нэмэгдүүлэхэд багш болон эцэг, эхчүүд анхаарах хэрэгтэй. Түгдрэлгүй шууд унших гэдэг нь ярианы хурдтай ижил түвшинд уншихыг хэлж байна. Түгдрэлгүй шууд уншиж байгаа сурагчдын ойлгох чадвар нь илүү байдаг. Эхийн агуулгыг ерөнхийд нь ойлгох чадварыг илрүүлдэг нэг хэлбэр бол уншсанаа эргүүлэн ярих юм. Сайн ярьж байна гэдэг нь ойлгож ухаарсны үр дүн гэж эрдэмтэн, судлаачид тэмдэглэсэн байдаг.

² БСШУСЯ, ДБ, БХ. (2018). Бага боловсролын монгол хэлний сургалтын хөтөлбөр, сурах бичигт хийсэн шинжилгээний тайлан. Улаанбаатар.

Эхийн агуулгыг ойлгох чадвар нь тухайн сонгосон эхийг уншаад тогтоосноо эргүүлэн ярихаас эхэлнэ. Уншаад тогтоосноо эргүүлэн ярих нь энэ ангийн сурагчдын хувьд нилээд хүнд даалгавар гэдгийг багш, эцэг, эхчүүд хүлээн зөвшөөрч тэдэнд урам, зориг өгөх хэрэгтэй. Харин уншаад эргүүлэн ярих чадвар нь төлөвшсөн үед уншаад ойлгосноо эргүүлэн ярихын зэрэгцээ тунгаан бодох чадварыг хөгжүүлэх арга зүйг хэрэгжүүлэхэд анхааран ажиллах шаардлагатай.

Арга зүйн нэгэн санаа

Сурагчдын унших чадварыг хөгжүүлэхийн тулд унших хэрэгцээг бий болгоход анхаарах нь чухал. Багш бидний нэг том алдаа бол унших үйл гэдэг сайн уншиж байгаа сурагчдын хувьд шагнал магтаал, тааруу уншиж байгаа сурагчдын хувьд шийтгэл-зэмлэл гэсэн ойлголтыг багаас нь өгсөн байдаг. Энэ алдааг яаж залруулах вэ?

• Унших хэрэгцээг бий болгох

Жишээлбэл: Ангийн бүх сурагчдад унших бичвэрийг 3-7 хоногийн хугацаатай өгөх. Энэ уншлагын зорилго бол тухайн сурагч сонгосон эх бичвэрийг тодорхой хугацаанд өөрөө бэлтгээд найз, нөхдөдөө уншиж өгөх юм. Энэ нь унших хэрэгцээг бий болгож байгаагийн нэг жишээ юм.

Унших бичвэр нь тухайн сурагчдын унших чадварт тохирсон байна. Сурагчдын чадвар өөр өөр учраас багш хэнд ямар дэмжлэг хэрэгтэй байгааг судлах хэрэгтэй. Унших чадвар сайтайг нь уншуулж магтаад, унших чадвар сул сурагчдыг дахин дахин уншуулж залхаадаг арга зүйгээс аль болох хол байх хэрэгтэй.

Тухайн сурагч анги хамт олондоо эх бичвэрийг уншиж өгөхөөр бэлтгэж байхад нь багш, эцэг, эхчүүд хамран ажиллаж, туслаж байна гэсэн ойлголтыг өгөх нь илүү үр дүнтэй арга зүй юм.

• Бүтээлч уншлагын аргуудыг сургалтад хэрэглэх

Жишээлбэл: Асуултын хариуг олж унших, тэмдэглэх, ярих

Нэгдүгээр ангид унших арга барил (унших техник) –д суралцдаг бол хоёрдугаар ангийн хувьд танил биш эхийг унших зорилго тавигддаг учраас түгдрэлгүй унших (fluent) чадварыг төлөвшүүлэх нь илүү чухал юм. Унших чадварт гарч байгаа ахиц дэвшил, өөрчлөлтийг судлан илрүүлэх даалгавар нь дараах хэлбэрүүдтэй байж болно. Эхийн агуулгыг ойлгох чадварыг үнэлэхдээ дараах байдлаар үнэлж болно.

1. Эхийг уншаад өгөгдлийн дагуу дутуу мэдээллийг нөхөх

Жишээлбэл: Хэрээ эрж явтал устай лонх тааралджээ. (сүү, ундаа, ус)

2. Эхийг уншаад асуултад хариулах

Эхийг уншаад асуултад амаар бичгээр хариулах

Эхийг уншаад асуултад хариулахдаа олон сонголттой хариултаас сонгож тайлбарлах

3. Эхийг уншаад, ярих

Эхийн үйл явдлыг дарааллын дагуу ярих

Хөтөлбөрийн агуулга нь мэдлэгт биш чадварт суурилсан бөгөөд сурагчдын хэлний үндсэн чадвар болох сонсох-ярих, унших-бичих чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн учраас сурагчид үйл ажиллагаанд оролцох, багшийн хувьд бэрхшээлийг даван туулахад нь чиглүүлэх үүрэгтэйгээр оролцох гэсэн арга зүйг голлосон байна.

Эхийн агуулгыг ойлгох чадварыг төлөвшүүлэхэд багшийн асуулт чухал үүрэгтэй байна.

Иймд тухайн эхийн агуулгатай холбоотой асуултуудыг бэлтгэх хэрэгтэй. Үүний тулд эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгээс оновчтой асуултуудыг асуухаас эхэлнэ.

Багш хичээлийн үе шат бүрт, сурагчдаас асуулт асууж, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулдаг. Боловсруулалт сайтай асуулт үнэ цэнтэй сургалтын хэрэгслэгдэхүүн төдийгүй, мэдлэг бүтээх хамгийн чухал арга зам байдаг. Хөтөлбөрт тусгаагүй асуулт сурагчдаас асуух, эсвэл хөтөлбөртөө сурагчдаас асуух асуултаа тусгадаггүй зэрэг нийтлэг алдааг багш нар гаргадаг. **Жишээлбэл:** Энэ эх дээр юу гарч байна? Энэ эхэд яг юуг өгүүлэх гээд байна? Эсвэл шууд учир шалтгааны асуулт асуух гэх мэт.

Асуултаа төлөвлөхгүй байна гэдэг түүхий эдээ бэлтгээгүй байж байшин барих гэж байгаагаар адил юм. Иймд багш нар асуултыг боловсруулахдаа шинжлэх ухаанч байдлаар хандах хэрэгтэй. Шинжлэх ухааны үндэслэлтэй, боловсруулалт сайтай багшийн асуулт сурагчдын мэдлэг, чадвар, хандлага болон итгэл үнэмшлийг дэмжих олон аргын нэг юм.

Асуулт бүрийг боловсруулахдаа SOLO, BLOOM-ын таксономийн үзэл баримтлалд нийцсэн, шинжлэх ухааны үндэслэлтэй, энгийн үг хэллэгтэй, найруулга сайтай байх зарчмуудыг баримтлан ажиллах нь, сургалтын чанарыг сайжруулах дидактик шийдэл болж чадна.

Танин мэдэхүйн түвшин	Түлхүүр санаа	Тулгуур үйл үг	Жишээ, даалгавар
I түвшин Сэргээн санах (Remembering)	тодорхой мэдээллийг сэргээн санах	нэрлэх, ялгах, таних, олох, тодорхойлох, ярих, мэдэх	Энэ зохиолыг хэн бичсэн бэ? Зохиолын гол дүр хэн бэ?
II түвшин Ойлгох (Understanding)	өгсөн мэдээллийг ойлгох	тайлбарлах, бэлтгэх, унших, өөрчлөх, ялгалт хийх, төлөвлөх, зөвлөх, үгээр илэрхийлэх, зарлах, цэгцлэх, дүгнэх, номлох	Эхэд юуны тухай өгүүлсэн бэ?
III түвшин Хэрэглэх (Applying)	ойлголтоо шинэ нөхцөлд хэрэглэх	өөрчлөлтийг урьдчилан таамаглах, сонгох, хөгжүүлэх, зохион байгуулах, ангилах, хандах	Үлгэрийн төгсгөл хэсгийг зургаар илэрхийлнэ үү?
IV түвшин Задлан шинжлэх (Analysing)	мэдээллийн бүрэлдэхүүн хэсгүүдэд задлан шинжилгээ хийж, харьцуулах	таамаглалаас дүгнэлт гаргах, ялгах, таних, ангилах, томъёолох, эсэргүүцэх, шүүмжлэх, засах залруулах, баримт үйлдэх, зорилго тодорхойлох, холбох	Цагаан сар ба шинэ жилийн баярыг харьцуулан ярина уу? Өөрийн үзэл бодлыг илэрхийлэн ярьж бичихдээ бусдын үзэл бодолтой харьцуулан ярих
V түвшин Үнэлэх (Evaluating)	асуудалд шүүмжлэлтэй хандах, өөрийн санааг баталж нотлох	стандартчилах, шүүн хэлэлцэх, маргах, эсэргүүцэх, дүгнэх, алдааг залруулах	“.....” үлгэрийг унших дуртай юу? Дуртай бол яагаад? Дургүй бол яагаад?
VI түвшин Бүтээх (Creating)	үүсгэх, төлөвлөх, зохион бүтээх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх	таамаглал дэвшүүлэх, үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, арга аргачлалыг боловсруулах, дизайнчлах, зохиох, шийдвэр гаргах арга, замуудыг тодорхойлох	Үлгэрийн төгсгөлийг өөрчилж бичнэ үү? Туулайд зориулан төрсөн өдрийн мэндчилгээний үг бичнэ үү?
2.1в. Уншсан үлгэр, өгүүллэгийг үйл явдлын дарааллын дагуу тоочих	Үйл явдлын дарааллын дагуу тоочихдоо: - Эхийг ойлгож уншина. - Уншихдаа үйл явдлын дарааллыг тэмдэглэн уншина. - Эхлээд ямар үйл явдал болов? - Дараа нь ямар үйл явдал өрнөв? - Төгсгөлд нь ямар үйл явдал болов? - Эхийг уншиж, хэн?, юу?, ямар?, хэд?, хэчнээн?, яах?, яав? яасан? гэсэн асуултад хариу олно. - Эхийн агуулгыг ярихдаа “эхлээд, дараа нь, тэгээд, эцэст нь” гэх мэт үг хэрэглэн үйл явдлын дарааллаар ярина. - Эхэд өгүүлэгдэж баатрын үйл хөдлөлийг тоочин тайлбарлана. - Уншиж ойлгосноо бусдад ярих - Эхийн үйл явдлыг зөв дараалалд оруулах Жишээлбэл: Үйл явдлын зөв дарааллыг зөв олох дасгал даалгавар оруулаарай.		- Үйл явдлын дараалалтай эх оронч үзэл санааг дээдэлсэн, тогтвортой хөгжлийн боловсролын утга агуулга, монгол ахуй амьдралыг тусгасан, хүний сайн сайхан зан чанарыг дээдэлсэн эх зохиол - “Монголын хүүхдийн уран зохиолын дээж” I, II дэвтэр, УБ., 2009 - “Дэлхийн хүүхдийн хүүрнэл зохиолын дээж” УБ., 2012 - “Монгол туургатны үлгэр” I, II дэвтэр, УБ., 2010 - Ц.Дамдинсүрэнгийн “Цэцэн хурга” - Г.Повор “Үлгэрийн орноор аялцаа” 2007, “Мөнхийн үсэг”
	Цэцэн хурга арга ухаан олж, амьд мэнд эргэж ирэв.	2	
	Салхинд хийссэн нэвсгэр цагаан юм нь адсага байжээ.	3	
	Хурганууд нэг нэвсгэр юмнаас айн сандарч зугтав.	1	

Багшийн анхаарах зүйл:

Сурагч тухайн эхийг ойлгосноо эхлээд ямар үйл явдал болов?, дараа нь ямар үйл явдал өрнөв?, төгсгөлд нь ямар үйл явдал болов? гэсэн асуултуудын дагуу үйл явдлын дарааллыг олж чадаж байна уу? гэдгийг анхаарч ажиллана. Үйл явдлыг илэрхийлсэн зургийг ажиглаад дарааллын дагуу ярина. Зургийн дагуу ярилцахдаа: (монголчуудын нүүдэл эх)

1. Нүүдлийн талаар сонирхсон зүйлээ багш болон найзаасаа асуух
2. Өөрийн мэддэг зүйлээ бусдаас тодруулж асуух
3. Бусдын хариултаас хэрэгтэй мэдээллээ тэмдэглэж авах

Монголчуудын нүүдэл эхийг уншаад юуны тухай өгүүлснийг асуултын дагуу ярилцана. Нэмж тодруулах зүйлээ, асуултаар бусдаас асуух даалгавар хийж болно. Асуултын хариултыг аль болох бүтэн өгүүлбэрээр хэлүүлэхийг анхаарна.

2.1г. Уншсан эхийн баатруудын сайн, муу үйлийг жишээгээр тайлбарлах	1. Сонгосон эх зохиолын агуулгыг ойлгож уншина. - Уншсанаа бусдад ойлгомжтой ярих, бие биедээ зохиолын агуулгын талаар асуулт тавих зэргээр идэвхтэй сургалтын аргыг хэрэглэж болно. 2. Зохиолын баатруудын тухай хэлэлцэхдээ: - Зохиолын ямар дүр чиний найз байх боломжтой вэ? - Эхийн үйл явдлын өрнөл дунд дүрүүд хоорондоо хэрхэн холбогдож байгааг зураг, бүдүүвчээр илэрхийлэх - Баатруудын сайн муу үйлийг дарааллуулан бичнэ. - Сайн муу үйлийг яагаад сайн үйл болох, яагаад муу үйл болохыг жишээгээр тайлбарлах - “...” өгүүллэгийн баатар, “...” үлгэрийн дүрийн оронд байсан бол? санаа бодлоо илэрхийлэх 3. Уншсан эхийн баатруудын сайн, муу үйлийг жишээгээр тайлбарлахдаа: - Зохиолоос тухайн баатрын хэлсэн үгийг жишээлэх - Зохиолоос тухайн баатрын хийсэн үйл хөдлөлөөс жишээлэх Жишээ нь: “Энэ дүр... ингэж хэлсэн учраас их нөхөрсөг тусч хүн юм”, “...ингэж амиа бодсон учраас, эсвэл тусалсан учраас ... зан чанартай гэж үзэж байна” гэх мэт өгүүлбэрийн найруулгаар ярина. Бүтээлч үйл ажиллагаа: 1. Таалагдаж байгаа, таалагдахгүй байгаа нэг нэг жишээ олох, таалагдаж байгаа учрыг тайлбарлах 2. Баатрын үйл хөдлөл, үг яриаг бодоод ямар үйлдэл хийвэл зөв болохыг хэлэх, өөрийнхөө зан чанартай харьцуулах	- Ёс суртахууны сэдэвтэй, сайн муу үйл нь ялгарсан эх, зохиол байна.
---	---	---

Багшийн анхаарах зүйл:

Энэхүү суралцахуйн зорилтын гол үнэлгээ нь ТАЙЛБАРЛАЖ чадаж байна уу гэдэгт чиглэнэ. Сайн тайлбарлана гэдэг нь эх зохиолоосоо жишээ татаж ярихыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, баатруудын хийсэн үйлдэл, хэлсэн үг зэргийг жишээ болгон ярина гэсэн үг. Зохиолоос баатруудын хэлсэн үгийг жишээ болгож тайлбарла гэсэн чиглүүлгийг багш өгч ажиллана. Багш “Яагаад сайн, муу үйл гэж үзэж байна вэ?, Уншсан зохиолоосоо хэлсэн үгээс нь жишээ татаарай” гэсэн асуултаар хөгжүүлнэ.

Зохиолын баатрын сайн муу үйлийг тайлбарлахдаа тэдгээрийн хийсэн үйл явдлыг хөөж унших замаар ямар зан чанар харуулсныг гаргаж болно. Зохиолын баатрууд хэл ярианы төдийгүй өнгөн талын ч ялгаатай байдаг байна. Зарим нь түргэн шулганаж ярьдаг, эсвэл чанга ярьж инээдэг. Эсвэл их дотогшоо дуугүй байх нь ч бий гээд олон янз.

Тэгвэл зохиолын баатруудын ярианы агуулгыг төдийгүй, ярьж буй намба төрхийг нь хүртэл гаргаж илэрхийлж болно. Баатруудын хэл ярианы дүрслэлийн үүрэг, өвөрмөц байдлыг хадгалах нэг чухал нөхцөл нь дуу хоолой, аялгууны үүрэг их. Тодорхой бүлэг хүмүүс, тухайн ард түмний ахуй амьдралын, хэл ярианы болон орон нутгийн онцлогийг тусгаж, зохиолын баатруудын нийгэм, соёлын хэмжээг тодорхойлох хэрэглүүр болдог. Уран зохиолын баатар бүр өөрийн гэсэн араншинтай, өөрийн гэсэн "хэл"-ээр ярьдаг. Жишээлбэл:

Баатрууд ямар, ямар сайн, муу үйл хийснийг тунгаан бодох, тэдний хийсэн үйлээс чухал үйлийг ялгаж бичих, яагаад чухал, яагаад чухал биш гэж үзэж байгаагаа тайлбарлаж ярилцах замаар зан чанарыг тодорхойлж болно.

2.1д. Талархал, мэндчилгээ, товч анкет, танилцуулга, заавар зэргийг уншиж, агуулга, бүтцийг тайлбарлах	Талархал уншихдаа: 1. Талархлын бүтцийг эхлэл хэсэгт-хэнд зориулж бичих, гол хэсэгт-хэн нэгэнд талархаж бичсэн сэтгэлийг үг, талархаж байгаагийн учир, төгсгөл хэсэгт-бичсэн хүний нэр, он, сар, өдөр) ажиглана. 2. Талархал бичихдээ (баярлаж талархсанаа, чин сэтгэлээсээ, илэрхийлье) зэрэг үг хэрэглэж илэрхийлснийг анзаарч уншина. 3. Талархлыг бүтцээр нь яаж бичдэгийг бусдадаа ойлгомжтой ярина. 4. Бусдын бичсэн талархлыг унших, санал бодлоо солилцоно. Мэндчилгээ уншихдаа: 1. Мэндчилгээний бүтцийг эхлэл хэсэгт -хэнд зориулж бичих, гол хэсэгт-мэндчилгээ бичиж байгаагийн учир төгсгөл хэсэгт- бичсэн хүний нэр, он, сар, өдөр) ажиглана. 2. Мэндчилгээ бичихдээ (аз жаргал, мэнд хүргэе, ажлын амжилт, хүсэн ерөөе) зэрэг үгийг хэрэглэж илэрхийлснийг анзаарч уншина. 3. Мэндчилгээг бүтцээр нь яаж бичдэгийг бусдадаа ойлгомжтой ярина. 4. Бусдын бичсэн мэндчилгээг унших, санал бодлоо солилцоно. Бүтээлч үйл ажиллагаа: 5. Талархал, мэндчилгээний аян өрнүүлж, ангийнхандаа зориулж бичсэн талархал, мэндчилгээгээ бусдад уншиж өгч болно. Товч анкет уншихдаа: 1. Анкет бөглөхөд юу хэрэгтэйг эргэцүүлэн бодно. 2. Загварын дагуу анкет бөглөхөд хэрэгтэй мэдээллийг урьдчилан тэмдэглэж ирнэ. 3. Овог нэр, төрсөн он сар өдөр, регистрийн дугаар, нас хүйс, гэрийн хаяг, аав, ээж, багш болон өөрийн холбоо барих утас зэрэг загварыг ажиглаж уншина. 4. Бичсэн өөрийн товч анкетаа бусдадаа ойлгомжтой танилцуулна. 5. Ярьсан зүйлийг сонсоод тодруулан асуух Танилцуулгыг уншихдаа: 1. Гэр бүлийн танилцуулга, өөрийн танилцуулгыг уншина. 2. Гэр бүлийн гишүүдээ танилцуулахдаа гадаад байдал, зан чанар, хүсэл сонирхлыг ямар үг хэрэглэн танилцуулсныг ажиглаж уншина.	- Бусдын бичсэн мэндчилгээ, талархал зэргээр ангидаа үзэсгэлэн гаргах - Сурагчдын бичсэн талархал, мэндчилгээг ангийн хананд байрлуулах - Төрөл бүрийн тоглоомын заавар, шүд угаах заавар гэх мэтээр эрүүл мэндтэй холбоотой эхүүдийн хайчилбар цуглуулга хийх - Бүтээгдэхүүний сав, баглаа боодол
--	---	---

	3. Өөрийгөө хэрхэн танилцуулсныг бодож уншина. Зааврыг уншихдаа: 1. Үйл ажиллагааны заавар, бүтээгдэхүүний заавар, тоглоомын зааврын дарааллыг ойлгож уншина. 2. Хичээлийн хэрэглэгдэхүүн болон хуваариялгах, дэвтрээ зөв хаяглах <i>үйл ажиллагааны зааврыг</i> ажиглаж уншина. 3. Тоглоом тоглохдоо хэрхэн, яаж тоглох, ямар дүрмийг баримтлан тоглох, юуг анхаарч тоглох зэргийг тусгасан <i>тоглоомын зааврыг</i> ойлгон, анхаарч уншина. 4. Тоглоомын зааврыг уншихдаа тухайн тоглоом нь ямар ач холбогдолтой болохыг нь ойлгон уншина. 5. Бүтээгдэхүүний зааврыг уншихдаа найрлага, үйлдвэрлэсэн огноо, хэрэглэх заавар, хадгалах нөхцөл, хугацаа, хаана үйлдвэрлэсэн эсэх, холбоо барих дугаар, бүтээгдэхүүний нэр зэрэг хаана ямар, ямар заавар байгааг анзаарч, ойлгож уншина. 6. Үйл ажиллагааны заавар, бүтээгдэхүүний заавар, тоглоомын зааврыг бусдадаа ойлгуулан тайлбарлана. 7. Ямар үед зааврыг яаж хэрэглэхээ бусдадаа илэрхийлж тайлбарлан ярина. 8. Хүнсний бүтээгдэхүүн худалдан аваад аялалд явах гэж байгаа бол хэд хоног явахаасаа шалтгаалж бүтээгдэхүүний зааврыг уншиж сонголт хийх	
--	---	--

Багшийн анхаарах зүйлс:

Энэхүү суралцахуйн зорилт нь хэрэглээний эхийг уншиж, ойлгохтой холбоотой юм. Ингэхдээ агуулгыг ойлгоно гэхээсээ илүү бүтцийг ажиглуулах, үг сонголтыг ажиглуулахад анхаарна. Мөн уншсан зүйлийг бусдад ойлгомжтойгоор яриулах, сонссон сурагч анхааралтай сонссоноо асуулт асуух замаар сонсох, ярих чадвараа хөгжүүлэх боломжийг олгоно. Ярих чадварыг үнэлэхдээ “ойлгомжтой байна уу?” гэсэн шалгуураар үнэлнэ. Унших чадварыг үнэлэхдээ “бүтцийг зөв ойлгож ярьж байна уу?” гэсэн шалгуураар, сонсох чадварыг үнэлэхдээ бусдын ярьсан зүйлээс тодруулж лавшруулан асууж байна уу? гэсэн шалгуурыг баримтална. Хоёрдугаар ангид “Анхааралтай сонсох” чадварыг хөгжүүлэхийг зорьсныг СОНСОХ-ЯРИХ хэсгээс харна уу. Ямар үйл ажиллагаа хийдэг хүүхдийг анхааралтай сонсогч гэх вэ? гэхээр бусдаас асуулт асууж, асуултад хариулдаг хүүхдийг хэлнэ. Иймээс сонсох, ярих чадварыг унших чадвартай хослуулан хөгжүүлэхийг ажлынхаа гол зорилгоо болгохыг зөвлөмжилж байна. “Суралцахуйн үйл ажиллагаа” хэсэгт буй хүүхдийн хийх үйл ажиллагааны үйл үгийн томъёоллыг сайн ажиглаж, ээлжит хичээлийн үйл ажиллагаа болгохыг анхаарна уу. Зааврыг дагаж мөрдөх нь чухал болохоос бус уншиж мэдэх, цээжлэх, бичих зэрэг нь ач холбогдолгүй юм.

Хүнсний бүтээгдэхүүн дээрх зааврыг уншихдаа:

- Сурагчид хүнсний бүтээгдэхүүн авч ирээд түүнийхээ зааврыг уншина.
- Өөрийн авч ирсэн бүтээгдэхүүний зааврыг найздаа уншиж өгч тайлбарлах.
- Дараа нь ангийхандаа уншиж өгөх дарааллаар явна.

Багш сурагчдыг унших явцад тухайн бүтээгдэхүүний талаарх танилцуулга, зааврыг ялгаж унших байгаа эсэхэд хяналт тавьж зөвлөлгөө өгнө.

Зааврыг уншиж сурах гэдэгт бичсэн зүйлийг уншсанаар хязгаарлаж болохгүй. Уншаад ойлгож байгаа эсэх, учрыг нь олж уншуулахад багш туслах, чиглүүлэх хэрэгтэй. Харилцан ярилцах зааврыг бичсэн багш баяжуулан хэрэгжүүлэх хэрэгтэй.

Шүд яагаад цоордог вэ? Загас яагаад унтдаггүй вэ? гэсэн олон яагаад? гэдэг асуултын хариуг олохыг хүүхэд бүр хүсч байдаг.

Номын зураг дээр харилцан ярилцах. Зураг дээр ярихдаа юу хийж байна, зургийг нэрлүүлэх төдийгөөр хязгаарлаж болохгүй гэдгийг анхаарах.

- Хүнсний ногооны талаар юу, юу мэдэх
- Хүнсний ногоо, жимсийг ялган нэрлэх

Хамгийн чухал нь зураг харж уншдаг болгоход үйл ажиллагаагаа чиглүүлэх хэрэгтэй.

Асуултын хариуг олохын тулд өөрөө эрэл хайгуул хийдэг байх өөрөөр хэлбэл мэдээлэлтэй ажиллах чадварыг хөгжүүлэхэд багшийн чиглүүлэг чухал үүрэгтэй байна. Сурагчдын үйл ажиллагааны зааврыг унших чадварыг илрүүлэхэд цагаан самбарыг ашиглаж болно. Ингэхийн тулд сурагчдад төрөл бүрийн бүтээгдэхүүний савыг тарааж өгч мэдээллийг унших даалгавар өгнө. Сурагчдыг уншиж дууссаны дараа багш асуулт асууна. Сурагчид асуултын хариуг цагаан самбар дээрээ бичиж харуулна.

Жишээлбэл:

- Бүтээгдэхүүний хугацаа хэзээ дуусах вэ?
- Хаана үйлдвэрлэсэн бэ?
- Найрлаганд нь юу, юу орсон байна? Аль нэгийг нь сонгож бичнэ үү?

Мөн хоёрдугаар ангид талархлын булан, мэндчилгээний булан ажиллуулах. Хэн нэгэнд баярлаж, талархсанаа илэрхийлсэн бичгийг эдгээр буланд байнга байрлуулахыг хичээх.

Хоёрдугаар ангийн сурагчдын хувьд багш, эцэг эхийн дэмжлэг хэрэгтэй учраас тэдэнд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Сурагчдын төрсөн өдрийн мэндчилгээний хуудсыг ангид хуваарийн дагуу байрлуулах. Багш тодорхой сурагчдад чиглүүлэг өгч, тэдэнтэй хамтран төрсөн өдрийн мэндчилгээний хуудсыг бэлтгэх нь илүү үр дүнтэй болно. Гэхдээ багш бүгдийг хийнэ гэсэн үг биш. Мэндчилгээний хуудсыг хийхдээ сурагчдыг багуудад хувааж, тэдэнд чиглүүлэг, дэмжлэг өгч өөрсдөөр нь хийгэхийг хичээгээрэй. Багуудын ажил нь хүүхэд нэг бүрийн оролцоо ямар байгааг ажиглаж, дүгнэх боломжийг багшид олгоно.

Хэрэглээний эх унших бүлгийн хүрээнд тусгагдсан үйл ажиллагаанууд нь сурагчдын мэдээлэлтэй ажиллах чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн бөгөөд асар хурдацтай хөгжиж байгаа нийгэмд амьдрах ирээдүйн ирээдүйн нэг чухал чадвар болох хэрэгтэй мэдээллээ олж сурах үйлийн баримжаатай болгох гол зорилгыг агуулж байна.

Мэдээлэлтэй ажиллах чадварыг хөгжүүлэхийн тулд сургалтын үйл ажиллагаанд төрөл бүрийн ажлуудыг төлөвлөж болно. Энэ нь хичээлийн хуваарь, жижүүрийн хуваарь, номын сангийн дүрэм, анхааруулсан санамж бичиг зэрэг хэрэглээний эхүүдийг уншиж ойлгохоос эхэлнэ.

2.1е. Цээжилсэн шүлэг, зугаа үг, хэл зүгшрүүлэх үгийг бусдын өмнө тод чанга дуугаар унших	1. Өөрийн мэддэг шүлэг, зугаа үг, хэл зүгшрүүлэх үгийг бусдад уншиж харуулах буюу сонсох 2. Юуны тухай өгүүлж байгааг асуултын дагуу ярилцах 3. Үгийн утгыг тайлбарлах 4. Цээжлэхийн тулд давталттайгаар унших 5. Шүлэг зугаа үгийг уран, тод уншиж байгаа хэлбэрийг үзэх, сонсох 6. Шүлэг зугаа үгийг уран, тод уншиж байгааг сонсохдоо дууны өнгө хаана өөрчлөгдөж байгааг тэмдэглэх 7. Шүлэг зугаа үгийг уран тод унших, хэл зүгшрүүлэх үгийг зөв, тод хурдан унших дасгал хийх, турших, бусдад унших Жишээлбэл: Шагайн наадгай Атга <u>дүүрэн</u> шагайгаа <u>Ахрын</u> эсгий дээр цацлаа Дүүгийн хаясан шагай <u>Дэвжээ</u> бүрхэн буулаа 8. Цээжилснээ тод чангаар уншиж харуулах	- Эх оронч үзэл санааг дээдэлсэн, тогтвортой хөгжлийн боловсролын утга агуулга, монгол ахуй амьдралыг тусгасан, хүний сайн сайхан зан чанарыг дээдэлсэн утгатай шүлэг - Шүлгийг тод чанга, хэмнэлтэй уншиж байгаа бичлэгийг үзүүлэх буюу сонсгох
---	--	---

Багшийн анхаарах зүйл:

Бид энэхүү хөтөлбөртөө ЗӨВ УНШИХ, ОЙЛГОН УНШИХ, ХУРДАН УНШИХ, УРАН УНШИХ гэсэн уншлагын чанарыг харгалзаж байгаа билээ. Уран уншуулахаас өмнө заавал дараах зүйлийг дэс дараалан баримтлахыг санал болгож байна.

1. Шүлэг дэх авиа үсгийг зөв дуудаж, тод, чанга унших
2. Зөв дуудаж уншсаны дараа шүлгийн утгаа хэр ойлгож байгааг багш судлах.

Судлахдаа блүүмийн таксономийн асуултын дарааллыг харгалзана.

3. Ойлгосны дараа уран уншуулах арга хэрэглэх

Шүлгийнхээ утгыг сайн ойлгоогүй бол, шүлэг дэх үгийг мэдрээгүй бол уран уншлагын хичээлийг орох боломжгүй. Иймд юун тухай өгүүлж байгаа утгыг сайтар ярилцаж тайлбарлаж ойлгосны дараагаар хүүхэд хурдан цээжилж өөрийн болгон уншина.

Шүлгийн авиа, үгийг тод хэлж, хэмнэлтэй унших чадвар нь сурагчдыг уран уншлагад бэлтгэх эхний алхам юм. Сурагчдын уран унших чадварыг хөгжүүлэхэд дараах хоёр үйлийн алхам чухал үүрэгтэй байна.

Сонсох чадварыг хөгжүүлэх дасгал: Шүлгийн уран сайхныг мэдрч сонсож чадаж байна гэдэг бол уран уншихад суралцах үндэс суурь нь юм. Багш өөрөө уран уншиж өгөхөөс гадна уран сайхны бичлэгүүдийг сонсгох. Мөн түүнчлэн уран уншдаг зочныг хичээлд урьж оролцуулж болно. Энэ насны сурагчдын онцлог нь бусдыг дуурайх, тэднээс үлгэрлэх чадвар нь илүү байдаг тул энэ аргыг хэрэглээрэй.

Утгын үүднээс дууны өнгө, өндөр нам, чанга сул зэргийг тохируулж сурах дасгал хийх.

Цэг, таслал, асуултын тэмдэг зэргийг уншихдаа анзаарч унших. Мөн баяр баясгалан, гомдол гуниглалыг дууны өнгөөр илэрхийлэх, баатруудын үгийг уншихдаа дууны өнгөө өөрчлөх зэрэг уран уншлагын эхний алхмуудыг эзэмших үйлийн баримжаатай болгохын тулд арга зүйгээ төлөвлөх хэрэгтэй.

Шүлгийг уран унших нь тухайн зүйлийн агуулгыг ойлгох, сурагчдын сэтгэл хөдлөл, урлагийн боловсролд чухал нөлөөтэй байдаг. Уран уншлага нь ойлгож уншихтай салшгүй холбоотой бөгөөд ойлгож унших, үгийн утгыг мэдэх зэрэг нь уран уншлагын бэлтгэл болно. Сурагчдаар цээжилсэн шүлгийг тод уншуулахаас гадна, бусад ном сурах бичгээс тухайн бүтээлийг тод (уран) унших дасгалыг сайн хийлгэх хэрэгтэй. Энэ чадварыг бий болгоход багшийн үлгэр жишээ уншлага чухал үүрэгтэй. Багш нарын гаргадаг нийтлэг алдаа бол сурагчдын насны онцлогт тохироогүй том хэмжээний шүлгийг цээжлүүлэх, сурагчид утгыг нь сайн ойлгохгүй байж хоосон цээжээ дэлдэж унших, зорилгогүй хөдөлгөөн хийх нийтлэг алдаа байдаг. Энэ алдааг аль болгох гаргахгүй байхыг зөвлөж байна.

Уран унших чадвар гэдэг нь утга зохиолын хэлний дуудлага өргөмтийн хэм хэмжээг судлах, зөв дуудах зүйд суралцахаас эхэлнэ. Аялга, түүнийг бүрэлдүүлэгч зүйлсийг мэдэх, эзэмших, өгүүлбэрийн болон утгын өргөмтийг ялгах, хэрэглэх, зогсох, хурдац, хэмнэл тохируулах, ярианы хөг аяыг эзэмших, дууны өнгө, ярианы орчноо мэдрэх, уран дүр бүтээх, хүний сэтгэл зүйд нөлөөлөх зэргээр үүнд суралцдаг. Уншлага бол жирийн нэг үндсэн чадвар төдий биш оюуны нарийн төвөгтэй процесс юм. Унших чадварыг хэрхэн эзэмшинээс тухайн хүүхдийн оюуны хөгжил ямар байх нь шууд хамаардаг. Иймд сурагчдын түгэрэлгүй зөв, шударга унших чадварыг хөгжүүлэхэд сургууль, багш, эцэг эхчүүдийн анхаарал, дэмжлэг хамгийн чухал үүрэгтэй байдаг.

Эхийн далд утгыг бүтээлчээр ойлгон унших

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
2.1ж. Өгсөн зургаас баатрууд хоорондоо юу ярилцсаныг ургуулан төсөөлөх	1. Зохиолын баатар юу ярилцаж байгааг төсөөлөн ярилцаж, санал бодлоо найз нөхөдтэйгөө хуваалцах - Уншсан хэсгийн агуулгын талаар асуулт зохиож уншсанаа хэлэлцэх, бие биеийнхээ санаа бодлыг анхааралтай сонсох, асуулт асуух 2. Уншсан зохиолын үйл явдал, гол баатрын үйл хөдлөлийн талаарх төсөөллөө улам гүнзгийрүүлэн унших 3. Зургийг хараад ямар зан ааштай, ямар дуу хоолойны өнгөтэй байх зэргийг төсөөлөн ярих	 http://www.childrenslibrary.org - Үйл явдалтай цуврал зураг бүхий эх, өгүүллэгүүд - Зурагтай үлгэрийн ном - Монгол ардын аман зохиол

Хөтөлбөрийн “Эхийн далд утгыг бүтээлчээр ойлгох” чадвар нь “Зохиолд юу өгүүлэхийг төсөөлөх”, “Зохиолын төгсгөлийг таамаглах” гэсэн хоёр хэсгээс бүрдэж байгаа бөгөөд энэ нь бүтээлчээр унших арга барилд сургах нэг арга юм.

Төсөөлөл /Visualizing / - уншигчийн оюун санаанд буусан дүр зураг юм.
Зохиолыг унших үед уншигчийн мэдрэмжээр дамжин бүтээгддэг.

Төсөөлөн унших нь:

1. Зохиолын гарчиг, зураг, түлхүүр үгс зэргээр баримжаалан зохиолд юуны тухай өгүүлэхийг төсөөлөн бодох
2. Өөрийн төсөөллийг бусадтай хуваалцах буюу мэдээлж ярих, илэрхийлэх
3. Төсөөллөө батлахын тулд зохиолыг унших буюу мэдээллийг гадаад орчноос хүлээн авах
4. Мэдээллийг хадгалах, боловсруулах
5. Уншиж, ойлгосон мэдээллийг бусадтай хуваалцах гэсэн үйлийн алхмаар хэрэгжинэ.

Зохиолын баатруудын үйл хөдлөл, дүр төрхийг төсөөлж унших

Төсөөлөл гэдэг нь ямар нэгэн зүйлийг оюун ухаандаа зураглаж, түүнийгээ бодит болгохыг хэлнэ. Жишээлбэл: Уншиж байгаа зохиолын баатруудын үйл хөдлөл, дүр төрхийг төсөөлөн бодох нь бүтээлчээр уншиж байгаа нэг хэлбэр юм. Өөрөөр хэлбэл уншлага нь тодорхой зорилготой болж байна гэсэн үг. Уншлагыг тодорхой зорилгогүйгээр зохион байгуулах нь мэдээллийг хадгалах, боловсруулахад ямар нэгэн байдлаар саад болдог байна.

Зохиолыг унших явцдаа зогсолт хийж үйл явдал хэрхэн өрнөв? Цааш ямар үйл явдал өрнөх бол? гэж төсөөлөн бодож унших, өөрийн төсөөллийг зохиолын бодит байдалтай харьцуулан бодох үйлийн явцад оюуны идэвхтэй үйлдэл хийгдэж, мэдээлэл хадгалагдан үлдэх нь илүү байдаг байна.

2.13. Өгсөн зургаас үндэслэн үйл явдлыг таамаглах	1. Уншихын өмнө зургаас үйл явдлыг таамаглах 2. Эхийг уншихын өмнө зураг ба гарчгаас юуны тухай унших гэж байгаагаа таамаглаж, ярилцах 3. Сонгосон эх зохиолын зургаас үндэслэн үйл явдлыг таамаглах Жишээ нь: • Зургийг ажиглан, дүрийн үйлдлээс цаашид юу болохыг таамаглах • Зургийн орчноос үйл явдал цаашид хэрхэн өрнөхийг таамаглах, зурагт ...ийнхүү дүрслэгдсэн учраас ...ингэж таамагласан гэж ярих 4. Таамаглалуудаа бие биедээ сонирхол татам \ зургаар, хүснэгтээр гэх мэт\ ярих 5. Ярьснаа алдаагүй зөв бичих	- Үйл явдалтай цуврал зураг бүхий эх, өгүүллэгүүд - Зурагтай үлгэрийн ном
---	---	--

Багшийн анхаарах зүйлс:

Зохиолд юу өгүүлэхийг таамаглах: Таамаглах /predicting / -зохиолд гарсан зүйл, болсон явдалд тулгуурлан юу тохиолдохыг урьдчилан хэлэх юм. Бодит амьдралаас мэдсэн зүйлдээ тулгуурлан таамаглаж болно.

Таамаглан унших нь:

1. Зохиолын эхлэл, гол хэсгийг унших, сонсох буюу мэдээллийг гадаад орчноос хүлээн авах
2. Зохиолын төгсгөл хэсгийг урьдчилан таахын тулд өөрийн суурь мэдлэг буюу уншсан мэдээлэл дээрээ тулгуурлан таамаглал дэвшүүлэх
3. Дэвшүүлсэн таамаглалаа бусадтай хуваалцах
4. Энэ таамаглалаа юунд үндэслэн дэвшүүлснээ тайлбарлах
5. Төгсгөл хэсгийг унших
6. Өөрийн таамаглал, зохиолын төгсгөлийг харьцуулан ярих, бичих гэсэн үйлийн алхмаар хэрэгжинэ. Зохиолд юуны тухай өгүүлэхийг төсөөлөх нь уншихаас өмнөх үйл ажиллагаа бол таамаглан унших нь зохиолыг унших явц дахь үйл ажиллагаа юм.

Дээрх хоёр үйл нь уншихын өмнөх, унших үйлийн явц дахь гэдгээрээ ялгарч байгаа боловч хүүхдэд унших сонирхол, мотивацийг буй болгодог гэдгээрээ ялгаатай.

Дээрх хоёр үйл ажиллагааг зохион байгуулахдаа сурагчдын унших чадварт үндэслэн тохирох эхийг сонгоно. Сурагчдын уншлагын хурд харилцан адилгүй байдаг тул бичвэрийн хэмжээг тооцож үзэх хэрэгтэй. Сурагчид зохиолд юу өгүүлэхийг төсөөлөх, таамаглахдаа дараах өгүүлбэрүүдийн загварыг ашиглаж болно.

- Гарчгаас нь үзвэл энэ зохиолд тухай өгүүлэх юм шиг байна.
- Энэ зохиол нь магадгүй.....
- Дараагийн удаа ...ийм зүйл тохиолдож болох юм.
- Энэ зохиол нь миний таамагласнаас ялгаатай байлаа.
- Энэ зохиол нь миний төсөөллөөс ялгаатай байлаа.
- Би одоо бодохдоо...

Зохиолд юуны тухай өгүүлэх, цаашид ямар үйл явдал өрнөхийг сурагчдаар яриулахаас өмнө бэлтгэл болгож төрөл бүрийн дасгалуудыг хийлгэж болно. Жишээлбэл:

Зургийг ажиглаад, сурагч номыг уншихаас өмнө хэрхэн төсөөлж байгааг ярих.



Өгөгдлийг уншиж, судалж, ажиглаад хэрхэн төсөөлж, таамаглаж байгаагаас тухайн сурагчийн харилцаа, хандлагын онцлогийг таньж болно. Тухайлбал:

- Сурагч зохиолын баатрын хийсэн үйлийг хэрхэн төсөөлж, ямар үгээр илэрхийлсэн
- Өөрийн бодлыг хэрхэн тайлбарласан
- Таамаглал дэвшүүлэн ярихдаа өмнөх хэсгүүдтэй хэрхэн холбож байгаа

Сурагчдын төсөөлж буюу таамаглан унших чадварыг хөгжүүлэхэд явцын үнэлгээ чухал үүрэгтэй.

2 од нэг хүсэл	Багшийн санал бодол
	Бэлэн амтай залхуу хулганы тухай өгүүлнэ гэж бодож байна. Өөрөө хийнэ гэж хэлчихээд хэлсэн амандаа хүрдэггүй хулганы тухай өгүүлдэг байх гэж төсөөлж байна гэх мэт номын гарчгийг ашиглан төсөөлөн ярьж чадсан.
	Хулганууд олуулаа амьдардаг байсан. Будаагаар хооллодог байсан. гэж номын зургийг ашиглан төсөөлж ярьж чадсан.
	Ярихдаа зөвхөн нэг сурагч руу харж ярьсан. Дараа энэ алдааг давтахгүй байхыг зөвлөж байна

№	Шалгуур	1	2	3	4
1	Эхийн эхлэл, гол хэсгийг төгсгөл хэсэгтэй холбож чадсан эсэх				
2	Таамаглал хэр үндэслэлтэй байсан				
3	Таамаглал сонирхолтой байсан эсэх				
4	Яагаад ингэж бодсоноо баталж, нотолсон эсэх				
5	Таамаглал дэвшүүлэхдээ өгөгдлийг оновчтой ашигласан эсэх				

Таамаглан унших үйлийг зохион байгуулах нэгэн жишээ

Үнэнч нөхөр

Урьд нэг баян хүн хоточ сайн нохойтой байв. Хөрөнгөө сайн хамгаалдаг гэж нохойдоо их хайртай байдаг байжээ.

Гэтэл нохой хөгширч, залуугийнхаа адил байхаа болив. Тэрээр нохойгоо хаяхаар завиар авч явлаа. Баян хүн нохойгоо өшиглөн унагатал завь холбирч, баян усанд унажээ. Түүнийг усанд живж байтал нэг юм чирээд, эрэг дээр гаргав. Миний нөхдийн хэн нь ирж аврав гэж бодоод хартал нохой нь байв. Баян хүн нохойныхоо ачийг сая л мэдэв.

Үйл ажиллагааны дараалал

1. Өгсөн эх болон үйл явдалтай зургаас үндэслэн эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг таамаглах, зургаас ерөнхийд нь таамаглаж болно. Жишээлбэл: Дээрх эхийн эхлэл, гол хэсгийг өгүүлбэр бүр тусдаа байхаар багуудад тарааж өгнө.

Нэгдүгээр багт: Хөрөнгөө сайн хамгаалдаг гэж нохойдоо их хайртай байдаг байжээ. Урьд нэг баян хүн хоточ сайн нохойтой байв. (эхлэл хэсэг)

Хоёрдугаар багт: Баян, нохойгоо өшиглөн унагатад завь холбирч, баян усанд унажээ. Тэрээр нохойгоо хаяхаар завиар авч явлаа. Гэтэл нохой хөгширч, залуугийнхаа адил байхаа болив. (гол хэсэг)

2. Багийн гишүүд өгүүлбэрүүдийг уншаад зөв дараалалд оруулж, нөхдөдөө уншиж танилцуулах
3. Уншиж танилцуулсны дараа эхийн аль хэсэг болохыг тодорхойлох
4. Эхийн эхлэл, гол хэсэг дээр тулгуурлан үлгэрийн төгсгөлийг үргэлжлүүлэх (таамаглах)

Үнэнч нөхөр

Урьд нэг баян хүн хоточ сайн нохойтой байв. Хөрөнгөө сайн хамгаалдаг гэж нохойдоо их хайртай байдаг байжээ. (эхлэл хэсэг)

Гэтэл нохой хөгширч, залуугийнхаа адил байхаа болив. Тэрээр нохойгоо хаяхаар завиар авч явлаа. Баян, нохойгоо өшиглөн унагатад завь холбирч, баян усанд унажээ. (гол хэсэг)

.....

 (төгсгөл хэсэг)

5. Үлгэрийг хэрхэн үргэлжлүүлж (таамаглах) зохиосноо найз, нөхдөдөө уншиж танилцуулах
- Зохиолын төгсгөлийг таамаглан унших арга**

1. Түлхүүр үгийн арга
2. Асуултын арга
3. Асуудал дэвшүүлэх арга
4. Түлхүүр санааг зургаар өгөх арга
5. Эвлүүлгийн арга
6. Солилцооны арга гэх мэт

Түлхүүр үгийн арга нь суралцагчдын уран сайхны мэдрэмж, уран сэтгэмжийг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй. Энэ аргыг хэрэглэхдээ түлхүүр үгийг маш оновчтой сонгох хэрэгтэй. Эдгээр үгс нь зохиолын баатруудын дүр төрхийг зөв таамаглахад чиглэл болох хэдий ч утгыг бүрэн дэлгэрүүлэхгүй үгс байх хэрэгтэйг анхаарах.

“Үнэнч нөхөр” үлгэрийн төгсгөл

Түлхүүр үг: живэх, ачийг санах

Зохиолыг таамаглан унших

Бяцхан Моцартын бэлэг

1762 оны тавдугаар сар. Хөгжмийн зохиолч, хөгжимчин Леопольд Моцарт нээлттэй цонхны дэргэд суугаад, өөрийн эзэн Зальцбургийн захиалсан бүжгийн ая зохиож байлаа. Энэ аяыг эзэн өөрийн олон хамаатан садны нэгний нь төрсөн өдөрт зориулж захиалсан байжээ. Л. Моцарт хөгжмийн зохиомжоо бичиж дуусаад:

- Вольфганг түргэн ороод ир гэж цонхоор дуудав. Хашаанд хоёр хүүтэй тоглож байсан 6 настай хүү Моцарт тоглоомноосоо салж ядан, шатаар дурамжхан өгсөж ирлээ.

(Зогсосхийлт1)


Эцэг хүү Моцартыг юуны учир дуудсан бол?

- Хүү минь. Яг одоо энэ хөгжмийн нотыг ордонд хүргэж өг! Замдаа бүү саатаарай! Ноён фон Данвицын бэлтгэгчдэд заавал гардуулж өгнө шүү! Тэгээд халааснаасаа жижигхэн зэс зоос гаргаж:
- Буцаж ирэхдээ алим авч идээрэй хэмээн хүүд өгөв. Тэгснээ хэсэг дуугүй байж байгаад хүүгээ энхрийлэн тэвэрч, би чамд нэг бяцхан **нууц** хэлье! Энэ хөгжмийг зохиосны хөлсөнд ирэх мөнгөөр эзжид чинь төрсөн өдрөөр нь шинэ даашинз авч өгөх гэсэн юм. Харин энэ тухай хэнд ч үг бүү цухуйлгаарай! гэв.

Бяцхан Моцарт баяр хөөр болсоор гадагш гарлаа. Тэр явсаар горхин дээрх гүүрэнд тулж ирснээ **усанд** сэлж буй галууг шохорхон харлаа. Тэдний тоглохыг сонирхон харсаар нот бичсэн хуудас нь усанд унахыг ч анзаарсангүй. Ноттой хуудсаа уснаас гарган автал бэх нь уусаж, урсжээ. Цөхрөнгөө барсан хүү чулуу сандайлан уйлж суужээ. Гэнэт тэр уйлаад ямар ч **ашиг** тус болохгүйг ойлгож **нүдээ** түргэн арчаад, Мальвиц эзний номын дэлгүүр лүү итгэлтэй нь аргагүй алхав.

(Зогсосхийлт 2)

Дараах зургуудыг ажиглан үйл явдал хэрхэн өрнөхийг төсөөлөн ярина уу?



- Өдрийн мэнд ноён Мальвиц ! гэж хүү малгайгаа авч мэхийн мэндлээд, алим авах гэж байсан зэс зоосоо өгч:

- Нотны хуудас өгөөч !

- Тэгэлгүй яахав, эрхэм Моцарт минь гэж Мальвиц инээмсэглээд, түүнд хуудас авч өглөө.

- Харин та надад бэх, үзэг хоёроо түр зээлдүүлээч ! гэжээ. “Энэ хүү юу хийх гэсэн юм бол доо” хэмээн дэлгүүрийн эзэн бодсоноо:

- Тэг тэг миний өрөөнд ороод юу л бичнэ, бүгдийг бич гэв. Вольфганг тэр өрөөнд орж, нэг цаг орчим болоод, хөгжмийн нот дүүрэн бичсэн хуудас барьсаар гарч ирэв. Тэр Мальвицад талархсанаа илэрхийлээд, ордны зүг гүйн одлоо...

ХОЁР. БИЧИХ ЧАДВАР

Хоёрдугаар ангийн сурагчдын бичих чадварт тавигдах шаардлага: **Үг холбон, өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих, өгүүлбэр, эхийг бүтцийн дагуу хичээнгүй алдаагүй бичих.**

Тус ангид (ертөнцийн гурав) уран зохиолын эхийг дуурайн зохиож бичихээс гадна талархал, мэндчилгээ, товч анкет, зааврын дагуу гэр бүлийн танилцуулж бичих зэрэг хэрэглээний эхийг зохиож бичих чадвар эзэмшинэ. Эдгээр эхийг дараах бичих арга барилын дарааллаар бичиж сургахыг анхаарна уу.

Чадвар, арга барил	
Зөв бичих	- н,г үсгээр утга ялгаж үгсийг зөв унших, нүдлэх, зөв бичих - Эр, эм үгэнд “ы, ий” залгаврыг зөв залган бичих - Үгийг үеэр таслан мөр шилжүүлж зөв бичих - Цагаан толгойн үсгийг эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсэг гэж ангилж, бүлэглэх
Бичих санаагаа олох, төлөвлөх	- Юуны тухай, юуг бичихээ бодох, эргэцүүлэх - Бичих санаагаа эргэцүүлэн бодох, бусадтай хэлэлцэх - Эхийн бүтцийн дагуу бичих үйлээ төлөвлөх Эхлээд, дараа нь, төгсгөлд нь юу бичих вэ? - Бичих зорилгоо сонгох (талархал, мэндчилгээ, товч анкет, гэр бүлийн танилцуулга, заавар, болсон явдал,)
Санаагаа зохиож, байрлуулан бичих	- Төлөвлөсний дагуу ноороглон бичих
Бичсэнээ хянах сайжруулах	- Бичсэн зүйлээ дахин унших - Зөв бичгийн дүрмийн болон найруулгын алдааг багштайгаа хамтран хянаж, засах - Хэн нэгэнд уншиж, зөвлөгөө авах - Бичсэнээ нягталж дахин сайжруулах (үг, өгүүлбэр нэмэх, хасах, өөрчлөх) - Дахин сайжруулж, хичээнгүй бичих

Өгүүлбэр эхийг дэгийн дагуу хичээнгүй сайхан бичихийн тулд дараах шалгуурт тохируулан бичиж сурахад анхаарна.

- Үсгийн бичих хэв маягийг баримтлах
- Үсгийн эхлэх, үргэлжлэх, төгсөх цэгийг зөв төлөвлөх
- Үсгийн өндөр намыг зөв тохируулж муруй хазгай биш бичих

- Үсгийн эгц болон ташууг зөв бичих. Налалт (65°) жигд зөв.
- Үсгийн өргөнийг тохируулах
- Үсэг хоорондын холболт зөв
- Үг ба үсгийн хоорондын зайг ижил хэмжээтэй бичих
- Үг, үсгийг дэвтрийн шугаман дээр налуу бичих
- Үзэгний даралт, жигд хөнгөн байх
- Үгийг үзэг салгахгүй, тасралтгүй бичих
- Үсэг ба үгийн эцсийн орхицыг шидэхгүй, тогтоож бичих
- Цэг цэглэлийг зөв хэрэглэх (зураас, хашилт, хаалт, тодорхойлох цэг, цэг, таслал, том үсгээр бичих зэргээс ойлгон хэрэглэх)
- Догол мөр гарган хуулан бичих

Хичээнгүй сайхан бичиж сурснаа харуулахын тулд дараах үйл ажиллагаануудыг хийж болно.

- Дээрх шалгуурт нийцүүлэн хуулан бичих
- Хичээнгүй бичгийн хуудсыг хүүхэд бүрт хийх
- Хичээнгүй сайхан бичсэн зурган самбар, плакат бүтээх
- Дэгийн дагуу бичээгүй эхийг дэгийн дагуу болгон бичсэнээ харуулсан хуудас хийх

Ямар ч тохиолдолд дэгийн дагуу хичээнгүй сайхан бичиж сурсныг харахын тулд бусад хичээлийн дэвтрийг шалгаж дүгнэлт өгч ажиллахыг санал болгож байна.

Бичих арга барилыг эзэмшүүлэхдээ дараах зүйлийг анхаарна.

- Нэн тэрүүнд ямар нэгэн эхийг зохиож бичүүлэхийн тулд юу юу бичиж болохыг сайтар бодуулж, тэмдэглүүлэх хэрэгтэй. Хэрвээ мэндчилгээ зохиож бичихээр бол хэнд зориулж, ямар учраас бичих вэ? гэсэн асуултыг хэрэглэн эргэцүүлэхэд багш чиглүүлнэ. Жишээ нь, найздаа зориулж төрсөн өдрийн мэндчилгээ бичих гэх мэт. Эхлээд юу бичих вэ?, дараа нь юу бичих вэ?, төгсгөлд нь юу бичих вэ? гэсэн асуултаар чиглүүлж, санаагаа байрлуулж сургахад анхаарна.
- Бичих санаагаа олж, төлөвлөсний дараа ноороглуулж сургах хэрэгтэй. Нооргийг хүүхдийн дэвтэрт хийлгэнэ. Ноороглосны дараа найруулгын болон зөв бичгийн дүрмийн засвар хийнэ. Найруулгын засвар хийхдээ дараах шалгуурыг хэрэглээрэй.
 1. Бичсэн эхийг уншихад ойлгомжтой байна уу?
 2. Үг, өгүүлбэр нэммээр байна уу? Ямар үг өгүүлбэр нэмэхээ бодоорой.
 3. Үг, өгүүлбэр хасмаар байна уу? Ямар үг өгүүлбэр хасахаа бодоорой.
 4. Үгийн байрлалыг солимоор байна уу?
 5. Үгийг солих уу?

Зөв бичгийн дүрмийн засвар хийхдээ дараах байдлаар хийж болно. Багш та өөрийнхөө арга зүйгээр нэмж ажиллаж болно.

1. Бичих гэсэн зорилготой ээлжит хичээл бүр дээр хүүхдийн зохион бичсэн, найруулж бичсэн байдлаас нь алдсан үгийг **ИЛРҮҮЛНЭ**.
2. Илрүүлсэн үгээ **ОНОШИЛНО**. Ямар дүрэмтэй холбоотой болохыг оношилно гэсэн үг. Мөн сурагч бүр ямар дүрмийн алдаа гаргаж байгааг ялгаатай харах боломжийг олгоно.
3. Буруу бичсэн үгийг зөв болгон, холбогдох зөв бичгийн дүрмийн утга учрыг сурагчдын оролцоотойгоор **ТАЙЛБАРЛУУЛНА**. Тухайлбал, зөв болон буруу бичсэн үгсийг харьцуулж яагаад зөв болох, яагаад буруу болох, аль үсэг зөв бичихэд нөлөөлж байна /явахын, явхын/ гэх мэтээр ажиглах, харьцуулах чадварыг хөгжүүлэх зэргээр сурагчийн оролцоо, үйл ажиллагааг идэвхжүүлэх арга зам хайхыг зөвлөж байна. Буруу бичсэн үгийг яаж зөв болгосон байна вэ? Сурагч Батын бичсэн нь зөв юм. Яагаад зөв бэ? Буруу хувилбарыг яагаад буруу байгааг тайлбарлана уу. Дүрмийг уншаад тайлбараа нягтална уу. Тайлбарласан дүрмээ бусдад ойлгомжтой болгохын үүднээс найруулж бичиж үзнэ үү гэх мэт асуултын хувилбар байж болно. Нэг ангид 14 нэгж хичээлийг судална гэвэл 14 удаагийн давтамжтай

бичих зорилготой хичээл төлөвлөх тул тэр бүрд нь тухайн ангид эзэмших ёстой зөв бичгийн дүрмийн чадваруудыг дахин дахин давтан ярилцах, сурагчдыг өөрсдөөр нь үнэлүүлэх зэргээр ажиллуулж болно.

/Мэдээж, нийтлэг алддаг дүрэм бүхий үгсийг сонгож ажиллах нь зүй/ Жишээ нь, Батын бичсэн эхийг 5 хүүхэд шалгана уу. Шалгахдаа бидний үзэж байсан “ы, ий”-ийг зөв залган бичсэн үгийг сонгоно уу. Яагаад зөв гэж үзэв? гэх мэтээр бичих арга барилыг дэмжсэн асуултыг хэрэглэхийг санал болгосон. Бага боловсролын зорилго бол сурах арга барил эзэмших явдал юм.

4. ТАЙЛБАРТАЙ ДАСГАЛЫН АРГА³ хэрэглэж, сурагч дүрмийн зүй тогтлыг тайлбарлах нь чухал тул багш чиглүүлэх асуултаа тодорхой, оновчтой боловсруулах шаардлагатай юм.
5. Тайлбартай дасгалын аргыг хэрэглэн дүрмийн зүй тогтлыг тайлбарлуулсны дараа АЛДСАН ҮГИЙГ ОРОЛЦУУЛЖ, ӨГҮҮЛБЭР ЗОХИОЛГОХ дасгал ажиллаж, дүрмийн бататгалыг хийнэ.
6. АЛДСАН ҮГИЙГ ОРОЛЦУУЛЖ, цээж бичиг хийх дасгал ажиллана.
7. АЛДСАН ҮГИЙГ ОРОЛЦУУЛЖ, дүрмийн бататгал дасгал хийлгэнэ. Ангийнхаа сурагчдын ямар дүрмийг алдаж байгааг судлах нь чухал. Сурагч өөрийн алддаг дүрэмтэй холбоотой дасгалыг сонгож ажиллахад багш бүр анхаараарай. Энэ нь сурагчийн хэрэгцээн дээр суурилсан хөтөлбөрийн үзэл баримтлалтай холбоотой юм.

Тухайн дүрэмтэй холбоотой үгсийг бүлэглэж, нүдлэх тогтоолгох аргыг хэрэглэх нь бага ангид үр дүнтэй. Хэрэв унших болон ярих чадвар нь таны ангийн хүүхдэд тодорхой хэмжээгээр илэрч байвал дараа дараагийн нэгжийн хичээлийг зохион байгуулахдаа бичих чадварын цагийг ихэсгэж, унших, ярихын чадварыг багасгаж болох юм. Бүтэн жилд эзэмших чадварыг бүхлээр нь харах нь чухал тул хүүхдийнхээ хурд, хүлээн авах чадвар, суралцах явцыг ажиглаад, нэгж бүр дэх унших, ярих, бичих зорилго бүхий хичээлийнхээ цагийг багш зохицуулж болно гэсэн үг. Тиймээс дүрэм дээр тогтож ажиллах шаардлагатай гэж үзэж байгаа бол “бичих зорилготой” хичээлийн дараа 1-2 цаг дан дүрмийн дасгалыг ажиллуулж, гэрт нүдлүүлэх даалгавар өгч болох юм. Хамгийн гол нь нүдэлсэн үгс юугаараа төстэй, ямар дүрмийн дагуу бичигдсэний утга учрыг тайлбарлаж чаддаг байх нь хичээлийн үр дүн болох учиртай.

ЗӨВ БИЧИХ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
2.2а. [н,г] үсгээр утга ялгаж үгсийг зөв унших, нүдлэх, зөв бичих	Алдаагүй зөв бичихдээ: - Утга ялгасан “н,г” гийгүүлэгчийг ялгах үүрэгтэй холбон тайлбарлаж, зөв дуудаж нүдлэх - Утга ялгасан “н,г” зөв бичихдээ эдгээр үгсийг багтаасан эх уншуулах үгийг утгын тайлбар хийлгэх - Онъсого буюу уншсан эхээсээ “га,го” төгсгөлтэй үгийг сонгож зөв унших дасгал даалгавар ажиллах - Харьцуулан заах аргыг ашиглаж тарга-тараг, араг-арга, булаг-булга зэрэг үгийг сонсоод ялгаж бичих - Хэрхэн бичсэнээ тайлбарлана. Утгаараа ямар ялгаатай байгаа тухай харилцан ярилцана.	- Харьцуулан унших үгс: он-оно, сан-сана, тан-тана, баг-бага, булаг-булга, цан-цана, араг-арга - Монгол гэрийн хэрэглэлийн зураг (унь, тооно, багана, хана) хурдан зөв уншуулахад зориулсан үгийн таблец сурах бичгийн хуудас 67-г баяжуулан ашиглах эдгээр үгсийг зөв уншиж бичихэд нь

³ “Тайлбартай дасгалын арга, 50 жил”, ред.С.Жагдал, Уб., 2016 он

	Жишээ нь: - Багны зураг үзүүлээд баг гэж бичих үү? Бага гэж бичих үү? гэсэн асуудал дэвшүүлнэ. Ийнхүү бичсэн утгыг нь ярилцсан үгээ харьцуулан ярилцаад “г” гийгүүлэгчийг хэлэхэд ямар байна? “га,го”-г хэлэхэд ямар байгааг харьцуулан ярилцана, дараа нь бичиж тэмдэглэхэд ямар ялгаа байгааг ярилцана. - Үгийн утганд тулгуурлан хоолойн “г” хэлний “г” ялгаж сурч байгаа учраас өгүүлбэрийг гүйцээж үг сонгож бичих, өгөгдсөн үгэнд тайлбар бичих зэргээр чадварыг нь хөгжүүлж болно. Үүнтэй нэгэн адил хэлний үзүүрийн “н” хэлний угийн “н” ялган харьцуулан заах аргаар таниулана. Үүний тулд: 1. Үгийг сонсоод ялган бичих 2. Ялган бичсэн үгийнхээ хэрэглээний утгыг тайлбарлах 3. Харьцуулан уншсан үгнүүдээрээ өгүүлбэр зохиох 4. Чадваржуулах зорилгоор зураг, үгийн утгыг тайлбарлан өгүүлбэр зохиож бичих дасгал ажиллах	анхаарах - Зөв бичих дүрмийн лавлах, загвар - Тарааж өгөх материал, төрөл бүрийн нөхөх болон сонгох, тохируулах, бүлэглэх гэх мэт сорил даалгавар, төрөл бүрийн үзүүлэн
2.26. Эр, эм үгэнд “ы, ий” залгаврыг зөв залган бичих	Алдаагүй зөв бичихдээ: - Эр, эм үгийг эгшгийн тусламжтайгаар ялган бүлэглэх. - Бүлэглэхдээ хичээлийн хэрэглэлүүдийг эр, эм үгээр нэрлэн бүлэглэх ажлыг хийж болно. 1-р алхам Дан эр эгшигтэй үгнүүдийг ялгаж сурах. Ялгахдаа өнгөөр зурах, эр эгшгүүдийг нөхөж бичих үг өгүүлбэр дэх эр эгшгийн давтамжуудыг тодорхойлох. 2-р алхам Эгшигтэй үгийг дээрх байдлаар ялгаж тэмдэглэх, түүнчлэн үг бичихдээ тодорхой сэдвийн хүрээнд үг олж бичнэ. Тухайлбал ах дүү садан төрлөө ам бүлээ нэрлэх, төл малыг нэрлэх гэх мэт. 3-р алхам Эр, эм, саармаг эгшиг холилдон орсон жишээ үгэн дээр ажиллах. Жишээлбэл: бөжин, ишиг, эгшиг, гийгүүлэгч, алим гэх мэт үгсийг ажиглан эр үг үү?, эм үг үү? гэсэн асуулт тавих, хариулж байгаа тохиолдолд яагаад гэсэн асуулт тавьж ярилцах. “И” эгшиг эр ба эм эгшигтэй холилдон орно гэсэн ч саармаг үг гэхгүй эр эм үг гэж 2 ангилахыг тайлбарлан таниулна. Жишээ нь “бөжин” гэдэг үгэнд эм эгшиг “бө” саармаг эгшиг “и” орсон эм үг, “ажил” гэсэн үгэнд “а”- эр эгшиг “и”- саармаг эгшиг орсон эр үг гэж тодорхойлно. Эр үгийн “ы” эм үгийн “ий”-г заахаасаа өмнө “и”-ийн урт эгшгүүдийг сэргээн сануулах хэрэгтэй. Туслах эгшиг “ы” нь “и”-ийн урт эгшиг бол “й” бол “и”-гийн хагас дуудлага байна гэдгийг нүдэлж тогтоолгох арга таниулна. Түүнчлэн урт эгшгийг давтах үедээ “а”-ын урт эгшгийг 2 “аа”-аар тэмдэглэдэг түүнтэй адил “и”-ийн урт эгшгийг 2-“ий”-ээр хэлбэрээр тэмдэглэдэг, сүүлийн “и” эгшгэн дээр зартиг тавьдгийг тайлбарлан ойлгуулж, “и”-ийн урт эгшиг 2 хэлбэртэй байдгийг тайлбарлан ойлгуулж нүдэлж тогтоолгоно. Ингэж тогтоолгохдоо “ы”-тэй хэсгийг ялган бодох, “ы”-тэй үгийг зохиолоос түүвэрлэн бичих. Дээрх үйл ажиллагаанууд нь “и”-ийн урт эгшиг 2 хэлбэртэй байдгийг ойлгож үүний дараа тодорхой үгнүүд дээр ажиглалт хийлгэж сурагчаар дүгнэлт гаргана, үүний тулд дараах алхмуудыг хийнэ.	- Бүлэглэж төрөлжүүлсэн үзүүлэнгүүд. Жишээ нь: (сургуулийн, эгшгийн, баллуурын, дэвтрийн, нумны, харандааны, будгийг, шугамны, аймгийн, ангийн, найзын, ээжийн, аавыг, удмын, намрын, самрын, нагачын, авгын, сурагчийн, хургын, ботгоны, азарганы,) гэх мэт. - Хүснэгтийн аргаар бүлэглэх загвар - Дэвтрийн нүүрний загвар - Слайдаар бүлэглэхэд зориулсан баримтын эх байх, - (сургуулийн тухай, анкет, дэвтрийн нүүр, гэр бүлийн танилцуулга) - “ы, ий”-г улаанаар бичсэн карт байх, энэхүү картыг багш үг хэлэхэд ямар “и” залгах вэ? гэдгийг картаа өргөж үнэлүүлэх юм.

	1-р алхам: Эр, эм үгэнд “ы,ий” залгаж бичсэн баримтын эх уншуулж урт “ий” эгшигтэй үгийг ялгуулна (эр үгэнд эм үгийн “ий” залгасан тохиолдлыг энд авч үзэхгүй) 2-р алхам: “ы,ий”-г үгэнд хэрхэн залгаж бичихийг тайлбарлах хүртэл сургуулийн, дүүргийн, удмын, хуваарийн гэх мэт үгсийг нүдлүүлэн цээжлүүлж болно. “ы,ий” залгасан үгсээ 2 бүлэг болгож хуваахыг хүүхдүүдэд санал болгоно. 3-р алхам: “ы,ий”-г ямар эгшигтэй үгэнд залгасан байна вэ гэж асууна. 4-р алхам: Дээрх 3 алхмын үр дүнд буй болсон мэдлэгээ хэрэглэх зорилгоор өөрийнхөө нэр, амьдардаг дүүрэг, сургууль, гэр бүлийн гишүүд, хүүхэлдэйн киноны баатрууд, таван хошуу малын нэр зэрэгт “ы,ий”-г залгаж бичих даалгавар өгнө. 5-р алхам: Зарим нэг үг тухайлбал мэргэжлийн үг бүлэглэхдээ “ы,ий”-г залгуулж эр үг мөртлөө зарим нэг үгийн төгсгөлөөс хамаарч эм үгийн “ий”-г залгаж бичдэгийг олон жишээ үгийн тусламжтайгаар нүдлүүлнэ. Жишээлбэл: тогоочийн, багшийн, жолоочийн гэх мэт, харин багш энэ үед “ж, ч, ш, ь, и, г”-ээр төгссөн эр үгэнд “ий” бичдэгийг учир зүйн үүднээс таньдаг байх хэрэгтэй. Тухайлбал нутаг гэдэг үгний “г” араасаа эр үгийн “ы” авбал хоолойн “г” гийгүүлэгч болж хувирна, тиймээс утга ялгах зорилгоор “г”-ээр төгссөн эр үгэнд “ий”-г бичдэгийг мэддэг байх. Дан буюу давхар зөөлөрсөн гийгүүлэгч мөн адил утга ялгах зорилгоор араасаа “ий”-г дагуулж байгааг мэддэг байх ёстой. Харин “ж,ч,ш” бол ямагт зөөлөн хэлэгддэг гийгүүлэгч учраас “ий” бичдэг байна.	- Жишээлбэл: багш богино хэмжээний үлгэр унших явцад “и” эгшигтэй үг тохиолдох бүр сурагч “и”-ийн 2 хэлбэрийн урт эгшгийг аль нэгийг өргөж харуулах юм.								
2.2в. Үгийг үеэр таслан мөр шилжүүлж зөв бичих	Зөв бичих дүрмийг ойлгохдоо: - Үеэр үг бүтээж унших, бичих - Үеийн тухай тайлбарлах - Задгай ба битүү үеийг ялгах - Үгийг үеэр зөв зааглах Эхийг уншаад хүснэгтийн дагуу үеэр зааглан бичих дасгал хийх, хэрхэн зааглаж бичсэнээ тайлбарлан ярих Салхитай тэнгэрийн үүл нэг хурдан Саруул ухаантны санах нэг хурдан Сайн морины явдал нэг хурдан <table><tr><td>1 үетэй үг</td><td>2 үетэй үг</td><td>3 үетэй үг</td><td>4 үетэй үг</td></tr><tr><td>нэг</td><td>хур-дан</td><td>тэн-гэ-рийн</td><td>са-наа-тан-тай</td></tr></table> Сурах бичигт үеэр тасалж сургах зорилгоор 1-р ангид үзсэн үеийн тухай ойлголтыг давтах, эгшгийн тоогоор үг үелэгддэгийг ойлгуулахын тулд эхлээд үгэн дэх эгшгийг тоолж тооцоолох, түүнчлэн үеийн заагт хэдэн гийгүүлэгч байгааг тооцоолж сурах, харин хэрэглэгдэхүүн сонирхолтой эх байх. Тухайлбал: 1. Шувуунд шүд байдаг уу? Яагаад? 2. Пингвин шувуу мөн үү? 3. Шувууг будаанд дуртай гэж хэлэлцдэг.	1 үетэй үг	2 үетэй үг	3 үетэй үг	4 үетэй үг	нэг	хур-дан	тэн-гэ-рийн	са-наа-тан-тай	ТОГЛООМЫН КАРТ
1 үетэй үг	2 үетэй үг	3 үетэй үг	4 үетэй үг							
нэг	хур-дан	тэн-гэ-рийн	са-наа-тан-тай							

	Ямар учиртай вэ? зэрэг асуултад хариулж бичихдээ шувуу-у, уу гэсэн 2 эгшигтэй учир 2 үе болно, шүд- ү гэсэн 1 эгшигтэй, 1 үе болно, ...яагаад - яа,аа гэсэн 2 урт эгшигтэй, 2 үе болно. Үеэр зааглахдаа эгшгүүдийг заагласан гийгүүлэгчийг тоолж, хамгийн сүүлийн гийгүүлэгчийн өмнүүр зааглах аргыг ажиглуулж, дуурайн зааглах, улмаар олон дахин давтан үйлдсэнийхээ дүнд зааглаж сургана. Үеэр зааглаж сурсны дараа нэг эхийг үеэр зааглаж, шинэ мөрд шилжүүлсэн 3 тохиолыг үзүүлж ажиглуулна. Ажиглахдаа багтахгүй үгийг шинэ мөрд үеэр таслан шилжүүлдгийг ойлгоно. Бичгийн эх дээр удаан ажиллахад хүүхэд залхдаг учир бас тоглуулна. Сурах бичиг дээр 10 см-ийн хуваарьтай цаас эсвэл шугам ашиглан үгийг байрлуулан багтахгүй бол шинэ мөрд шилжүүлэх тоглохыг зааварчилсан байгаа.	
Багшийн анхаарах зүйл: <i>Амьсгалын нэг түрэлтээр хэлэгдэх нэг буюу хэд хэдэн авиаг үе гэнэ. Үгэнд хэчнээн эгшиг байна, түүний тоогоор үелнэ. Жишээ нь: өгүүлбэрийнхээ 5 үе, үеэр тасалж мөрд шилжүүлэх 3 боломж байна (өгүүл-бэрийнхээ, өгүүлбэ-рийнхээ, өгүүлбэрийн-хээ). Бүтцийн хувьд Э(ай\раг), ЭГ,ГЭ(ах\мад), ГЭГ(мод), ЭГГ(эгч\тэй), ГЭГГ(су-рагч), ЭГГГ(элст), ГЭГГГ(төрөлхт\ний) 8 бүтэц бий. Тэгэхдээ бага ангид Э,ГЭ, ЭГ, ГЭГ гэсэн 4 үеийг онцлон ойлгуулж эдгээр бүтцээр үгийг үеэр таслуулан бүлэглэнэ.</i>		
2.2г. Цагаан толгойн үсгийг эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсэг гэж ангилж, бүлэглэх	Цагаан толгойн үсгийг эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсэг гэж ангилж, бүлэглэхдээ:  <pre> graph LR A[35 үсэг] --- B[20 гийгүүлэгч] A --- C[2 тэмдэг үсэг <math>\langle\mathbf{ь,э}\rangle</math>] A --- D[13 эгшиг] B --- E[9 заримдаг гийгүүлэгч
 (цоожоо засаад тушаачих)] B --- F[7 эгшигт гийгүүлэгч
 (монгол баавар)] B --- G[4 онцгой гийгүүлэгч
 (к,л,ф,ц)] D --- H[7 үндсэн эгшиг
 (а,о,у,и,э,я,ү)] D --- I[6 туслах эгшиг
 (я,е,ё,ю,й,ы)] </pre> - Эгшиг авиаг эр, эм эгшгээр нь ялгаж бүлэглэх - Өнгөөр болон зураасаар ялгаж тэмдэглэх - Гийгүүлэгч авиаг эгшигт гийгүүлэгч, заримдаг гийгүүлэгч, онцгой дөрвөн гийгүүлэгч гэж 3 бүлэг болгон тогтоолгохдоо: - Эгшигтэй бичигддэгийг нь эгшигт гийгүүлэгч, заримдаа эгшигтэй заримдаа эгшиггүй бичигддэг гийгүүлэгчийг нь заримдаг гийгүүлэгч гэнэ. - Мөн учир шалтгааны тайлбар хийлгүйгээр тулгуур үг ашиглан нүдлэн тогтоолгоно. (Монгол баавар- эгшигт гийгүүлэгч, цоожоо засаад тушаачих-заримдаг гийгүүлэгч) - Үгэн дэх гийгүүлэгч авиануудыг бүлэглэх ажил хийлгэнэ. Тухайлбал: - Орхигдсон гийгүүлэгчүүдийг нөхөөд эх бүтээж түүнийгээ унших үсгүүд дотроос ялган бүлэглэх - Улмаар үгсийг дан эгшигт гийгүүлэгч, дан заримдаг гийгүүлэгчтэй үг гэх мэтээр ялгах жишээлбэл: ангийнхаа хүүхдийн нэрүүдийг бүлэглэх, ам бүлийнхээ нэрийг бүлэглэх, мэддэг гол мөрөн, уул ус, хот дүүргээ бүлэглэх зэргээр нэмэлт ажлууд өгч болно.	- Цагаан толгойн үсгийн дараалал бүхий карт - Үсэг нэг бүрээр карт хийх (үсэг нэг бүрээр хийсэн карт улаан,цэнхэр,ногоон, хар гэсэн 4 өнгөтэй байна.) - улаан-эгшиг, - цэнхэр-эгшигт гийгүүлэгч, - ногоон-заримдаг гийгүүлэгч, - хар-онцгой дөрвөн гийгүүлэгч гэх мэт.

Багшийн анхаарах зүйл:

Эх, өгүүлбэрийг дэгийн дагуу бичүүлж сургахдаа дараах аргыг хэрэглэж болно.

Хоёрдугаар ангийн хүүхдийн бичгийн хэв элемэнтэн дэвтэрт сайтар жигдэрсэн байдаг ч тууш дэвтэрт шилжихээр үсгийн харьцаа, хэмжээ алдагдаж бичгийн хэвэнд өөрчлөлт ордог учраас хүүхэд бүрийн бичих хурд, үсгийн холбоос, үг хоорондын зай, том жижиг үсгийн харьцаа, хэмжээ, хичээнгүй, сайхан бичиж байгаа эсэхийг багш ажиглаж, туслах хэрэгтэй. Үүний тулд дараах аргаас хэрэглэж үзээрэй.

1. Тодруулан бичих арга

2 дугаар ангид сурагчдын дэвтэрт үсэг үгийг цэглэн тэмдэглээд түүний дээгүүр дагуулж бичүүлдэг нэгдүгээр ангийн сурагчдад хэрэглэдэг аргыг хэрэглэж болох юм. Ингэхдээ энэ загвараа том цаас, самбар дээр багш дагуулан хийж эхлэл, үргэлжлэл, төгсгөлийг хаана яаж хийхийг нарийн зааж өгөх, агаарт дагуулан бичих зэргээр бэлтгэх хэрэгтэй. Мөн багш сурагчийн дэвтэрт үсэг, үг, өгүүлбэрийг балын харандаагаар бичиж, дээгүүр нь дагуулан бичүүлж болно. Зарим багш нар тусгайлан бичсэн бичвэр дээр калькан цаас тавьж, мөн тодруулан бичүүлдэг туршлага байдаг.

2. Дуурайн бичих

Үлгэр жишээ бичлэг харан дуурайж бичүүлдэг. Мөн багш өөрөө хичээнгүй бичсэн бичлэгээ хувиан слайд хийж дуурайн бичих, давхарлан бичих тарааж өгөх материал бэлтгэж өгч болно.

3. Төрөлжүүлэн бүлэглэх арга

Үсгийг зурлагын ижил төстэй байдлаар төрөлжүүлж хөнгөнөөс хүндрүүлэх замаар ялган хуваагаад бичиг сайжруулах дасгал хийлгэх арга юм.


Цэвэр, нямбай бичих үйлийг удирдахдаа сурагчдад зөв суух, дэвтрээ зөв байрлуулах, үзгээ зөв барьж бичих дадал эзэмшүүлэхэд байнга анхаарах хэрэгтэй. Үг, өгүүлбэрийг бичихэд үсгийн холбоосыг зөв бичиж сургахад анхаарна. Ялангуяа, эгшгийн дараа “л” үсгийг бичихдээ дараагийн үсэгт шууд залгахгүй, тусгайлан эхлэлтэй бичдэгийг онцгой анхаарах хэрэгтэй.

Зөв бичүүлж сургах. Сурагчдыг зөв бичиж сургахад тэдний сонсох ба харах эрхтэн, гар хурууны зөв хөдөлгөөн, зөв суулт зэрэг нь чухал ач холбогдолтой. Буруу ойлгосон, эсвэл буруу бичиж сурсных нь дараа засах нь шинээр заахаас хэд дахин илүү төвөгтэй хэцүү байдаг.

ЗОХИОН НАЙРУУЛЖ БИЧИХ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
2.2д. Багшийн хэлсэн 5-6 өгүүлбэрийг сонсож, цээжээр бичих	Багшийг хэлсэн 5-6 өгүүлбэрийг сонсож, цээжээр бичихдээ: - Багшийн хэлснийг анхааралтай сонсох - Ямар утгатай өгүүлбэр болохыг ойлгох - Амандаа давтан хэлэхгүйгээр холбоо үг болон бүтэн өгүүлбэрээр тогтоон бичих - Эр, эм үгэнд “ы, ий” залгаврыг зөв залган бичих - Хэлэх аялгыг анзаарч өгүүлбэрийг том үсгээр эхэлж, төгсгөлд нь цэг, зэрэгцсэн хоёр үгийн дунд таслах бичих - Бичсэнээ шалгаж, нягтлах	- Утгын холбоо бүхий энгийн өгүүлбэрүүд
2.2е. Өгсөн бүтцийн дагуу мэндчилгээ бичих	Мэндчилгээ бичихдээ: 1. Хүмүүсийн бичсэн мэндчилгээ болон сонин сэтгүүл номоос мэндчилгээ олж уншиж, ойлгох 2. Мэндчилгээний бүтцийг ажиглах 3. Бичихийн тулд мэндчилгээнийхээ зорилгоо тодорхойлох (баяр хүргэх, сайн сайхныг ерөөх) 4. Хэн нэгэнд зориулж бичих (бүх хүнд эсвэл хэн нэгэнд зориулан бичнэ.) 5. Мэндчилгээ бичсэн хүн болон хамт олны нэрийг бичих 6. Он сар өдрөө бичих 7. Бичсэн мэндчилгээгээ хянах, сайжруулах 8. Сайжруулсан мэндчилгээгээ эцэслэж бичих 9. Бичсэн мэндчилгээгээ хүмүүст хүргэх	- Зурган эх, - Хэнд, ямар зорилгоор бичсэн эсэх, хэн, хэзээ бичсэн эсэхийн аль нэгийг гүйцээж бичих загвар - мэндчилгээний загвар хуудас

	Мэндчилгээ бичихдээ ашиглах үгс: баярын, өдрийн, мэнд хүргэе, аз жаргал, эрүүл энх, ажлын амжилт, хүсэн ерөөе, хүсье - Заавал байх хэсгүүдийг нь (эхлэл хэсэгт -хэнд зориулж бичих, гол хэсэг-мэндчилгээ бичиж байгаагийн учир төгсгөл хэсэг- бичсэн хүний нэр, он сар өдөр) орхигдуулсан мэндчилгээг гүйцээн, нөхөж бичих дасгал даалгавар ажиллах	
2.2ж. Өгсөн бүтцийн дагуу болсон явдлаа ойлгомжтой бичих	Болсон явдлаа ойлгомжтой бичихдээ: Сэдвээ сонгох 1. Өөрт тохиолдсон болсон явдлаа санах 2. Тохиолдсон явдлуудаа жагсаан бичих 3. Бичсэн жагсаалтаасаа өөрт таалагдсан нэгийг сэдвээ болгон сонгох 4. Юуны тухай бичихээ өөрийн хүсэл, мэдрэмж, төсөөллөөр дүрслэн зурах Эхээ бичих 1. Зурсан зургаасаа сэдэвлэн эхээ зохион бичих 2. Бичих дарааллаа төлөвлөх - Эхлээд юу болсон бэ? - Цааш нь яасан билээ? - Юу болж төгссөн билээ? гэсэн асуултыг өөртөө тавьж бичих зүйлийнхээ дарааллыг олно. 3. Амьтдад тохиолдсон сонирхолтой явдлыг санах 4. Өөрт тохиолдсон явдалтайгаа харьцуулах 5. Төлөвлөснөө үйл явдлын дагуу ноороглон бичих Эхээ сайжруулан бичих 1. Нооргоо засан сайжруулах 2. Зөв бичгийн алдаа болон найруулгыг алдаа гаргасан эсэхээ өөрөө болон бусадтай хамтран хянаана. 3. Алдсан үгийн дүрмийг тайлбарлах, бусадтайгаа ярилцах 4. Алдсан үгээ зөв болгон бичих, төлөвлөгөөгөө дахин хичээнгүй бичих 5. Хэн нэгэнд уншиж өгөх, зөвлөгөө авах	- Өөртөө тохиолдсон явдлыг бичиж сурахын тулд сэдвийг зөв оновчтой сонгож сурах зорилгоор 2-р ангийн хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан хөгжилтэй, сонирхолтой, үйл явдал бүхий зохиолуудыг сонгосон байна. Жишээ нь: - “Гаварт тохиолдсон явдал”, - “Хулганад тохиолдсон явдал” эдгээр зохиолуудаас сэдэвлэн өөрт тохиолдсон явдлаа сэдвээ сонгож сурна.
2.2з. Өгсөн бүтэц зааврын дагуу баярлаж талархсанаа илэрхийлсэн талархал бичих	Талархал бичихдээ: 1. Хүмүүсийн бичсэн талархал, сонин сэтгүүл номоос талархал олж уншиж, ойлгох 2. Талархлын бүтцийг ажиглах 3. Бичихийн тулд юуны учир талархаж байгаа зорилгоо тодорхойлох (талархлаа илэрхийлье) 4. Хэнд талархаж бичиж байгаа эсэх (бүх хүнд эсвэл хэн нэгэнд зориулан бичнэ.) 5. Талархлаа илэрхийлсэн хүн болон хамт олон нэрээ бичих 6. Он сар өдрөө бичих 7. Бичсэн талархлаа хянах, сайжруулах 8. Сайжруулсан талархлаа эцэслэж бичих 9. Бичсэн талархлаа хүмүүст хүргэх Талархлаа бичихдээ ашиглах үгс: баярлаж талархсанаа, чин сэтгэлээсээ, амжилт хүсье, баярлалаа, илэрхийлье Заавал байх хэсгүүдийг нь (эхлэл хэсэгт -хэнд зориулж бичих, гол хэсэг-хэн нэгэнд талархаж бичсэн сэтгэлийг үг, талархаж байгаагийн учир,төгсгөл хэсэг- бичсэн хүний нэр, он сар өдөр) орхигдуулсан талархлыг гүйцээн, нөхөж бичих дасгал даалгавар ажиллах	- Зурган эх, - Хэнд, ямар зорилгоор бичсэн эсэх, хэн, хэзээ бичсэн эсэхийн аль нэгийг гүйцээж бичих загвар, - талархлын загвар хуудас

2.2и. Сэдэвт болон цуврал зурийн дагуу утгын холбоотой 4-5 өгүүлбэр бүхий эх зохиох	- Утгын холбоотой 4-5 өгүүлбэр бүхий эх зохиолгож сургахын тулд өгсөн зургаас үйл явдлын дарааллыг тодорхойлох - Зургаас ажигласан үйл явдлаа хэн нэгэнд ярьж өгөх, бусдын ярьсныг нь сонсож санаагаа болон үйл хөдлөлийг баяжуулах - Үйл явдлын дарааллын дагуу 4-5 өгүүлбэр бүхий эх зохиох - Эцэст нь өөрийнхөө бичсэн эхийг хянаж засан сайжруулах - Зөв бичгийн дүрмийн алдаа гаргасан эсэхээ багштайгаа хамтран хянах - Алдсан үгийн дүрмийг тайлбарлах, бусадтайгаа ярилцах - Алдсан үгээ зөв болгон бичих, төлөвлөгөөгөө дахин сайжруулан бичих - Хэн нэгэнд уншиж өгөх, зөвлөгөө авах Бататгал болгож цуврал зургууд дээр ажиллуулж сургана. Бичихээс өмнө эдгээр үйл ажиллагаанд чадваржуулхаас гадна үйл явдлыг төсөөлөн бодож, ярьж зурж чаддаг болох. Жишээ нь: Сурах бичиг дэх “Бяцхан хулгана” үлгэрийг уншхаасаа өмнө зургийг ажиглаад төсөөлөн бодох даалгавар өгнө. Дараа нь цуврал зургийн дарааллыг ашиглан утгын холбоотой 4-5 өгүүлбэр бүхий эх зохионо.	Янз бүрийн үлгэрийн зохиомж бүхий цуврал зургууд болон сурах бичиг дэх үйл явдал бүхий цуврал зургууд  
2.2к. Ертөнцийн гурвын хэлбэрийг дуурайн зохиож бичих	- Ертөнцийн гурвыг ухаарч унших - Дараалал тогтоох арга болон цээжилж тогтоох аргыг ашиглан тогтоох - Цээжилснээ шалгах, загвар ашиглан зохиож бичнэ. - Дуртай ертөнцийн гурваа зохиох - Дуурайж зохиох - Багшийн санал болгосон сэдвээр зохиох (Сурах бичгийн 56-59)	- Нөхөх, дуурайх зохиох, загварууд - Ертөнцийн гурав
2.2л. Зааврын дагуу гэр бүлийн танилцуулга бичих	- Өөрийнхөө тухай танилцуулж ярих - Бусдын ярьсантай харьцуулах, дэлгэрүүлж бичих - Загвар ашиглан анкет бичих, номын сангийн карт бөглөж сурах, ном захиалах - Ураг төрлөө нэрлэж сурах - Зураг ашиглан гэр бүлийн танилцуулга хийх - Гэр бүлийн танилцуулга хийхдээ зорилгоос хамаарч төлөвлөлт хийх, мэдээлэл цуглуулах - Танилцуулга бичих, танилцуулах, бусдын санааг сонсох зөвлөлдөх - Хянах, засвар хийх, засвар хийхдээ тэмдэглэгээ, өнгийн харандаа бал ашиглах	- Ургийн мод - Гэр бүлийн зураг - Анкетын загварууд

Багшийн анхаарах зүйл:

Янз бүрийн зорилгоор эх бичих: Хоёрдугаар ангид янз бүрийн зорилгоор талархал, мэндчилгээ, заавар, танилцуулга зэргийг бичнэ. Мөн оньсого, үлгэр, ертөнцийн гурав зэргийг бичнэ.

Ямар ч эхийг зохиож бичихдээ:

1. Юу бичих зүйлээ баримжаалдаг, төсөөлдөг байх үйл ажиллагаанд сургана.
2. Бичих зорилгоо тодорхойлж хэнд юуны тухай бичих гэж байгаагаа урьдчилан боддог байх.
3. Зорилгоосоо хамаарч ямар үг хэллэг хэрэглэж болох, түүнийгээ жагсаан бүлэглэн бичих аргаар үг хэллэгийн сонголтдоо хийнэ.
4. Бичих зүйлээ төлөвлөн, төлөвлөгөөний дагуу бичихдээ учир шалтгааны дараалалтай бичих, бичсэн зүйлээ хэн нэгэнтэй хуваалцах.
5. Бусдын санал зөвлөмжийн дагуу засаж сайжруулан, эцэст нь бусдын санал зөвлөмжийн дагуу зассанаа зөв болгож сийрүүлэн бичнэ.

ГУРАВ. СОНСОХ- ЯРИХ ЧАДВАР

Нэгж хичээл бүрд УНШИХ, БИЧИХ чадварыг эзэмшүүлэх ээлжит хичээлийн үйл ажиллагаатай уялдуулан тод чанга, ойлгомжтой, бүтэн өгүүлбэрээр, тодорхой ярих гэсэн шаардлагыг багш тавина.

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
2.3а. Болсон явдал, сонссон зүйлийг ойлгомжтой мэдээлж ярих	<i>Өөрт болсон явдлаа бусдын өмнө ойлгомжтой ярихдаа:</i> - Бусдад тохиолдсон явдлыг сонсох, унших, таамаглан хэлэх, харилцан ярилцах - Хэзээ ч мартагдахааргүй, сэтгэл хөдөлгөсөн, ховор, азтай, ухаарсан тохиолдлууд эсвэл өдөр тутам тохиолдсон явдлаасаа нэгийг сонгон тэмдэглэх - Өөрт тохиолдсон явдлыг ярихад бэлтгэх Ярихын тулд үйл явдал, цаг хугацааны дарааллын дагуу төлөвлөгөө гаргах - Эхлээд яасан? - Дараа нь яасан? - Төгсгөлд яасан? гэсэн асуултын дагуу ярих - Хэзээ, хаана юунаас болж юу болсныг мэдээлж ярихад бэлдэх - Бэлдсэнээ самбарын өмнө, эсвэл тойрч зогсоод бусдын өмнө тодорхой ярих - Ярьснаа эргэн хянах, тодорхой байж чадсаныг үнэлэх, бусдын дэмжих <i>Сонссон зүйлээ бусдын өмнө мэдээлж ярихдаа:</i> - Багшийн уншсан үлгэрийн үйл явдлыг анхааралтай сонсох - Сонсоод, асуултад хариулж утгыг ярилцах - Баатруудын хийсэн үйлийг тоочиж бичээд, юу юу болсныг хосоороо хэлэлцэх - Хэлэлцсэнээ бусдын өмнө ойлгомжтой ярих Ярьснаа эргэн хянах, ойлгомжтой байж чадсаныг үнэлэх, бусдыг дэмжих	- Тохиолдсон явдлаа учир шалтгаантай илэрхийлж бичсэн бичвэр - Самбарын өмнө, цэх, өөртөө итгэлтэй, ангийнхан руугаа харж зогсож байгаа хүүхдийн зураг байж болно - Эсвэл өөртөө итгэлгүй, доошоо харсан, биеэ барьж зогссон хүүхдийн зураг байж болно - Сонсгох үлгэр
Багшийн анхаарах зүйл: Болсон явдлаа өөртөө итгэлтэй зөв, тод, ойлгомжтой мэдээлж ярих: Ярих чадвар нь унших, бичих, сонсох чадвартай салшгүй холбоотой бөгөөд сайн ярьж байгаа нь ойлгож ухаарсны үр дүн гэж сэтгэлзүйн судлаачид хэлсэн байдаг. Ярих чадварыг нэмэгдүүлэхийн тулд уншаад ойлгосноо ярих, сонсоод ойлгосноо ярих, бичээд ойлгосноо ярих үйл ажиллагааг сургалтын явцад байнга зохион байгуулах хэрэгтэй. Энэхүү суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхдээ 2 өөр үйл ажиллагаагаар хэрэгжүүлж болно. Эхлээд өөрт болон бусдад тохиолдсон үйл явдлыг дарааллын дагуу яриулаарай. Ингэхдээ сэтгэл хөдөлгөөм ямар үйл явдал тохиолдсоныг эсвэл хэзээ ч мартагдахааргүй, ховор, аз таарсан, эсвэл азгүй, бас ухаарч явмаар тохиолдлуудыг яриулахдаа үйл явдлаа мэдээлж, ойлгомжтой яриулахад анхаараарай. “Тэр үед тохиолдсон юм. Тэгэхэд би..... байсан. Ингэсэн нь надад ингэж бодогдож байсан. Би ч гайхсан” гэх зэрэг үг хэллэгийг хэрэглэхийг санал болгож болно. “Яасан байхгүй юу, юу л даа, нөгөө” гэх мэт сул үг хэрэглэхгүй байх, “тэгээд, тэгээд”, “тэгсэн чинь, ингэсэн чинь” олон дахин давтаж ярихгүй байхыг сануулах хэрэгтэй. Үнэлгээний шалгуурт ч оруулж тооцож болно. Энэхүү чадварыг эзэмшсэнийг шалгах үнэлгээний шалгуурыг дараах байдлаар боловсруулж болно. - Өөртөө тохиолдсон явдлаа ярихдаа үйл явдлын дарааллаар ярьж байна уу? Дарааллын дагуу ярихын тулд: Ярих зүйлээ төлөвлөх - Зургаар төлөвлөх		

- Асуултаар төлөвлөх
- Хэсгүүдэд гарчиг өгч төлөвлөх
- 2. Бусдын өмнө гарч, өөртөө итгэлтэй, тод дуугаар ойлгомжтой ярьж байна уу? Ойлгомжтой гэдэгт дараах зүйлийг харгалзана. Үйл явдлын дараалал.
- Сонссон үлгэрийнхээ үйл явдлыг тодруулахдаа дараах шалгуурын дагуу яриулахад сургана.
- 1. Үлгэрийнхээ баатруудын хийсэн үйлдлийг сайн мэдэж байна уу?
- 2. Баатруудын хийсэн үйлдлүүдийг ойлгогдохоор ярьж байна уу?

Ярихдаа бусдын өмнө ойлгомжтойгоор, ярьж илэрхийлж чадаж байна уу? Ойлгомжтой гэдэгт дараах зүйлийг харгалзана. Баатруудын үйл хөдлөл тэдгээрийн дараалал.

2.36. Бусдын яриа, асуулт, зааврыг анхааралтай сонсож, ойлгосноо харуулах	- Багшийн өгсөн асуултыг анхаарч унших - Уншиж байгаа эхийг анхааралтай сонсох - Сонсохдоо асуултын хариулт сонсож байгаа эхэд байгаа эсэхийг анхааран сонсох - Ойлгомжгүй болон сонирхсон, мэдэхийг хүссэн зүйлээ тодруулан асуух замаар анхааралтай сонссоноо илэрхийлэх - Бусдыг сонсож, ээлж дараагаар асуултаа тавих - Асуултын хариултын талаар өөрийн санал бодлоо нөхөдтэйгөө хуваалцах - Асуултын зөв хариултыг олж тэмдэглэх - Асуултын дагуу хос хосоороо ярилцаж хамгийн зөв хариултыг олох	- Сонсох буюу үзэх бичлэг - Асуулт, хариултын хувилбар - Эх, асуулт бүхий хуудас - Хамтран ажиллах үйлийн болон сэтгэл зүйн орчныг бүрдүүлэх
---	--	---

Багшийн анхаарах зүйл:

Хоёрдугаар ангийн сурагчдын хувьд багаар ажиллах чадвар дутмаг байдаг. Багаар ажиллах чадварт сургах эхний алхам нь хос хосоороо ажиллах юм. Сурагчдын сонсох-ярих чадварыг хөгжүүлэхэд хосоор ажиллах нь илүү үр дүнтэй гэж үзэж байна. Багшийн гол үүрэг бол тухайн даалгаврыг хэрхэн гүйцэтгэх зааврыг сайн ойлгуулах. Багаар ажиллаж байх үед багш сурагчдад саад болохгүй байхыг хичээх хэрэгтэй. Учир нь багшийг ойр байх үед сурагчдын чөлөөтэй сэтгэх, үйл ажиллагаанд оролцох оролцоо нь буурдаг гэж судлаачид үзсэн байдаг. Өөрөөр хэлбэл юуг хэрхэн яаж хийх нь ойлгомжтой бол сурагчид өөрсдөө үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно. (Тоглоомын дүрэм тодорхой байх)

Зарим нэг үйл ажиллагааг зохион байгуулахад сурагчдын ялгаатай байдлыг тооцох нь зүйн хэрэг юм.

Асуултад хариулахын тулд эхийг унших үйл

Сурагчид асуултын хариултыг олохын тулд эхийг бүхэлд унших хэрэгтэй болно. Ингэснээр сурагчдын уншлага зорилготой болж байгаа бөгөөд асуултад оновчтой хариулах нэг үндэс болно.

1. Асуултын хуудсыг унших

Асуултын хуудас

- Үлгэрт хэдэн амьтан гарч байна вэ?
- Уралдааны гараа, бариаг ямар амьтан товлож тогтоосон бэ?
- Үлгэрт юуны тухай өгүүлсэн бэ?
- Үлгэрийг уншаад юу ухаарсан бэ?
- Үлгэрийн эхлэл, гол, төгсгөл хэсэгт нэр өгөөрэй.
- Яст мэлхий, туулай хоёрын дүрийг харьцуулан яриарай?
- Яст мэлхий яагаад туулайтай уралдвал түрүүлнэ гэж боддог байсан бэ?
- Яст мэлхий, туулай хоёр уралдааны зам сонгох, гараа бариаг товллохдоо яагаад үнэгийг урьсан бэ?
- Туулай унтаагүй байсан бол яст мэлхий “- Чи хэдий салхи шиг хурдан ч би чамтай уралдвал түрүүлэхдээ л түрүүлнэ” гэж хэлсэн үгэндээ хүрч чадах байсан уу? Яагаад?
- Хэрвээ чи TV-ийн сурвалжлагч байсан бол уралдааны дараа яст мэлхий, туулай, үнэг гурваас ямар асуулт асуух байсан бэ?
- Асуултаа төлөвлөөрэй.

Яст мэлхий, туулай хоёр (үлгэр)

Нэг туулай “Явж бүтдэггүй, мөлхөж барагддаггүй удаан амьтан” гэж яст мэлхийг үргэлж шоолно. “- Чи хэдий салхи шиг хурдан ч би чамтай уралдвал түрүүлэхдээ л түрүүлнэ” хэмээн яст мэлхий инээд алдан хариулдаг байжээ. “Энэ бол бүтэшгүй хэрэг” гэж туулай бодоод яст мэлхийтэй уралдахыг зөвшөөрчээ.

Хоёул хэлэлцэн үнэгийг урьж, уралдах замаа сонгуулаад уралдааны бариа гараагаа товлон тогтжээ.

Уралдах өдөр болж тэд гараанаасаа зэрэг хөдөллөө. Яст мэлхий хором ч зогсолгүй алгуур шийдмэг алхаагаар барианы зүг урагшилна. Харин туулай хурдан хөлтэй төрсөндөө эрдэн уралдааныг юман чинээ бодолгүй замдаа унтаад өгчээ. Сэрэнгүүтээ үхэн хатан гүйсээр бариан дээр хүрэхэд яст мэлхий аль хэдийн оччихсон тухтайхан дугжирч хэвтэв.

2. Хамтран ажиллах, саналаа солилцох үйл ажиллагааг зохион байгуулахад анги зохион байгуулалт чухал үүрэгтэй.

3. Асуултын дагуу хос хосоороо ярилцаж хамгийн зөв хариултыг олох

Анги зохион байгуулалт нь тухайн хичээлийн зорилгоос хамаарч өөр өөр байж болно.

Ангийг өөр өөрөөр зохион байгуулах нь заах арга, үйл ажиллагааны дэмжлэг болно. Ангийн ширээнүүдийг урагш нь харуулж цувуулан байрлуулсан бол сурагчид бүгд ангийн төв хэсэг болсон багш, самбар хоёр дээр анхаарлаа төвлөрүүлж чадна. Асуулт хариулт зөвхөн урдаас л зохион байгуулагдана. Ийм зохион байгуулалтын үед сурагчид зөвхөн багштайгаа юмуу хажуудаа сууж байгаа хүүхдүүдтэй л харьцах боломжтой байдаг.

Харин ширээнүүдийг өөд өөдөөс нь харуулан дугуйруулан U хэлбэрээр зассан үед сурагчид бие биенээ сонсох, хоорондоо ярихад илүү хялбар болдог. Бүлгээр ярилцаж байхад өөд өөдөөсөө харж суух нь зохион байгуулахад хялбар бөгөөд урд талаас нийтэд өгч байгаа журам зааврыг сонсох анхаарах боломж хэвийн байдаг.

Ширээнүүдийг жижиг бүлгээр ажиллахад зориулан зохион байгуулж болно. Суудлыг ингэж засахад сурагчдад хоорондоо харилцахад хялбар болж цагийг дэмий үрэхээс хамгаална. Ийм маягаар суулгахдаа ямар ч хүүхдийг самбар руу нуруугаар нь харуулахгүйгээр шаардлагатай үед бүгд урагшаа харахад бэлэн байхаар суулгажболно.

Багш бүтээлчээр хувилбартай хандах боломж:

Сурагчдын асуулт асуух чадварыг хөгжүүлэхийн тулд чадварын ялгаатай байдалд тохирсон даалгавар боловсруулах хэрэгтэй. Зарим сурагчид асуултаа төлөвлөж чадахгүй байвал чиглүүлэх даалгавар өгөх.

Жишээлбэл: Асуултын дутуу үгийг гүйцээж асуулт зохиох

- Туулай яагаад яст шоолдог байсан бэ? Туулай унтсан бэ?
- түрүүлсэн бэ? Уралдаанд аль нь хоёрын туулай, яст мэлхий

Дээрх үгүүдийг зөв байрлуулж асуулт асуух

Хариултуудаас зөв хариултыг сонгож, түүнийг ашиглан асуултад хариулах.

Туулай яагаад яст мэлхийг шоолдог байсан бэ?

А. Туулай “Явж бүтдэггүй, мөлхөж барагддаггүй удаан амьтан” гэж яст мэлхийг үргэлж шоолдог байсан.

В. Яст мэлхий “Явж бүтдэггүй, мөлхөж барагддаггүй удаан амьтан” гэж туулайг үргэлж шоолдог байсан.

Явцын үнэлгээг хийхдээ дараах зүйлд анхаараарай. Үүнд:

- ✓ Сурагчид санаа бодлоо бусдад ярьж илэрхийлж чадав уу?
- ✓ Сурагчид бусдын үзэл бодлыг сонсож, тодруулах зүйлээ асууж чадсан уу?
- ✓ Ямар чухал асуудлууд болон санал нийлэхгүй асуудал гарсан бэ?
- ✓ Хүүхдүүдэд ямар чадвар илүү болон сул хөгжсөн ажиглагдав? гэх мэтээр дүгнэлт хийнэ.

2.3в. Санаа бодлоо өөртөө итгэлтэйгээр ойлгомжтой, тод дуугаар илэрхийлэх

- Ярих зүйлийнхээ агуулгыг сайн ойлгож, түүнийгээ илэрхийлэх
 - Ярих зүйлээ төлөвлөж, төлөвлөгөөний дагуу ярих
 - Үгийн нөөц, сонголт зөв байх, үгийг зөв сонгож ярих
 - Өөртөө итгэлтэйгээр, ойлгомжтой, тод ярих (цээжилж тогтоосноо ярихаас гадна өөрийн уншсан мэдээлэлтэй холбон ярих)
- Хувилбар1
- Зурган эхийг үйл явдлын зөв дараалалд оруулах
 - Зурган эхийн үйл явдлын дагуу өөртөө ярих, ярихад бэлтгэх
 - Үйл явдлыг дарааллын дагуу найз, нөхдөдөө ярьж өгөх

- Монголын болон дэлхийн зохиолчдын хүүхдэд зориулсан бүтээлийг сонгох
- “Дэлдгэр туулай” УБ., 2006, “Мөнхийн үсэг”
- Товч агуулга Энэ үлгэрт хүүхдэд хэрхэн сэтгэл дүүрэн баяртай байхыг сургасан, уншиж өгөхөд ч баярлуулж чадах, аз жаргалыг

Хувилбар2	бэлэглэх үлгэрүүд багтсан байгаа.
- Сонгосон эхийн эхлэл, гол, төсгөл хэсгийг зөв дараалалд оруулж, унших - Эхийг бүтнээр нь унших, ярихад бэлтгэх - Үйл явдлыг дарааллын дагуу ярих	
Хувилбар 3	
- Үлгэр, богино өгүүллэгийг сонсох Эхлээд яасан? Дараа нь яасан? Төгсгөлд яасан? гэсэн асуултын дагуу ярих төлөвлөгөө гаргах - Төлөвлөлтийн дагуу ярьж, турших - Ярьж чаддагаа найз, нөхдөдөө харуулах	

Багшийн анхаарах зүйл:

Ярих чадварыг нэмэгдүүлэхийн тулд уншаад ойлгосноо ярих, сонсоод ойлгосноо ярих, бичээд ойлгосноо ярих үйл ажиллагааг сургалтын явцад байнга зохион байгуулах хэрэгтэй.

Ярих үйл нь харилцан ярилцах, бусдад хандан илтгэж ярих, өөрийн яриаг мэдээллийн технологийн хэрэгслээр бусдад хүргэх гэсэн гурван төрөл байдаг. Иймд сурагчдын илтгэж ярих чадварт анхаарахын зэрэгцээ харилцан ярилцах боломжийг сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан олгоход анхаарч ажиллах нь чухал юм.

Мөн сурагчдаар өдөр тутмын амьдралд тохиолдсон хөгжилтэй, сургамжтай явдал, сонирхол татсан зүйлийг яриулахаас гадна уншсан ном зохиолоосоо ярих боломжийг олгох хэрэгтэй. Үүний тулд тэдний унших хүсэл сонирхлыг бий болгож, хаанаас, ямар зохиолыг, яаж сонгож, хэрхэн унших талаар зөвлөгөө өгөх, номын мэдээллийн булан ажиллуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж болно. Уншсанаа хэрхэн ойлгож цэгцлэх, хэрхэн ярьж илэрхийлэх, бусдын ярианаас ойлгож тогтоох, асуулт тавьж ярилцах зэргээр сурах арга барилд сургахад түлхүү анхаарах нь чухал.

Ярих дарааллаа төлөвлөх, өөртөө ярьж турших, бусдад ярих гэх мэт сурагчдыг ярианд сургах олон арга байдаг. Ярих үйлийг зохион байгуулахдаа сайн ярьж сурсан сурагчаар яриулах, хичээлийг баг, бүлгийн хэлбэрээр зохион байгуулах, хөгжим, зураг, нэвтрүүлгийг үзэж, сонсоод төрсөн сэтгэгдлийг саналаар нь яриулах, урьдчилан бэлтгүүлж яриулах, шууд нэр цохож яриулах зэрэг ярих арга техникийг эзэмшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулж болно.

Юу заах вэ? гэдгээсээ илүү хүүхдийн танин мэдэхүйн хэрэгцээ, сонирхол, хүртэх болон сэтгэх чадвар зэрэг сэтгэл зүйн онцлогийг судлан тэднийг хэрхэн хөгжүүлэх вэ? гэдэгт анхаарлаа хандуулах хэрэгтэй.

Өөртөө итгэлтэй ярих, бусдын яриаг анхааралтай сонсох чадварыг хэрхэн хөгжүүлэх вэ?

Сурагчдын сонсох-ярих чадварт гарч байгаа ахиц, дэвшлийг үнэлэхдээ ажиглалт, тэмдэглэл хөтлөхөөс гадна рубрикийг ашиглах нь илүү үр дүнтэй байдаг.

Сурагч дараах эхийг уншаад, багшийн төлөвлөсөн асуултын дагуу багш сурагч хоёр ярилцана.

Дугуйтай жаал

Манай хөрш айлд Төмөр хотоос ирж амарсан юм. Гялалзсан хар дугуйтай. Дугуйгаараа өөдөө сөргөө зогсоо зайгүй жирийлгэнэ. Хотон дундуур давхиж хонь үргээнэ. Түүгээр ч барахгүй нэг удаа үхрийн эзлэн дундуур давхин орж Цэвээн эгчийн хувинтай сүүг дайрч асгаад, бөөн хэл ам боллоо. Түүнээс хойш “Чойжав гуайнд ирсэн энэ дугуйтай жаал үймүүлээд болохоо байлаа” гэсэн яриа дээдэх болов. Нэг удаа би гуйж байж дугуйг нь унаж үзэх болов. Төмөр тачигнатал инээж:

-Үгүй ээ! Энэ муу Тогоогийн хөглөж байгааг. Дугуй ч унаж чадахгүй шүү гээд л бараг тэр оройжингоо шоолж хөхрөв.

Нэг өдөр Төмөр:

-Тогоо! Би чиний морийг унаж үзье гэхэд:

-Чи морь унаж чадах уу ? гэв.

-Чадахаар барах уу хотод хүүхдийн парк гэж байдаг юм. Тэнд би бүтэн сайн өдөр бүр эргүүлэгт тоглоом дээр морь унадаг гэхэд нь би толгой дохив. Удсан ч үгүй Төмөр уйлах нь тэр. Юу болсныг гарч харвал тэр маань тушаатай морин дээр мордоод, дэгэнцэхээр нь ойчжээ.

-Чи морины тушааг нь авч мордохоо мэддэггүй юм уу? гэж асуухад

-Үгүй ээ, би жинхэнэ ийм морь унаж үзээгүй гээд л үргэлжлүүлэн уйлав. Би түүнийг өчүүхэн ч шоолсонгүй. Харин Төмөрийг буцахаас нь өмнө морь унуулж сургасан билээ.

Эхийг уншаад дараах асуултын дагуу ярилцах

№	Түвшин	Асуулт
1	Сэргээн санах (Remembering)	“Чойжав гуайнд ирсэн энэ дугуйтай жаал үймүүлээд болохоо байлаа” гэсэн яриа яагаад дэгдэх болсон бэ?
2	Ойлгох (Understanding)	Төмөр яагаад дугуй унаж чадахгүй байсан бэ?
3	Хэрэглэх (Applying)	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэгт гарчиг өгөөрэй.
4	Задлан шинжлэх (Analysing)	Хот, хөдөөгийн амьдралыг харьцуулан ярилцаарай. Төмөр, Тогоо хоёрын дүрийг харьцуулан ярилцаарай.
5	Үнэлэх (Evaluating)	<u>Эхийн төгсгөлийг үргэлжлүүлж яриарай.</u> Би түүнийг өчүүхэн ч шоолсонгүй. Харин Төмөрийг буцахаас нь өмнө морь унуулж сургасан билээ.
6	Бүтээх (Creating)	Төмөр дугуйгаа унаад Тогоо морио унаад сумын төв орохоор давхиж явлаа. Гэтэл Төмөрийн унадаг дугуйны нэг дугуй нь хагарч орхилоо. Тэр хоёр ямар шийдвэр гаргасан бол.

№	Сурагчийн нэр	Сэргээн санах	Ойлгох	Хэрэглээ	Задлан шинжлэх	Үнэлэх	Бүтээх
1	Е.Тэмүүжин	3	3	2	2	1	0

Сурагчдын ярих чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахдаа сурагч ярих үйлд өөрөө оролцох боломжийг бүрдүүлэхийг чухалчлах.

Тухайн хичээл дээр олон сурагчийг хамарч, сурагчдын ярих чадварыг нэмэгдүүлдэг нэг арга бол тайлбартай дасгалын арга юм. (Монгол улсын гавьяат багш Г.Рэнцэндорж) Жишээлбэл:

Сурагчид эхийг уншиж дууссаны дараа багшийн асуултад хариулах гэхдээ сайн ярьдаг сурагчаар эхэлж яриулах нь үр дүнтэй гэсэн байдаг. Энэ сурагчдад дуурайх загвар болж өгдөг.

Энэ арга нь эхний үед бэрхшээлтэй учирдаг боловч олон дахин давтсны үр дүнд сурагчид тайлбарлан ярих арга барилыг эзэмшдэг.

Ярих чадварыг хөгжүүлэх үйлийн алхмын жишээ: Сэдэв “Хот ба хөдөөгийн амьдрал”

1. Сэдвийн талаар мэддэг зүйлээ бичиж тэмдэглэх, зурах
2. Багш тухайн сэдэвтэй холбоотой мэдээлэл өгөх, сурагчид мэдээлэлтэй танилцах (унших)
3. Жижиг багуудад хуваагдаж мэдээлэл солилцох, тухайн сэдвээр хэрхэн мэдээлэл хийхээ хамтарч бэлтгэх
4. Багшийн дүгнэлт яриатай өөрсдийн яриаг харьцуулан сонсох
5. Сурагч бүр өөрийн олж авсан мэдээлэл дээр тулгуурлан тухайн сэдвээр найз нөхдөдөө илтгэн ярих

2.3г. Зохиолын баатрын үг яриаг цээжилж тогтоон, харилцан яриагаар дүрд тоглох	- Зохиолыг сонгож багаараа унших - Зохиолын талаар ярилцах, санал бодлоо хуваалцах - Дүрүүдийг хуваарилж авах - Зохиолын баатрын дүрийг цээжлэх - Цээжилсэнээ багийн гишүүд дээхаруулах - Дүрийн гадаад төрх байдал болон ааш, зан төрх, дотоод сэтгэлийн талаар төсөөлөн бодоод саналаа хуваалцах - Багаараа бэлтгэсэн тоглолтоо найз, нөхөд гэр бүлийнхэндээ тоглож үзүүлэх	- Үлгэр болон богино хэмжээний өгүүлэл - Дүрд тоглох байдлыг харуулсан сонсгох буюу үзүүлэх бичлэг - Үлгэрийн баатруудын зураг, дүрс, тоглоом, хуруун хүүхэлдэй
--	---	---


Багшийн анхаарах зүйл:

Сурагчдын хувьд үлгэрийн баатрын дүрд тоглох нь хамгийн сонирхолтой сайхан үйл байдаг. Иймд тэдний сонирхол, тэмүүлэл дээр тулгуурлан сонсох-ярих чадварыг хөгжүүлэхэд их ач холбогдол өгч ажиллах хэрэгтэй. Энэ үйл ажиллагааг зохион байгуулахад гэр бүлийн гишүүдийн оролцоо дэмжлэг их чухал үүрэгтэй. Хүүхэд нэг бүрийг хамруулах хэрэгтэйг онцгой анхаараарай. Зохиолын сонголт, багшийн чиглүүлэг энэ үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгоно.

Жишээлбэл:

“Зараа хулгана хоёр” үлгэрийг сонгож авсан бол үлгэрийн баатруудын үгийг сурагчдад хуваарилж өгөхөд, багш, эцэг эхчүүдийн тусламж, чиглүүлэг чухал үүрэгтэй байна.

Зараахан минь, чамтай найзалж чадахгүй нь ээ. Би үргэлж үсэрч, дэвхэрч явдаг шүү дээ. Тэгэхээр бид яаж тохирох вэ? Чи өөртөө тохирох найзтай болсон нь дээр байх аа



Царцаа минь надтай найзлаач! Би энд их ганцаардаж байна.



Тухайн үлгэрийн баатруудаар хуруун хүүхэлдэй хийж тоглуулж болно. Дүрд тоглохдоо үлгэрийн баатрын ааш, зан төрх, дотоод сэтгэлийн талаар төсөөлөн бодоод найз, нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ зөвлөлдөх тэднээс зөвлөгөө тусламж авах хэрэгтэйг сануулаарай.

Жишээлбэл: Оготно хэлж байгаа хоёр үгийг өөр өөр байдлаар хэлэхийг сануулах, туршиж үзэх дасгал хийх. Эдгээр дасгалууд нь зохиолын баатрын дүр төрхийг гаргахад дууны өнгө, аялга чухал үүрэгтэй байдгийг сурагчдад ойлгуулахад тустай юм.

Сурагчдын бусдаас уучлалт гуйх, талархал илэрхийлэх, харилцагчдаа хүндэтгэн эелдэг үг хэрэглэн ярих чадварыг төлөвшүүлэхэд тэдний унших дуртай үлгэрийн баатруудын нөлөө их гэж үзэж байна. Иймд сурагчдад энэ төрлийн үлгэр болон богино өгүүллэгийг уншуулах, тэдгээрээр жүжигчилсэн тоглолт хийлгүүлэх үйлийг эцэг эх болон бусад хүмүүстэй хамтран зохион байгуулах нь илүү үр дүнтэй юм.

Сурагчдын үйл ажиллагаанд оролцож байгаа байдал, тэдний хандлага төлөвшилд гарч байгаа ахиц, дэвшлийг багш ажиглаж тэдэнд зөвлөгөө өгч туслах нь явцын үнэлгээний зорилго байх болно.

Оготно:

- Сайн байна уу?
Зүүний уут минь
(Тохуурхсан, үл тоосон)

Оготно:

- Намайг уучлаарай зараахан минь, би өмнө гаргасан алдаандаа харамсаж байна.
(Уучлалт гуйсан, буруугаа хүлээсэн)

Бусдаас уучлалт гуйх, талархал илэрхийлэх, харилцагчдаа хүндэтгэн эелдэг үг хэрэглэх зэрэгт гарч байгаа ахиц, дэвшил нь тэдний өдөр дутмын үйл ажиллагаанаас харагдах учраас тэр бүр тодорхой шалгуураар үнэлэх нь төвөгтэй байж болно. Гэвч багш сурагчдын харилцаанд гарч байгаа эерэг, сөрөг өөрчлөлтийг соргоогоор мэдэрч, үйл ажиллагаагаа зохион байгуулахыг чухал хэрэгтэй.

Дүрийн тоглолтыг бэлтгэхдээ тухайн зохиолд хэдэн дүр байгааг анзаарч сурагчдаа багуудад хуваах хэрэгтэй. Багийн гишүүдийг хуваарилахдаа сурагчдын чадварыг харгалзах хэрэгтэй.

Жишээлбэл:

“Зараа хулгана хоёр” үлгэрт зараа, царцаа, шоргоолж, шувуу, могой гэсэн дүрүүд байгаа бөгөөд өгүүлэгч сурагчийг оруулаад 6 сурагч дүрийн тоглолтод оролцох болно. Багш сурагчдыг дүрд тоглуулахын тулд энэ үлгэрийн зарим хэсгийг хураах, нэмж дэлгэрүүлэх зэрэг шаардлага гарах тул сурагчдад тохирсон жүжгийн зохиол болгох асуудлыг өөрөө хариуцана. Зохиолын баатруудын дүрд тоглож, сайн муу зан чанарыг харьцуулснаар тэдний зан чанар, төлөвшилд эерэгээр нөлөөлнө гэж үзэж байна. Иймд зохиолын сонголтон дээр анхаарлаа хандуулаарай.

Сурагчдыг дүрд тоглохоор бэлтгэж байгааг ажиглаад хэнд ямар тусламж, дэмжлэг хэрэгтэй байгааг мэдэж, юу нь сайн байгааг болон юуг сайжруулах хэрэгтэй байгааг 2 од 1 хүсэл аргаар зөвлөнө.

2 од нэг хүсэл	Багшийн санал бодол
	Бэлэн амтай залхуу хулганы тухай өгүүлнэ гэж бодож байна. Өөрөө хийнэ гэж хэлчихээд хэлсэн амандаа хүрдэггүй хулганы тухай өгүүлдэг байх гэж төсөөлж байна гэх мэт номын гарчгийг ашиглан төсөөлөн ярьж чадсан.
	Хулганууд олуулаа амьдардаг байсан. Будаагаар хооллодог байсан. гэж номын зургийг ашиглан төсөөлж ярьж чадсан.
	Ярихдаа зөвхөн нэг сурагч руу харж ярьсан. Дараа энэ алдааг давтахгүй байхыг зөвлөж байна

Үлгэрийн баатруудын дүрд тоглуулах ажлыг бэлтгэх хугацааг сайн гаргах хэрэгтэй. Энэ чадварын эцсийн үнэлгээ бол дүрд тоглож чадаж байгаагаа гэр бүл, найз нөхдөдөө үзүүлж байгаа үе бөгөөд амралтын өдрүүдэд хуваарь гаргаж, тэдний тоглолтыг үзүүлэхийг чухалчлаарай.

Жишээлбэл: Танай анги 42 сурагчидтай гэж бодвол 7 багийн тоглолт байна. Үүнийг 2 амтралтын өдөр дамнуулан эхний өдөр 3 багийн тоглолтыг үзүүлэх, дараагийн өдөр 4 багийн тоглолтыг үзүүлж болно. Сурагчдын хувьд мэргэжлийн жүжигчид биш учраас өндөр шаардлага тавьж, олон хоног залхтал бэлтгэх, чадахгүй байна гэж зэмлэхээс аль болох татгалзах хэрэгтэй. Хамгийн гол нь сурагч бүр өөрсдийн хэмжээнд оролцох нь эхний амжилт юм.

ДӨРӨВ. ХЭЛЗҮЙ, ҮГИЙН САН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
2.4а. Эх, өгүүлбэрээс хэн? юу? ямар? хэд хэчнээн?, яах?, яав? яасан? гэсэн асуултад хариулагдах үгсийг олох, эх, өгүүлбэр зохиохдоо зөв хэрэглэх	- Уншсан эхээс, өгүүлбэрээс эдгээр асуултад хариулагдах үгсийг түүж бүлэглэх - Бүлэглэсэн үгэндээ асуулт тавих. Жишээ нь: хүний нэрийг ялган бичээрэй, чи яагаад хүний нэр гэж ялгасан, ямар учраас..., асуулт тавивал хэн? юу? - Алийг нь ашиглах вэ? гэх мэтээр энгийнээс эхлэх - Хэн? ямар? юу? яав? гэх мэт асуултын бүтцээр өгүүлбэр зохиох, өгүүлбэр дэх үгэнд асуулт тавих - Хүн, амьтдын зан чанарыг илэрхийлсэн зохиол дээр ажиллаж байвал зан чанарын эерэг ба сөрөг шинжийг илэрхийлсэн үгсийг түүж бичих болон нэмж жагсааж бичих - Бичих чадварыг хөгжүүлэх хичээл дээр асуултыг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох - Зөв ярих, бичихийн тулд асуултыг хэрэглэх Бүтээлч үйл ажиллагаа - Өгсөн загвар бүтцийг дагуу өгүүлбэр зохиох - Эх, өгүүлбэрийг асуултад хариулагдах үгсээр дэлгэрүүлэн бичих - Асуултад тохирох үгийг нөхөж бичих	- Загвар 1 - Ямар? - Ямар? юу? яав? - Ямар? - Загвар 2 - Хэн? - Яав? - Хэн? - Юуг? - Яав? - Хэний? ямар? юуг? яав? - Загвар 3 - Эр шагай, эм шагай олж, дөрвөн бэрх буулгав. - Асуулт тавинарай. - Загвар 4 - Мэргэжлийн нэрлэсэн үгийг ялгаад асуулт тавих
2.4б. Асуусан, хүүрнэсэн өнгө аястай өгүүлбэр зохиохдоо асуултын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэх	- Уншсан эхийн өгүүлбэрүүдийн утгыг ярилцах хүүрнэх, асуух өгүүлбэрийг яаж ялгаснаа хэлэх - Асуух өгүүлбэр нь хүүрнэх өгүүлбэрээс юугаараа ялгаатай болохыг жишээн дээр ажиглах, хэлэлцэх,	- Асуултын тэмдэггүй, таслалгүй, цэггүй өгүүлбэр, эх загвар жишээ - Асуух өгүүлбэрийн тухай онолын тодорхойлолт

	- Эх уншаад, асуултын тэмдэг, таслал, цэгийг яаж, ямар тохиолдолд хэрэглэснийг өөрийн ажигласнаар хэлэх - Асуух, хүүрнэх өгүүлбэрийг ялгах, өнгө аясыг илтгэх, зөв бичих - Асуусан өгүүлбэр хариулсан өгүүлбэрийн бичлэгийн хэлбэрийг ажиглаж аялгын ялгааг нь сурагчид өөрсдөө гаргах - Харилцан яриа бүхий эх ашиглаж уншуулах - Хуруу хүүхэлдэй ашиглан харилцан яриа өрнүүлэх - Харилцан яриа бүхий эхийг сэтгэлийг хөдөлгөөний өнгө аясаа илэрхийлэн төлөөлөн унших Бүтээлч үйл ажиллагаа - Зохиол уншаад асуулт зохиох, хариулах загвар ашиглан асуусан ба хүүрнэсэн өгүүлбэр зохиож сурах - Цэг, тэмдэг, таслал нөхөж бичих, цэг, тэмдэгт тохируулан өгүүлбэр зохиох - Тэмдэг тэмдэглэгээг ашиглан аялгаа тохируулан унших, ярих - Хүүрнэх өгүүлбэрийг асуух, асуух өгүүлбэрийг хүүрнэх болгон хувиргаж бичих	- Асуулт хариулттай харилцан яриа - Үлгэр - Өгүүллэг - Өгүүлбэрийн загварууд - Үгэн тоглоомон эхийн загварууд - Хуруу хүүхэлдэй - Харилцан яриаг ашиглан гүйцээж бичих загвар
2.4в. Эсрэг утгатай үгийг таних, өгүүлбэр зохиохдоо хэрэглэх	Мэдлэгээ хэрэглэж сурахын тулд - Эсрэг утгатай үгийг таних, тайлбарлах - Утга эсрэгцсэн зүйр үгийн утгыг тайлбарлах - Эх, өгүүлбэрээс эсрэг үгийг ялгаж бичих, өнгөөр тодруулах - Эсрэг утгатай үгээр өгүүлбэр зохиож, өгөгдсөн өгүүлбэртэй харьцуулах, таавар, үгийн сүлжээ таах - Үгийг эрэмбэлэн эсрэгцүүлдэг аргаас суралцах Бүтээлч үйл ажиллагаа - Эсрэг утгатай өгүүлбэр зохиох - Цэгийн оронд эсрэг утгыг нөхөх - Ертөнцийн гурав, шүлэг, үлгэр зохиохдоо эсрэг утгатай үгийг хэрэглэх - Эсрэг утгатай үгийг асуултаар таних	- Хосоор нь харгалзуулахаар бэлтгэсэн тараах материал - Эсрэг утгат үг, өгүүлбэр нөхөх материал, загвар - Эсрэг утга харуулсан зургийн цуглуулга - Жишээ нь: өндөр, намхан барилга, халуун хүйтнийг харуулсан зураг гэх мэт
2.4г. Хэлц үгийн тайлбарыг уншиж ойлгох, цээжилж тогтоох	1. Хэлц үгийн тайлбарыг унших 2. Яагаад ийнхүү өвөрмөцөөр хэлэлцэх 3. Утгыг ойлгосноо тайлбарлах 4. Цээжилж тогтоох 5. Тогтоосноо үг яриа, эх зохиохдоо ашиглах 6. Өгүүлбэрээс хэлц үгийг ялгах Бүтээлч үйл ажиллагаа: - Хэлц үгийн эсрэг хэлцийг олохдоо тайлбар унших - Хэлцийн үгийн утгыг тайлбараар бяцхан ном хийх - Сургамжит хэлцийг тогтоох	- Хэлц үгийн төрөл бүрийн толиуд - Хэлцийг өгүүлбэр, эх бичихдээ ашиглах тарааж өгөх материал

Багшийн анхаарах зүйл:

Дээрх 4 суралцахуйн зорилтыг тусад нь ээлжит хичээлийн зорилго болгож ажиллахаас гадна хэл зүйн талаас хэрэглэж сургах зорилгын үүднээс унших, ярих, бичих, сонсох зорилготой хичээл бүрд үйл ажиллагааг интеграцлах хэрэгтэй.

2.4.в. кодтой суралцахуйн зорилтыг унших, бичих чадвартай хичээлд хэрэглэхдээ найруулан бичүүлэх дадалтай болгох зорилго тавина.

Харин эсрэг утгыг таниулахдаа дараах 7 төрлийн дасгалаар чадваржуулаарай.

Дасгал 1: Аль нь зүйр үг, аль нь оньсого вэ? Таагаарай.

Хол явъя гэвэл ойроос эхэл
Ихийг хийх гэвэл багаас эхэл
Унтаж, мартаж уруудахын шинж
Санаж сэдэх өөдлөхийн шинж
Харахад бага
Ханилахад их

1. Өнгөөр ялгаж бичсэн үгсийг хоёр хоёроор нь хуулж бичье.

Үлгэрлэвэл: мартаж-сэдэх, өндөр-нам,

2. Эдгээр үгсийг харьцуулж уншаарай, ямар утгатай үг гэж нэрлэж болох вэ?

Дасгал 2: Зургийг ажиглаад, нэрлэж бичээрэй.

Өндөр - нам, урт - богино, уйлах - инээх, олон - цөөн, том - жижиг

Дасгал 3: Зүйр үгэнд үг нөхөж бичээрэй, ямар ямар эсрэг утгатай үг үүссэн бэ? Ялгаж бичье.

Сайныг дагавал сарны гэрэл
..... мууг дагавал могойн хор
Үнэн үг үнэд хүрнэ
.....үг хор хүргэнэ
Инээсэн бүхэн нөхөр биш
.....бүхэнбиш
Өлсөхөд өлөн бугын эвэр зөөлөн
.....цагаан хурганы сүүл.....

Дасгал 4: Хүснэгтэд эсрэг утгатай үг нөхөж бичээрэй, ямар ямар эсрэг утгатай үг үүссэн бэ?

Үнэн		Нөхөр		Зөөлөн
	Инээх		Өлсөх	

Дасгал 5: Үгийн сүлжээн дэх эсрэг утгатай үгийг олоорой. Зөв олбол догшин гэдэг үгийн эсрэг утгатай үүснэ.

1	Н								
	2	О							
		3	м						
			4	Х					
				5	о				
					6	н			

Өндрийн

Холын

Сайны

Цагааны

Цөөний

Дайсны

эсрэг утга

Дасгал 6: Үгийн утгыг эсрэгцүүлэн зүйр үг зохиож бичье.

- Ямар юм, хүн, үйл хөдлөл, шинж байдлын эсрэг утгыг гаргах уу гэдгээ бодоорой.

Тухайлбал: хүний сайн, муу чанарын тухай бичье.



Ажилч хүн арван гартай, тэгвэл ямар хүн ганц гаргүй мэт байж болох уу?

- Сонгож буй үгийн утга тохирох эсэхийг ярилцаарай. Тухайлбал: амтай, тэнэмэл, өөдгүй, худалч, залхуу гэх мэт үгсийг сонгон ярилцаж үзээрэй.

- Аль үг нь онож хэрэглэхээр эсрэг утга үүсгэж байна? Яагаад?

- Зохиож сурсан бол өөрөө зохиогоод үзээрэй.

Дасгал 7: Зураглалыг тайлж уншаад, жишээ өгүүлбэрээр батлаарай.



2.4.г суралцахуйн зорилт нь монгол сэтгэлгээг төлөвшүүлэхэд зориулагдсан юм. Хэлц үгийг хүүхэд мэдэх ёстой гэсэн үнэлгээний зорилго тавихгүйгээр хэлц үг ба түүний тайлбар гэсэн бүтцээр ээлжит хичээлээ төлөвлөхийг санал болгож байна. Хэлц үгийн тайлбарыг ойлгосноор сурагчид өгүүлбэр зохиохдоо хэрэглэнэ. Тайлбараа мэдэхгүйгээр, хэлц үгийн цаана ямар утга байгааг мэдрэхгүйгээр өгүүлбэрт оновчтой хэрэглэж чадахгүй юм. Иймээс үнэлгээний даалгаврыг зөв тавилтай зохиох хэрэгцээ үүсэж байна. Дараах хоёр үнэлгээний даалгаврууд яагаад зөв, яагаад буруу болохыг тунгаан бодоорой.

Зөв хувилбар	Буруу хувилбар
Дараах өгүүлбэрүүдэд алинд нь “маш их баярлах” буюу “Магнай тэнийн” гэдэг хэлцийг хэрэглэх вэ? Сайн сурсанд минь аав минь бахархаж байлаа. Айсан хүнийхээ өмнө байдгаараа онийж гараа алдлан зогсов.	“Магнай тэнийх” гэсэн хэлц үгийн утгыг тайлбарлаарай.
Утгыг ойлгох чадварыг шалгахад чиглэгдсэн. Хэлцийн утгыг мэдэж оновчтой хэрэглэж сурах нь хөтөлбөрийн зорилгод нийцнэ.	Мэдлэг шалгахад чиглэгдсэн. Бүх хэлцийг сурагч мэдэхэд бэрхшээлтэй.

ГУРАВДУГААР АНГИ

Танилцуулга

Энэ нь гуравдугаар ангийн монгол хэлний хичээлийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэл болох үлгэрчилсэн төлөвлөлтийн нэгэн хувилбар юм. Тухайн ангийн сургалтын зорилтуудыг унших, бичих, сонсох, ярих чадвар болон хэл зүй, үгийн санг хэрэглэх чадварт хувааж тухай бүрд эзэмших мэдлэг чадварыг үйл ажиллагааны хувилбаруудаар баяжуулан төлөвлөлөө.

Эдгээрийг орон нутгийн онцлог, шаардлага, нөөцөөс хамаарч заах дараалал, арга аргачлал нь таны хувьд нээлттэй. Суралцахуйн удирдамж нь уян хатан тул суралцагчдын суралцах хурд, сургалтын цагтай уялдуулан агуулгыг судлах цагаа зохицуулах боломжтой.

НЭГ. УНШИХ ЧАДВАР

Унших чадварыг эзэмшүүлэхийн тулд уншихын чанар гэгддэг шаардлагуудыг харгалзахыг зөвлөж байна.

3 дугаар ангийн сурагчдын унших чадварт тавигдах шаардлага: **Унших хурдаа нэмж, өгсөн эхийг бусдын дэмжлэгтэй, ойлгож унших.** Ямар ч төрлийн эхийг уншихдаа өөртөө уншиж, эхийн агуулгыг ойлгож байна уу, ойлгож уншихдаа хурдтай байна уу гэх зэргээр үнэлэхэд анхаарна.

Эхийн агуулгыг ойлгосноо харуулах

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
3.1а. Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс үсгийн дарааллаар олж, агуулгыг ойлгох	Утга нь танил биш үгийн утгыг ойлгон уншихдаа - Зурж тэмдэглэх, эсвэл тусгай тэмдэглэгээ наах - Танил биш үгийн илэрхийлэх утгын талаар саналаа дэвшүүлэхдээ өгүүлбэр дэх тухайн үгийн өмнөх, дараах үг, бусад өгүүлбэрийн утгатай холбон таамаглах - Танил биш үгийг мэддэг үгтэйгээ харьцуулахдаа адил төстэй хэсгүүд байгаа эсэхийг нягталж үгийн утгыг ойлгох - Гаргасан саналыг толь бичиг ашиглан тайлбарлахдаа аль утга нь илүү оновчтой байгаа, мөн өөр ямар үгээр илэрхийлж болох талаар ярилцах - Зохиогчийн сонгон авсан энэ үг уншигчдад хэрхэн нөлөөлдгийг тайлбарлах гэх мэт төрөл бүрийн даалгавар ажиллах. Жишээ нь: Зохиогч “архирсан” гэсэн үгийг яагаад сонгов? Энэ үгийг сонгосон нь түүний ямар зан чанарыг тодотгов? Энэ үг чамд ямар мэдрэмж төрүүлж байна вэ? гэх мэт. Толь бичгээс танил бус үгээ хайхдаа: - Толгой үсгээр нь хайж олох - Үгийн тайлбарт байгаа танил биш үгийг толь бичгээс дахин дэлгэрүүлж унших. Жишээ нь: (АРХИРАХ араатан амьтан бүдүүн дуугаар хүрхрэн ярдаглах) (ЯРДАГЛАХ ярдаг зан ааш гаргах, адайр зан гаргах) (ЯРДАГ амьтны хэдэрлэх) (ХЭДЭРЛЭХ хэдэр ярдаг зан байдал гарган аашлах) (ХЭДЭР хүн амьтны зан ааль догшин хэвцэг) - Толь бичигт байгаа тухайн үгийн бүх утгын тайлбарыг унших. Жишээ нь: (ДҮЛИЙ: I чих огт сонсохгүй буюу муу сонсох) ДҮЛИЙ: II бөөрөнхий мөөгөнцөр зүйл тэнгэрийн дүлий)	“Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь” (Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, УБ., 2008) “Монгол хэлний өвөрмөц хэлцийн толь” (Б. Уянга нарын УБ., 2011) гэх мэт төрөл бүрийн толь бичиг “Монгол хэлний товч тайлбар толь” (Я.Цэвэл, УБ., 2013, 2 дугаар хэвлэл) “Сурагчийн толь” 2018 он /бага ангийн сурагчдад зориулав/ tsevel.toli.query.mn

	(ДҮЛИЙ: III бүдэг цэхэр, гэрэл муутай , дүлий хөх, дүлий шил) 4. Хам сэдэвт орсон үгийн утгыг сонгож авах 5. Эхэд үндсэн утгаараа ороогүй үгийг ялган тэмдэглэж утгыг олох Бүтээлч үйл ажиллагаа: Зарим утга нь мэдэгдэхгүй, хүнд үгийн утгыг олохдоо сонгино хальслах аргаар хайж олох - Энэ үгийн зохиол дахь болон ерөнхий утга нь юу вэ? - Ямар бүтцийг өөртөө агуулж байна вэ? - Эхийг дараах байдлаар мэдрэхэд энэ үг туслах уу? Өөрөөр хэлбэл харах сонсох, мэдрэх үнэрлэх гэсэн утгыг энэ үг илэрхийлэх үү? - Энэ үг надад ямар нэгэн хүн, амьтан болоод газрын талаар хэлж байна уу? Эсвэл энэ үг сэтгэл хөдлөл болоод хэн нэгний хандлагыг илэрхийлж байна уу? гэх мэтээр эрж хайх	
--	--	--

Багшийн анхаарах зүйл:

Унших чадварын эхний алхам нь үгийн утгыг ойлгож, зохиол дахь үгээр дамжуулж агуулгыг ойлгох явдал юм. Багш уншиж байгаа зүйлийн утга агуулгыг ойлгоход шаардагдах зарим үг хэллэгийг урьдчилан бэлтгэж, ямрыг нь уншихын өмнө, алийг нь уншсан дараа тайлбарлаж ярилцахаа төлөвлөх юм. Жишээ нь: АРХИРАХ (араатан амьтан бүдүүн дуугаар хүрхрэн **ярдэглах**) гэсэн нэг л үгийн утгыг мэдэхийн тулд түүнээс урган гарсан 5 үгийг мөн толиос харах шаардлага гарч байна. Энэ нь үгийн утгыг өргөн хүрээнд хэрэглэж сурахад хэрэгтэй билээ.

Энэхүү суралцахуйн зорилт нь бусад суралцахуйн зорилтуудаас ялгаатай нь 1 гэсэн кодтой УНШИХ чадварыг хөгжүүлэх зорилготой ээлжит хичээл бүрийн нэг үйл ажиллагаа болж орох юм. Өөрөөр хэлбэл ямар нэгэн эхийн утгыг ойлгож унших явцад хэрэгжүүлэх суралцахуйн зорилт юм. Гол үнэлгээний шалгуур нь эх унших явцдаа танил бишээ үгээ сонгон, толь бичгээс цагаан толгойн үсгийн дарааллаар олж чадаж байна уу гэдэг нь юм. Танил биш үгэн дээр ажиллаж сурсан хүүхдийг унших арга барилтай болж байна гэж үнэлж болно.

Уншлагад бэлтгэх үйл ажиллагааны үед үгийн утгын талаар багшийн тайлбараас гадна сурагчдын чөлөөт яриа, харилцан яриа их чухал үүрэгтэй. Гэхдээ уншлагад бэлтгэх ажил нь унших хүсэл эрмэлзлийг өрнүүлэх зорилготой ч хэт их цаг зарвал үндсэн агуулгад зарцуулах цаг хүрэлцэхгүй гэдгийг тооцох хэрэг гарна.

Танил биш үгийн тайлбарыг хийхдээ бие даан бичих бэрхшээл учирдаг хүүхдүүдийг эхэлж яриулаад дараа нь бичүүлэх гэх мэт өөрийнх нь илэрхийлэх онцлогт тулгуурлан өөр өөр арга хэрэглэж болох юм. Хичээл зааж байхдаа багш “Энэ хичээл дээр та нарын мэдэхгүй ийм ийм үг байгаа, энэ нь ийм утгатай” гээд шууд хэлж өгөөд зохиолоо уншуулах нь төдий л сайн арга биш байдаг. Учир нь зарим сурагч тэр үгийн утгыг мэдэж байдаг, зарим нь өөрөө энэ үгийг олж өмнөх хойтох үгээс нь эсвэл өгүүлбэрийн утгаас эргэцүүлэх чадвар нь сайжрах боломж байдаг зэргийг харгалзан үзэж төлөвлөлтөө хийх нь үр дүнтэй. Үгийн утгыг мэддэг сурагчдаар тайлбар хийлгэвэл ихэд урамшин цаашид олон үгийн утга тайлбарлаж чаддагаа харуулахын тулд өөрсдөө бие даан хичээж сургалтын бус цагаар ч шинэ үгэнд анхаардаг болох сайн талтай. Сурагчид унших явцдаа мэдэхгүй үгээ олж, утгыг мэдэж чадаж байна гэдэг бол ойлгон унших чадвар болон хэр зэрэг бүтээлч уншиж байгааг нь хянах нэг арга ч болж болох юм. Сурагчдын хийсэн ажлыг анги болон сургуулийн хэмжээнд дэлгэн үзүүлбэл тухайн даалгаварт санаа тавьж бүтээлчээр ханддаг болоход тустай. Энэ нь багш нэг удаа сайн гэж үнэлснээс илүүтэй явцын сайн үнэлгээ болдог. Учир нь сурагчид өөрийнхөө хийсэн зүйлийг бусдын хийсэнтэй харьцуулж өөрийн давуу ба сул талаа олж харан, дараа нь яаж хийх аргаа бусдынхтай харьцуулан олж авдаг. Ер нь хүүхдийн өөрийнх нь хийсэн зүйл ямар ч үед хамгийн үнэ цэнтэй зүйл нь байдаг тул алдаатай байсан ч түүнийгээ ямаат чухал зүйл гэж үзсээр байдаг. Найзууд болон ангийнхандаа өөрийн хийснээ яагаад ингэж зурах, будах, бичих болсноо тайлбарлаж, ярих дуртай байдаг ба ингэж байхдаа өөрөө хөгжиж байдаг сайн талтай.

Үгийн утгыг тайлбарлах явцад нэрлэх үсгийн тухай ойлголттой холбон дэлгэрүүлэх. Жишээ нь: Энэ үгийн утга нь “.....” байж магадгүй яагаад гэвэл.... гэх зэргээр үгийн утгыг аль болох олон талаас нь таамаглуулснаар дараа дараагийн суралцахуйн зорилтод дэмжлэг болно.

Сурагчдыг мэдэхгүй үгээ “Монгол хэлний тайлбар толь” ашиглаж олдог аргад сургаснаар нэг үгийн утгыг хайж байх явцдаа бусад утгуудыг мэдэх, мөн нэг язгууртай төрөл үгийн утгыг ч мэдэх сайн талтай. Энэ нь бие даан сурч болох юм байна гэсэн итгэлтэй болоход ч тусалдаг.

3.16. Уншсан эх, үлгэр, өгүүллэг, шүлгээс чухал хэсгийг ялгаж, ойлгосноо харуулах	1. Хүүрнэл эхийн агуулгыг ойлгож унших, уншсанаа ярих, асуулт зохиож ярилцах Ярилцахдаа хурдан давтан унших - Уншиж эхлэхийн өмнө унших зорилгын талаар бодох - Унших явцдаа таамаглал дэвшүүлж, тэр таамаглалдаа хариулт хайж гүйлгэн унших - Өөрт хэрэгтэй мэдээллийг олохын тулд гүйлгэн унших - Асуултад хариулахын тулд гүйлгэн уншиж сонгон унших 2. Зохиолын аль хэсэг хамгийн чухал мэдээлэл агуулж байгааг ярилцах - Яагаад энэ хэсэг чиний анхаарлыг их татав? - Чамд энэ хэсэг яагаад чухал вэ? гэх мэт асуултын дагуу давтан уншин, ярилцах 3. Чухал хэсгийг олохын тулд баатруудын үйлийг харьцуулан унших: Ингэхдээ - Баатруудын хийсэн үйлүүдийг ялгаж жагсаах - Баатруудын хийсэн үйлээс чухлыг ялгах - Нэг баатрын үйлээс чухлыг нь ялгах - Яагаад чухал гэж үзсэнээ тайлбарлах Бүтээлч нэмэлт үйл ажиллагаа: Эхийг хурааж уншихдаа - Гол чухал биш гэж үзсэн зүйлээ дарж, хасаж унших - Эхийн зарим хэсгийг яагаад гол чухал биш гэж үзсэн талаар ярилцах - Үлдсэн хэсгийг уншихад ямар ойлголт үлдэж байгааг ярилцах Зааврын дагуу эхийг хурааж бичихдээ - Баатрын үйл хөдлөлийг хурааж бичих - Нэг баатрын үйл хөдлөлийг хөөж унших, бичих - Эхийг хурааж гол чухал зүйлийг бичих гэх мэт - Уншиж байхдаа гол чухал хэсэг, мэдэхгүй үг, сонирхолтой хэсгийг тэмдэглэн унших	- Богино өгүүллэг, сургамжтай үлгэрээс сонгон авах. Жишээ нь: “Богинохон нөхөрлөл” “Битгий ай” “Жинхэнэ найзууд” гэх мэт - Бие даан ажиллах даалгаврын сан
--	--	---

Багшийн анхаарах зүйл:

Уншсан эхээс чухал хэсгийг ялгах чадвар нь 4 дүгээр ангид эзэмших “Гол санааг тайлбарлах” чадвартай агуулгын залгамж холбоотой юм. Сурагч эхийг уншаад өөрт нь чухал гэж үзсэн хэсгээ, эсвэл баатрын хийсэн үйлүүдээс чухал гэж үзсэнээ тайлбарлах нь гол үйл ажиллагаа. Багшийн хувьд тухайн эхийн зохиолчийн санаа буюу гол санааны талаас хариулах ёстой гэж үнэлэхгүйгээр сурагчдад өөрт нь чухал гэсэнээ хэлж, тайлбарлах боломжийг олгох нь зүйтэй. Чухал гэсэнээ тэмдэглэх зарим нэг аргыг танилцуулъя.

Номын онцгой анхаарал татсан, сонирхолтой эсвэл чухал зүйлүүдийг доогуур нь зурж тэмдэглэдэг. Энэ нь номоос чухал ойлголтоо дахин олоход хялбар байх болно. Энэ аргыг хэрэглээд сурвал анги ахих тусам уншсанаасаа эшлэл авч бичих, эшлэлтэй ярьж сурахад нь дөхөм болж байгаа юм.

Заримдаа санааны чухлыг төдийгүй сонирхолтойг хүртэл тэмдэглэх нь бий.

Доогуур нь хоёр давхар шугамаар зурагдсан нь нэг зураасаар зурагдсанаас илүү чухал. Заримдаа асуултын эсвэл анхаарлын тэмдэг ашигладаг. Эхнийх нь санааны эргэлзээтэй эсвэл түүнтэй санал нийлэхгүй байгааг, хоёр дахь нь харин эерэг дүгнэлтийг ихэвчлэн илэрхийлдэг. Эдгээр болон бусад тэмдэгтүүдийн хослол нь өөр олон утга санааг илэрхийлнэ. Гэхдээ бага насны хүүхдийн хувьд хэт олон тэмдэглэгээ нь төөрөгдүүлэх талтайг анхаарч нэг хоёр төрлийн тэмдэглэгээ хийж сурсны дараа энэ аргачлалуудыг сонирхуулж болох юм.

Жишээ нь: “Эрх цэнхэр ишиг” эхийг уншихдаа тэмдэглэгээ хийх даалгаврыг харъя. Даалгавар “Эрх цэнхэр ишиг” эхийг уншихдаа дараах асуултын хариулт болох хэсгийг тэмдэглэж уншаарай.

Санамж: Тэмдэглэгээ хийхдээ ээжийн хэлсэн Асуулт

үгийн ард 

Бусад асуултад  тэмдэг тавина.

1. Ээж нь ишгэндээ юуг захисан бэ?

2. Ишиг ээжийнхээ захисныг биелүүлсэн эсэх?

3. Ишиг аврагдсан эсэх?

Эрх цэнхэр ишиг

“Ишигхэн минь дээ жижигхэн цагаан дэлбээтэй энэ ургамлыг идэж болохгүй. Харин үүнээс бусад өвс ногоогоор хооллож бай.” гэж ижий нь хэлжээ. Ишиг ижийнхээ хэлснээс зөрж нөгөө ургамлыг идэхээр завдан тас хазаж, захилахын өмнө эх нь болиулжээ. Эрх ишиг: -Би заавал тэр цэцгийг иднэ. Бусад нь амтгүй байна гэж уурлав. Эрх цэнхэр, эхийнхээ амарч байх үеэр сэм явсаар түрүүнийхээ бэлчээрт хүрэв. Нөгөө цагаан дэлбээтэй ургамлаа идэж үзжээ. Тэр нь дэвхрээгийн цагаан ургамал юмсанж. Удсан ч үгүй ишигний амнаас цагаан хөөс цахарч, дөрвөн хөл нь тэрий хадан унасныг малч хүүхдүүд хотондоо авчран, аманд нь сүү цутгасаар арай гэж хөл дээр нь босголоо. Энэ тэмдэглэгээ нь сурагчдыг дараагийн үйл ажиллагаа болох эхээс баатрын хэлсэн үг, зохиогчийн хэлсэн үгийг ялгаж сургахад аажимдаа чиглэж байгаа болно. Дараах асуултаар хөтөлж уншуулахдаа эхийн гол хэсэг үлдэж байгааг ярилцах хэрэгтэй. Тухайлбал:

Ээж нь ишгэндээ юу гэж хэлсэн бэ?

Ишиг ээжийнхээ хэлсэн үгийг биелүүлсэн болов уу? Яагаад?

Ишиг хортой ургамал идсэн ч аврагдах болов уу?

3.1в. Уншсан үлгэр, өгүүллэг дэх баатрын үйл хөдлөлийн учир шалтгааныг тайлбарлах

1. Сонгосон эх зохиолын агуулгыг ойлгож уншина. Уншсанаа бусдад ойлгомжтой ярих, бие биедээ зохиолын агуулгын талаар асуулт тавих зэргээр идэвхтэй сургалтын аргыг хэрэглэж болно.
 2. Эхэд гарч буй баатрын үйл хөдлөлийг хөөж унших
 - Хэн хэн юу хийж байна вэ?
 - Хэний дараа хэн юу хийж байна вэ?
 3. Баатрын хийсэн үйлийн шалтгааныг тодруулан дахин унших. Уншихдаа дараах асуултыг хэрэглэж болно.
 - Үүнийг ... хийсэн нь ямар шалтгаантай байсан бэ?
 - Юунаас болж ийм үйлдэл хийсэн юм бол?
 - Эсвэл өөр шалтгаан байсан уу?
 - Нэг шалтгаан байна уу? Эсвэл хэд хэдэн шалтгаан байна уу?
- Асуултын дагуу ярилцсанахаа дараа тайлбарлах. Тайлбарлахдаа зохиолоос үг хэрэглэн, жишээ татна. Жишээ нь, “Тэр баатар ... ийм үйлдэл хийснээс шалтгаалж, тэгэж бодсон, эсвэл тийм үйлдэл хийсэн, эсвэл сайн хүн болсон, эсвэл ... гэх мэт найруулгаар ярих, бичих
- Бүтээлч үйл ажиллагаа:
1. Эхийн үйл явдлыг сонсоод, сонссоноосоо баатрын хийсэн үйлийн учир шалтгааныг тодруулах

- Учир шалтгааны учир холбогдолтой, эх оронч үзэл санааг дээдэлсэн, тогтвортой хөгжлийн боловсролын утга агуулга, монгол ахуй амьдралыг тусгасан, хүний сайн сайхан зан чанарыг дээдэлсэн эх зохиол

Багшийн анхаарах зүйл:

Тайлбарлана гэдэг нь зохиолоос жишээ татаж ярихыг хэлэх үйл ажиллагаа бүхий чадвар юм. Өмнөх ангид багш сэргээн санах асуултыг хэрэглэн, тоочин хэлэх чадварыг хөгжүүлэхийг голлож байсан бол 3 дугаар ангид сэргээн санах асуултын зэрэгцээ учир шалтгааны асуултаар уншсан зүйлийнх нь учрыг ухааруулж, унших чадварыг хөгжүүлнэ. 1 дүгээр анги- Уншсан эхийн үйл явдлыг асуултын дагуу тоочин ярих (эхлээд? дараа нь, эцэст нь?) 2 дугаар анги- Уншсан үлгэр, өгүүллэгийг үйл явдлын дарааллын дагуу тоочих. Харин 3 дугаар ангийн энэ суралцахуйн зорилт буюу чадвар эзэмшсэнийг үнэлэх гол шалгуур бол баатрын үйл хөдлөлийн учир шалтгааныг тайлбарлахдаа зохиолоос жишээ татаж байгаа эсэх явдал юм.

Тиймээс багш та “Энэ баатар ЮУНААС БОЛЖ? ЯАГААД? ЯМАР УЧРААС? ийм үйлдэл хийсэн бэ?, Та нар яагаад ингэж хэлж байна вэ? Зохиолоос жишээ татаж тайлбараа хийнэ үү.” гэх мэт асуултаар чиглүүлж ажиллах хэрэгтэй.

Багш дээрх хичээлийг удирдах явцдаа сурагчид учир шалтгааны асуултыг ойлгон тайлбарлах, учир шалтгааныг асууж байгааг ойлгож түүнд тохирсон хариулт өгөх цаашид мөн учир шалтгааны асуулт тавих чадвар нь хэр ахиж хөгжиж байгааг ажиглалт үнэлгээ хийж, дэмжлэг шаардлагатай сурагчдад туслах арга зүй хэрэгтэй. Хичээлийн явцад учир шалтгааныг тайлбарлах үйл ажиллагааг дараах шалгуур бүхий үйл ажиллагаатай хослуулахыг санал болгож байна. Бусдын ярьсныг хүндэтгэн сонсож, харилцаж байгаа байдал, ярьснаас нь лавшруулж, тодруулан асуух замаар идэвхтэй сонсох чадвараа хөгжүүлж байгаа байдал, бусдын хэлснийг өөрийн саналтай харьцуулж байгаа байдал зэргийг ажиглан үнэлгээ хийх хэрэгтэй. Энэ нь унших чадварыг ярих, сонсох чадварыг хослуулан сургах арга зүй бөгөөд тухайн хичээлийн явцын үнэлгээ болох юм.

3.1г. Эхээс баатрын болон зохиогчийн үгийг ялгах	1. Сонгосон эх зохиолын агуулгыг ойлгож унших, уншсанаа бусдад ойлгомжтой ярих, бие биедээ зохиолын агуулгын талаарх асуулт тавьж ярилцах 2. Эхийн үг, өгүүлбэрийг зохиолч, эсвэл баатар аль нь өгүүлж байгааг хэлэх 3. Эх зохиолд тодруулсан, зохиогч (өгүүлэгч)-ийн хэлсэн үгийг бусдад ойлгомжтой унших 4. Уншсаны дараа зохиолчийн үгээс юу ойлгосноо ярилцана. Хэрэглэх асуулт: - Үйл явдал хаана эхэлж байгааг зохиолч юу гэж хэлсэн бэ? - Баатрын хийдэг үйл, зорилго, мөрөөдөл, зан чанар, гадаар төрх байдал зэргийг ямар үг хэрэглэн яаж танилцуулсан бэ? 5.Эх зохиолд тодруулсан, баатрын хэлсэн үгийг өөрийн дуу хоолойны өнгөөр өөрчлөн уншина.	- Суралцахуйн үйл ажиллагаанд заасан үйлийг хийлгэж болохуйц богино өгүүллэг, үлгэр, аман зохиолоос сонгон авах
---	--	--

Багшийн анхаарах зүйл:

3 дугаар ангийн сурагчдаар эх уншуулахдаа зохиолчийн үг, баатрын хэлсэн үгийг ялгуулах гэхээсээ илүү, дүрд тоглон уншуулахад анхаарна. Дээрх асуултыг багш хэрэглэн уншсан хэсэгт анализ хийлгүүлж болно. Багшаас эхийг ойлгох, задлан шинжлэх чадвар шаардана. Тухайлбал, “Муурын байшин” зохиолд” Энхрий хүүхэд та нарт энэ үлгэрийг ярья. Алс газраас ирсэн Ангар нутгаас ирсэн айхтар нэгэн муур алтан дэлхийд байжээ. Муур муурнаас өөр гэнэ. Мухлагт хоргодож унтахгүй, байшин бариад сууж гэнэ. Бамбагар зөөлөн ортой гэнэ. Өнгөтэй торгон хөнжилтэй гэнэ. Өдтэй зөөлөн дэртэй гэнэ. Өргөн хашааных нь үүдийг өвгөн манаач манадаг гэнэ. Өвгөн муур түүний өнө цагийн зарц гэнэ. Хашаа байшинг цэвэрлэж, хамаг ажлыг нь хийдэг гэнэ. Цэвэрхэн хашаан дотор нь чацаргана, гүзээлзгэнэ ургадаг гэнэ. Өвгөн зарц Василий амьтан хүнийг ялгахгүй, айхтар чанд манадаг гэнэ. Нэг өдөр муурын хоёр ач нь ирж гэнэ. Өнчин хоёр ач нь өнөөх баян муурын хаалга үүдийг нь тогшиж, хайр өршөөлийг гуйжээ” гэсэн зохиогчийн үгийг уншаад яагаад зохиогчийн үг болох талаас тайлбарлуулах гэж ХИЧЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨЛӨВЛӨХГҮЙ харин асуултын аргаар зохиогчийн үгийг ойлгоход чиглүүлнэ. Жишээ нь,

1. Ямар амьтны тухай үлгэр гэж зохиолч танилцуулсан бэ?
2. Зохиогч яагаад алтан дэлхий гэж бичсэн бэ? Та нар юу гэж бодож байна вэ?
3. Муурын нэрийг хэн гэж, хаанаас ирсэн гэж зохиолч танилцуулсан бэ?
4. Зохиолч яагаад муур муурнаас өөр гэж бичсэн бэ? Уншаад та нар юу гэж бодов?
5. Зохиогчийн хэлснээс үзэхэд муурыг ажилсаг гэж бодсон уу? Хүн шиг амьдардаг гэж бодсон уу? Муурны талаар юу гэж бодсон бэ?
6. Ор, дэр, хөнжлийг нь ямар үг хэрэглэж бичсэн байна вэ? Та нар уншаад баян чинээлэг муур гэж бодсон уу? Эсвэл?
7. Өвгөн муурны тухай зохиолч хэрхэн танилцуулав? Зохиолоос үг хэрэглэн, тоочиж яриарай.
8. Хашаан дотор нь ямар жимс ургадаг гэж зохиолч хэлсэн бэ? Жимсний нэрийг бичнэ үү.
9. Хоёр ач нь хайр өршөөл гуйж ирэхэд нь баян муур юу гэж хариулах бол? Баатрын хэлсэн үгийг зохиогоорой.

3.1д. Уншсан зохиолын баатруудын зан чанарыг эхээс жишээ татаж тайлбарлах	1. Сонгосон эх зохиолын агуулгыг ойлгож уншина. Уншсанаа бусдад ойлгомжтой ярих, бие биедээ зохиолын агуулгын талаар асуулт тавих зэргээр идэвхтэй сургалтын аргыг хэрэглэж болно. 2. Зохиолын баатруудын тухай хэлэлцэнэ. Ингэхдээ: - Зохиолын ямар дүр чиний найз байх боломжтой вэ? - Эхийн үйл явдлын өрнөл хэсэгт дүрүүд хоорондоо хэрхэн холбогдож байгааг зураг, бүдүүвчээр илэрхийлэх - Баатруудын үйлээс хамгийн зөв, сайн гэж бодсон үйлээ жагсаан бичих - Жагсаалтаа ашиглан хэний хийсэн үйл бусдаасаа яагаад илүү болсныг харьцуулан дүгнэж бичихийг оролдох - “...” өгүүллэгийн баатар “...” үлгэрийн дүрийн оронд байсан бол? санаа бодлоо илэрхийлэх - Та өөрийгөө эзгүй арал дээр үлдсэн гэж төсөөл. Та зохиолын ямар баатраас ямар тусламж хүсэх вэ? Та энэ баатрыг яагаад тусална гэж бодож байгаагаа тоочин бичих - Өөрт таалагдсан нэг баатрыг сонгон аваад түүнийг дэмждэг аль эсвэл эсэргүүцдэг нэг баатрыг сонгон ав. Хэрвээ эсэргүүцдэг баатрыг сонгосон бол яагаад тэр дандаа эсэргүүцдэг тухай товч тайлбар хийгээд тэр хоёр хэн хэн нь ямар үйлдэл хийвэл ойлголцож болохыг ярих гэх мэт. 3. Зохиолын баатраас нэгийг сонгож, баатруудын зан чанарыг тайлбарлах даалгавар гүйцэтгэнэ. Тайлбарлахдаа: - Зохиолоос тухайн баатрын хэлсэн үгийг жишээлэх - Зохиолоос тухайн баатрын хийсэн үйл хөдлөлөөс жишээлэх Жишээ нь: “Энэ дүр... ингэж хэлсэн учраас их нөхөрсөг тусч хүн юм”, “...ингэж амиа бодсон учраас, эсвэл тусалсан учраас ...тийм зан чанартай гэж үзэж байна” гэх мэт өгүүлбэрийн найруулгаар ярина. Бүтээлч үйл ажиллагаа: 3. Таалагдаж байгаа, таалаглахгүй байгаа нэг нэг жишээ олох, таалагдаж байгаа учрыг тайлбарлах 4. Баатрын үйл хөдлөл, үг яриаг бодоод ямар үйлдэл хийвэл зөв болохыг хэлэх, өөрийнхөө зан чанартай харьцуулах	- Уран зохиолын төрөл бүрийн богино эх, зүйр цэцэн үг, оньсого, үлгэр гэх мэт - Шүлэг - Бодит явдал, уран сэтгэмж холилдсон эх
--	--	--

Багшийн анхаарах зүйл:

Энэхүү суралцахуйн зорилтын гол үнэлгээ буюу гүйцэтгэл нь ТАЙЛБАРЛАЖ чадаж байна уу гэдэгт чиглэнэ. Сайн тайлбарлана гэдэг нь эх зохиолоосоо жишээ татаж ярихыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, баатруудын хийсэн үйлдэл, хэлсэн үг зэргийг жишээ болгон ярина гэсэн үг. Зохиолоос баатруудын хэлсэн үгийг жишээ болгож тайлбарла гэсэн чиглүүлгийг багш өгч ажиллана. Багш “Яагаад энэ баатрыг сайн зан чанартай гэж үзэж байна вэ?, Уншсан зохиолоосоо хэлсэн үгээс нь жишээ татаарай” гэсэн асуултаар хөгжүүлнэ.

Зохиолын баатрын зан чанарыг тайлбарлахдаа тэдгээрийн хийсэн үйл явдлыг хөөж унших замаар ямар зан чанар харуулсныг гаргаж болно. Зохиолын баатрууд хэл ярианы төдийгүй өнгөн талын ч ялгаатай байдаг байна. Зарим нь түргэн шулганаж ярьдаг, эсвэл чанга ярьж инээдэг. Эсвэл их дотогшоо дуугүй байх нь ч бий гээд олон янз.

Тэгвэл зохиолын баатруудын ярианы агуулгыг төдийгүй, ярьж буй намба төрхийг нь хүртэл гаргаж илэрхийлж болно. Баатруудын хэл ярианы дүрслэлийн үүрэг, өвөрмөц байдлыг хадгалах нэг чухал нөхцөл нь дуу хоолой, аялгууны үүрэг их.

Тодорхой бүлэг хүмүүс, тухайн ард түмний ахуй амьдралын, хэл ярианы болон орон нутгийн онцлогийг тусгаж, зохиолын баатруудын нийгэм, соёлын хэмжээг тодорхойлох хэрэглүүр болдог. Уран зохиолын баатар бүр амьсгаатай, тэд өөрийн гэсэн араншинтай, өөрийн гэсэн “хэл”ээр ярьдаг. Жишээлбэл:

Баатрууд ямар, ямар үйл хийснийг тунгаан бодох, тэдний хийсэн үйлээс чухал үйлийг ялгаж бичих, яагаад чухал, яагаад чухал биш гэж үзэж байгаагаа тайлбарлаж ярилцах замаар зан чанарыг тодорхойлж болно.

3.1ө. Талархсан захидал, зорилгодоо хүрэх төлөвлөгөө, номын тэмдэглэл, хаяг, шошго, (хоолны жор) зэргийг уншиж, агуулга, бүтцийг тайлбарлах	Талархсан захидал уншихдаа: 1. Захидлын бүтцийг (Эхлэл-мэндчилгээ, огноо, захидлын гол хэсэг-хэн нэгэнд талархаж бичсэн өрнөл хэсэг, төгсгөл хэсэг-захидал бичигчийн нэр) ажиглах 2. Захидлын гол хэсэгт юмс, үзэгдлийг хэрхэн дүрсэлснийг бодож унших 3. Захидлын гол хэсэгт захиа бичигч нь хайрлаж хүндэлсэн, талархсан сэтгэлээ ямар үг хэрэглэж илэрхийлснийг анзаарах 4. Захидлыг бүтцээр нь яаж бичдэгийг бусдадаа ойлгомжтой ярих 5. Ярьсан зүйлийг сонсон, ойлгоогүй зүйлээ лавшруулан тодруулан асуух Бүтээлч үйл ажиллагаа: 6. Талархлын захианы аян өрнүүлж, ангийнхандаа зориулж бичсэн захиа, зурвасаа бусдад уншиж өгч болно. Номын тэмдэглэл уншихдаа: 1. Зохиогчийн нэр, зохиогдсон он, хаана хэвлэгдсэн газар, гол баатрын нэр, номын агуулга, хуудасны тоо зэрэг бүтэцтэйг ажиглаж унших 2. Номын агуулга хэсэгт үйл явдлыг, зохиолоос юу ойлгосноо хэрхэн бичсэнийг уншиж, дүгнэлт хийх 3. Номын тэмдэглэлийг бүтцээр нь яаж бичдэгийг бусдадаа ойлгомжтой ярих 4. Ярьсан зүйлийг сонсон, ойлгоогүй зүйлээ лавшруулан тодруулан асуух Шошгоны тайлбарыг уншихдаа: 1. Шошгон дээрх таних тэмдгийг ажиглан, тайлбарыг унших 2. Шошгоны тайлбарыг бусдадаа ойлгуулан ярих 3. Ямар үед шошгыг яаж хэрэглэхээ бусдадаа илэрхийлж ярих Хоолны жор уншихдаа: 1. Хоолны жорыг тоочин дараалж бичсэнийг ажиглах 2. Хэмжээ заасан тооны нэр, хэмжигдэхүүний нэрийг хэрхэн бичдэгийг ажиглах 3. Жор бичихэд хэрэглэгдэх тусгай тэмдэглэгээнүүдийг тайлж унших. Жишээ нь, ц\х-цайны халбага 4. Хоолны жорыг хэрхэн дараалж бичдэгийг цуврал зураг хэрэглэн бусдадаа ойлгомжтой ярих 5. Ярьсан зүйлийг сонсон, ойлгоогүй зүйлээ лавшруулан тодруулан асуух Бүтээлч үйл ажиллагаа: 1. Хүнсний бүтээгдэхүүн худалдан аваад аялалд явах гэж байгаа бол хэд хоног явахаасаа шалтгаалж зурагт байгаа зүйлийн шошгын зааврыг ашиглан сонголт хийх	- Байгалийн зураглалтай захиа, талархлын захиа гэх мэт - Номын тэмдэглэл бичсэн загвар эх - Шошгоны тайлбарууд - Төрөл бүрийн хоолны жор
---	---	--

	2. Өөрийнхөө өдөр тутам хэрэглэдэг ямар бүтээгдэхүүн ямар ашигтай болон сөрөг талтайг мэдэхийн тулд бүтээлчээр асуудал дэвшүүлж, сэдвийг хайж олж унших 3. Төрөл бүрийн зааварчилгаа, шошгын цуглуулга хийж хоорондоо зөвлөгөө болгон ярилцахдаа дүрийн тоглолт хийх	
--	--	--

Багшийн анхаарах зүйл:

Энэхүү суралцахуйн зорилт нь хэрэглээний эхийг уншиж, ойлгохтой холбоотой юм. Ингэхдээ агуулгыг ойлгоно гэхээсээ илүү бүтцийг ажиглуулах, үг сонголтыг ажиглуулахад анхаарна. Мөн уншсан зүйлийг бусдад ойлгомжтой яриулах, сонссон сурагч лавшруулан тодруулан асуух замаар ярих, сонсох чадвараа хөгжүүлэх боломжийг олгоно. Ярих чадварыг үнэлэхдээ “ойлгомжтой байна уу” гэсэн шалгуураар үнэлнэ. Унших чадварыг үнэлэхдээ “бүтцийг зөв хэлж ярьж байна уу” гэсэн шалгуураар, сонсох чадварыг үнэлэхдээ бусдын ярьсан зүйлээс тодруулж лавшруулан асууж байна уу? гэсэн шалгуурыг баримтална. 3 дугаар ангид “Идэвхтэй сонсох” чадварыг хөгжүүлэхийг зорьсныг СОНСОХ-ЯРИХ хэсгээс харна уу. Ямар үйл ажиллагаа хийдэг хүүхдийг идэвхтэй сонсогч гэх вэ гэхээр бусдаас лавшруулж, тодруулж асууж сурсан хүүхдийг хэлнэ. Иймээс сонсох, ярих чадварыг унших чадвартай хослуулан хөгжүүлэхийг ажлынхаа гол зорилгоо болгохыг зөвлөмжилж байна. Практикаас харахад шошго, хоолны жортой холбоотой уншихын хичээлийн зорилгыг буруу ойлгосноос шалтгаалж, эх хэлний хичээлийн мөн чанарыг алдагдуулсан тал ажиглагддаг. Тиймээс “Сурах үйл ажиллагаа” хэсэгт буй хүүхдийн хийх үйл ажиллагааны үйл үгийн томъёоллыг сайн ажиглаж, ээлжит хичээлийн үйл ажиллагаа болгохыг анхаарна уу. Шошгыг **тайлбарлах**, хоолны жорыг **дарааллыг тогтоож унших нь** чухал болохоос бус хоол хийх тухай ярих, шошгоны тухай ярьж, цээжилж мэдэх нь өөр асуудал юм. Энэ уншихын суралцахуйн зорилтыг бичих чадвартай холбон дараах байдлаар үнэлгээний даалгавар боловсруулж болно. Ямар нэгэн хоолны жор бүхий цуврал зургийг харуулан, “Цуврал зургийг ажиглаад, хоолны жорыг тоочин жагсааж алдаагүй зөв бичээрэй” гэсэн даалгаварт ТООЧИН ЖАГСААН, ТЭМДЭГЛЭГЭЭГ ТОВЧЛОН, АЛДААГҮЙ, ЗӨВ БИЧИЖ БАЙНА УУ гэсэн шалгуураар үнэлж болно.

5 оноо – Хоолны жорыг тоочин жагсааж, тэмдэглэгээг зөв товчлон, зөв бичгийн дүрмийн алдаагүй бичвэл

4 оноо - Хоолны жорыг тоочин жагсааж, тэмдэглэгээг зөв товчлон, 1-2 үгийг зөв бичгийн дүрмийн алдаатай бичвэл

3 оноо - Хоолны жорыг тоочин жагсааж, тэмдэглэгээг бичээгүй, 3-4 үгийг зөв бичгийн дүрмийн алдаатай бичвэл

2 оноо - Хоолны жорыг тоочин жагсаагаагүй, тэмдэглэгээг зөв товчлоогүй, 3-4 үгийг зөв бичгийн дүрмийн алдаатай бичвэл

“Бантан хийх хоолны жор” бичнэ үү гэсэн даалгаврын тавил буруу байгаагийн учир нь бантан хийж сураагүй хүүхэд, сурсан хүүхэд гэж үнэлэх гээд байгаагаар холбоотой. Эх хэлний хичээл гэдэг утгаараа УНШИХ, БИЧИХ, ЯРИХ, СОНСОХ чадварыг хөгжүүлж үнэлэх юм.

Номын тэмдэглэл уншуулснаар номын тэмдэглэл бичүүлж сургах юм. Номын тэмдэглэлийн бүтцийг багш өөрийн арга туршлагаар баяжуулж болно.

Тухайлбал, зохиогчоос асуух асуулт, хамгийн чухал санагдсан үг хэллэг, дуртай баатар, энэ баатарт дуртай байдгийн учир⁴ гэх мэт

Бага ангиас эхлэн ном сонгож унших, уншсанаа тэмдэглэх, уншсанаа ойлгох, ойлгосноо бичих ярихдаа ашиглах чадварыг насанд нь тохируулан олгох нь цаашид амжилттай суралцах нэг алхам болно. Ийм чадвар нь мэдээллээр дамжуулан өөрийн оюуны чадамжийг дээшлүүлэх боломж олгодог. Сурагчдад хичээл дээр унших хүрэлцээтэй цаг гаргаж өгөх нь унших үйлд сургахад тун чухал. Ингэхдээ 5-10 минутаас эхлэн аажмаар хугацааг нэмэгдүүлэх нь тохиромжтой. Ангид цаг гаргахын учир нь цаашид уншихын тулд цаг хугацаа гаргаж түүнийгээр үр бүтээлтэй ашигладаг болохыг мэдрүүлэхэд чиглэж байгаа болно. Номын тэмдэглэл хөтлүүлэхийн тулд ном унших дур сонирхолтой болгох нь зүй юм.

Долоо хоногийн тодорхой өдрүүдэд “Бүтээлч уншигчийн цаг”, “Номоор ярилцах цаг”, “Чимээгүй 5 минут” гэх зэргээр зорилгоор нэрлэсэн цаг гаргаж ч болно.

Уншигчийн эрх - Ихэвчлэн багш сурагчдадаа юуг, яаж, хэзээ уншихыг зааж өгдөг. Ингэснээр тэд өөрсдийн төлөө биш, хэн нэгний төлөө унших ёстой мэт сэтгэж, идэвхгүй оролцдог тал бий.

⁴ Жорж Хунт, Унших-1, Унших-2, ред.Ц.Өнөрбаян, 2002 он

Иймээс тэдэнд сонгох бололцоо олгож, тэдний сонгосон, сонирхсон ном, бичвэрийг тодорхой зорилгынх нь дагуу уншуулах нөхцөл бүрдүүлэх нь идэвхтэй уншигч болгох анхны алхам болно.

“Шинэ мэдээ” булан ажиллуулж тэнд сурагчид уншсан номынхоо тухай дараах байдлаар мэдээлэл бичиж байрлуулж болно.

✓ “..... аргыг би туршиж үзмээр байна. Энэ бол “.....” номд өгүүлсэн зүйл.

✓ “Бяцхан туулайд гэж хэлмээр байна. Тэгвэл тэр болох байх. Энэ бол “.....” номын баатар юм.

✓ Тэр зорилгодоо хүрэхийн тулд (тэр зүйлээ, тийм зангаа гэх мэт) -ээ орхисон. Түүнийг би зөв гэж бодохгүй байгаагаа хэн нэгэнтэй санал сольж ярилцмаар байна.

Ингэснээр сурагчид янз бүрийн ном сонирхож сонгон унших сэдэл, сонирхолтой болно. Өөр нэг хувилбар нь: Хэд хэдэн номоос нэг нэг хэсгийг бэлтгээд сурагчдад тарааж өгч уншуулаад дараах асуултаар ярилцах юм.


- Энэ хэсгийг уншихад чамд ямар сэтгэгдэл төрж байна?
- Энэ зохиолыг цааш яаж өрнөнө гэж таамаглаж байна?
- Энэ зохиолд юуг нэмж өгүүлээсэй гэж хүсэж байна?
- Энэ зохиолыг цааш нь зохиож бичвэл чи ямар баатрыг нэмж гаргах вэ? Яагаад?
- Ямар баатрыг нь хасмаар байна? Яагаад?

Зохиолын хэсгүүдээс нэг сурагч хоёроос дээш уншиж дээрх асуулт ярилцлагад оролцоно. Ингэж зохиол сонгох мэдрэмжийг өдөөж өгнө.

Ном унших дур сонирхолтой болгох, унших чадварыг дэмжихдээ сурагчдыг дараах байдлаар оношилж болно.

Илрүүлэх шалгуур	Хааяа	Ихэвчлэн	Бараг үгүй
Унших сонирхолтой			
Хурд сайтай, ойлгож уншдаг			
Мөр төөрдөг			
Унших дуртай номтой			
Тэмдэглэл хөтлөх дуртай			

Сурагчдаар өөрсдөөр шинээр гарсан номын талаар бусдадаа мэдээлдэг самбар ажиллуулах нь үр дүнтэй арга юм.



Дээрх самбарыг ажиллуулснаар багш, сурагчид, эцэг эхийн төлөөлөл оролцож өөртөө байгаа нөөц бололцоогоор тусалснаар сурагчид хүсэл сохирхолдоо нийцсэн ном унших, анги сургуулийн орчинд номын сантай болж ч болох юм.

Багшийн зүгээс эцэг эх, олон нийтийн байгууллагуудад хандаж номын сантай болсноор сурагчид хаа ч очсон номын хүрээлэлд байх боломжтой болно. Ингэснээр тэдэнд эерэг хандлага төлөвших сайн талтайг бас зөвлөж байх хэрэгтэй.

“Захидал”-тай холбоотой агуулгын анги хоорондын залгамж холбоог дараах байдлаар хараарай.

3-р анги	4-р анги	5-р анги
Талархсан захидал унших	Талархсан эсвэл бахархсан утгатай захидал уншихдаа санаагаа цогцолбороор илэрхийлснийг ажиглах	Санаагаа цогцолбороор илэрхийлэхдээ, бусдын үзэл бодлыг дэмжиж, эсвэл эсэргүүцэхдээ яаж бичсэнийг ажиглах

3-р ангийн шалгуур нь: Захидлыг эхлэл, гол, төгсгөл хэсгээр нь ялгаж байна уу, гол хэсэгтээ захиа бичигч нь талархлаа илэрхийлэхдээ ямар үг сонгосныг ажиглан хэлж байна уу

4-р ангийн шалгуур нь: Гол хэсэгтээ захиа бичигч нь талархлаа илэрхийлэхдээ ямар үг сонгосныг хэлж байна уу, цогцолбор бүрт ямар утга илэрхийлж бичсэнийг хэлж байна уу

5-р ангийн шалгуур нь: Цогцолбор бүрт ямар утга илэрхийлж бичсэнийг хэлж байна уу, бусдын үзэл бодлыг дэмжиж, эсвэл эсэргүүцэхдээ ямар үг хэрэглэснийг ажиглан, хэлж байна уу

3.1ж. Цээжилсэн шүлгийн утгыг мэдэрч, мэдрэмжээ илэрхийлэн уран унших	1. Сонссон хүний сэтгэлийг хөдөлгөхийн тулд шүлгийг яаж уншихаа төсөөлөн бодох 2. Шүлгийн утгыг ойлгож унших, юуг мэдэрснээ, юуг ойлгосноо ярилцана. Ярилцах явцдаа бие биеийнхээ санаа бодлыг хүндэтгэн сонсож, шүлгийн утгын талаар тодруулж асууж болно. 3. Шүлгийн бадаг бүрт сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэх 4. Жишээ нь, "Энэ бадгийг уншихад өрөвдөх эсвэл хайрлах, жигших, гомдох сэтгэгдэл төрлөө", "Хөгжмийн утас тасардаг гэнэ" гэж бичсэнээс ... ийм ийм зүйл бодогдлоо" гэх мэтээр сэтгэгдлээ илэрхийлэх. "Энэ бадгийн энэ үгээс ... ийм зүйл харагдлаа, эсвэл сонсогдож байна гэх мэтээр мэдрэмжээ илэрхийлэх 5. Шүлгээс мэдэрсэн хэсгээ нүүр царайны ямар хувирал гаргах, дууны ямар өнгөөр илэрхийлж уншихаа төлөвлөх 6. Төлөвлөсний дагуу уран унших дасгал ажиллах 7. Хэрхэн уншсанаа дүгнэн ярилцах. Дүгнэхдээ "Харамссан, өрөвдсөн сэтгэлээ илэрхийлэхдээ дуу хоолойны өнгө тохирсон эсэх, нүүрний хувирлаа зөв илэрхийлсэн эсэх" гэх мэт	- Эх оронч үзэл санааг дээдэлсэн, Тогтвортой хөгжлийн боловсролын утга агуулга, монгол ахуй амьдралыг тусгасан, хүний сайн сайхан зан чанарыг дээдэлсэн утгатай, мэдрэмжийг хөгжүүлэх зорилготой шүлэг, найраг
---	---	--

Багшийн анхаарах зүйл:

Бид энэхүү хөтөлбөртөө ЗӨВ УНШИХ, ОЙЛГОН УНШИХ, ХУРДАН УНШИХ, УРАН УНШИХ гэсэн уншлагын чанарыг харгалзаж байгаа билээ. Уран уншуулахаас өмнө заавал дараах зүйлийг дэс дараалан баримтлахыг санал болгож байна.

1. Шүлэг дэх авиа үсгийг зөв дуудаж, тод, чанга унших
2. Зөв дуудаж уншсаны дараа шүлгийн утгаа хэр ойлгож байгааг багш судлах. Судлахдаа блүүмийн таксономийн асуултын дарааллыг харгалзана.
3. Ойлгосны дараа уран уншуулах арга хэрэглэх

Шүлгийнхээ утгыг сайн ойлгоогүй бол, шүлэг дэх үгийг мэдрээгүй бол уран уншлагын хичээлийг орох боломжгүй.

Сурагчдын суралцахуйг дэмжихийн тулд сурагчид шүлгээс мэдэрсэн үг хэллэгийн утгад тохируулж дуу хоолойны өнгө, нүүрний хувирлаа хэр зэрэг төлөвлөж байгааг анзаарах, дэмжих, уншсаны дараа өөрсдийн хийсэн үйлээ шалгуурын дагуу үнэлж, цаашид юуг засахаа ярилцаж байгаа эсэхийг хянаж, чиглүүлнэ.

Сурагчдыг мэдрэмжийг хөгжүүлэхийн тулд "Шүлгийн аль үг чиний сонирхлыг татав?, Яагаад татав? Аль хэсэг, аль бадгийн ямар үгээс өрөвдөх, хайрлах, гомлох гэх мэт сэтгэл төрөв? Шүлгийг унших явцад юу харагдав? Ямар нэгэн дуу чимээ сонсогдсон уу? гэх зэргээр асууна.

Сэтгэгдэл гэж юу вэ? comment	Мэдрэмж гэж юу вэ? feeling
Сэтгэлийн олон өнгө аясаа илэрхийлэхийг сэтгэгдэл гэнэ. Өрөвдөх, хайрлах, жигших, гайхах гэх мэт	5 мэдрэхүйгээр хүртэж байгаа зүйл. Харах, сонсох, хүртэх, амтлах, үнэрлэх гэх мэт үйл үгийг хэрэглэж, юуг яаж мэдэрснийг харилцан ярилцана.

Яруу найраг, шүлгийг хүүхдүүд анги нийтээрээ чангаар олон удаа давтан унших нь унших чадварыг хөгжүүлэх сайн арга юм. Яруу найраг нь мөр толгой холбосон, шүлгийн агуулга, түүний илэрхийлэл болсон хэлбэрт тохирсон хөг эгшиг, аялгуу хөгжимтэй, бусдад уншиж өгөхөд тохиромжтой байдлаар зохиогдсон байдаг онцлогтой. Шүлэг найргийг анги нийтээрээ хоолой нийлүүлэн унших нь хөгжилтэйгээс гадна уран илэрхийлэл болон дуу хоолойгоо хөгжүүлэхэд тусална. Хүүхдүүд шүлгийг сонсголонтой уншихын тулд өөрсдийн дуу хоолойдоо анхаарал тавьж сурна.

Сурагчдад цээжлүүлэх шүлгийг олшруулж хувилах, эсвэл дэлгэцээр харуулах, бичлэг сонсох, шүлгийн утга санаанд тохирсон зураг үзүүлэх, зурах зэргээс сонгох боломжтой. Жишээлбэл "Талын шувуудын өндгөнд сүүдрээ бүү хүргээрэй" шүлэг нь хөдөөгийн хүүхдэд ойлгомжтой олон үг байгаа ч хотын хүүхдүүд ойлгохгүй "ташуурын сүүдэр, салхины хөл гэх мэт" үг нэлээд байгаа. Иймд эдгээр үгийг сурагчдаар өөрсдөөр нь сайтар эргэцүүлэн бодуулж хооронд нь яриулахдаа

“Энэ үгийн утгыг надад биш түүнд л ойлгуул даа”, “Ямар байдлаар энэ үгийг найддаа ойлгуулж болох вэ? Жишээ хэл дээ. Үгийн утгыг яаж мэдэж болох вэ?, Тэдгээр үг ямар утга илэрхийлж байгаа талаар өөрийнхөө саналыг дэвшүүлж хэлээрэй. Бусдын гаргасан ямар ямар саналтай санал нийлж байна, ямартай нь санал нийлэхгүй байна гэх зэргээр чөлөөтэй ярих боломж олгож үгийн утгыг дэлгэрэнгүй тайлбарлан ярилцах юм.

Гэрийн даалгаврын жишээ:

“Өөр нэгэн шүлгийг уншаад гэрийнхэнтэйгээ ярилцаарай. Ярилцсанаа алдаагүй зөв бичээрэй. Бас ээж ааваараа ах эгчээрээ хянуулаарай. Ажлын хуудас

Гэрийнхэнтэйгээ ярилцах асуулт	Гэр бүлийнхний хариулт	Миний хариулт
Уншсан шүлэгт юуны тухай, яаж өгүүлж байна вэ? Аав ээж нь шүлгийн утгыг юу гэж ойлгосныг алдаагүй зөв бичээд ирээрэй.		
Шүлгийн ямар үг анхаарлыг чинь их татав? Яагаад? Гайхсан уу? баярласан уу? эсвэл өрөөдсөн үү? гэх мэтээр сэтгэгдлээ бичээрэй.		
Шүлгээс юу сонсогдов? Эсвэл ямар нэгэн зүйл харагдсан уу? Ямархуу байдалтай харагдаж байна вэ?		
Шүлгээс мэдэрснээ яаж уншихаар болов? Дуу хоолойныхоо өнгийг аль үгэн дээр өөрчлөх гэж байна? Нүүрний хувирлыг аль хэсэгт яаж гаргах гэж байна вэ?		

Энэхүү ажлын хуудас нь эцэг эхийг хүүхэдтэй нь ажиллуулах, хүүхдээ мэдрэхэд, хүүхдэдээ зөвөөр нөлөөлөхөд нь дэмжлэг үзүүлэх зорилготой. Ер нь гэрийн даалгаврыг сурагч бие даан хийхээс эхлээд хэн нэгэнтэй хамтарч хийх, санал бодлыг солилцуулахад чиглүүлэх нь орчин үеийн сургалтын үзэл баримтлалтай холбоотой. Учир нь “Боловсрол 2030” дэлхийн багш нарын хөтөлбөрт “Боловсрол бол харилцан ойлголцол, хүлээцтэй байдал”⁵ гэж тунхаглажээ.

Эхийн далд утгыг бүтээлчээр ойлгох

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
3.13. Үлгэр, өгүүллэгийн үйл явдлыг уншихдаа гол баатрын хэлэх үгийг ургуулан бодож, төсөөлөх	1. Сонгосон эх зохиолыг унших, уншсан хэсгийн агуулгын талаар асуулт зохиож уншсанаа хэлэлцэх, бие биеийнхээ санаа бодлыг хүндэтгэн сонсох, лавшруулан тодруулж асуух 2. Зохиолын орхисон хэсэгт баатрын хэлэх үгийг ургуулан бодож төсөөлөх 3. Төсөөлснөө ярилцаж, бичих	- Баатрын хэлэх үгийг орхисон эх зохиолууд

Багшийн анхаарах зүйл:

Унших чадварын бүтээлч үйлийн түвшинд сурагчдыг төсөөлүүлэх, таамаглуулах үйлийг удирдан чиглүүлдэг. Өөрөөр хэлбэл бүтээлчээр ойлгоно гэдэг нь төсөөлж, эсвэл таамаглаж байгаа үйлийг хэлнэ. Төсөөлж ярьж байгаа нь таамаглан ярихаас өөр чадвар гэдгийг багш анхаарна. Төсөөлөх нь сурагчдыг нэг хэв загварт баригдахгүй чөлөөтэй сэтгэхийг шаарддаг. Сурагчид зохиолд бичигдээгүй зүйлийг буюу далд утгыг “*implicit main*”⁵ өөрсдөө ургуулан бодож, бүтээлчээр төсөөлөн бодно. Харин таамаглах чадвар нь сурагчдаас үндэслэлтэй ургуулан бодож, таамаглаж ярихыг шаардана.

“Төсөөлөх чадвар”-ыг үнэлэхдээ зохиолд ү өгүүлбэрээр бичигдээгүй тэр зүйлийг өөрийн бодол, хандлагаараа сурагчид хэрхэн ургуулан бодож байна вэ гэдгийг харгалзана. Гол баатрын үйл, зохиолын явдлаас ургуулан гол баатрыг дүрслэн төсөөлж яриулахдаа:

- Лусын хааны хаалганы өмнө зогсож байхдаа тэр ямархуу байдалтай байх бол?
- Тэр ...байх үедээ ямар хувцас өмссөн байх бол? Яагаад?
- Чи хэрвээ энэ баатрын оронд байсан бол ямархуу хувцас өмсөх бол? Юу гэж хэлэх бол? Яагаад?

⁵ Unesco.mn

- Хааны өмнө зогсож байхдаа юу бодож байсан бол? гэх мэтээр зохиолд үг, өгүүлбэрээр илрүүгүй далд утгуудыг зохиолын гол баатрыг зураглан төсөөлөх, хэлсэн үгийг төсөөлөх, үйл хөдлөлийг төсөөлөх зэргээр ургуулан бодуулна.

Өөрөөр хэлбэл төсөөлөх нь чөлөөтэй сэтгээнэ гэсэн үг юм. Бодох сэтгэхийн дээд боломж нь хүүхэд өөрөө зохиох явдал юм. Энэ нь зүгээр л зохиож бич гэсэн үг биш ээ. Тодорхой нөхцөл, жишээ баримт, тайлбар зэргийг огт өөрөөр төсөөлөн бодож сэтгэлгээг нь задлах үйл ажиллагааг ихээр хийх хэрэгтэй.

Зохиол дотор эзж хүү хоёр ярилцаж байхад эзжийн ярианд “Тэдний уур сайхан дуутай. Эдний уур сайхан хэвтэй гээд л ярилцах” гэсэн баримт байна. Энэ баримтын нөхцөл нь цай нүдэх уур нүдүүрийн дуугаар хотоос ирсэн хүү нь сэрснээр эзж хүү хоёрын хооронд болж байгаа яриа юм. Энд байгаа баримтыг огт өөр болгож зохиохын тулд янз бүрээр төсөөлөн бодуулна. Ингэснээр дараах хувилбарууд ч гарч болох юм.

Хувилбар-1.	Хувилбар-2.	Хувилбар-3.
Уур нүдүүртэй айл ч ховор доо. Хааяа нэг чол чол хийсэн дуу л гарах. Хэв муутай болохоороо дуу нь ч муу гарна.	Айлуудын уурыг үзэх сэн гэж их бодно. Даанч айлууд үзүүлэхгүй.	Манай уур сайхан дуутай. Тэдний уур цалгай амсартай болохоор дуу сайнгүй. Манай уур тэднийхээс огт өөр хэвтэй.

Бүтээлч унших, бичих, ярих, сонсох төрөл бүрийн даалгавар өгөх нь зохиолыг дахин давтан унших боломжийг сурагчдад олгодог давуу талтай.

Сурагчид унших, сэтгэх болон дүрслэн бодохыг чармайхгүйгээр унших нь олонтоо тохиолддог бөгөөд энэ нь уншлагын хамгийн том садаа юм. Иймээс сурагчдыг уншихын өмнө, унших явцад, уншсаны дараа төсөөлөн бодох үйлийг хийлгэж хэвшүүлэх нь үр дүнтэй. Дүрслэн бодох чадвараа дайчлан уншиж чадвал “Чи өрөөндөө суунгаа мориор давхиж, салхийг мэдэрч, аянгын догшин нүргээнийг сонсож болно” гэх мэтээр сурагчдад сэтгэгдэл төрүүлж өдөөвөл зүгээр.

Унших зорилготой даалгаврын үр дүнг бичих чадвартай холбож ажиллавал илүү сайн. Иймээс гэрийн даалгаварт төсөөлснөө алдаагүй зөв бичих дасгал өгч болно. Төсөөлснөө ноороглох, ноорого засах, зассаны дараа дахин сайжруулж бичих гэсэн үйлээр ажиллахыг хүүхдүүдэд зөвлөөрэй. Гэрийн даалгавраа хийгээд ирсний дараа дараах асуултын дагуу хүүхдүүдийг самбарын өмнө гаргаж, тод чанга яриулна.

1. Төсөөлж бичихэд ямар бэрхшээл байсан бэ?
2. Төсөөлж бичихдээ зохиолд гараагүй үг хэллэгээр бичсэн үү?
3. Зөв бичгийн ямар дүрэмтэй үгийг алддаагүй сайн бичдэг вэ? Зөв бичгийн ямар дүрмийн алдаа гаргасан бэ?
4. Бичсэн төсөөлөл нь ойлгомжтой байна уу? Гэрийнхэн нь уншаад ойлгосон уу?
5. Бичсэн ноорогтоо үгийг давтсан алдаа гаргасан уу? Үгийг хасаж, нэмж ажилласан уу?
6. Найруулгын болон зөв бичгийн дүрмийн алдаагаа засаж дахин сайжруулж, хичээнгүй бичсэн үү?

3.1и. Уншсан үлгэр, өгүүллэгийн гол хэсгийн үйл явдлыг хэрхэн өрнөхийг таамаглах	1. Сонгосон эх зохиолыг унших, уншсан хэсгийн агуулгын талаар асуулт зохиож уншсанаа хэлэлцэх, бие биеийнхээ санаа бодлыг хүндэтгэн сонсох, лавшруулан тодруулж асуух 2. Эхний өгүүлбэр эсвэл эхлэл хэсгийг уншаад, цаашид гол хэсгийн үйл явдал хэрхэн үргэлжлэх талаар таамаглах. Таамаглахдаа дараах найруулгын хэв маягаар ярина. Жишээ нь, - Зохиолын гарчгаас ..., эсвэл эхлэл хэсэгт ингэж бичсэнээс ийм ийм үйл явдал өрнөх байх, ...ийм ийм баатрууд ингэж хэлж, бодож, харилцах байх - Эхлэл хэсэгт ...ингэж бичсэн учраас гол хэсэг дэх үйл явдал ингэж өрнөнө гэж таамаглаж байна. 3. Таамаглалуудаа бие биедээ сонирхол татам (зургаар, хүснэгтээр гэх мэт) ярих 4. Ярьснаа алдаагүй зөв бичих	- Сонирхолтой үйл явдалтай, адал явдалтай үлгэр өгүүллэг
---	--	--

Багшийн анхаарах зүйл:

Хүүхэд уншсан зохиолынхоо эхлэл хэсгийн үйл явдлаас үндэслэл аван, ургуулан бодсоныг таамаглах чадвар эзэмшлээ гэж үзнэ. Цаашид болох үйл явдлыг таамаглахдаа уншсан эхийн эхлэл хэсгийн агуулга, үйл явдал, баатруудын тухай мэдээлэл маш чухал байдаг гэдгийг анхаарна. Явцын үнэлгээний арга техникийг хэрэглэж сурагчдаа үнэлнэ. Жишээ нь:

Хэрвээ би дараах зүйлийг амжилттай гүйцэтгэх бол

- Би таамаглахдаа зохиолын эхлэл хэсгийн үйл явдлаас, бас баатрын үйл хөдлөл, хэлсэн үг, зан чанараас ургуулан бодсон
- Би таамаглалаа бусдадаа илэрхийлж сайн ярьсан
- Би ярьснаа зөв бичих дүрмийн алдаагүй бичсэн гэх мэт. Багшийн өмнө хийсэн явцын үнэлгээ нь сурагчдын ахиц амжилтыг тодорхойлж байдаг. Хэрэв ахиц гарахгүй байвал бэрхшээл байгааг харуулж байгаа хэрэг юм.

Эхийн хоосон зайг нөхөх даалгаврыг хийлгэхдээ өгүүллэгийн өрнөлийн өмнөх ба дараагийн хэсгийг хэрхэн ашиглаж чадаж байгаа эсэхийг ажиглаарай. Үүгээр сурагчдын уншсан зүйлдээ үндэслэн таамаглал дэвшүүлэх, түүнийгээ үнэлэх чадвар нь харагддаг. Мөн энэ даалгаврыг бүтэн үгээр биш зарим үгийн зөвхөн нөхцөл, эсвэл дагаврыг орхисон байдлаар ч хийж болох юм.

Зохиолын гарчгаас буюу эхний хэсгийг таамаглана гэвэл энэ нь батлагдана, няцаагдана. Нотолж болох нотолгоог шаардвал таамаглах үйл болох юм.

Зохиолын үйл явдлыг харуулсан зургийг хараад зохиолыг таамаглуулж болно. Яагаад гэвэл энэ зургийн үйл явдал зохиолыг уншихад батлагдаж байгаа учраас тэр.

Эхийн эхний хэсгийг уншаад цааш ямар үйл явдал болсныг үргэлжлүүлж бичүүлэх буюу яриулж болох юм. Энэ нь таамаглах чадварыг бататгаж байгаа даалгавар болно.

Таамаглах чадварыг хөгжүүлэх хувилбарт дасгалууд:

Зохиолын эхний хэсгийг уншаад цаашид ямар үйл явдал болохыг үргэлжлүүлж зохионо.

Үнэг

Эрт дээр үед нэг өлсгөлөн үнэг ойгоор гэтэж яваад зугаалж байгаа гэр бүлийнхнийг харж гэнэ. Үнэг мөлхөж очоод хоолноос нь хулгайлахаар шийджээ. Ганц харайгаад нэг боов шүүрэх гэж байтал ард нь хүмүүсийн дуу сонсогджээ. Тэгэхээр нь тэр зүгт мөлхөж очоод хартал ойн захад бас нэг гэр бүл зугаалга хийж байхыг үзжээ. Тэдний хоол эхний айлынхаас амттай харагдсан тул тэдний хоолноос хулгайлахаар шийджээ.

Гэтэл хоол илүү амттай мэт санагдсан боловч тийм их байхгүйг нь мэдээд эргэж эхний айл руу мөлхөж гэнэ...

Эхийг уншуулаад гол баатрын үйлээс ургуулан төсөөлж яриулахдаа дараах байдлаар асуудал дэвшүүлж болох юм.

- Үнэг эхний айлын хоолыг хараад ямархуу үйл хөдлөл хийх бол?
- Хоёр дахь айлын хоолыг хараад үнэгийг хийсэн үйлийг эхний айлын хоолыг хараад хийсэн үйл хоёрт ямар ялгаа гарах бол? Яагаад?
- Үнэг айлуудын хооронд явахдаа ямар үйл хөдлөл хийх бол? Яагаад?
- Өлсгөлөн үнэг буцаж явахдаа ямархуу байдалтай явах бол гэх мэт.

Зохиолын үргэлжлэл

Мөлхөж явах замдаа хоёр дахь айлын хоолыг идэхгүй өнгөрөх нь дэндүү хайран санагдсан тул буцан мөлхөөд очиход нь тэд аль хэдийнээ бүх хоолоо идэж дууссан байв. “За яахав нэг дэх айлын хоол руу буцан очъё” гээд яаран мөлхжээ. Үнэгийг очиход нэг дэх айл ч хоолоо идэж дууссан байсан тул өлсгөлөн үнэг гунигтайхан цааш явжээ.

Зохиолын зарим хэсгийг нөхүүлэн зохиолгож бичүүлж болно. Үнэг

Эрт дээр үед нэг өлсгөлөн үнэг ойгоор гэтэжзугаалга хийж байгаа гэр бүлийнхнийгҮнэг очоод хоолноос нь шийджээ. Ганц харайгаад нэг боовгэж байтал ард нь хүмүүсийн дуу сонсогджээ. Тэгэхээр нь тэр зүгт мөлхөж очоод хартал ойн захад бас нэг гэр бүл зугаалга хийж байхыг үзжээ. Тэдний хоол эхний айлынхаас амттай харагдсан тул тэдний хоолноос хулгайлахаар шийджээ. Гэтэл хоол илүү амттай мэт санагдсан боловч тийм их байхгүйг нь мэдээд эргэж эхний айл руу мөлхөж гэнэ. Мөлхөж явах замдаа хоёр дахь айлын хоолыг өнгөрөх нь дэндүү хайран санагдсан тул мөлхөөд очиход нь тэд аль хэдийнээ бүх хоолоо идэж дууссан байв. “За яахав нэг дэх айлын хоол руу буцан очъё” гээд ...мөлхжээ. Үнэгийг очиход нэг дэх айл ч хоолоо идэж дууссан байсан тул өлсгөлөн үнэг гунигтайхан цааш явжээ.

Энэ гурван даалгаврын эхний ба гурав дахь даалгавар нь таамаглах, хоёр дахь нь төсөөлөх чадвараа ашиглан гүйцэтгэнэ гэсэн үг юм.

ХОЁР. БИЧИХ ЧАДВАР

3 дугаар ангийн сурагчдын бичих чадварт тавигдах шаардлага: **Авиа, үсгийг зөв холбон, үгийг үеэр зөв таслан, өгүүлбэрийг том үсгээр эхлэн, өгүүлбэр, эхийг бүтцийн дагуу хичээнгүй зөв бичих чадвар**

Тус ангид үлгэр, шүлэг, “Ертөнцийн гурав” зэрэг уран зохиолын эхийг дуурайн зохиож бичихээс гадна номын тэмдэглэл, тоглоом тоглох заавар, талархсан захидал, 7 хоногийн төлөвлөгөө зэрэг хэрэглээний эхийг зохиож бичих чадвар эзэмшинэ. Эдгээр эхийг зохиож бичихдээ дараах бичих арга барилын дарааллаар бичиж сургахыг анхаарна уу.

Бичих арга барил эзэмшүүлэх үйлийн алхмууд	
Зөв бичих	- Өгүүлбэр, эхийг дэгийн дагуу бичих - Утга ялгасан үгийг /н,г,х/ зөв дуудах, нүдлэх, өгүүлбэрт утга ялган зөв хэрэглэх - Эгшгийн эгшигжүүлэх үүргийг мэдэх, бичихдээ хэрэглэх - Дараалсан гурван гийгүүлэгчийн дүрмээр зөв бичих - Газар орон, байгууллага зэргийн оноосон нэрийг зөв бичих
Бичих санаагаа олох, төлөвлөх Санаагаа зохиож, байрлуулан бичих	- Юуны тухай, юу юуг бичихээ бодох, эргэцүүлэх - Бичих санаагаа эргэцүүлэн бодох, бусадтай хэлэлцэх - Эхийн бүтцийн дагуу бичих үйлээ төлөвлөх \Эхлээд, дараа нь, төгсгөлд нь юу бичих вэ? - Төлөвлөсний дагуу ноороглон бичих
Бичсэнээ хянах сайжруулах	- Бичсэн зүйлээ дахин унших - Зөв бичгийн дүрмийн болон найруулгын алдааг багштайгаа хамтран хянаж, засах - Хэн нэгэнд уншиж, зөвлөгөө авах - Бичсэнээ нягталж дахин сайжруулах (үг, өгүүлбэр нэмэх, хасах, өөрчлөх) - Дахин сайжруулж, хичээнгүй бичих

Өгүүлбэр эхийг дэгийн дагуу хичээнгүй сайхан бичихийн тулд дараах шалгуурт тохируулан бичиж сурахад анхаарна.

- Үсгийн бичих хэв маягийг баримтлах
- Үсгийн эхлэх, үргэлжлэх, төгсөх цэгийг зөв төлөвлөх
- Үсгийн өндөр намыг зөв тохируулж муруй хазгай биш бичих
- Үсгийн эгц болон ташууг зөв бичих. Налалт /65° / жигд зөв.
- Үсгийн өргөнийг тохируулах
- Үсэг хоорондын холболт зөв
- Үг ба үсгийн хоорондын зайг ижил хэмжээтэй бичих
- Үг, үсгийг дэвтрийн шугаман дээр налуу бичих
- Үзэгний даралт, жигд хөнгөн байх
- Үгийг үзэг салгахгүй, тасралтгүй бичих
- Үсэг ба үгийн эцсийн орхицыг шидэхгүй, тогтоож бичих
- Цэг цэглэлийг зөв хэрэглэх (зураас, хашилт, хаалт, тодорхойлох цэг, цэг, таслал, том үсгээр бичих зэргээс ойлгон хэрэглэх)
- Догол мөр гарган хуулан бичих

Хичээнгүй сайхан бичиж сурснаа харуулахын тулд дараах үйл ажиллагаануудыг хийж болно.

- Дээрх шалгуурт нийцүүлэн хуулан бичих
- Хичээнгүй бичгийн хуудсыг хүүхэд бүр хийх
- Хичээнгүй сайхан бичсэн зурган самбар, плакат бүтээх
- Дэгийн дагуу бичээгүй эхийг дэгийн дагуу болгон бичсэнээ харуулсан харьцуулсан хуудас хийх

Ямар ч тохиолдолд дэгийн дагуу хичээнгүй сайхан бичиж сурсныг харахын тулд бусад хичээлийн дэвтрийг шалгаж дүгнэлт өгч ажиллахыг санал болгож байна.

Бичих арга барилыг эзэмшүүлэхдээ дараах зүйлийг анхаарна.

Нэн тэрүүнд ямар нэгэн эхийг зохиож бичүүлэхийн тулд юу юу бичиж болохыг сайтар бодуулж, тэмдэглүүлэх хэрэгтэй. Хэрвээ үлгэр зохиохоор бол юуны тухай бичих вэ гэсэн асуултыг хэрэглэн эргэцүүлэхэд багш чиглүүлнэ. Жишээ нь, найзынхаа эелдэг зан чанарын тухай, өөрийнхөө дутагдлын тухай гэх мэт. Эхлээд юу бичих вэ, дараа нь юу бичих вэ, төгсгөлд нь юу бичих вэ гэсэн асуултаар чиглүүлж, санаагаа байрлуулж сургахад анхаарна.

Бичих санаагаа олж, төлөвлөсний дараа ноороглуулж сургах хэрэгтэй. Нооргийг хүүхдийн дэвтэрт хийлгэнэ. Ноороглосны дараа найруулгын болон зөв бичгийн дүрмийн засвар хийнэ. Найруулгын засвар хийхдээ дараах шалгуурыг хэрэглээрэй.

- a. Бичсэн эхийг уншихад ойлгомжтой байна уу?
- b. Үг, өгүүлбэр нэммээр байна уу? Ямар үг өгүүлбэр нэмэхээ бодоорой
- c. Үг, өгүүлбэр хасмаар байна уу? Ямар үг өгүүлбэр хасахаа бодоорой
- d. Үгийн байрлалыг солимоор байна уу?
- e. Үгийг солих уу?

Зөв бичгийн дүрмийн засвар хийхдээ дараах байдлаар хийж болно. Багш та өөрийнхөө арга зүйг тусган нэмж засварлаж болно.

1. Бичих гэсэн зорилготой ээлжит хичээл бүр дээр хүүхдийн зохион бичсэн, найруулж бичсэн байдлаас нь алдсан үгийг **ИЛРҮҮЛНЭ**.
2. Илрүүлсэн үгээ **ОНОШИЛНО**. Ямар дүрэмтэй холбоотой болохыг оношилно гэсэн үг. Мөн сурагч бүр ямар дүрмийн алдаа гаргаж байгааг харж, сурагчдын ялгаатай байдлыг илрүүлнэ.
3. Буруу бичсэн үгийг зөв болгон, холбогдох зөв бичгийн дүрмийн утга учрыг сурагчдын оролцоотойгоор **ТАЙЛБАРЛУУЛНА**. Тухайлбал, зөв болон буруу бичсэн үгсийг харьцуулж яагаад зөв болох, яагаад буруу болох, аль үсэг зөв бичихэд нөлөөлж байна (явахын, явхын) гэх мэтээр ажиглах, харьцуулах чадварыг хөгжүүлэх зэргээр сурагчийн оролцоо, үйл ажиллагааг идэвхжүүлэх арга зам хайхыг зөвлөж байна. Буруу бичсэн үгийг яаж зөв болгосон байна вэ? Сурагч Батын бичсэн нь зөв юм. Яагаад зөв бэ? Буруу хувилбарыг яагаад буруу байгааг тайлбарлана уу. Дүрмийг уншаад тайлбараа нягтална уу. Тайлбарласан дүрмээ бусдад ойлгомжтой болгохын үүднээс найруулж бичиж үзнэ үү гэх мэт асуултын хувилбар байж болно. Нэг ангид 10 нэгж хичээлийг судална гэвэл 10 удаагийн давтамжтай бичих зорилготой хичээл төлөвлөх тул тэр бүрд нь тухайн ангид эзэмших ёстой зөв бичгийн дүрмийн чадваруудыг дахин дахин давтан ярилцах, сурагчдыг өөрсдөөр нь үнэлүүлэх зэргээр ажиллуулж болно. /Мэдээж, нийтлэг алддаг дүрэм бүхий үгсийг сонгож ажиллах нь зүй/ Жишээ нь, Батын бичсэн эхийг 5 хүүхэд шалгана уу. Шалгахдаа бидний үзэж байсан “Гээгдэх эгшгийн дүрэм”-ээр бичсэн үгийг сонгоно уу. Яагаад зөв гэж үзэв? гэх мэтээр бичих арга барилыг дэмжсэн асуултыг хэрэглэхийг санал болгосон. Бага боловсролын зорилго бол сурах арга барил эзэмших явдал юм.
4. **ТАЙЛБАРТАЙ ДАСГАЛЫН АРГА**⁶ хэрэглэж, сурагч дүрмийн зүй тогтлыг тайлбарлах нь чухал тул багш чиглүүлэх асуултаа тодорхой, оновчтой боловсруулах шаардлагатай юм.
- 5: Тайлбартай дасгалын аргыг хэрэглэн дүрмийн зүй тогтлыг тайлбарлуулсны дараа **АЛДСАН ҮГИЙГ ОРОЛЦУУЛЖ, ӨГҮҮЛБЭР ЗОХИОЛГОХ** дасгал ажиллаж, дүрмийн бататгалыг хийнэ.
- 6: **АЛДСАН ҮГИЙГ ОРОЛЦУУЛЖ**, цээж бичиг хийх дасгал ажиллана.
- 7: **АЛДСАН ҮГИЙГ ОРОЛЦУУЛЖ**, дүрмийн бататгал дасгал хийлгэнэ. Ангийнхаа сурагчдын ямар дүрмийг алдаж байгааг судлах нь чухал. Сурагч өөрийн алддаг дүрэмтэй холбоотой дасгалыг сонгож ажиллахад багш бүр анхаараарай. Энэ нь

⁶ “Тайлбартай дасгалын арга, 50 жил”, ред.С.Жагдал, УБ., 2016 он

сурагчийн хэрэгцээн дээр суурилсан хөтөлбөрийн үзэл баримтлалтай холбоотой билээ.

Тухайн дүрэмтэй холбоотой үгсийг бүлэглэж, нүдлэх тогтоолгох аргыг хэрэглэх нь бага ангид үр дүнтэй. Хэрэв унших болон сонсох-ярих чадвар нь даасан ангийн хүүхдэд тодорхой хэмжээгээр илэрч, зохих хэмжээний үр дүн гарч байвал дараа дараагийн нэгжийн хичээлийг зохион байгуулахдаа бичих чадварыг хичээлийнхээ цагийг ихэсгэж, унших, сонсох-ярихын чадварыг багасгаж болох юм. Бүтэн жилд эзэмших чадварыг бүхлээр нь харах нь чухал тул хүүхдийнхээ хурд, хүлээн авах чадвар, суралцах явцыг ажиглаад, нэгж бүр дэх унших, сонсох-ярих, бичих зорилго бүхий хичээлийнхээ цагийг багш зохицуулж болно гэсэн үг. Тиймээс дүрэм дээр тогтож ажиллах шаардлагатай гэж үзэж байгаа бол “бичих зорилготой” хичээлийн дараа 1-2 цаг дан дүрмийн дасгалыг ажиллуулж, нүдлүүлэх ажил өгч болох юм. Хамгийн гол нь нүдэлсэн үгс юугаараа төстэй, ямар дүрмийн дагуу бичигдсэний утга учрыг тайлбарлаж чаддаг байх нь хичээлийн үр дүн болох учиртай.

ЗӨВ БИЧИХ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн						
3.2а. Утга ялгасан үгийг /н,г,х/ зөв дуудах, нүдлэх, өгүүлбэрт утга ялган зөв хэрэглэх	Алдаагүй зөв бичихдээ - Өмнө нь нүдлэн тогтоож бичиж сурснаа балархай эгшгийн “-х” гийгүүлэгчийг ялгах үүрэгтэй холбон тайлбарлаж, бичиж сурах, төрөл бүрийн дасгал даалгавар ажиллах - Үгэнд “-ий, - ы” нөхцөл залган зөв бичих - “аргал” зэрэг бичлэгтэй үгэнд байгаа балархай эгшгийн ялгах ба эгшигжүүлэх үүргийг тайлбарлаж бичих үгсийн бүлэг үүсгэх - “торх-торох, өрх-өрөх” зэрэг дуудлага адил үгсийн утгыг тайлбарлаж, жишээ гаргах - Үйлт нэрийн “-х” утга ялгаж байгааг тайлбарлах	- Зөв бичих дүрмийн лавлах, загвар тарааж өгөх материал, төрөл бүрийн нөхөх болон сонгох, тохируулах, бүлэглэх гэх мэт сорил даалгавар, төрөл бүрийн үзүүлэн						
3.2б. Балархай эгшгийн эгшигжүүлэх үүргийг мэдэх, бичихдээ хэрэглэх 3.2в. Дараалсан гурван гийгүүлэгчийн дүрмээр зөв бичих	Зөв бичих дүрмийг ойлгохдоо: - Ижил дүрэм бүхий үгсийг ангилах, ялгах, бүлэглэх - Үгийн язгуур үндсэн дээр дагавар, нөхцөл залгаж бичих - Үгийг бүлэглэж бичих - Алдаа засах - Нийтлэг алддаг үгс болон төвөгтэй бичлэгтэй үгс, дуудлагаараа төсөөтэй үгсийг тодруулах, доогуур нь зурах зэргээр тэмдэглэх, нүдлэн тогтоох - Тухайн бичлэгийн зүй тогтлыг ухаарч ярилцах. Жишээ нь: - “Авзага” гэсэн үгийг ажиглаад яг ийм байдлаар бичигдэх үг зургааг олж бичих гэх мэт. - Өгүүлбэр, эх зохион бичихдээ зөв хэрэглэх - Дүрэмтэй холбоотой хэл зүйн таавар зохиох - Зохиолоос үг түүж бүлэглэн бичих Жишээ нь: <table><tr><td>харгана</td><td>адасга</td></tr><tr><td>чацаргана</td><td>.....</td></tr><tr><td>.....</td><td>.....</td></tr></table> - Дээрх үгийг бүлэглэхдээ зүй тогтлыг яаж ухаарч байгаагаа бусдад тайлбарлан ярих	харгана	адасга	чацаргана				- Бүлэглэж төрөл-жүүлсэн үзүүлэн-гүүд. Жишээ нь: аньсага авзага харцага халбага хавтага тарвага оньсого зулзага бортого хоромсого
харгана	адасга							
чацаргана								
.....								

3.2г. Газар ус, улс орон зэрэг оноосон нэрийг ялгах, зөв бичих	1. Уншсан эхээс том үсгээр бичсэн үгсийг ажиглах, яагаад том үсгээр эхэлж байгааг өөрийн ойлголтоор тайлбарлах 2. Том үсгээр эхэлж бичсэн үгийг улс орны нэр гэх мэтээр төрөлжүүлэх, ялгах дасгал ажиллах 3. Улс, нийслэл, хот, аймаг, сум, газар усны нэрийг томоор бичдэг дүрмийг унших, дүрмээс юуг ойлгосноо ярилцах 4. Эх зохиож бичихдээ том үсгийн дүрмийг баримталж бичих 5. Бичсэнээ хянах 6. Яагаад том үсгээр бичсэнээ ярилцах	- Оноосон нэр нөхөж бичих хэрэглэгдэхүүн
---	--	---

Багшийн анхаарах зүйл:

Эх, өгүүлбэрийг дэгийн дагуу бичүүлж сургахдаа дараах аргыг хэрэглэж болно.

1. Тодруулан бичих арга

3 дугаар ангид орсон ч бичгийн хэлбэр сайнгүй сурагчдын дэвтэрт үсэг үгийг цэглэн тэмдэглээд түүний дээгүүр дагуулж бичүүлдэг нэгдүгээр ангийн сурагчдад хэрэглэдэг аргыг хэрэглэж болох юм. Ингэхдээ энэ загвараа том цаас, самбар дээр багш дагуулан хийж эхлэл, үргэлжлэл, төгсгөлийг хаана яаж хийхийг нарийн зааж өгөх, агаарт дагуулан бичих зэргээр бэлтгэх хэрэгтэй.

2. Төрөлжүүлэн бүлэглэх арга

Үсэг бүрийн бичлэгийг ижил төстэйгээр нь бүлэглэж бичүүлэх юм. Тухайлбал “а, о, ө” үсгүүдийг, “у, ү, д” үсгүүдийг гэх мэтээр бүлэглэн бичүүлбэл гарын хөдөлгөөний нэг чиглэлээр хурдан дадаж хэвшдэг.

Зөв бичих үйл нь өнгөн бүтэцдээ “зүгээр л” зөв бичих дүрмийн дагуу бичих асуудал юм шиг боловч гүн бүтэцдээ бол цэвэр логик сэтгэлгээний гаргалгаа гэж болно. Учир нь үг бүхний цаана ертөнцийн бодит болон бодит бус түг түмэн юмыг ухагдахуунаар дамжуулан төсөөлж мэдрэн, мэдрч төсөөлөн, ухаарч ойлгон, ойлгож ухаарснаараа тусган хүлээж авч тархиндаа боловсруулж гадагш нь илэрхийлдгээрээ өвөрмөц юм. Жишээ нь: Нохойн төрлийн сүүн тэжээлтэн, махчин амьтан бол чоно. Чоно үүрэндээ өлзийтэй. Чонын нүхэнд хонь хадгалах гэх мэтээр “чоно” гэдэг үг хэл зүйн хэчнээн хувилбараар хэчнээн утга үүргээр хэлний үүрэг гүйцэтгэх вэ? (чоно, чонын бэлтрэг, азарган чоно, өлөгчин чоно, чоно улих, чоно гийнах, чонон гутал, чонон дах, чонон хөнжил, чонон санаа, чонын хөрвөш, чоно махнаас гарах, чоно үүрэндээ өлзийтэй, чоно хонь хоёр шиг, чоно харсан юм шиг, чонын амнаас гараад барын аманд орох, хонинд орсон чоно шиг, хонио чоноор мануулах хөгшин чоно, чонын элэг, чонын хэл, чонын өргөс) гэхэд нэрлэсэн утга бүр нь сэтгэн бодохуйн их тойрогт өрнөнө. Энэчлэн үнэнийг бичих, үнэнийг зөв бичих, үнэнийг үсгийн дүрмийн алдаагүй бичих, үнэнийг үнэт эрдэнэсээр бичих гэхчлэн ахиулаад үзвэл “Зөв бичих гэдэг зөвхөн зөв бичих харин зөвд суралцах, зөвд сурах дэг - сахилга, зөв байх хариуцлага” гээд бодоход хэлний үнэт асуудал мөн.

Эгшигийн эгшигжүүлэх үүргийг сайн ойлгосон бол түүнийг нөхцөл залгахдаа гээхгүй юм байна гэдгийг төвөггүй мэдэж хэрэглэнэ. Балархай эгшигийг гээхгүй бичих нь:

Эгшигт гийгүүлэгчийн аль нэг эгшиггүй болоход хүрвэл гээхгүй.
Жишээ нь: самбарын, салбараас

Заримдгийн дараах заримдаг эгшиггүй болоход хүрвэл гээхгүй. Жишээ нь: нөхцөлийн, буцсанаас, үзчихээд

Гэтэл “-х” залгаврын өмнөх богино эгшигийг гээхгүй. (Жишээ нь: буцахын, үзэхээр) тул “-х”-г ялгах үүргийг “сэрх- сэрэх, чимх- чимэх” гэх зэрэг жишээгээр зааж байхдаа л түүнийг гээхгүй бичих юм гэдгийг ойлгуулж болно. Ялгах эгшигийг гээхгүй бичих ч мөн адил. Жишээ нь, онолоор, хагасыг гэх мэт. Том үсгээр бичихийг судалж мэдүүлэхдээ л оноосон нэрийн балархай эгшигийг гээхгүйг ойлгуулна. Жишээ нь: Улаанбаатарын, Болорын гэх мэт. Хүүхэд бүрийн зөв бичиж сурах хугацаа, арга барил нь харилцан адилгүй. Иймд багшаас янз бүрийн хэрэглэгдэхүүн ихээхэн шаардах ажил.

Уншуулж нүдлүүлэн тогтоолгох эхийн санг дараах байдлаар төрөлжүүлэн бүрдүүлсэн байж болох юм.

Урт болон хос эгшигтэй	“-ий, -ы” зөв бичих
Тоглоод гүйхээр тоодоггүй нойр Томоотой суухаар хүрдэг нойр Мойл идэхээр сэргэдэг нойр Номоо уншихаар нозоордог нойр Нойр, мойл хоёр холбоотой юм уу Ном, тоглоом хоёр хамаатай юм уу	Хуруу Аавын арван хүү ажилсаг, ээжийн арван охин эрх гэж оньсого таалцлаа. Миний гарын хуруу их ажилтай нь үнэн шүү. Зурна, будна, бичнэ, наана гээд л. Харин хөлийн хэдэн хуруу минь залхуу юм болов уу даа.
Монос модонд ургасан Мойл жимс нь амттай даа Хайс хашаанд ургасан Зүлэг ногоо нь гоёхон доо	Хөвчийн бор Хөвчийн бор бусадтай эвтэй амьдардаг. Харин зөгийтэй бол сайнгүй. Ажилч зөгийний алаг цэцэгнээс хураасан амтат балыг нь мань хөвчийн бор андахгүй. Хоншоор савраа долоолон, долоолон үмхэлдэг гээч. Бүргэдийн үүрэнд хоол эрсэн ангаахайнууд ангалзаж, түүнээс горьдоно. Хөвчийн бор тоох ч үгүй балаа иднэ.
Нутаг сэлгэж айлууд нүүнэ Нүүдэл тосож цай барина Айл саахалтын амь нэг Ард олны заншил энэ	Би Шөнийн олон үнэр Би дундаас Би Өөрийн гэрийн утааг Би чадна ялгана
Гайхмаар юм Далайн хөлөг онгоцыг анх удаа харлаа, би. Дугуйгүй мөртлөө яваад байдаг, далавчгүй мөртлөө хөдлөөд байдаг гайхмаар юм. Шугуй дундуур нэвтэрдэг болов уу? Хурмаст тэнгэрт нисдэг болов уу?	Юуны төлөө Энэ хамар Хамартай билээ Таных ч биш Үнэртэж чадна Талын тармаг Чинийх ч биш өвсөн дундаас Минийх минийх Таанын хурц үнэрийг ялгана Ж.Дашдондог
Эхийн сан нь аль болох нэг дүрмээр хэд хэдэн эхтэй байвал хүүхэд сонгож сонирхож хэрэглэх боломжтой болно. Зарим хүүхэд нэг зүйлийг удаан хугацаагаар нухацтай судлан хичээж хийж байж чадварждаг онцлогтой. Тэгвэл тийм хүүхдэд зориулсан мөн янз бүрийн эх бичвэр, холбоо үгийн сантай байх хэрэг гарна. Жишээ нь: Тэнэг чоно Чоно шарга дааганы хэлсэн ёсоор нь шаврыг нь хэлээрээ долоож арилгаж орхиод идэх гэтэл: - Миний хөлийн туурайнд нэг бичиг бичээстэй бий. Та үүнийг минь үзээд иднэ үү гэжээ. Чоно туурайны бичгийг үзэх гээд очтол шарга даага дагзыг нь хага өшиглөж орхиод, давхиад явчихжээ. “н, г”-тэй үг: чоно, шарга, даага хага –Эдгээр үгэнд нөхцөл залгавал яаж бичих вэ гэдгийг “дааганы” гэж бичсэнээс ухаарч бичиж сурах зэргээр “нухаж” ажиллана. Өмнөх ангидаа сурагчдын эзэмшсэн балархай эгшиг үгийн нэгдүгээр үеэс хойш байрладаг, богино эгшиг гэсэн ойлголт дээр нь тулгуурлан балархай эгшигийн үүргийг дасгал, дадлага ажлаар дамжуулан ойлгуулна. Үүргийг нэг дор заах нь сурагчдад бэрхшээлтэйг бодолцон улиралд хуваан төлөвлөөрэй. Хэлний дүрэм тодорхойлолтыг хоосон цээжлүүлэхийн оронд хэлний жишээ баримт ажиглуулж, ижил ба ялгаатай байдлаас дүгнэлт хийлгэн учрыг ойлгуулах ажил хийлгэх нь оновчтой. Багш тухайн дүрэмд тохирох үгийг бүлэглэсэн үзүүлэн, бүлэглэх даалгавар өгөх, тараах материалын сан бүрдүүлж сурагчдын бичих чадварт тохируулан ялгавартай өгч бичүүлж сургаж болно. Жишээ нь: дараах байдлаар үзүүлэнг бүлэглэсэн тогтолцоогоор бэлтгэж хэрэглэж түүнийгээ дагуулан зөв бичүүлэх эхийг бэлтгэж болно. Ингэхдээ хүүхдийн танин мэдэхүйг хөгжүүлэхэд чиглэсэн агуулгаар боловсруулах нь хэрэгтэй.	

г		н	
тараг айраг араг савар уураг сүү буг чөтгөр алаг эрээн	тарга хүч арга ухаан уурга хуйв буга согоо гарын алга	цан хүүрэг он жил хан уул тоон шулуун орон гэр олон түмэн манан будан эм тан хон хон дуутай	цана чарга цохиж оно хана унь тооно хаалга гэрт орно эрж олно зурна, будна тана эрдэнэ гэртээ хоно
аяга таваг, хутга заазуур, тулга тогоо, атга чихэр, авга ах, буга, булга, салхи шуурга, ой тайга, дээвэр туурга, хаалга			
тотго, чанга дуу, унага даага, ботго тором, хурга ишиг, тугал бяруу, шарга азарга, шударга хүүхэд, шатрын аварга		• чанар, хоног, тэнэг, зөнөг, цэнэг үнэр өнөр, хоног, анар, онол, санал, • сана, хоно, уна, чана, зөнө, шивнэ, суна, туна, оно хана	

Н,Г үсэгтэй үгийг зөв бичихэд төл малын сэдэвтэй агуулгаар хэд хэдэн хичээл бэлтгэж болох жишээг харууллаа.

унага даага	ботго тором	тугал бяруу	хурга ишиг
-------------	-------------	-------------	------------

Унага даага

Толгой хаялан нааддаг
Тоос татуулан давхидаг унага минь
Эр хүний нөхөр эмээл хазаарын эзэн
Хурдан даага болно доо

Ботго тором

Бүлээн зөөлөн хошуутай
Бүлтгэр борхон ботго минь
Хойтон жилийн өдийд
Хоёр бөх нь туг ширээ
Хонгор хөөрхөн тором болно доо.

Зөв бичихийн тулд тухайн бичиж буй зүйлийнхээ утга, санааг сайн ойлгож байх нь чухал.

Алга болсон гэж эрсэн азаргаа өөрөө унаад л яваад байсан байгаа юм.	Алаг голдуу хэдэн сайхан адуу туусан адуучин тааралдлаа.
Малын тарга хүч сайн байна.	Тараг уух нь эрүүл мэндэд тун сайн.
Арга чадал сайтай аргат үнэгний тухай үлгэр уншлаа.	Араг үүрээд аргал түүхээр явлаа.
Хатуу чанд хуультай улс орон.	Хилийн чанадад амьдардаг Монголчууд.

Жишээ нь: “булаг, булга” гэж саланги хэлэхэд сонсогч утгыг төдийлөн анзаарч ялгахгүй. Харин “Булга усанд амьдардаг. Булаг усны эхийг түрүү гэж нэрлэнэ.” гэсэн өгүүлбэрээр илэрхийлбэл утга нь сайн ойлгогдоно. Тэгвэл энэ хоёр онцолсон үгийн бичлэг нь тухайн үгсийн утгын ялгаж байгааг харуулна. Иймээс утга ялган зааж байгаа болохоор өөр өөрөөр бичиж энд ямар нэгэн дүрэм, зүй тогтол байгааг хүүхэд мэдэхийг хүсэх болно. Эсвэл зөвхөн үгийг өгөөд сурагчдаар утгыг гаргуулсан өгүүлбэр зохиолгох гэх мэт. Эхийг уншиж ойлгох, гүйцээн бичих явцдаа зөв бичих дүрэмтэй холбон тайлбарлаж байх хэрэгтэй. Жишээ нь: Шанх сайтай шарга, саваа сайтай сарлаг гэсэн түргэн хэллэг “Цадахад цагаан хурганы сүүл хатуу, өлсөхөд өлөн бугын эвэр зөөлөн” гэсэн зүйр үгт байгаа “н,г” үсгийн ялгааг тайлбарлах гэх мэт.

Байнга алдаатай бичдэг сурагчдаар бусад сурагчдын бичсэн цээж бичгийг засуулахад хурдан хугацаанд зөв бичиж сурдаг. Учир нь бусдын бичсэн зүйлийн зөв бурууг хянахын тулд өөрөө тухайн үгийн зөв бичлэгийг тулган харж нягтална. Зөв бичих чадварыг илрүүлэхдээ алдаатай үгтэй даалгавар өгөөд түүнийг олж засуулах нь багш засаж өгснөөс хамаагүй үр дүнтэй арга юм.

Жишээ нь: Арц эхэд байгаа зөв бичгийн дүрмийн алдаатай 8 үгийг олж засаарай гэсэн даалгавар өгч хийлгэх гэх мэт.

Арц

Арц говь, говийн өндөр уулстай газар урагддаг, мөнх ногоон сөөг урагмал юм. Арц анхилуун сайхан үнэртэй, ариутгах чанартай эмийн ургамал. Арцыг дэлхийн орон болгонд нян болон бохирыг ариутгах зорилгоор хэрэглэдэг. Арцыг түүж, хатааж, нүдэж нунтгалаад ариун үнрийг уугиулан гэр орон, өрөө тасалгааг ариутган цэвэршүүлхэд хэрэглэнэ. Аль нутагт урагснаас шалтгаалан арцны үнэр өөр өөр байдаг. Отгонтэнгэрийн арц бусад нутагийн арцнаас үнэрээрээ сүрчигтэй төсөөтэй холимог үнэр гаргадгаараа ялгаатай.

Дараалсан гурван гийгүүлэгчтэй үйл үгийг зөв бичих

сүлжилдэнэ хөөцөлдөнө ганганалдана хөжилдөнө хөгжилдөнө барилдана уралдана тулалдана	дөмөлзөнө мэлтэлзэнэ сэвэлзэнэ улалзана цайвалзана тормолзоно сүүмэлзэнэ өрвөлзөнө	туслалцана бодолцоно үсдэлцэнэ будалцана өгөлцөнө харилцана бичилцэнэ зууралцана	бодогдоно санагдана харагдана танигдана үзэгдэнэ мэдэгдэнэ сонсогдоно түлэгдэнэ
---	---	---	--

Тогтолцоогоор нь харах:

- -лд, -лз, -лц, -гд залгасан үгс байгааг
- -ш, -т, -д, -с дагаврууд байгааг
- Дараалсан 2 гийгүүлэгчээр төгссөн үг тус тус байгааг ойлгож мэдвэл эдгээрт -на, -нэ, -но, -нө залган бичиж байгаа зүй тогтол нь адил байгааг

ээнэгшинэ үүлшинэ хоногшино гаршина хуршина омогшино эрэмшинэ давшина урамшина	будантана гэмтэнэ өрөмтөнө цантана сүүдэртэнэ халтартана устана мөстөнө үсчинэ	мөрдөнө мордоно зальдана хөлдөнө олдоно хуурдана өлдөнө амдана бярдана	нойрсоно амсана намсана ханьсана хужирсана найрсана харамсана хөндөлсөнө
--	--	--	---

хөгжинө түгжинэ нэгжинэ эмжинэ шинжинэ дэмжинэ өнжинө унжина	дэгдэнэ бардана хавдана бэлдэнэ элдэнэ булдана мандана алдана	тэнцэнэ элдэнэ хөлдөнө халдана дэлдэнэ дэгдэнэ сөгдөнө өртөнө	урсана дурсана элсэнэ загсана загьсана зогьсоно өмсөнө төгсөнө
---	--	--	---

Багш энэ байдлаар зүй тогтлыг ажиглаж ухаарах үзүүлэн хэрэглэгдэхүүн бэлтгэх боломжтой. Зөв бичиж сургах арга:

Үгт карт бэлтгэж багуудад өгнө. Багууд оногдсон үгийн утга бичлэгийг тайлбарлан хэлэлцээд мөн ингэж бичих үгийн жагсаалт гаргана.

хувилбар -1

сүлжилдэнэ	дөмөлзөнө	туслалцана	бодогдоно
------------	-----------	------------	-----------

хувилбар -2

ээнэгшинэ	будантана	мөрдөнө	үүрсэнэ
-----------	-----------	---------	---------

хувилбар -3

хөгжинө	мандана	өртөнө	нойрсоно
---------	---------	--------	----------

Эгшгийн эгшигжүүлэх үүргийг мэдэх. Зөв бичих чадвар нь ухамсарт үйл болж чадсан цагт л дадал хэвшил болж үлдэнэ. Алдаагүй зөв бичих чадварыг цээж бичгээр хэмждэг уламжлалт ойлголтыг арай өөр аргаар шийдэж болох билээ. Зөв бичихийн хэрэглээ нь аливаа бодол санаа, мэдээ мэдээлэл, уншсан, сонссон зүйлээ өөрийн оюун бодолдоо тунгаан боловсруулж бичгээр илэрхийлэх үйл юм. Аливаа хүний амьдралын туршид алдаагүй бичиж байгаа тэр байдал нь дээрх нөхцөлд л илэрч байдаг шүү дээ. Гэтэл бид хөндлөнгийн удирдлагаар алдаж болзошгүй үгийг л цуглуулан байж цээжээр бичүүлээд “алдлаа” гэж дүгнэдэг. Энэ нь үнэндээ зөв бичихийн хэрэглээ бус харин алдаж бичихийн шалтгаан болдог ч байж мэднэ.

Цээжээр бичих тохиолдол нь сонсогчид хэд хэдэн бэрхшээлийг үүсгэж байдаг. Үүнд:

1. Дасал болоогүй дуудлага
2. Сэтгэл зүйн хувьд таатай бус “шалгуулж байгаа” орчин
3. Бодож тунгаагаагүй агуулга
4. Заавал дүгнэгдэх дүн
5. Богино цаг хугацаа
6. Өөрөөс хамааралгүй үйл бага байх гэх мэт. Энэ бүхэн нь зөв бичихийн ухамсарт байдлыг бий болгож чадахгүйд хүргэдэг байна.

Харин өөрөө сонсож, уншсан мэдээллээ боловсруулж бодож тунгаасны эцэст сая цаасан дээр буулгах нь “өөрийн болсон” агуулгыг өөрийн ухамсарт үйлээр хийж байгаа хэрэг. Зөв бичих нь сэтгэлгээний асуудал тул ухамсарт үйлээр хэвшинэ. Иймээс аль болох уншиж, ажиглаж, эргэцүүлж, адилтгаж, эсрэгцүүлж байж зөв бичихийг ухамсарлана. Жишээ авч үзье. Цээжээр бичих эх:

Цээжээр бичих:

- | | |
|--|---|
| 1. Ороо нь ороогоороо
Жороо нь жороогоороо | 4. Амьд хүн аргатай
Аргалын гал цогтой |
| 2. Илжигний чихэнд ус хийсэн ч сэгсэрнэ
Алт хийсэн ч сэгсэрнэ | 5. Эрийг бүү бас
Далайг бүү янд |
| 3. Хүний эрхээр жаргахаар
Өөрийн эрхээр зов | |

Өөрийн эрхээр зов

Бичих зүйлийн агуулгыг хүүхдүүд өмнө нь сонсож, уншиж, бас бодож байгаагүй өөрөөр хэлбэл сэтгэн бодох ямар ч шаардлага, нөхцөл үүсээгүй тийм байдалд хэн нэг хүн өөрийн дуудлага, хэллэгээр богино цагт хэлж бичүүлнэ. Тэгвэл яавал зохимжтой бол? “Хэлцийн судалгаа хийх” аргаар ажиллах. Хэлц үгийг утгын тайлбартай нь өгч өгүүлбэр зохиох даалгавар өгнө. Утгын тайлбарыг жижиг цаас дээр бичиж бие биедээ дамжуулна.

Ороо нь ороогоороо

Жороо нь жороогоороо - Аливаа хүн нь өөрийн хэр хэмжээ, үзэл бодол, хүсэл сонирхлоороо ойр төсөөтэй хүнтэй холбоотой байдаг гэсэн утгатай

Энэ картыг авсан хүүхэд ар талд нь түүнтэй ойролцоо утгатай хэлц нэгийг тайлбартай нь нэмж бичнэ.

Ойролцоо утгатай хэлц нь:

Сайн нь сайнаараа

Муу нь муугаараа

Энэ аргаар дээрх 4 өвөрмөц хэлцийн утга, ойролцоо хэлцүүдийг судалж олуулсны дараа юу хийх вэ?, цээжээр бичүүлэх үү?

Судалгааны ажлын үр дүнд юу чаддаг болсныг, юу чадаж байгааг бичүүлж болно.

Бичихийн тулд дараах асуултыг чиглүүлэг болгон өгнө.

1. Зорилгоо биелүүлэхийн тулд ямар ямар ном ашигласан бэ?
2. Шинэлэг зүйл юу юу олж мэдэв?
3. Ямар бэрхшээл тохиолдов?
4. Шинээр мэдэж тогтоож авсан өвөрмөц хэлц гурвыг бичнэ үү.
5. Илүү сайн амжилтад хүрэхийн тулд өөр юу хийх бодолтой байна вэ?
6. Судалж мэдсэн хэлц үгээ жагсаан бичнэ үү.
7. Утгын тайлбарыг жишээгээр харуулна уу.

Хүүхдүүд эдгээр асуултын дагуу өөрөө хийсэн ажлаа эргэцүүлэн тунгаан бодож тайлбарлаж, эргэцүүлж бичнэ. Энэ бичвэрээ алдаагүй бичиж л байгаа бол тэд зөв бичих чадвартай болсныг харуулж байгаа юм.

Нөгөө тал нь ингэж судалж бодож бичих нь хүүхэд өөрөө “суралцах үйлд” өөрийн удирдлагатай оролцож байгаагаараа давуу тал болж байгаа билээ. Дээрх таван хэлц үгийг уншаад орхих бус утгыг нарийн сайн мэдэж авсан нь түүний ойролцоо утгатай хэлцийг олж хэрэглэж чаддаг болсонд байгаа юм.

Хэлц үгийн утгын тайлбар, тэдгээрийн ойролцоо утгатай хэлцийг олох зэрэг ажлыг даалгавар-2 болгож тусад нь бичүүлэн авч ч болно.

Дараах загвар материалыг багт нэгийг өгөөд “-ын, -ийн” нөхцөлтэй үгийн эгшигт ба заримдаг гийгүүлэгчийг эгшигжүүлж байгаа эгшигийг олуулж дүгнэлт гаргуулна. Энэ нь болжморын гэсэн үгийн “о” балархай эгшиг нь “м” эгшигт гийгүүлэгчийг эгшигжүүлж байна гэсэн шууд тайлбараас арай бүтээлч хандах даалгавар юм. Доорх загварт эгшигжүүлэх үүрэг зургаан өөр өөр нөхцөлд бий болж байгааг нэгтгэн дүгнэж ойлгохоор байгаа тул гуравдугаар ангийн сурагчдын бодит чадвар түвшнээс хамаарч янз бүрийн байдлаар судлуулж болох юм.

	Нэр үг	Үйл үг
I	Болжморын ангаахай, хэллэгийг тогтоох, өгүүлбэрийн утга, тайлбарыг унших, айлдвараа айлтгах, найдварын гэрээ, аргалын утаа, өвгөний яриа, төгсгөлийн мөр, улиангарын навч, дэргэдээс салахгүй, мэргэнээс асуух, амьсгалын дасгал, хүндрэлээс гарах, царцаа дэвхрээгийн цаг, нөмрөгөө дэргүүлэх, өтгөсөө асрах, өвгөдөө хүндлэх, дэвсгэрээ гүвэх, тэнгэрийн заадас	хөглөрөөд харагдах уулс, бөглөрөөд битүүрэх, эвлэрээгүй бяслаг
II	нөхцөлөө өөрчлөх, бусдадаа түгээх, нөхдөдөө талархах, малчдадаа хүргэх, төлчдөдөө туслах, зочдодоо бэлэглэх, чавхдасыг хөглөх	өвдтөлөө мөлхөх, багтдагийг нь авах, ойрттолоо танигддаггүй, туйлдсаны дараа, ундаассанаас болж, аргамжсанаа шалгах, жиндсэнээс үүдэлтэй, мэддэгээ харуулах, гүйцэгддэгийн даваан дээр, нар туссаныг хараад, шаргалтсаныг хараад
III	танхимын хурал, солирын бороо, хоригийг цуцлах, янгирын сүрэг, ахицыг тооцох, мангирын амт, тамхины хавтага, залхуурлыг зоригоор ялах, ангирын зулзага, үвдисаар тэтгэх, бархираа ишиг, онгиороо залуу, баримаар хэмжих, арвиныг нь харах, халимын нуруу, тахилын боов, гурилаа исгэх	нулимаад хаях, тохироод явах, даргилаад буцлах, залгилаарай, цоргилоод нүхлэх, зангилаад уях, доргимоор хөдлөх, хахираагүй байхад, бургилаагүй байгаа, оргилон асгарах, бархираагүй бол, нохой архираагүй байгаа
IV	дасгалын дэвтэр, ялгахаа мартаж, нагацаас асуух, хялгасаар томох, дурсгалын зураг, хоёр загалаа эмээллэх, аргалаа зарах, чанараа хадгалах, хоногийн хоол	хагараад унах, сугараад үлдэх, хоргодоод хоцрох, тунараад үлдэх, ханараад унах
V	Хонгорын элс, Арцатын өвөр, Улаанбаатарын өглөө, Бумбатын өртөө, Хонхорын станц, Дуламын хүү, Санчирын аав, Идэрийн ном, Бүгтэрийн бууц, Энэтхэгийн хойг	
VI	сонсогдохоо болилоо, хуцахаар нь харах, бичихийн учир, хооллохоор суух, амрахаа мартаж, амьдрахаар явах, тээнэгэлзэхээ болих, туслахаа мартаагүй, халтирахаас болгоомжил, зүүрмэглэхээр, илүүдэхээр байх, ялгарахааргүй адилхан, зогсохыг хориглох, ичихээ мэдэхгүй, хариулахаар явах, хазахаас болгоомжлох	

Дээрх хүснэгтэд байгаа үгсийг зөв бичих үүднээс ашиглахаас гадна зохиож ярих бичих үйлд үг сонголт хийхээр ашиглаж болохоор тул сурагчийн лавлах хэрэглэгдэхүүн болгон ашиглах боломжтой. Учир нь тэр бүр хүүхдүүд сонгон хэрэглээ болгоод байдаггүй үг хэллэг багагүй байгаагаас гадна холбоо үгээр өгөгдсөн тул хэрэглэхэд ойлгомжтой байх юм. Эх зохиож бичихдээ тухайн сэдвийн хүрээнд хэрэглэж болох үгийг эндээс түүж бүлэглэж болно. Жишээлбэл: “Миний дүүгийн анхны хөдөө” сэдвээр бичих бол дээрх тараах материалаас дараах үгсийг түүж бүлэглэн бэлдэж болох юм.

болжморын ангаахай, аргалын утаа,
дэргэдээс салахгүй, нөмрөгөө
дэрвүүлэх, өвдтөлөө мөлхөх,
багтдагийг нь авах, багаддагийг нь
солих, нар туссаныг хараад,
мангирын амт, нулимаад хаях,
бархираагүй бол, нохой архираагүй
байгаа

Сэдэвт тохирох үгийг ингэж түүх нь:

Үгээ сонгож байхдаа бичих санаагаа давхар бодож байдаг. Түүж бичихдээ зөв бичлэгийг нүдэлж тогтоож байдаг. Үгийн утгыг эргэцүүлж боддог. Үгийн хэрэглээг тунгаан бодож байдаг. Үгийн нөөц нэмэгддэг зэрэг олон давуу талтай.

ЗОХИОН НАЙРУУЛЖ БИЧИХ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
3.2д. Баярласан сэтгэлээ илэрхийлж, бүтцийн дагуу талархсан утгатай захидал бичих	Захидал бичихдээ 1. Хэнд, юунд талархаж бичихээ төлөвлөх, эргэцүүлэх 2. Захидлын бүтцийн дагуу бичиж ноороглох 3. Захидлын гол хэсэгт баярлаж, талархсан сэтгэлээ тодорхой гаргах 4. Ноороглох 5. Бичсэнээ хянах, бусдаар хянуулах, найруулгын болон зөв бичгийн дүрмийн алдаагаа засах 6. Зөв бичгийн дүрмийн бататгал дасгал ажиллах 7. Хэн нэгэнд уншин өгч, зөвлөгөө өгөх 8. Дахин сайжруулж, хичээнгүй хуулж бичих 9. Захидлыг зөв хаяглаж сурах Бүтээлч үйл ажиллагаа: Заавал байх хэсгүүдийг нь орхигдуулсан захидлыг гүйцээн, нөхөж бичихдээ (мэндчилгээ, огноо, захидал бичигчийн нэр, гарын үсэг...) - Заавал байх хэсгүүд нь өгөгдсөн захидлын загварт хэн нэгэнд зориулсан өөрийн сэтгэлийн үгийг нөхөн бичих - Захидалдаа хайртай тоглоом, амьтан, хүмүүсийнхээ тухай дүрслэн бичих - Ойр дотныхоо хүмүүст зориулж талархлын захидал бичихдээ дүрсэлж бичсэн хэсэг заавал оруулсан байх - Асуулт бүхий загварт хариулах аргаар захидалдаа дүрслэн бичсэн хэсгийг оруулах. Жишээ нь: Чиний тоглоом ямар? өнгөтэй, ямар? хэлбэртэй, хэдэн ширхэг вэ?...гэх мэт - Захидлаас Хэн?, юу?, хэзээ?, хаана?, хэд?, хэчнээн?, ямар? яаж байна? гэх зэрэг асуултад хариулагдах үгсийг түүж бүлэглэх - Дээрх асуултад хариулагдах үгийн утга, үүргийг ойлгож бичих	- Зохиолчдод сурагчдаас бичсэн захидал, хүмүүсийн хувийн захидлууд - Захидалд чухам юуны тухай бичээд байгааг тодруулан бичиж захианы эхлэл төгсгөлийг гүйцээх загварт үзүүлэн. Жишээ нь: “..... Түүнд нь хэчнээн баярласан гээч. Надад захиалсан юм шиг л таалагдсан шүү. Цэцгүүдийнх нь нэрийг сайн мэдэхгүй ч ягаан дэлбээгээрээ инээмсэглэл бэлэглэж байгаа юм шиг л харагдсан.”

Багшийн анхаарах зүйл:

Энэхүү суралцахуйн зорилтыг нэгж хичээлийн түвшинд 3.1е. суралцахуйн зорилттой холбоорой. Өөрөөр хэлбэл сурагчид талархсан утгатай захидлыг уншаад, хэнд юунд хэрхэн талархаж байгааг ажиглаж уншсаны дараа баярласан сэтгэлээ илэрхийлж, талархсан утгатай захидлыг бичүүлэхэд багш анхаарна. Гол шалгуур нь захидлын бүтцийн дагуу баярлаж талархсанаа илэрхийлсэн байна уу, алдаагүй зөв бичсэн байна уу, нооргоо засаж бичиж байна уу гэдгийг л багш анхаарч үнэлнэ.


3.2е. Хүсэл мөрөөдөл, зорилготойгоо нийцүүлж төлөвлөгөө зохион бичих	1. Төлөвлөгөөг яаж бичих талаар төсөөлөн бодох 2. Төлөвлөгөө бичихийн тулд хүсэл мөрөөдлөө илэрхийлж ярих 3. Мөрөөдөлдөө хүрэх өөрийнхөө зорилгыг эргэцүүлэх, зорилгоо тодорхойлох Ингэхдээ энэ 7 хоногт, эсвэл энэ сард гэх мэт хугацаагаа сонгоно. 4. Зорилгодоо хүрэх үйл ажиллагаагаа эргэцүүлэх, төлөвлөх Төлөвлөхдөө - Би мөрөөдөлдөө хүрэхийн тулд ямар зорилго тавих вэ? - Зорилгодоо хүрэхийн тулд юу юу хийх ёстой вэ? - Бусдын төлөө юу хийж болох вэ? - Илүү сайн сурах зүйл юу билээ? Түүний төлөө юу бэлтгэх, юу хийх вэ? 5. Төлөвлөгөөгөө цэгцлэх 6. Цэгцэлснээ бичиж ноороглох 7. Нооргоо засах, засахдаа зөв бичгийн дүрмийн алдаа гаргасан эсэхээ багштайгаа хамтран хянах 8. Алдсан үгийн дүрмийг тайлбарлах, бусадтайгаа ярилцах 9. Алдсан үгээ зөв болгон бичих, төлөвлөгөөгөө дахин хичээнгүй бичих 10. Хэн нэгэнд уншиж өгөх, зөвлөгөө авах	- 7 хоногийн төлөвлөгөөг бичсэн загвар жишээнүүд - Сурагчийн хийсэн төлөвлөгөөний жишээнүүд - Төлөвлөгөө бичих хуудас - Төлөвлөлтийн загвар үзүүлэн
--	---	--

Багшийн анхаарах зүйл:

Энэхүү суралцахуйн зорилтыг нэгж хичээлийн түвшинд 3.1е. суралцахуйн зорилттой холбоорой. Сурагчид төлөвлөгөөгөө 7 хоног, сар, жилээр гэх мэтээр өөрөө цаг хугацаагаа сонгож төлөвлөж болно. Төлөвлөгөөг цаг хугацааны дарааллаар бичдэгийг сурагчдад сануулна. Багш үнэлгээ хийхдээ дараах зүйлийг анхаарна.

1. Төлөвлөхөөсөө өмнө хүсэл мөрөөдлөө ярьж, ярилцаж байна уу?
 2. Хүсэл мөрөөдлийнхөө дагуу зорилгоо тодорхойлж байна уу?
 3. Зорилгодоо хүрэх үйл ажиллагаагаа төлөвлөгөөндөө тусгасан уу?
 4. Төлөвлөгөөгөө ноороглосон уу?
 5. Нооргоо засаад, дахин сийрүүлж бичиж байна уу? гэсэн асуултыг хэрэглээрэй. Багш та сурагчдын бичсэнийг шалгаад, зөв бичгийн дүрмийн алдаатай эсэхийг хянаад, засан сайжруулж өгнө үү. Сурагчид ямар дүрмийг алдааг хийцгээдгээ мэддэг болбол хичээлийн үр дүн харагдана.
- Долоо хоногт хийхээр төлөвлөсөн зүйлээ яаж хэрэгжүүлж байгаа, төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэхэд ямар бэрхшээл байгаа түүнийг хэрхэн даван туулж байгааг тус тус яриулж, явцын үнэлгээ хийнэ. Ингэж яриулсны зорилго бол хэлний хичээлээр дамжуулж, хүүхдийн зөв хандлагыг, өөрөө өөрийгөө таньж жолоодохын утга учрыг мэдрүүлж, төлөвшүүлэхтэй холбоотой. Гэрийн даалгаврыг бие даалгахаас гадна хосоор нь эсвэл багаараа ямар хүсэл мөрөөдөл дээр тулгуурлан, ямар зорилго тавьж, ямар төлөвлөгөө боловсруулж болох талаас сэдэлжүүлбэл сайн. Эсвэл алдаагүй зөв бичсэн эсэхийг гэрийнхэнтэйгээ, эсвэл найз нөхөдтэйгээ хянах чиглүүлэг өгч болно. Мөн гэр бүлийн гишүүдийнхээ 7 хоногийн ажлын төлөвлөгөө, эсвэл хувь хүний төлөвлөгөө, эдийн засгаа мөнгө санхүү хэмнэх төлөвлөгөөг сонсоод бичих, хамтарч бичих даалгавар өгвөл сурагчдад бүтээлч хандлага төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах юм.

3.2ж.Өгсөн зааврын дагуу тоочин жагсааж бичих (жор)	1. Хоолны жорыг бичсэнийг ажиглаад, ярилцах 2. Жор хэмжээг яаж тэмдэглэж, товчилсныг хэлэх 3. Хоолны тухай бичсэн мэдээллээс жорыг нь дарааллуулж ярих дасгал ажиллах 4. Зураг харж, хоол хийх дарааллыг ажиглаад, орц, хэмжээг тусган тоочин дарааллуулж ноороглон бичих 5. Нооргоо засан сайжруулах 6. Зөв бичгийн дүрмийн алдаа гаргасан эсэхээ багштайгаа хамтран хянах 7. Алдсан үгийн дүрмийг тайлбарлах, бусадтайгаа ярилцах 8. Алдсан үгээ зөв болгон бичих, төлөвлөгөөгөө дахин хичээнгүй бичих 9. Хэн нэгэнд уншиж өгөх, зөвлөгөө авах	- Хоол хийх дараалал харуулсан зураг - Хоолны төрөл бүрийн жор бүхий эмхэтгэл
Багшийн анхаарах зүйл: Энэхүү суралцахуйн зорилтыг нэгж хичээлийн түвшинд 3.1ө. суралцахуйн зорилттой холбоорой. Энэ хичээлийн үнэлгээний гол зорилго бол ТООЧИН ЖАГСААН БИЧИХ чадварыг эзэмших үйлтэй холбоотой. Өөрөөр хэлбэл хоол хийх дарааллыг мэдэх нь чухал биш, хоолны цуврал зургийг хараад “дарааллуулАН ТООЧИН, АЛДААГҮЙ, ЗӨВ БИЧИЖ байна уу гэдэг нь гол үнэлгээ юм. Үнэлгээний даалгавар боловсруулахдаа дарааллуулж ТООЧИН бичиж байгааг илрүүлэх зорилго тавина. Хоолны төрөл бүрийн жор бүхий эмхэтгэлийг хэрэглэхийн учир нь хүүхдийн үгийн сангийн нөөцийг нэмэгдүүлэх, гадаад үгийг тогтоон бичихэд чиглэгдэнэ. Хүүхдийг гэр орных нь ажилд оролцуулангаа гэрийнхээ хийдэг хоолны жорыг, хийх дараалалтай нь бичүүлэх гэрийн даалгавар өгч болно. Гэрийнхнээр нь зөв бичгийн дүрэм бүхий үгийг хянуулах, эцэг эхтэй нь хамтарч хийлгэх зорилго тавьж болно. Эцэг эх, гэр бүлийнхэнд нь зориулсан гэрийн даалгаврыг шалгах хуудасны жишээ: 1. Хоолны жорыг бичихдээ дарааллаар нь ТООЧИЖ бичсэн эсэх 2. Үгийн сангийн нөөц нэмэгдсэн эсэх, шинэ үг мэдэж авч байгаа эсэх 3. Бичихдээ зөв бичгийн ямар дүрмийн алдаа гаргаж байна вэ? Жишээ бичнэ үү. 4. Та хүүхэдтэйгээ хамтарч зөв бичгийн дүрмийн алдаагаа зассан уу? Тэдэнд зөвлөсөн үү? 5. Хүүхэд тань алдаагаа засаж, хичээнгүй бичиж байна уу? гэх мэт		
3.2з. Өгсөн сэдэв, бүтцийн дагуу үлгэр зохиож бичих	1. Зургийг дарааллын дагуу ажиглах 2. Юу бичихээ бодох эргэцүүлэх Жишээ нь, - Ямар нэртэй гарчиг өгч болох вэ? - Сайн хүний тухай болов уу? Сайн морины тухай болов уу? - Морь, хүн хоёрын найз нөхөрлөлийн тухай болов уу? - Эхлээд юу болсон бол, бодъя - Дараа нь баатруудад юу юу тохиолдов, бодъя - Тэгээд яасан бол? - Сонин сонин үйл явдал болсон болов уу? - Төгсгөлд нь яаж дуусах бол? 3. Илүү нарийвчилсан асуултын дагуу үйл явдлыг ургуулан бодох, төлөвлөх, хосоороо ярилцах Эхлэл хэсэгт: - Хаана, хэзээ болсон үйл явдал болсон бол? - Баатрыг хэн гэж нэрлэх вэ? Амьтдад ямар нэр өгөх вэ? Гол хэсэгт: - Жаалхүүд юу юу тохиолдох бол? Амьтдад бас юу юу тохиолдох бол?	- Цуврал зургууд  - Янз бүрийн үлгэрийн зохиомж бүхий цуврал зургууд

	- Тэдэнд бэрхшээл гарсан болов уу? - Бэрхшээлээ яаж шийдсэн бол? - Тэд хэний төлөө юу хийсэн бол? Тэр нь сайн үйл болов уу? Төгсгөл хэсэгт: - Эцэст нь яаж дуусав? - Та нар яагаад ингэж дуусгав? 4. Төлөвлөсний дагуу асуултад хариулах замаар, зургийн үйл явдлын дагуу ноороглон бичих 5. Нооргоо засан сайжруулах 6. Зөв бичгийн дүрмийн алдаа гаргасан эсэхээ багштайгаа хамтран хянах 7. Алдсан үгийн дүрмийг тайлбарлах, бусадтайгаа ярилцах 8. Алдсан үгээ зөв болгон бичих, төлөвлөгөөгөө дахин хичээнгүй бичих 9. Хэн нэгэнд уншиж өгөх, зөвлөгөө авах Бүтээлч үйл ажиллагаа: 1. Тэгээд, дараа нь, яагаад, яав гэх мэтээр хүүрнэмж эхийг дуурайн бичих 2. Бусдын санааг цаг хугацааны дарааллаар үргэлжлүүлэн бичих - Сурагч бүр өөрийн төсөөллийн хамгийн чухал гэж үзсэн нэг өгүүлбэрийг бичээд бусдад тойрог хэлбэрээр дамжуулна. - Хүн бүхний бичсэн санааг цаг хугацааны дарааллаар үргэлжлүүлэн нэг нэг өгүүлбэр бичсээр хүн бүрийнх өөртөө эргэж ирнэ. - Эхлэн төсөөлж байсан зүйл олон хүний санаагаар баяжин хэр өөрчлөгдсөн байгаа талаар ярилцах. Үйл явдлын дарааллыг гаргахын тулд бичиж илэрхийлж байгаа зүйлдээ цагийн утгыг зөв гарган илэрхийлж бичих. Жишээ нь Өнгөрсөн цагийн ... нөхцөлийг зөв ашигласан эсэх гэх мэт. -Цаг хугацааны шулуун байгуулж бичихдээ дэвтэртээ шулуун шугам зураад үйл явдлыг цагийн дарааллаар товчоор тэмдэглэх  Хаврын сүүл сард төрсөн	
--	---	--

Багшийн анхаарах зүйл:

Энэхүү суралцахуйн зорилт нь 3.1в, 3.1д-тэй холбоотой юм. Сурагчдаас төсөөлөн бодох, ургуулан бодох чадвар шаардах тул өмнөх бичих чадваруудаас харьцангуй хүнд байж болох талтай. Гэхдээ багш та бэрхшээлийг өндөрсгөх сурган хүмүүжүүлэх зармчыг баримтлан, зураг ажиглуулан, асуулт хэрэглэн, сурагчдын зохион бичих чадварыг хөгжүүлэхийг зориорой. Хамгийн гол нь сурагчдыг үлгэр уншуулах дуртай болгож, үлгэрийн талаар ярилцах дуртай болгож гэмээнэ үлгэр бичүүлэхэд чиглүүлээрэй. Огт үлгэр уншдаггүй хүүхэд бичихдээ бэрхшээлтэй байна. 2 дахь үйл ажиллагаа нь эхлээд зохиох үлгэрийнхээ талаар ерөнхий бодуулах, эхлэл, гол, төгсгөлөөр нь бодуулах зорилготой. 3 дахь үйл ажиллагаа нь нэлээн нарийвчилсан асуултын төлөвлөлттэй байгаагаас гадна та өөрийнхөө туршлага, оюуны сэтгэлгээгээрээ асуултуудыг улам баяжуулах байх. Үлгэр анх зохиолгохдоо багаар нь юм уу хосоор нь ярилцуулж бичүүлэхэд анхаараарай. Зохиох арга барилтай болсон тохиолдолд бие даан хийлгүүлэхийг бодоорой. Магадгүй эхнээсээ ганцаараа зохиох сонирхолтой сурагч байхыг үгүйсгэхгүй.

Дүрсэлж бичүүлж сургахын тулд ямар гэсэн асуултаар өгүүлбэрийг дэлгэрүүлж болно. Жишээ нь, Багш сурагчийн харилцан ярианы загвар: Багш: Хаана үйл явдал болсон байж болох вэ? Сурагч: Уулын нөмөрт, эсвэл тал хээр газар Багш: Ямар уулын нөмөр байж болох вэ? Тал хээрийг илүү тод дүрсэлье гэвэл дараах үгсээс хэрэглээрэй. Цэцгээр дүүрэн тал, өвсөн толгой ганхсан тал, зам сүлжилдсэн тал гэх мэт Сурагч: Оройдоо цастай уул, мод ихтэй уул, ширээ шиг тэгшхэн уул, өндөр сайхан уул Багш: Тал хээрийг илүү тод дүрсэлье гэвэл дараах үгсээс хэрэглээрэй. Цэцгээр дүүрэн тал, өвсөн толгой ганхсан тал, зам сүлжилдсэн тал гэх мэт Уламжлалт сургалтаар бичих сэдвийг багш оноож, бичүүлдэг аргаас аль болох зайлсхийж сурагчдаар өөрсдөөр нь хэлэлцүүлэх нь тухайн зохиолыг хэчнээн олон талаас нь бичиж болохыг ойлгуулахад сайн талтай. Жишээлбэл: Зохиолыг уншсаны дараа ангиараа ямар сэдвээр бичихээ зөвлөлдөнө. Сурагчдаас гарсан саналуудыг жагсаан бичнэ. Сурагчид бичиж байхдаа шинэ санаа гаргаж байдгаас энэ жагсаалтад нэмэлт өөрчлөлт орж болохыг сануулна. Бичих сэдвээ сонгосны дараа түүндээ өөрийн байр сууриас хандах, бас тэдний бичсэнд нь зохиогчийн эрхийг нь хүндэтгэж байх, өгсөн зөвлөгөөг хүлээж авах эсэхээ сурагч өөрөө шийдэх эрхтэй байх зэргийг багш анхаарснаар хүүхэд бүрийг бичих чадварт сайн сургаж чадна. Орчин нөхцөлийн болон суралцахуйн ялгаатай байдлыг бичих үйл явцад яаж тооцох вэ? Энэ нь сургалтын материал хэрэглэгдэхүүний олдоц, ховор байдлаас төдийлөн шалтгаалахгүй талтай, харин хүүхдийн сурах арга барилын ялгаатай байдалд л багшаас өөр өөр ур чадвар шаардах юм. Бичих явцад нь эргүүлэн нягталж уншаарай, юуг өөрчилмөөр байна гэсэн “будилуулах” зааврууд огт хэрэггүй. Учир нь бичих явцад улам санаа төрж байдаг болохоор тэр. Юутай ч чөлөөт сэдвээр санаа бодлоо цэгцлэх, тодорхой нэг сэдвээр санаа бодлоо цэгцлэх гэсэн хоёр өөр шугам байгааг хүүхдийн ялгаатай байдалд нийцүүлэн зохион байгуулах юм. Үүнд: - Эхийн дутуу хэсгийг холбоо хамаарлаас нь гүйцээн бичихдээ зураг, төлөвлөгөө, зохион бичих гэх мэт янз бүрийн хэлбэрээр хийлгэж болох юм. - Эхийн орхигдсон үгийг өгүүлбэрийн утгаас нөхөн гүйцээж бичих, ингэхдээ үгийн утга болон өгүүлбэр зүйн тогтолцоог бодож тааварлан нөхөж бичих - Эхийн орхисон хэсгийн үйл явдлыг харуулсан зургийг ажиглаад ургуулан бичих гэх мэт. - Зохиолын дутуу хэсгийг зохиомжлон бичихдээ эхлэл хэсгийг уншаад үргэлжлүүлэн зохиож бичих, төгсгөл хэсгийг уншаад эхлэл хийж бичих, эхлэл, төгсгөл хэсгийн дунд үйл явдлыг үргэлжлүүлэн холбож бичих гэх мэт.		
3.2и. Шүлэг, ертөнцийн гурвын хэлбэрийг дуурайн зохиож бичих	1. Дуурайн бичих шүлэг юм уу. Ертөнцийн гурваас сонгох 2. Дуурайн бичих хэлбэрээ сонгох - Толгой холбож бичсэнийг дуурайн бичих - Агуулгыг дуурайж бичих - Сүүл холбон бичсэнийг дуурайн бичих - Мөр бүрийн үгсийн тоог дурайн бичих 3. Дуурайн бичин ноороглох 4. Нооргоо сайжруулахын тулд хянах шалгах - Тэгэхдээ доорх шалгуурыг үндэс болгоно. - Асуултын дагуу бичиж чадаж уу? - Сэдэв нь өөр байж чадаж байна уу? - Хэлбэр хэв маяг нь төстэй болж чадсан байна уу? - Найруулгын ямар нэгэн алдаа байна уу? - Зөв бичих дүрмийн алдаа байна уу? 5. Бусдаас суралцахын тулд бусдын зохиосон зохиолтой танилцах - Бичсэнээ сольж унших - Зарим сурагч өөрсдийн хүсэлтээр өмнө гарч унших - Бүтээлийн үзэсгэлэн гаргах зэрэг	- Дуурайн бичихэд хялбар бүтэцтэй богино хэлбэрийн эх сонгох. Жишээ нь: Д.Равжаа зохиолчийн Хоёр нь Саруул мунхаг хоёр нь Онох эндүүрэх хоёр Цагаан хар хоёр нь Авах гээх хоёр Өвөл зун хоёр нь Хүйтэн халуун хоёр Төрөх үхэх хоёр нь Бүтэх эвдрэх хоёр

Багшийн анхаарах зүйл:

2 дугаар ангидаа “Ертөнцийн гурав”-ыг дуурайн бичиж сурсан тул энэ ангид “Ертөнцийн гурав”-аас гадна шүлгийг дуурайн бичүүлэхэд анхаарна. 4 мөртөөс хэтрэхгүй шүлэг дуурайлган зохиолгоход анхаарна уу. Шүлэг дуурайлган бичүүлэхээс өмнө дуурайн бичсэн загвар жишээг ажиглуулж, ярилцвал үр дүнтэй. Багш нь мөр бүрийн үг бүрт асуулт тавин, хүүхдээр дуурайлгах үйл хийлгэж болно. Жишээ нь:

Миний хэнз хурга

Магнай халзан зурвастай гэхийг дуурайлгая гэвэл

Хэний ямар амьтан?

Хаанаа ямар содон тэмдэгтэй вэ? гэх маягаар зохиолгож болно. Энэ нь үгийн аймагтай танилцахаас гадна хэл зүйн анхан шатны ойлголттой болох зорилготой юм.

3.2к.Өгсөн бүтцийн дагуу уншсан номоо тэмдэглэн бичих	1. Үлгэрийн ном сонгон унших 2. Уншсан номоо хэрхэн тэмдэглэн хөтлөхөө хэлэлцэх 3. Уншсан номоо тэмдэглэхийн учир зорилгын тухай хэлэлцэх 4. Уншсан номын талаар тэмдэглэх. Жишээ нь, - Зохиогчийн нэр, зохиогдсон он, хаана хэвлэгдсэн газар, гол баатрын нэр, номын агуулга, хуудасны тоо зэргээс өөр юу тэмдэглэж болохыг ярилцах 5. Номын агуулга хэсэгт үйл явдлыг, зохиолоос юу ойлгосноо хэрхэн бичсэнийг уншиж, дүгнэлт хийх 6. Тэмдэглэлээ бусдад танилцуулах бэлтгэл хийх 7. Хэрхэн тэмдэглэснээ ажиглах, үнэлэх Үнэлэхдээ: - Зөв бичгийн дүрмийн алдаагүй байна уу? - Бичих гэсэн зүйлээ бичиж чадсан уу? Бүтээлч үйл ажиллагаа: - Номын тэмдэглэлд юу юуг тэмдэглэхээ зураглах, хүснэгт зохион хэлэлцэх	- Номын тэмдэглэл хийх загварын хувилбарууд
---	---	---

Багшийн анхаарах зүйл:

Энэхүү суралцахуйн зорилтыг нэгж хичээлийн түвшинд 3.1е. 3.1б гэсэн суралцахуйн зорилтуудтай холбоорой. Бичсэн номын тэмдэглэлээ танилцуулах ажлыг зохион байгуулахдаа 4 дүгээр ангийн сурах бичиг дэх агуулгыг багш судалж, хэрэглэж болно. Сурагч бүр номын танилцуулга хийсний дараа багш дараах байдлаар нэгтгэж болох юм. Эхлэн суралцахын тулд ямар сэдэвтэй ном уншсанаа тэмдэглэх эхний алхам:

Номын нэр	Ан амьтны онцлогийн талаар	Ажил хөдөлмөрийн талаар	Монгол ёс заншлын талаар	Зан чанарын талаар	Амьтан хайрлах талаар
Чулуун домог					
Шаргачин					
Зугаат зуны амралт					
Яагаад саван хөөсөрдөг вэ?					
Зохиол 4					
Зохиол 5					
Зохиол 6					

Сэдвийн хувьд сурагчдын хүсэл сонирхол, зорилгоос хамаарахаас гадна тэдний онцлогт нийцүүлэн багш бас өөр сэдэв ч нэмж өгч болох бөгөөд хамгийн чухал нь нь ямар ямар сэдвээр хэд хэчнээн ном уншсанаа дээрх байдлаар тэмдэглэж цэгцэлж явах юм. Санааг тодорхойлох дараагийн алхам: Энд сэдвээр төрөлжүүлэхдээ уг зохиолуудын өөртөө чухал гэсэн санааг тодорхойлно.

Номын нэр	Ан амьтны онцлогийн талаар	Ажил хөдөлмөрийн талаар	Монгол ёс заншлын талаар	Зан чанарын талаар	Амьтан хайрлах талаар
Чулуун домог			чухал санаа		
Шаргачин	чухал санаа				
Зугаатай зуны амралт		чухал санаа			
Яагаад саван хөөсөрдөг вэ?					чухал санаа
Зохиол 4			чухал санаа		
Зохиол 5		чухал санаа			
Зохиол 6			чухал санаа		
Мэдээллээ боловсруулах			Зохиолуудын хоорондын хамаарлыг тогтооно.		

Өөрөөр хэлбэл чадвараа ахиулах замаар хүснэгтэд уг зохиолын өөртөө чухал гэсэн санааг, шинэ санаа, асуудлыг гэх мэтээр мэдээллээ эмхэлж цэгцлэн товчлон тэмдэглэж явснаар аливааг системтэйгээр танин мэдэх боломжтой болно. Монгол зан үйлийн сэдэвтэй зохиолуудын гол санаануудыг тодорхойлсноор тэдгээрийг харьцуулах, нэгтгэн дүгнэж мэдээлэл боловсруулах зэргээр сурагч боловсруулах ур чадварт суралцах боломжтой болно.

Эдгээр нь аливаа зохиолыг уншаад юуны тухай гарав? Хэн хэний тухай?, Хэн яасан? гэх мэт ерөнхий асуултаар ярилцдаг сурах арга барилаас өөр юм.

Уншсан номын агуулгыг төрөлжсөн байдлаар цэгцэлж авах нь танин мэдэхүйн цар хүрээгээ өргөтгөх, мэдлэгийн тогтолцоо үүсгэхэд чухал нөлөөтэй. Ингэснээр системт мэдлэгийн бүтэц үүснэ. Үүний төлөө зорилго, хүсэл эрмэлзлийнхээ хүрээнд хүрэлцээтэй уншсан байх хэрэгтэй болно.

3.2л. Уншсан зохиолын талаар сэтгэгдлээ илэрхийлэн бичих	1. Уншсан зохиолын хүрээнд сэтгэгдлээ илэрхийлэн ярих дасгал ажиллана. Зохиолын аль хэсэгт, ямар дүрд баярласнаа, өрөвдсөнөө, гомдсоноо гэх мэтээр сэтгэлийн олон өнгө аясаа илэрхийлэн ярих	- Төрөл бүрийн утгатай эх - Дүрийн янз бүрийн үйлдэлтэй эх зохиол
	2. Ярьсны дараа ноороглон бичнэ. Эхлээд яасан, дараа нь юу болсон, тэгээд яав гэсэн асуултын дарааллаар бичих 3. Ноороглосноо хянах. Ингэхдээ багштайгаа хамтарна. - Найруулгын засвар хийнэ. Ойлгомжтой байна уу? Үг нэмэх үү? Эсвэл үг хасах уу? Үгийн байрлалыг солимоор байна уу? Үгийг солих уу? гэсэн асуултыг хэрэглэнэ. - Зөв бичгийн дүрмийн засвар хийнэ. 4. Засвар хийсний дараа сайжруулан хичээнгүй бичих 5. Хэн нэгэнд уншин, зөвлөгөө авах	

Багшийн анхаарах зүйл:

Энэхүү суралцахуйн зорилтыг хүүхдийн уншсан бүхий л зохиолтой холбон хэрэгжүүлж болно. Хамгийн гол нь мэдрэмж илэрхийлж бичихээс ялгаж үнэлнэ. Сэтгэгдэл гэдэг бол сэтгэлийн олон өнгө аясыг хэлж байгаа учраас зохиол уншаад ямар санагдсаныг тодруулахдаа айх, гайхах, баярлах, гомдох, уярах, сэтгэл догдлох, өрөвдөх, хайрлах гэх мэт үйл үгийг хэрэглэж багш асуулт зохиоход анхаарна. Хамгийн гол нь сурагч ямар үйл явдлаас, ямар дүрийн ямар үйл хөдлөлөөс, ямар үгээс сэтгэлийн өнгө аяс гаргаж байгааг багш илрүүлж, дүгнэхэд анхаарна. Мөн сэтгэгдлээ ярьсны дараа алдаагүй зөв бичиж байгааг, бичихээсээ ноороглож байгаа эсэхийг, нооргоо засаж байгаа эсэхийг, алдаагаа засаж бичиж байгаа эсэхийг сайтар анхаарч сурагчдыг чиглүүлнэ.

Анхны эх нооргоо гаргахдаа төлөвлөснийхөө дагуу зохион найруулж бичихийг сануулаарай. Хүүхдүүд дахин бичих, засан сайжруулах боломжийг олгохоор үйл ажиллагааг зохион байгуулах хэрэгтэй.

Сурагчид бичсэн зүйлээ бусдад уншиж өгөх, бусдын саналыг сонсох, өөрсдөө саналаа хэлэх зэрэг нь өнөөгийн сургалтад давамгайлдаг зөвхөн багшаар уншуулдаг, багшийн л саналыг авахаас илүү сонирхолтой, үр дүнтэй арга тул аль болох энэ боломжийг олгож байгаарай.

ГУРАВ. СОНСОХ- ЯРИХ ЧАДВАР

Нэгж хичээл бүрд УНШИХ, БИЧИХ чадварыг эзэмшүүлэх ээлжит хичээлийн үйл ажиллагаатай уялдуулан тод чанга, ойлгомжтой, бүтэн өгүүлбэрээр, тодорхой ярих гэсэн шаардлагыг багш тавина.

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
3.3а. Болсон явдал, сонссон зүйлийн учир шалтгааныг бусдын өмнө тодорхой ярих	Болсон явдлын учир шалтгааныг бусдын өмнө тодорхой ярихдаа: 1. Хэзээ ч мартагдахааргүй, сэтгэл хөдөлгөсөн, ховор, азтай, ухаарч үргэлж бодож явахаар тохиолдлууд эсвэл өдөр тутам тохиолдсон явдлаасаа нэгийг сонгон тэмдэглэх 2. Болсон явдлаа ярихдаа үйл явдал, цаг хугацааны дарааллын дагуу эхлээд, дараа нь төгсгөлд нь юу болсныг тодорхой ярих талаар бэлдэх 3. Хэзээ, хаана юунаас болж юу болсныг, хэрвээ ... тийм явдал болоогүй бол азтай (ховор, мартамгүй, сэтгэл хөдлөм, ухаармаар гэх мэт) тохиолдол тохиолдохгүй байсныг тодруулж, учир шалтгаантай ярихад бэлдэх 4. Ярихдаа “тийм учраас, ийм учраас, тэгснээс шалтгаалж, ингэснээс шалтгаалж ...ийм зүйл болсон” гэх мэт үг хэллэг хэрэглэх 5. Бэлдсэнээ самбарын өмнө, эсвэл тойрч зогсоод бусдын өмнө тодорхой ярих 6. Ярьснаа эргэн хянах, тодорхой байж чадсан эсэхийг үнэлэх, бусдын дэмжих Сонссон зүйлийн учир шалтгааныг бусдын өмнө чөлөөтэй ярихдаа: 1. Багшийн уншсан үлгэрийн үйл явдлыг анхааралтай сонсох 2. Сонсоод, асуултад хариулж утгыг ярилцах 3. Баатруудын хийсэн үйлийг тоочиж бичээд, хэнээс болж юу болсныг багаараа хэлэлцэх 4. Хэлэлцсэнээ бусдын өмнө тодорхой ярих 5. Ярьснаа эргэн хянах, тодорхой байж чадсан эсэхийг үнэлэх, бусдын дэмжих	- Болсон явдлаа учир шалтгаантай илэрхийлж бичсэн бичвэр - Самбарын өмнө, цэх, өөртөө итгэлтэй, ангийнхан руугаа харж зогсож байгаа хүүхдийн зураг байж болно. Эсвэл өөртөө итгэлгүй, доошоо харсан, биеэ барьж зогссон хүүхдийн зураг байж болно. - Сонсгох үлгэр

Багшийн анхаарах зүйл:

Болсон явдал гэдэг бол үнэн бодитой түүх юм. Энэхүү суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхдээ 2 өөр үйл ажиллагаагаар хэрэгжүүлж болно. Өөртөө тохиолдсон явдлаа 2 дугаар ангид бичиж сурсан гэж үзэж байгаа ч зарим хүүхдийн хувьд ярих чадвар төдийлөн сайн эзэмшээгүй бол 3 дугаар ангид нь дэмжлэг болгож, болсон явдлыг яриулаарай. Ингэхдээ сэтгэл хөдөлгөм ямар үйл явдал тохиолдсоныг эсвэл хэзээ ч мартагдахааргүй, ховор, аз таарсан, эсвэл азгүй, бас ухаарч явмаар тохиолдлуудыг яриулахдаа учир шалтгааны асуултын дагуу яриулахад анхаараарай. “Тэр үед тохиолдсон юм. Тэгэхэд би..... байсан. Ингэсэн нь надад ингэж бодогдож байсан. Би ч гайхсан” гэх зэрэг үг хэллэгийг хэрэглэхийг санал болгож болно. “Яасан байхгүй юу, юу л даа, нөгөө” гэх мэт сул үг хэрэглэхгүй байх, “тэгээд, тэгээд” олон дахин давтаж ярихгүй байхыг сануулах хэрэгтэй. Үнэлгээний шалгуурт ч оруулж тооцож болно. Энэхүү чадварыг эзэмшсэнийг шалгах үнэлгээний шалгуурыг дараах байдлаар боловсруулж болно.

1. Болсон явдлаа ярихдаа үйл явдлын дарааллаар ярьж байна уу?

2. Ярихдаа учир шалтгааныг тодруулж ярьж байна уу?

3. Бусдын өмнө гарч, өөртөө итгэлтэй, тодорхой ярьж байна уу?

Тодорхой гэдэгт үйл явдлын дараалал, учир шалтгаан гэсэн хоёр зүйлийг харгалзана. .

Сонссон үлгэрийнхээ учир шалтгааныг тодруулахдаа дараах шалгуурын дагуу яриулахад сургана.

1. Үлгэрийнхээ баатруудын хийсэн үйлдлийг сайн мэдэж байна уу?

2. Баатруудын хийсэн үйлдлүүдийн учир шалтгааныг тодруулж ярьж байна уу?

3. Ярихдаа бусдын өмнө тодорхой ярьж байна уу? Тодорхой гэдэгт дараах зүйлийг харгалзана.

Баатруудын үйл хөдлөл, тэдгээрийн учир шалтгаан

3.36. Хэлэлцүүлгийн үед бусдын ярианаас лавшруулан, тодруулан асуух замаар идэвхтэй сонссоноо харуулах	1. Юуг хэлэлцэхээ тодруулах, зорилго тавих 2. Хэлэлцэх үедээ бусдын ярьснаас тодруулан, лавшруулан асуух зүйлээ бодох 3. Бусдыг сонсож, ээлж дараагаар асуултаа тавих Өөрийн сэтгэгдлийг бусадтай хуваалцах Хэрэглэх үгийн зарим жишээ: Ойлголт, ярьсан зүйлийг тодруулахдаа - Миний ойлгож байгаагаар та ...тухай ярьж байна. - Таны чиний ярьснаас ингэж ойлголоо. Гэхдээ ...ийм мэдээллийг тодруулмаар байна. - Энэ нь надад өмнө сонссон тухай санагдуулж байна. - Та ... гэж ярьж байна. Үүнийг жаахан тодруулахгүй юу? - Би зарим ... –д бүр төөрчихлөө гэх мэтээр тодруулгаар хэлэлцүүлгийг өрнүүлэх - Өгүүлэгч өөд харах, үл мэдэг гэлжийх, яриаг таслахгүй байх, инээмсэглэх, бага зэрэг толгой дохих гэх мэтээр анхаарч сонсох үйлүүдийг хийх	- Хэлэлцэн ярилцах чөлөөт сэдвүүд - Тодруулах зорилготой асуултыг байрлуулах самбар байж болно
--	---	---

Багшийн анхаарах зүйл:

Энэхүү суралцахуйн зорилт нь ИДЭВХТЭЙ СОНСОХ чадварыг хөгжүүлэх зорилготой. Идэвхтэй сонсоно гэдэг нь ярилцагч харилцагчаасаа ямар нэгэн зүйлийн тухай тодруулж асуухыг хэлж байгаа юм. Сайн идэвхтэй сонсогчийг төлөвшүүлье гэвэл анхааралтай ойлгож сонсоод, ойлгомжгүй юм уу сонирхолтой санагдсан зүйлээ тодруулж лавшруулж асууж сургахад чиглүүлнэ гэсэн үг. Юуг тодруулж асуумаар байна? Юуг лавшруулан сонирхмоор байна вэ? гэсэн асуултаар багш чиглүүлнэ.

Сурах үйл ажиллагааны 1-рт төлөвлөснөөр юуг хэлэлцэхийг дараах байдлаар чиглүүлээрэй.

1. Тодорхой чөлөөт сэдвээр өрнүүлэх

2. ХГҮА-ны цаг, СТЕМ хичээлийн үйл ажиллагаатай холбох. Тухайлбал, жин хэмжигчийг хийхийн тулд ямар ямар блокууд орохыг хэлэлцэх, хийснийхээ дараа яаж хийснээ хэлэлцэх гэх мэт

3. Бусад хичээлүүдтэй интеграцилан сурагчдын энэ чадварыг хөгжүүлэх хэрэгтэй. Жишээ нь, тоогоо хэрхэн бодох, хэрхэн бодсоноо хэлэлцэх гэх мэт. Ер нь СОНСОХ зорилготой хичээлийг дан ганц монгол хэлний хичээлээр хөгжүүлэхээс гадна бусад хичээл дээр үнэлгээний шалгуур болгож, сурагчдыг хөгжүүлбэл үр дүнд хүрнэ.

Хүүхэд өөрийнхөө чухал гэж үзэж байгаа бодол санаагаа зөв хэлбэрээр бусдад ойлгуулж чаддаг байх хэрэгтэй юм. Тэдэнд юу хэлэхээ эргэцүүлэн бодох хугацаа өгнө. Тэд бодсоноо цаасан дээр буулгасан бол ярихад нь улам хялбар байх учраас багш бичгээр, зургаар, бүдүүвчээр тэмдэглэхийг дэмжиж байх хэрэгтэй. Сурагчид ярих сонирхолгүй байвал “зөв” хариулт өгөх нь чухал боловч гол нь янз бүрийн санал, үзэл бодлыг судлах нь чухлыг сануулж дэмжээрэй.

Зөвхөн хэдхэн сурагч идэвхтэй оролцоод байвал санал хэлэхгүй байгаа сурагчдаас асуулт асуух, өмнө гаргасан саналын жагсаалтыг дахин уншуулах гэх мэтээр оролцох идэвхийг өрнүүлэхэд анхаарна.

Явцын үнэлгээг хийхдээ дараах зүйлд анхаараарай. Үүнд:

- ✓ Сурагчид мэдэж байгаа зүйлээ бусадтай хуваалцаж, хэлэлцэж чадав уу?
- ✓ Сурагчид бусдын үзэл бодлыг сонсож, тодруулах зүйлээ асууж чадсан уу?
- ✓ Ямар чухал асуудлууд болон санал нийлэхгүй асуудал гарсан бэ?
- ✓ Хүүхдүүдэд ямар чадвар илүү болон сул хөгжсөн ажиглагдав? гэх мэтээр дүгнэлт хийнэ.

3.3в. Хэлэлцэх, ярилцах үед хүсэл, санаа бодлоо бусдын өмнө чөлөөтэй илэрхийлэх	Уншсан зохиолын талаар хэлэлцүүлэг өрнүүлэхдээ: 1. Эхийн агуулгыг ойлгож унших, уншсанаа ярилцах 2. Зохиолд юуг сургамжилсныг хэлэлцэх 3. Зохиолын баатруудын хийсэн үйл зөв эсвэл буруу болсныг хэлэлцэх, зохиолоос жишээ татах 4. Багшийн гаргасан тодорхой асуудлын хүрээнд санал хэлж, хэлэлцүүлэгт оролцох - Дэмжиж байна, эсвэл дэмжихгүй байгаагаа илэрхийлэн санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх Тодорхой сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлэн ярихдаа - Чөлөөтэй хэлбэрээр ярих Жишээ нь: Би энэ тухай сайн мэдэхгүй ч ... гэж хэлж болох юм шиг санагдлаа. - Ном уншихын давуу талыг “...” номонд “...” гэж бичсэн байсан шүү. Түүнийг уншвал “...” “...” гээд олон шинэ мэдээлэл олж авч болно гэх зэргээр ном унших ач холбогдлын талаарх сэдвийн хүрээнд ярина гэсэн үг. - Тухайн сэдвийн хүрээнд зохистой зүйр цэцэн үг хэлэх Чөлөөтэй, тодорхой харилцахын тулд - Өөрийн бодлыг бичиж тэмдэглэх - Зурж тэмдэглэх - Төлөвлөх - Жагсаалт хийх - Өөрийн бодож, мэдэрч, төсөөлж байгаа зүйлээ тодорхой илэрхийлэх - Дууны өнгө, нүүр царайны хувирал, хөдөлгөөнөө ярьж байгаа зүйлдээ тохируулах - Сонсогчийг анзаарч ярих. Тухайлбал, анхаарсан, сонирхсон, төвөгшөөсөн байдлыг анзаарч мэдрэх	- Хүсэл тэмүүлэлтэй, зорилготой хүний тухай өгүүлсэн ярилцлага - Зохиомол тохиолдол бүхий эх - Зохиогчийн үзэл бодлын талаар эргэцүүлэн бодохуйц эх бичвэр тэр эхээс хэд хэдэн дүгнэлт тайлбар гаргах боломжтой байх. Өөрөөр хэлбэл олон хувилбарт санаатай байх. Үлгэр нэлээн тохиромжтой.
---	--	---

Багшийн анхаарах зүйл:

Энэхүү суралцахуйн зорилтыг УНШИХ зорилготой ээлжит хичээлтэй интеграцилан нэг нэгж болгон хэрэгжүүлж болно. Хэлэлцэнэ гэдэг нь хэлэлцэж байгаа асуудлыг дэмжиж ч болно, дэмжихгүй байхыг ч хэлнэ. Яагаад дэмжиж байгаагаа хэлэх нь, яагаад дэмжихгүй байгаагаа хэлэх нь хэлэлцүүлгийн гол мөн чанар. Хүүхдийн санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг ямар нэгэн зүйлийг хэлэлцэх үйл явц олгодог. Багш хэлэлцүүлэг хийхдээ эхлээд ямар асуудлын талаар хэлэлцэхээ урьдчилан тогтсон байх нь зүйтэй. Тэрхүү асуудал нь хүүхдэд тулгамдсан асуудал байж болно, эсвэл бэрхшээлтэй асуудал байж болно. Эсвэл асуудлыг тодруулж ярихаар, олон янзаар тайлбарлаж болохуйц эх зохиол байж болно. Тухайн асуудлын талаар хүүхэд бүр өөр өөрийнхөө санаа бодлыг нээлттэй илэрхийлэх боломжийг өгөхүйц байдлаар зохион байгуулна.

Хэлэлцүүлгийн тухай заах биш хүүхэд бүр асуудалд яаж хандаж, ямар санаа бодолтой явдгийг илрүүлэх нь энэ хичээлийн зорилго юм. Гол үнэлгээ нь, үнэлгээний гол шалгуур нь бусдын өмнө санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж байна уу гэдэгт анхаарна.

3.3г. Зохиолын баатрын дуу хоолой, биеийн хөдөлгөөн, харцыг дуурайн, дүрд тоглох	1. Эхийн утгыг ойлгож унших, ярилцах 2. Ярилцахдаа бусдын яриаг анхааралтай сонсон, зарим зүйлийг тодруулж асуух 3. Уншсан зохиолоосоо нэг баатрыг сонгох 4. Сонгосон баатрынхаа зан чанарыг тайлбарлах 5. Зан чанарт нь тохируулж дуу хоолойны өнгөө өөрчлөх дасгал хийх, жишээ нь: <i>Чоно уурлавал, гунивал, өлсвөл ямар дүрх төрхтэй байх бол?</i> 6. Зан чанарт нь тохируулж харцаа өөрчлөх, биеийн хөдөлгөөнөө өөрчлөх 7. Дүрд хэрхэн тоглохоо ярилцах 8. Дүрд тоглох 9. Хэрхэн тоглосноо эргэн дүгнэх Дүгнэхдээ: - Дуу хоолойныхоо өнгийг баатрын зан чанарт тохируулж чадсан уу? - Харц, биеийн хөдөлгөөн нь залхуу, эсвэл ажилсаг, харамч, сайхан сэтгэлтэй гэх мэт зан чанарыг харуулж чадсан уу? гэх мэт	- Дүрийн зан чанар нь өөр хоорондоо ялгарсан, харилцан яриа сайтай эх зохиол
---	---	---

Багшийн анхаарах зүйл:

Зохиолын баатрын дуу хоолойны өнгөө, биеийн хөдөлгөөнийг (харц) тохируулан жүжиглэх ээлжит хичээлийн хувилбарыг санал болгож байна.

Сэдэлжүүлэх: Сурагчдыг багт хувааж хоёр баг нь чонын хийж болох үйлдлийг жагсаан бичээд хөдөлгөөнөөр үзүүлэх, нөгөө хоёр баг нь зарааны хийж болох үйлдлийг жагсаан бичээд хөдөлгөөнөөр үзүүлэх (явахдаа ямархуу байдалтай, ярилцаж уулзахад ямархуу дүр төрх харуулах гэх мэтээр чиглүүлэх)

Сэдэлжүүлэх үедээ зараа, чоно хоёрын өвөрмөц дүр төрхийг гаргасан зургийг харуулбал сурагчдад илүү ойлгомжтой байх болно.

Багууд даалгавраа танилцуулсны дараа нөгөө багт байгаагүй ямар санаа гарсан талаар ярилцах “Чоно зараа хоёр” эхийг уншаад хоёр хоёроороо дүрчилсэн тоглолт хийхээр бэлтгэх даалгаврыг сурагчдад өгнө.

Чоно зараа хоёр Чоно зараатай тааралдаж ийн ярилцжээ.	
	
- Зараа, чи учиггүй энэ олон зүүгээр яадаг байна?	- Учгаар яах юм, тэртэй тэргүй сүвэгчгүй юм чинь
- Тэгвэл учиг ч үгүй, сүвэгч ч үгүй хэрэггүй олон зүүгээ авч хаявал таарна.	- Яаж болох вэ чоно гуай? Араатан танаас айлгүй хэдэн үг сольж байгаа минь түүний л ач шүү дээ.
- Ээ халаг, ээ халаг ...	

Дүрээ тухайн нөхцөл байдалд юу хүсэж байгааг ойлгох нь чухлыг асуултаар чиглүүлж болно. Жишээ нь:

- Энэ дүр юу хүсэж байгаа бол? Яагаад?
- Энэ дүр ямар үр дүнд хүрэхээр найдлага тавьж байгаа бол?
- Чоно ямар шийдвэр гаргахыг оролдож байна вэ?
- Ингэх үедээ тэр ямархуу дүр төрх, хандлагыг гаргах бол?
- Зараа чонотой уулзангуутаа балмагдсан байх болов уу? Яагаад?
- Чоно зарааг харангуутаа шууд л идэхийг завдах болов уу? Яагаад?
- Ээ халаг, ээ халаг ... гэсэн өгүүлбэрийг хэлэх үедээ чоно ямархуу харц, дуу хоолойтой байх бол?

Ямар хөдөлгөөнөөр энэ нь илэрч болох вэ? гэх мэтээр сайтар чиглүүлж өгөх хэрэгтэй. Дүрд тоглох нь сурагчдыг хөгжөөдөг тул асуудлын мөн чанарыг анхаарахгүй байх талтайг багш бодолцвол зохино. Зөв ярьж сурахын тулд хүүхэд бүрийг хөгжүүлэхийн тулд тэдний сурах хүслийг төрүүлэх зорилго багш тавих хэрэгтэй.

Ялангуяа сургалтын явцад тухайн бүлгийн зорилтот хичээл эхлэхээс өмнө юуг сурвал чамд хэрэгтэй вэ гэдгийг ярилцах нь хүүхдийн сурах үйл ажиллагааг дэмжээд зогсохгүй үр дүнд хүрэхийн тулд яаж хийхээ, яаж сурахаа төлөвлөхөд нь тус болох юм. Тухайлбал:

- ✚ Жүжиглэн тоглож сурснаар чиний юуг өөрчилнө гэж бодож байна вэ?
- ✚ Дуу хоолойны өнгө тохируулж ярьж сурах нь чамд яагаад хэрэгтэй вэ?
- ✚ Бусадтай санал нийлэхгүй байгаагаа соёлтой илэрхийлж сурах нь чамд хэрэгтэй юу?

“Жүжиглэн үзүүлэх” суралцахуйн зорилтын хүрээнд сурагчдын ялгаатай байдал тод илрэх тул ичимхий, бүрэг сурагчдад дүрийн гадаад төрх болон дотоод санаа бодлыг хэрхэн дүрсэлснийг сайтар төсөөлүүлсний дараа дүрд тоглохыг санал болгох шаардлагатай. Өөрөөр хэлбэл зохиолоо, дүрээ сайн мэдэрсэн сурагч дүрд тоглох сэтгэлзүйн бэлтгэлтэй болдог.

Багш сурагчдыг уншсаны дараа дүрийн мөн чанарыг ойлгож мэдэрч чаддаг болгохын тулд яагаад, ямар учраас, яаснаас болж, яагаад ийм болов гэх мэт учир шалтгааны асуултыг тавьж, дүрд тоглохыг дэмжээрэй.

Жүжиглэн тоглохоо **илүү сайн аргаар яаж хийж үзүүлэх вэ** гэсэн асуултаар хөтлөн сурах арга барилыг эзэмшүүлэхийг санал болгож байна.

Өгүүллэг, үлгэр, домгийн үйл хөдлөлийг сэтгэлийн хөдөлгөөнтэй илэрхийлж яриулж сургахын тулд тухайн эх зохиолын чухам аль хэсэгт сэтгэл хөдөлснийг асуух, яагаад хөдөлснийг тодруулан ярилцах боломжтой. Тухайн үед тайзнаа тавигдаж буй жүжгийн зохиолыг үзэж, дүрүүдийн харилцан яриаг ажиглах дасгал ажиллаж болох юм.

“Хүн орчин, Хүн нийгэм” хичээлтэй холбон ямар нэгэн тохиолдол өгөөд санал нийлэхгүй байгаагаа илэрхийлэх дасгалыг ажиллуулж болох юм. Хамгийн гол нь монгол хүн ямар үг хэрэглэдэг вэ, гадаад хүн санал нийлэхгүй байгаагаа яаж соёлтой илэрхийлдэг вэ гэдгийг судлуулж, зохист үг хэрэглэж сурах дасгалыг давтан хийх шаардлагатай. Уншсан зохиолын тухай ярилцах, хэлэлцэх үйл ажиллагаа нь бүлэг бүрд бий тул ийм хичээл бүрд энэ чадварыг эзэмшүүлэхийг зорьж, хэрэгжүүлж болох юм.

ДӨРӨВ. ХЭЛ ЗҮЙ, ҮГИЙН САН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
3.4.а. Эх өгүүлбэрээс хэн?, юу?, яав?, яаж?, яагаад?, ямар учраас? гэсэн асуултад хариулагдах үгсийг олох, хэрэглэх	- Уншсан эхээс эдгээр асуултад тохирох үгийг түүж бүлэглэх - Хүн, амьтдын зан чанарыг илэрхийлсэн зохиол дээр ажиллаж байвал зан чанарын эерэг ба сөрөг шинжийг илэрхийлсэн үгсийг түүж бичих болон нэмж жагсааж бичих - Учир шалтгааны утгатай эх зохиол байвал тохирох асуултыг хэрэглэн, зохиолын агуулгыг ярих - Бичих чадварыг хөгжүүлэх хичээл дээр асуултыг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох - Зөв ярих, бичихийн тулд асуултыг хэрэглэх Бүтээлч үйл ажиллагаа: - Яагаад, ямар учраас? гэх мэт учир шалтгааны асуултаар өгүүлбэрийг дэлгэрүүлж бичих - Учир шалтгааны дарааллаар дэлгэрсэн өгүүлбэрийн холбоосыг ашиглан өөр өгүүлбэр зохиох - Өгүүлбэрийг тийм учраас, ийм учраас, яагаад гэвэл, ингэснээс, тэгснээс болж гэх мэт холбоосоор холбож дэлгэрүүлэх	- Асуулт бүхий картууд - Янз бүрийн бичвэр - Богино хэлбэрийн зохиолууд

3.4б. Уншсан эхээс анхааруулах өгүүлбэрийг ялган таних, бичихдээ анхаарлын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэх	1. Уншсан эхийн өгүүлбэрүүдийн утгыг ярилцах, анхааруулах, хүүрнэх, асуух өгүүлбэрийг яаж ялгаснаа хэлэх 2. Хүүрнэх өгүүлбэр, асуух өгүүлбэр нь анхааруулах өгүүлбэрээс юугаараа ялгаатай болохыг жишээн дээр ажиглах, хэлэлцэх 3. Эх уншаад, анхаарлын тэмдэг, таслал, цэгийг яаж, ямар тохиолдолд хэрэглэснийг өөрийн ажигласнаар хэлэх 4. Анхаарлын тэмдэг, таслал, цэггүй өгүүлбэр, эхийн утгыг ойлгож, цэг, таслалыг зөв хэрэглэх дадлага хийх 5. Анхаарлын тэмдэг, таслал, цэгийг яаж хэрэглэсэнээ бусдадаа тайлбарлах Бүтээлч үйл ажиллагаа: - Өгүүлбэрийн хэлэх зорилгыг өөрчлөн бичих. Асуух өгүүлбэрийг анхааруулах өгүүлбэр болгох дасгал ажиллах	- Анхаарлын тэмдэггүй, таслалгүй, цэггүй өгүүлбэр, эх загвар жишээ - Анхааруулах өгүүлбэрийн тухай онолын тодорхойлолт
3.4в. Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох	Өмнөх мэдлэгээ сэргээн санахын тулд - Эсрэг ба ойролцоо утгатай хос үгийг олж бичих - Эх, өгүүлбэрээс эсрэг ойролцоо үгийг ялгаж бичих, өнгөөр тодруулах - Цэгийн оронд нөхөх - Эсрэг болон ойролцоо үгийн эгнээ үүсгэх Мэдлэгээ хэрэглэж сурахын тулд - Өгүүлбэр зохиох - Ойролцоо эсрэг утгат үгийн утгыг ойлгож, өгүүлбэр зохиох - Өгүүлбэрийг дуусгах	- Хосоор нь харгалзуулахаар бэлтгэсэн тараах материал - Ойролцоо эсрэг утгат өгүүлбэр нөхөх материал
3.4г. Хэлц үгийн тайлбарыг уншиж ойлгох, өгүүлбэр зохиохдоо хэрэглэх	1. Хэлц үгийн тайлбарыг унших 2. Яагаад ийнхүү өвөрмөцөөр хэлснийг хэлэлцэх 3. Хэлц үгийн олон тайлбаруудаас оновчтой хэлц үгийг сонгон, өгүүлбэрт хэрэглэх 4. Зөв сонгосон эсэхээ ярилцах 5. Өгүүлбэрээс хэлц үгийг ялгах Бүтээлч үйл ажиллагаа: - Хэлц үгийн ойролцоо эсрэг хэлцийг олохдоо тайлбар унших - Хэлцийн утгыг тайлбарласан эх зохиох	- Хэлц үгийн төрөл бүрийн толиуд - Хэлцийг ашиглан өгүүлбэр, эх зохиох тарааж өгөх материал

Багшийн анхаарах зүйл:

Дээрх 4 суралцахуйн зорилтыг тусад нь ээлжит хичээлийн зорилго болгож ажиллахаас гадна хэл зүйн талаас хэрэглэж сургах зорилгын үүднээс унших, ярих, бичих, сонсох зорилготой хичээл бүрд үйл ажиллагааг интеграцилах хэрэгтэй.

3.4.в. кодтой суралцахуйн зорилтыг унших, бичих чадвартай хичээлд хэрэглэхдээ найруулан бичүүлэх дадалтай болгох зорилго тавина. Хүүхэд эх зохиохдоо үгийг их давтдаг учир давтсан үгийн оронд ойролцоо утгатай өөр ямар үг хэрэглэж болохыг багш та зөвлөх учиртай. Түүнээс биш ойролцоо утга гэж үүнийг хэлнэ гэж заах зорилго тавихгүй. Тиймээс багш та ойролцоо утгатай үгийн нөөцийг сайтар бэлдэх хэрэгтэй. Мөн төлөөний үгийг хэрэглэж сурахад анхаараарай. Манай ах гэж бичээд дараагийн өгүүлбэртээ ахын хийх дуртай ажил гэж хүүхэд их бичдэг. Тэр тохиолдолд ахын гэдэг үгийн оронд түүний гэдэг төлөөний үг хэрэглэж болно гэдгийг л заах хэрэгтэй.

3.4.г суралцахуйн зорилт нь монгол сэтгэлгээг төлөвшүүлэхэд зориулагдсан юм. Хэлц үгийг хүүхэд мэдэх ёстой гэсэн үнэлгээний зорилго тавихгүйгээр хэлц үг, түүний тайлбарыг уншиж ойлгох гэсэн чадварыг эзэмшүүлэхээр ээлжит хичээлээ төлөвлөхийг санал болгож байна. Хэлц үгийн тайлбарыг ойлгосноор сурагчид өгүүлбэр зохиохдоо хэрэглэнэ.

Тайлбараа мэдэхгүйгээр, хэлц үгийн цаана ямар утга байгааг мэдрэхгүйгээр өгүүлбэрт оновчтой хэрэглэж чадахгүй юм. Иймээс үнэлгээний даалгаврыг зөв тавилтай зохиох хэрэгцээ үүсэж байна. Дараах хоёр үнэлгээний даалгаврууд яагаад зөв, яагаад буруу болохыг тунгаан бодоорой.

Зөв хувилбар	Буруу хувилбар
Дараах өгүүлбэрүүдэд алинд нь “маш их баярлах” буюу “Магнай тэнийн” гэдэг хэлцийг хэрэглэх вэ? Сайн сурсанд минь аав минь бахархаж байлаа. Айсан хүнийхээ өмнө байдгаараа онийж гараа алдлан зогсов.	“Магнай тэнийн” гэсэн хэлц үгийн утгыг тайлбарлаарай.
Утгыг ойлгох чадварыг шалгахад чиглэгдсэн. Хэлцийн утгыг мэдэж оновчтой хэрэглэж сурах нь хөтөлбөрийн зорилгод нийцнэ.	Мэдлэг шалгахад чиглэгдсэн. Бүх хэлцийг сурагч мэдэхэд бэрхшээлтэй.

ДӨРӨВДҮГЭЭР АНГИ

Танилцуулга

Энэхүү суралцахуйн удирдамж нь дөрөвдүгээр ангийн монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөлт юм. Унших, бичих, сонсох, ярих чадварын хүрээнд сурагчдын эзэмших чадвар буюу суралцахуйн зорилтуудыг заах хичээлийн дагуу үлгэрчилсэн байдлаар эрэмбэлэн байрлуулсан бөгөөд багш тухайн орон нутаг, сургууль, ангийн сурагчдын онцлогт тохируулан зорилтуудын дарааллыг өөрчлөх боломж нээлттэй. Суралцахуйн зорилтдоо хүрэх аргачлалын хувилбарыг сурах үйл ажиллагаа, хэрэглэгдэхүүн, багшид өгөх санамж хэсгүүдэд санал болгон зөвлөсөн болно.

НЭГ. УНШИХ ЧАДВАР

Унших чадварыг эзэмшүүлэхийн тулд уншихын чанар гэгддэг шаардлагуудыг харгалзахыг зөвлөж байна.

4 дүгээр ангийн сурагчдын унших чадварт тавигдах шаардлага: **Бусдын дэмжлэггүй өөртөө унших /дуугүй, харааны/, зөв, хурдан, ойлгож унших, уншсанаа бусадтай хуваалцах, ярилцах.** Ямар ч төрлийн эхийг уншихдаа өөртөө уншиж, зөв, хурдан уншихдаа эхийн агуулгыг ойлгож байна уу гэх зэргээр үнэлэхэд анхаарна.

Эхийн агуулгыг ойлгосноо харуулах

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
4.1а Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс олж, агуулгыг ойлгох	1. Эхийн утгыг ойлгож унших 2. Уншсан өгүүлбэр, эхээс утгыг нь мэдэхгүй үгсээ сонгох, түүх 3. Сонгосон (түүсэн) үгийн утгыг ойр орчмын үг, өгүүлбэрийн утгаас таамаглан хэлэх, харилцан ярилцах <u>Таамаглахдаа:</u> – Эхэд ерөнхийдөө юуны тухай өгүүлснийг бодох – Тухайн өгүүлбэрийн утгыг ярилцсаны дараа энэ өгүүлбэрт ямар утгаар орсныг хэлэх – Энэ үг нь тухайн өгүүлбэрт чухал мэдээллийг хадгалж байна уу, эсвэл чухал биш мэдээллийн утгатай байна уу гэдгийг ажиглах – Тухайн үг үндсэн утгаараа байна уу, эсвэл өөр шилжсэн утгаараа байна уу гэдгийг ярилцах – Зохиолч нь тухайн үгийг ямар зорилгоор хэрэглэсэн байж болохыг таамаглах – Тухайн үгийг өөр ойролцоо утгатай үгээр сольж илэрхийлж таамаглаж болно. 4. Толь бичгээс үгийн утгыг мэдэх, өөрийн тайлбартай харьцуулах, тухайн үг нь толь бичигт салаа утгатай байвал аль утгын үүргээр орсныг нягтлах 5. Тухайн өгүүлбэрт зохиолч яагаад энэ үгийг сонгосныг эргэцүүлэх 6. Өгүүлбэр зохиохдоо хэрэглэх	– Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” 2013 – Ж.Санжаа нарын “Монгол хэлний толь” 2014 – Эх орон, монгол зан заншил, ёс суртахуун, хүний зан чанар, байгаль ба хүний харилцаа зэрэг хам сэдэвтэй эх зохиолууд – Хэлц үгтэй, ойролцоо утгатай үгийн хувилбартай эх
Багшийн анхаарах зүйл: Үгийн утгыг тайлбарлах. Хүүхэд ямар арга замаар үгийн утгыг мэддэг болох вэ, яаж үгийн утгыг ойлгох вэ гэсэн арга зүй голлоно. Үгийн утгыг хүлээн авч байгаа хүүхэд бүрийн таамаглалын ялгаатай байдлыг тодруулж, ажиглахын зэрэгцээ тэдэнд толь бичгийг хэрхэн ашиглаж, толь бичгээс үгийн үндсэн, шилжсэн, салаа утгыг хэрхэн бичиж, тэмдэглэснийг харж болох зөвлөгөөг өгнө.		

Үгийн утгыг мэдэхийн тулд ямар ямар толь байдгийг ярилцахаас гадна толь бичгээс хайж байгаа үгийг олох дасгал хийнэ. Сурагчид 2, 3 дугаар ангидаа толь бичгээс үгийг яаж хайж олдгийг мэдэж, сурсан байдаг. Харин 4 дүгээр ангийн тухайд толь бичгээс үг салаа утгатай байдгийг мэдэж, түүнийг толь бичигт яаж тэмдэглэснийг ажиглаж, хэрэглэж сурах чадвар чухал юм. Үгийн утга нь олон янзаар илэрдэг болохыг ажиглуулаад, найруулж бичихийн тулд ямар үгийг сонгон хэрэглэж болох вэ гэсэн хувилбарыг тооцоолж, сурагчдад зөвлөхийг санал болгож байна. Үгийн салаа утгыг мэдэж, цээжлүүлэх дасгал байнга хийж хэвшвэл сурагчид үгийн баялагтай болох боломжтой болох юм. Энэхүү суралцахуйн зорилттой холбоотой үнэлгээний даалгавар боловсруулахдаа эхэд байхгүй үгийн утгыг мэдэх үү, тайлбарлана уу гэхээсээ илүү “Энэ ... үг эхэд ямар утгаар орсон бэ? Ойр орчмын үг өгүүлбэрээс утгыг нь юу гэж ойлгож байна вэ?” гэж асууж болно. Харин уншсан эхийн хүрээнд, сурах бичиг дэх эхийн хүрээнд ... **ҮГИЙН УТГЫГ ХЭЛНЭ ҮҮ** гэж болох юм. Мөн тайлбар толь бичиг ашиглаж, мэдэхгүй үгийн утгыг мэдэж байна уу гэдэг нь энэ суралцахуйн зорилтын гол гэдгийг зөвлөмжилж байна.

4.1б Уншсан эхийн болон, үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	1. Уншсан эх дэх үгийн утгыг тайлбарлах замаар эхийн агуулгыг ойлгож унших, уншихдаа хурдтай байх 2. Эхийн агуулгыг ойлгож сонсох, зөв ойлгосон эсэхээ илэрхийлэх - Уншсан эхийн агуулгын хүрээнд асуулт зохиож ярилцах 3. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг ялгах 4. Цогцолбор бүрт илрэх утгуудыг тодруулах, багшийн тавьсан асуултыг хэрэглэх Мөн “Юу юуны тухай өгүүлж байна вэ?, “Ямар утга санааг илэрхийлж байна вэ?” гэсэн асуултыг хэрэглэн ярилцах, цогцолборыг ялгахын тулд догол мөрийг ажиглах, яагаад догол мөр болсныг эргэцүүлэх, тайлбарлах 5. Зохиолч уншигчдад хэлэх гэсэн санаагаа эхлэл, гол, төгсгөл хэсгийн алинд нь эсвэл олон цогцолборуудаас аль цогцолборт илэрхийлснийг бодож унших 6. Гол санааг жишээ баримтаар батлах, жишээ нь оновчтой эсэхийг багаараа ярилцан хэлэлцэх Бүтээлч үйл ажиллагаа: - Эхийн гол санааг цөөн өгүүлбэрээр нэгтгэн бичих - Танил бус эхийг уншихдаа цогцолбороор зааглах дасгал хийх, тэмдэглэгээ тавих	
--	---	--

Багшийн анхаарах зүйл:

Цогцолборын тухай заана гэхээсээ илүү нэг цогцолборт ямар утгыг илэрхийлсэн бэ? гэдэгт анхаарна. Нэг утгыг илтгэхийн тулд догол мөрөөр заагладаг гэдгийг сурагчдад ойлгуулна. Энэ нь сурагч аливаа эхийг зохиож бичихдээ догол мөрөөр зааглан, нэг цогцолборт нэг санааг гаргаж сурахтай холбоотой суурь ойлголт юм. Төгсгөлийн цогцолборт зохиолч уншигчдад хэлэх гэсэн санаагаа илэрхийлдгийг мэддэг болно гэдэг нь сурагчид гол санаа, дүгнэлтээ төгсгөлийн цогцолборт илэрхийлж сурахад нь дэмжлэг болох учиртай юм.

Цогцолбор бүрийн утга санааг хүүхдүүдээр гаргуулахдаа багш Блүүмийн таксономийн эхний 3 түвшний асуултыг тавих хэрэгтэй байдаг. Шууд “Юуны тухай өгүүлсэн бэ?” гэж асуух нь хүүхдэд бэрхшээлтэй байдаг.

4.1в. Уншсан эх, үлгэр, өгүүллэгийн бүтцийн хэсгүүдийн учир шалтгааныг тайлбарлах	1. Эхийн утгыг ойлгож унших, ойлгосноо ярилцах, асуулт зохиож ярилцах 2. Уншсан эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг ялган утгыг ярилцах, хэд хэдэн цогцолбортой эхлэл, гол, төгсгөлийг ялгах 3. Эхлэл, гол, төгсгөл хэсгүүд утгаараа учир шалтгааны хувьд яаж хэрхэн холбогдож байгааг тайлбарлах 4. Тайлбарлахдаа бие биеэ хүлээцтэй сонсох, асуулт тодруулж асуух Жишээ нь: - Эхлэл хэсэгт гол баатрыг ингэж бичээгүй бол гол хэсэгт үйл явдал ийнхүү өрнөхгүй байх байсан... - Гол хэсэгт баатруудад ийм ийм үйл явдал тохиолдож, түүнийг тийнхүү даван туулсан тул төгсгөл хэсэгт үйл явдал ингэж төгсөхөөр болжээ гэх мэт	- Баатруудын холбоо хамаарлыг тодруулсан бүдүүвч зураг - Монгол бэлгэшээх ёс, амьдрах арга ухаан, хүний зан суртахууны сэдэв бүхий эх зохиол
--	---	---

	Учир шалтгааныг тайлбарлахдаа: 5. Уншсан эхийнхээ учир шалтгааныг тодруулахдаа “яагаад”, “ямар учраас”, “юуны тулд”, “яах гэж” гэх мэт асуулт хэрэглэн ярилцах Бүтээлч үйл ажиллагаа: 6. Баатруудын үйл хөдлөлийн холбоо хамаарлыг тогтоох Холбоо хамаарлыг тогтоохын тулд: 7. Баатар бүрийн хийсэн үйлдлийг нэрлэх 8. Хамгийн холбоотой баатруудыг нэрлэх, зураглах 9. Нэг баатар байхгүй бол нөгөө баатрын үйл хөдлөл тодрох болов уу? гэсэн асуултаар ярилцах, хэлэлцэх 10. Хэзээ, хаана үйл явдал өрнөснөөс шалтгаалж баатруудын хоорондын харилцаа өөрчлөгдөж байгааг анзаарч унших, бүдүүвч хийх Бүтээлч үйл ажиллагаа: 11. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг зөв дарааллуулах, үлгэр ба өгүүллэгийн үйл явдлыг зөв дарааллуулах <u>Зөв дарааллуулахын тулд:</u> - Эхлэл хэсэг дэх үйл явдал гол хэсгийн үйл явдалтай юугаар холбогдож байгааг бодох - Эхлэл, гол, төгсгөл хэсэг тус бүрд хэдэн цогцолбор байгааг олох - Хэрэв буруу дараалалд оруулбал эхийн утгад яаж нөлөөлөхийг бодох	- Үйл явдал нь хаана, хэзээ болж байгаагаас хамаарч, баатруудын хоорондох харилцаа, зан чанар нь өөрчлөгдсөн эх зохиол Жишээ нь: “Ховдог чоно”, “Арслан хулгана хоёр” гэх мэт монгол ардын үлгэр
Багшийн анхаарах зүйл: ТАЙЛБАРЛАХ чадварыг үнэлэхдээ зохиолоос жишээ татаж байна уу гэдгийг голлоно. Өөрөөр хэлбэл суралцахуйн зорилтын ШАЛГУУР НЬ “эхээс жишээ татаж” гэдэг нь юм. Энэхүү суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах 3 үйл ажиллагаанд илүү анхаараарай. I. Үлгэр, өгүүллэгийн бүтэц буюу эхлэл, гол, төгсгөл хэсгийг ялгана. Дараах тодорхойлолтыг уншаад асуулт боловсруулж хэрэглээрэй. - Эхлэл хэсэгт зохиолын баатар, орчныг танилцуулсан байдаг. Хэнийг яаж яагаад дүр төрх, дотоод зан чанар, зорилго, хүсэл мөрөөдөл танилцуулав? Ямар орчинд үйл явдал өрнөж эхлэх гэж байна? - Гол хэсэгт баатруудад тохиолдсон явдал, бэрхшээл, боломж, харилцан яриаг өрнүүлэн дүрсэлдэг юм. Баатруудад юу юу тохиолдов?, Ямар бэрхшээл таарав? Боломж байсан уу? Хоорондоо юу ярилцав? гэх мэт - Төгсгөл хэсэгт зохиолч уншигчдад хэлэх гэсэн санаагаа илэрхийлж, гол санаагаа гарган бичдэг. Зохиолч уншигчдад юуг хэлэхийг хүсэв? Үйл явдал яаж төгсөв? II. Эхийн бүтцийг ялгуулж, ойлгосныг яриулсны дараа учир шалтгааны холбоо хамаарлыг олуулахдаа дараах асуултыг хэрэглээрэй. Эхлэл хэсэгт баатрын зан чанарыг юу гэж танилцуулснаас болж гол хэсэгт тухайн баатар юу хийв? Жишээ нь, эвсэг хүн гэж бичсэн учраас гол хэсэгтээ хэнтэй ч муудаагүй, нөхөрлөж чаддаг гэж бичжээ гэж яриулж сургах. Гол хэсэгт баатруудад юу тохиолдсоноос болж төгсгөлдөө юунд хүрэв? Яаж төгсөв гэх мэтээр үйл явдлыг судалж уншуулж сургаарай. <u>3-рт.</u> Баатруудын үйл хөдлөлийн холбоо хамаарлыг тогтоолгоно. Хүүхдүүд “Бат ингэж хэлснээс болж, Болд ийм үйлдэл хийсэн гэх мэтээр учир шалтгааныг тодруулж, дүрүүдийн холбоо хамаарлыг ярина. Ярихдаа ОЮУНЫ ЗУРАГЛАЛЫн аргаар ярилцвал сайн.		
4.1г. Шүлэг дэх хоёр зүйлийн ижил төстэй шинжийг харьцуулан адилтган дүрслэлийг тайлбарлах	1. Шүлгийн утгыг ойлгож унших, ойлгосноо ярилцах 2. Ярилцахдаа бие биеэ хүлээцтэй сонсох, асуулт тодруулж асуух 3. Мэдэхгүй, танил бус үгийн тайлбар хийх, зохиолчийн үг сонголтын шалтгааныг тайлбарлах 4. Сонин содон санагдсан үг хэллэгийн талаар ярилцах 5. Багшийн сонгосон уран \адилтган\ дүрслэлт үгийг тайлбарлах	- Уран дүрслэл бүхий шүлэг

	Тайлбарлахдаа дараах 2 асуултыг хэрэглэнэ. - Юуг юутай адилтгасан бэ? - Ямар шинжээр нь адилтгасан бэ? 6. Хэрхэн тайлбарласнаа ярилцах, өөрийн үнэлгээ хийх	
--	--	--

Багшийн анхаарах зүйл:

Сурагч хоёр үзэгдлийн шинж байдлын адил төстэй шинжийг харьцуулан харж, адилхан болсныг тайлбарлах нь чухал. Иймээс багш шүлгээс адилтгасан дүрслэлт үгийг таних онолын мэдлэгтэй байх хэрэгтэй. Бодит ертөнцийн юмс үзэгдлийг өөр зүйлээр орлуулан бичсэнийг уран дүрслэлтэй болжээ гэдэг. Мойл шиг нүд гэдэг нь уран дүрслэлээр бичсэн. Мойлыг нүдтэй адилтгаж, өнгө, хэлбэрийн хувьд адил байх шинжээр нь адилтгасан учраас уран дүрслэл болж байгаа юм. Жишээ нь, “Халуун элгэн нутаг” дууны шүлэгт буй “эрдэнийн алтан өлгий” гэсэн мөр шүлэгт уран дүрслэл байна. Дээрх асуултыг хэрэглэвэл нутгийг өлгийтэй адилтгасан гэж хүүхэд хэлж байвал сайн. Ямар шинжээр нь адилхан байгааг хүүхэд бүр өөр өөрийнхөөрөө тайлбарлавал хичээлийн үр дүн гарна. Бид тайлбарлах чадварыг л эзэмшүүлэхийг зорьж байгаа болохоос биш адилтгалын тухай хүүхэд мэдэх ёсгүй юм. Энэ хичээл нь 5 дугаар ангийн “Онцсогын далд утгыг таамаглах”, “Онцсог зохиох” гэсэн 2 чадвартай агуулгын хувьд холбоотой юм.

4.1д. Эхэд ашигласан баримт ба өгүүлэгчийн үзэл бодлыг илэрхийлсэн хэсгийг ялгах	1. Эхийн агуулгыг ойлгож унших, уншаад ярилцах, үгийн утгыг тайлбарлах, тайлбараа тэмдэглэх, өгүүлбэр зохиох 2. Уншсанаа ярилцахдаа бие биеийнхээ яриаг дуустал хүлээцтэй сонсох 3. Эхэд гол баатар нь юунд ИТГЭЖ байгааг, ямар нэг зүйлийн талаар өөрийн үзэл бодлоороо ямар нэгэн САНАЛ хэлж байгааг судалж унших, “санал, итгэл үнэмшил” нь үзэл бодол болохыг ойлгох 4. Эхийн баатрууд үзэл бодлоо илэрхийлэхдээ ямар баримт, нотолгоо хэрэглэж байгааг эхээс ялгах 5. Яагаад баримт нотолгоо болсныг тайлбарлах, дахин уншиж нягтлах Бүтээлч үйл ажиллагаа: 1. Зурагт тулгуурлан үзэл бодлоо илэрхийлэхдээ “Итгэж байна, дуртай, зөв /буруу/ байна, сайн /муу/ байна” гэх мэт түлхүүр үг хэрэглэх 2. Өөрийн үзэл бодлоо баримтаар нотлон ярих	- Үзэл бодол, зан аашаар нь баатруудаа ялгаруулж, түүнийгээ баримтаар нотолсон эх зохиол - Зориг тэвчээр, өөрийгөө өөрчилж чадах их хүчний тухай өгүүлсэн орчин үеийн үлгэр, богино эх, дэлхийн сонгодог зохиол
--	--	--

Багшийн анхаарах зүйл:

Хэн нэгэн хүний “Санал, итгэл үнэмшил” нь үзэл бодол болохыг ойлгох нь чухал. Уншиж ойлгох чадварын бас нэг тал нь ЯЛГАХ ЧАДВАР ЮМ. Үзэл бодол буюу opinion нь хувь хүний санал, итгэл үнэмшлийг хэлж байгаа юм. “Миний багш их сайн хүн” гэж хэлж байгаа нь сурагч үзэл бодлоо илэрхийлж байгаа хэрэг. Өөрөөр хэлбэл сайн хүн гэдэгт нь итгэдэг гэсэн үг. Багшийн сайныг батлах зүйл нь баримт буюу fact нь дараах хэлбэрээр байж болно. Сайныг нотлох ТОХИОЛДОЛ \хугацаа зааж болно\, ХЭЛЦ ҮГ, ЗҮЙР ЦЭЦЭН ҮГ, УНШСАН, ХАРСАН, СОНССОН ҮЛГЭРИЙН КИНО, НОМЫНХ НЬ БААТРЫН ХЭЛСЭН ҮГ, ДУУНЫ ҮГ, ЗУРАГ гэх мэт үгсээр багшийнхаа сайныг сурагч нотолж болох юм. Баримт нь үнэн, бодитой, үндэслэлтэй байхыг багш анхаарна

4.1е. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэгт баатруудын зан чанар, үзэл бодолд гарсан өөрчлөлтийг харьцуулах	1. Баатруудын хэлсэн үг, харилцан яриаг бодож унших, баатруудыг ямар хүн юм бол гэж эргэцүүлэн унших, ярилцах 2. Ярилцахдаа бие биеийнхээ эргэцүүлж уншсаныг анхааран сонсох, яриаг дуустал хүлээцтэй сонсох 3. Баатрын зан ааш нь эхлэл, гол, төгсгөл хэсэгт хэрхэн өөрчлөгдсөнийг харьцуулан унших 4. Харьцуулан уншсаны дараа дүгнэх	- Хүүхдийн хүмүүжилд эерэгээр нөлөөлөх утга агуулгатай эх зохиол
--	--	--

	Эхлэл хэсэгт ...ийм ийм зан чанартай, үзэл бодолтой дүр байсан Гол хэсэгт ...ийм юмнаас болж ингэж өөрчлөгдсөн Төгсгөл хэсэгт ...ийм шалтгаанаар ...тийм зан чанартай дүр болсон Хэрэглэх асуулт: - Баатрын зан ааш, хүсэл зорилго нь юунаас болж өөрчлөгдөв? - Та нар өөрөөр яаж өөрчлөхийг хүсэж байна вэ? Яагаад? - Бүтээлч үйл ажиллагаа: Харьцуулахын тулд: - Баатруудын хэлсэн үг, харилцан яриаг бодож унших - Хэлсэн үгээс нь баатруудын зан чанарыг харьцуулах - Харьцуулснаа дүгнэж бичих - Баатруудын үзэл бодлыг өөрийн үзэл бодолтой харьцуулан зан чанараа тодорхойлох	
Багшийн анхаарах зүйл: Уншиж ойлгох чадварын бас нэг тал нь ХАРЬЦУУЛАН УНШИХ ЧАДВАР юм. Харьцуулан унших чадварыг эзэмшүүлэхдээ зохиолын баатрын зан чанар, үзэл бодлын өөрчлөлтийг ажиглан уншуулахыг гол зорилгоо болгоно. Хамгийн гол нь уншигч хүүхэд өөрийн зан чанарыг эргэцүүлэх нь энэ суралцахуйн зорилтын гол мөн чанар юм. Сурагч харьцуулах аргаар уншаад сурна гэдэг нь үлгэр, өгүүллэг зохиож бичихдээ эхлэл, гол, төгсгөл хэсэгтээ гол баатрынхаа зан чанарыг өөрчлөх арга барилтай болоход нөлөөлнө гэсэн үг юм.		
4.1ж. Урилга, уриалга, номын танилцуулга, сонины мэдээ, захидал зэргийн зорилго, бүтцийг тайлбарлах	- Урилга уншихдаа: - Хэнийг, хаана, хэзээ, юунд, хэн урьсныг хүндэтгэлийн ямар үг хэрэглэснийг ажиглан унших, дүгнэлт гаргах - Хатуугийн тэмдэг, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэн, урьж бичихдээ дүрмийг зөв хэрэглэх - Уриалга уншихдаа: - Бусдад хандаж, сайн сайхан зүйлд уриалахдаа хэнд, юуг, яаж уриалсныг бодож унших - Захидал уншихдаа: - Эхлэл, гол хэсгийн цогцолборуудад төгсгөл хэсгүүдэд санаагаа хэрхэн байрлуулж, цэгцтэй бичсэнийг захидлаас судалж унших - Сонины мэдээ уншихдаа: - Мэдээллээс суралцаж амьдралдаа хэрэгжүүлж сурахын тулд өөрт хэрэгтэй болон хэрэггүй мэдээллийг ялгах - Сурагчид өөрсдийн уншдаг болон бусад сонины мэдээ, мэдээллийг цуглуулах - Цуглуулсан мэдээллээс гайхалтай, хэрэгтэй, сонирхолтойг ялгаж тэмдэглэх - Уншсан эхээс сургамжтай, гайхалтай, чухал мэдээллийг ялгах - Номыг танилцуулгыг уншихдаа: - Уншсан номынхоо юуг юуг онцлон танилцуулж байгааг ажиглах - Номын танилцуулгын бүтэц нь ямар байгааг ажиглан дүгнэх Бүтээлч үйл ажиллагаа: - Олж авсан мэдээлэл буюу баримтаа зохиож найруулахдаа хэрэглэх - Багаар хамтарч ажиллах, бусдад зөв хариулах, бусдын яриаг дүгнэж сонсох	- Урилга, уриалга, номын танилцуулга, талархлын захидал, мэдээ

	- Өөрийн санаа бодлоо илэрхийлэхдээ тэмдэглэсэн мэдээллээс хэрэглэх - Мэдээ бэлтгэн ярихад бэлтгэх	
--	---	--

Багшийн анхаарах зүйл:

ТАЙЛБАРЛАХ чадварыг үнэлэхдээ зохиолоос жишээ татаж байна уу гэдгийг голлоно. Энэхүү суралцахуйн зорилт нь урилга, уриалга, номын танилцуулга, талархлын захидал, мэдээ зэрэг хэрэглээний эх дээр суурилсан уншиж ойлгох чадварыг дэмжих суралцахуйн зорилт юм. Эдгээр эхийн төрөл дээр ажиллуулахдаа БҮТЭЦ, ҮГ СОНГОЛТ зэргийг анзаарч уншуулахад анхаарна. Бүтэц, зорилго, үг сонголтыг ажиглаж, анзаарч унших нь бичих үйлийн эхлэл болдог тул багш нэгж хичээлийн хөтөлбөртөө унших, бичих чадварыг уялдуулж төлөвлөх нь зүйтэй.

Нэгжийн төлөвлөлт дээр энэхүү суралцахуйн зорилт дох эхүүдийг салган, бичих чадвартай нь холбоно. Тухайлбал, урилга бичих 4.2ж суралцахуйн зорилтыг “урилга уншиж, зорилго, бүтцийг тайлбарлах” гэсэн суралцахуйн зорилтыг 4.2н. суралцахуйн зорилттой холбон нэг нэгж болгох юм.

4.13. Хурд, дууны өнгөө тохируулан урнаар уншиж, шүлгийн утгыг ойлгосноо харуулах	1. Шүлгийн үг бүрийн утгыг ойлгож, үгийн утгыг мэдэрч унших 2. Хэрэв том хэмжээний шүлэг бол мөрийн утгыг, эсвэл бадгийн утгыг эргэцүүлэн унших <u>Ойлгож уншихын тулд:</u> - Зохиолч яагаад энэ үгийг сонгосон юм бол? - Энэ үг байхгүй бол ямар санаа алдагдах бол? 3. Уншсанаа ярилцах, бие биеийнхээ юуг мэдэрснийг сонсох 4. Шүлгийн утгыг илэрхийлэх хамгийн чухал үгийг тэмдэглэх 5. Тэмдэглэсэн үгс юуг мэдрүүлэв? Мэдэрснээ илэрхийлэх <u>Жишээ нь:</u> - “Салхи, тэнгис хоёр” шүлгээс маш их нүргээнтэй дуу чимээ сонсогдлоо. Бас хэн нэгэн хүчтэй исгэрээд байгаа юм шиг... - “Навч цэцэг бүхэнд Наалдаж хоцорсон салхи Чийгтэй хөрснөөс зуурсаар Чичирч байгаа үзэгдэнэ” гэсэн мөрийг уншаад салхийг өрөвдөх мэдрэмж төрлөө. Ялангуяа “наалдаж”, “чичрэх” гэдэг үгс салхины дүр байдлыг гаргахад хүч нэмсэн байна. 6. Ярианы хурд, дууны өнгөө тохируулан уран унших Уншихдаа: - Шүлгийн утгыг сонсогчдод мэдрүүлэхийн тулд унших - Үгийн утгыг ойлгосны үндсэн дээр аль үгэн дээр илүү тод чанга, эсвэл сул дуугарахаа бодох - Аль үг, холбоо үг, өгүүлбэрийг удаан хэмнэлтэй, хурдан хэмнэлтэй уншихаа тунгаан бодох, зохих үгийн доогуур зурж тэмдэглэх, багаар ярилцах 7. Уншсаны дараа яагаад удаан, эсвэл хурдан, эсвэл сул дуугаар, чанга хүчтэй дуу хоолойгоор уншсанаа ярилцан, бие биеэ дүгнэх Бүтээлч үйл ажиллагаа: - Сурагчид бие дааж, дуртай шүлэг яруу найргаа сонгох, олох, цээжлэх, уран унших дасгал хийх	- Монгол хүний үнэт зүйлсийн илэрхийлэл болсон, монгол үгийн сонголт сайтай, хүүхдийн нас, сэтгэхүйд тохирсон шүлэг, яруу найраг
--	---	--

Багшийн анхаарах зүйл:

Унших чадварыг эзэмшүүлэхдээ ЗӨВ, ХУРДАН, ОЙЛГОЖ, УРАН унших зэрэг уншлагын чанарыг харгалзана. Уран уншуулах үйл нь үг бүрийг ЗӨВ уншиж, утгыг ойлгосны үндсэн дээр УРАН уншуулж сургахтай холбоотой байдаг учраас шүлгийн утгыг ойлгосон гэдгийг үнэлэхдээ зогсолт, айзмыг ааж тохируулж уран уншиж байгаагаар үнэлж болно. Шүлгийн утгаа ойлгоогүй сурагч ярианы хурд, дууны өнгөө тохируулж чадахгүй юм. Багш уран уншиж сурах чадварыг дэмжихдээ үг бүрийн утгыг сурагчид хэрхэн мэдэрч хүлээн авч байгааг анзаарч, сурагчдын ялгаатай байдлыг тодруулж, үнэлгээ хийнэ.

Эхийн далд утгыг бүтээлчээр ойлгох

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
4.1и. Уншсан зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож төсөөлөх	Эхэд дүрслэгдсэн баатрын дүр байдлыг төсөөлснийг унших 1. Эхээс баатрын гадаад дүр байдлыг дүрсэлснийг ялган унших 2. Ялгасан үгс нь ямар асуултад хариулагдаж, шинж чанар, тоо хэмжээ, өнгө зүс заасан эсэхийг ярилцах, тэмдэг нэрийн тухай ойлголттой болох 3. Уншсан эхийн баатрын гадаад дүр байдлыг “Ямар” гэсэн асуултад хариулагдах үгс хэрэглэн тоочин ярих Төсөөлснөө тоочин ярихын тулд: - Зохиолын үг хэллэгийг ашиглах - Зургаар илэрхийлэх Эхэд дүрслэгдээгүй дүр байдлыг төсөөлөх 1. Баатрын хэлсэн үг, ярьсан ярианаас ямар хүн байж болохыг тодорхойлж, гадаад дүр байдлыг төсөөлөн ярих Жишээ нь: - “Ямар” гэсэн асуултад хариулагдах үг хэрэглэн, тоочин дүрслэх - Ингэж хэлж байхдаа ямар зүс царайтай байсан бол? - Яаж хөдөлсөн бол? - Түүнийг дараа нь юу гэж хэлэх байх гэж бодсон бэ? - Ямар сэтгэгдэлтэй байсан бол? гэх мэт 2. Төсөөлөн бодсоноо нүдэнд харагдтал дүрслэн бичих <u>Дүрслэн бичихийн тулд:</u> - Зохиолч яаж бичсэнийг эргэн санах, ямар үг хэрэглэж, уншигчдад нөлөөлснийг нягталсны үндсэн дээр зохиох - Юмс үзэгдлийн шинж чанар, тоо хэмжээг тодруулсан тэмдэг нэрийг хэрэглэх, дэлгэрүүлэх Жишээ нь: - Баатрын хувцас нь ямар байх бол? - Нүүр царай болон биеийн хөдөлгөөн, харцны өөрчлөлтийг ямар үгээр дүрслэх вэ? гэх мэт 3. Бие биенийхээ ярьсныг, бичсэнийг сонсоод, үргэлжлүүлэн санал хэлэх, зохион ярих 4. Багийн хэлэлцүүлэг хийх Бүтээлч үйл ажиллагаа: Зураг харж юмсын гадаад дүр байдлыг төсөөлөн дүрслэн ярих 1. Зургийг ажиглан, гадаад дүр байдал, шинж чанарыг ярилцах 2. Гадаад дүр байдлыг дүрслэн төсөөлөх, бодсон бодол, хийсэн үйлдлийг зохион төсөөлөх 3. Ямар зорилгоор гадаад дүр байдлыг төсөөлснөө илэрхийлэх	- Баатрын гадаад дүр байдлыг дүрсэлсэн үлгэр, өгүүллэг - Баатрын гадаад дүр байдлыг дүрслээгүй эх зохиол - Сонсох эх - Хүн ба амьтны гадаад төрх байдлыг тоочиж бичихүйц дүрслэлтэй уран зураг, фото зураг

Багшийн анхаарах зүйл:

Баатрын гадаад дүр байдлыг зохиолч ямар үг хэрэглэн, яаж дүрсэлснийг судалж уншуулж, мэдлэг бүтээлгэхэд анхаарна. Дараах асуултыг хэрэглээрэй.

1. Баатрын юу юуг дүрсэлсэн бэ? \нүдийг нь, үсийг нь гэх мэт хэлэхэд анхаарах\
2. Нүд, үсийг нь ямар үгээр дүрслэн тодруулсан бэ? \нүдийг тугал шиг нүд, бор том нүд гэх мэтээр хариулахад анхаарах\

3. Эдгээр дүрсэлсэн үгс нь шинж чанар заасан үгс үү? Тоо хэмжээ заасан үгс үү? Өнгө зүс заасан үгс үү? гэж асуух \шинж чанар, өнгө зүс заасан үгс байна гэж хүүхэд бодож хариулахад анхаарах\

4. Эдгээр үгс ямар асуултад хариулагдах бол? Дараах үгсээс сонгуулна. “Ямар”, “Яаж”, “Хэдэн” гэх мэт

Ийм 4 асуултын дагуу ярилцсаны дараа “Ямар гэсэн асуултад хариулах, шинж чанар, тоо хэмжээ, өнгө зүс заасан үгсийг тэмдэг нэр гэж хэлнэ” гэж дэвтэрт нь бичүүлж, үгсийн сангийн мэдлэгийг өргөжүүлнэ.

Багш та бүхэн төсөөлөх, таамаглах гэсэн хоёр чадварын ялгааг мэдэрснээр сурагчдыг зөв үнэлэх боломжтой болно. Таамаглах /Predicting/ гэдэг бол зохиолд гарсан зүйл, болсон явдалд тулгуурлан юу тохиолдохыг урьдчилан хэлэх, үндэслэлтэй таамаглахыг хэлнэ. Бодит амьдралаас мэдсэн зүйлстэй тулгуурлан таамаглаж болно. Төсөөлөл /Visualizing/ гэдэг бол уншигчийн оюун санаанд буусан дүр зураг юм. Зохиолыг унших үед уншигчийн мэдрэмжээр дамжин бүтээгддэг. Төсөөлөх, таамаглах гэсэн хоёр чадвар бол эхийг уншиж ойлгох БҮТЭЭЛЧ ЧАДВАР юм. Олон улсын хөтөлбөрүүдэд далд утга гэсэн нэр томъёонд харьяалагддаг байна. Эхийг унших явцад хүүхэд тухайн эхийн баатар, баатрын үйл хөдлөлүүд, эхийн орчин зэргийг өөрийнхөө төсөөллөөр амилуулж бодож байдаг байна. Тэрхүү төсөөллийг илэрхийлэн гаргахад энэ суралцахуйн зорилт тусална.

Өөрөөр хэлбэл тухайн эхэд бичигдээгүй утгыг хүүхэд өөрийнхөөрөө илэрхийлэн ярьж сэтгэх нь чухал юм. Хүүхдийн ярьж сэтгэж байгаагаас ямар үзэл бодолтой, ямар хандлагатай хүүхэд болохыг таньж болно. Жишээ нь: “Хулганы сумо” зохиолд “Туранхай хулганы “мөнгө аваад ир” гэсний хариуд баян хулганыг юу гэж хэлэх байх гэж төсөөлж байна вэ?” гэсэн асуултад буй баян хулганы бодол эх зохиолд байхгүй. Хүүхэд баян хулганы бодлыг өөрөө төсөөлөн бодно гэсэн үг. “Баян хулганыг ууттай мөнгөө үүрээд ирэхэд нь чи юу бодож байсан бэ?” гэсэн асуултын зорилго бол хүүхэд тухайн зохиолыг хэр хүлээн авч байгааг илрүүлэхэд чиглэгдсэн юм. Багш сурах бичиг дээр тавигдсан асуултын хувилбарыг боловсруулж сурагчидтай харилцан ярилцвал хүүхдийн өөрийн бодол хандлага төлөвших сайн талтай юм.

Далд утга байдаг гэдгийг заахыг зорихгүй, харин сурагчид далд утгыг илэрхийлэн тайлбарлаж байна уу, төсөөлж байна уу, таамаглаж байна уу гэдгийг анхаарч, “ярих, тайлбарлах” чадвар хэр эзэмшиж байгааг илрүүлж ажиллах нь зүйтэй.

4.1к. Эхийн үйл явдлын төгсгөлийг үндэслэлтэйгээр таамаглах	1. Эхийн үйл явдлын дэс дарааг ажиглах, эхийн бүтцийг яаж ялгадгаа сэргээн санах 2. Эхийн эхлэл, гол хэсэг бүрээс сонгон, үйл явдал хэрхэн өрнөхийг таамаглах <u>Таамаглахын тулд:</u> - Эхийн бүтэц /эхлэл, гол, төгсгөл/-ийн утгын холбоон дээр тулгуурлах Тухайлбал: - Эхлэл хэсэгт зохиолчийн танилцуулсан баатрын тухай эргэн санах - Баатрын тухай мэдээлэл нь дараагийн гол хэсэгт гарах үйл явдалтай хэрхэн холбогдсоныг эргэцүүлэх - Баатартай юу юу тохиолдсоныг бодоод, яаж төгсгөхөө таамаглах Жишээ нь: - “Тэр ах дүү байхгүй ч ер гутардаггүй” гэж эхлэл хэсэгт бичсэн. Гол баатрын тэрхүү сайхан шинжийг гаргаж дахин батлахын тулд төгсгөл хэсэгт баатрын зан чанарыг сорих өөр адал явдал зохионо. 3. Яаж төлөвлөснөө ярих, санал солилцох 4. Өөрийн таамаглалаа багшийн уншсан төгсгөл хэсэгтэй харьцуулах 5. Ижил ба ялгаатай талыг тодруулан, дүгнэлт гаргах 6. Таамагласнаа бичиж найруулах <u>Бичихийн тулд:</u> - Хэдэн цогцолборт юуны тухай ярихаа төлөвлөх, ерөнхий зураглал, бүдүүвч гаргах	- Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэг нь тодорхой ялгарсан эх зохиол - Тусч, үнэнч сэтгэлийн тухай сэдэвтэй монголын болон дэлхийн үлгэр, өгүүллэг
---	--	---

	– Санаагаа тэмдэглэх, байрлуулах, холбох Тухайлбал: “Гэтэл, тэгтэл, тэгсэн чинь, харин, гэхдээ, түүнчлэн, бас, бөгөөд” зэрэг холбоосыг хэрэглэх – Төлөвлөснөө ноороглох, бичиж найруулах – Найруулан бичсэнээ засан сайжруулах, бусдын зөвлөгөөг авах – Дахин сийрүүлж бичих 7. Бичсэнээ дараа явцын үнэлгээ хийх Хэрвээ би дараах зүйлийг амжилттай гүйцэтгэх бол – Би таамаглахдаа зохиолын эхлэл, гол хэсэгт бичсэн үйл явдлаас, бас баатрын үйл хөдлөлөөс үндэслэн ургуулан бодсон – Би сонирхолтой дүр бүтээж чадсан – Би зөв бичих дүрмийн алдаагүй бичсэн гэх мэт	
Багшийн анхаарах зүйл: Хүүхдийг яаж таамаглан унших арга барилтай болгох вэ? Хүүхэд уншсан зохиолынхоо үйл явдлаас үндэслэл аван, ургуулан бодно гэсэн утга тодорч байна. Иймээс дараах үйл ажиллагаагаар дамжуулж сурах арга барилыг эзэмшүүлнэ. Хүүхэд таамаглан зохиохын тулд уг зохиолын утгыг сайн ойлгож, улмаар зохиолч яаж бичсэнийг судалж байж үр дүнтэй болно гэдгийг анхаарах 1. Цаашид болох үйл явдлыг таамаглахдаа уншсан эхийн эхлэл, гол хэсэг дэх /эсвэл эхлэл, төгсгөл хэсэг/ агуулга, үйл явдал, баатруудын тухай мэдээлэл маш чухал байдаг гэдгийг анхаарах Тухайлбал: Зохиолын эхэнд дүрслэгдсэн баатрын сайн сайхан шинж нь гол хэсэгтээ яаж батлагдаж байгааг ойлгож, бодож уншсаны үндсэн дээр төгсгөл хэсэгтээ ямар үндэслэлээр тухайн баатрын амьдралыг яаж зохиохоо бодно гэсэн үг. Хүүхэд дараах өгүүлбэрийн бүтэц, найруулгаар ярьж байвал чадвараа эзэмшиж байна гэж дүгнэж болох юм. “Эхлэл хэсэгт баатрыг ...ингэж дүрсэлсэн тул би түүнийг дэмжиж төгсгөл хэсэгтээ сайн сайхан амьдарна гэж таамаглаж байна”, “Гол хэсэгт баатарт ...ийм ийм үйл явдал тохиолдсон учраас баатрын зан чанарыг шалгахын тулд төгсгөл хэсэгтээ баатрын зан чанарыг сорьж, гол хэсэгт дүрслэгдсэнээс нь илүү адал явдал зохионо гэж бодож байна” гэх мэтээр ярьж болно.		
Эхлэл хэсэгт дүрслэгдсэн баатрын /баатруудын/ тухай мэдээлэл хэр чухал вэ? Яагаад? Жишээ нь: “Тагтааны бэлэг” зохиолд эхний цогцолборт Кижаван хэмээх ядуу тариачны тухай өгүүлэхдээ “хэдийгээр ах дүү, хамаатан садан байхгүй ч тэр ер гутардаггүй, хүмүүстэй эвтэй, амьтадтай ч нөхөрлөдөг” гэсэн байна. Энэ нь тухайн баатрын тухай өгүүлсэн чухал мэдээлэл юм. Яагаад гэвэл тэр хүн гутардаггүй, бусадтай эвсэг байдаг зан чанарынхаа хүчээр бусдад тусалж чаддаг, бас бусдын тусыг авч байдаг гэж 2-4 дүгээр цогцолборт гардаг.	Хэрэв чухал гэж үзэж байгаа бол төгсгөл хэсэгтээ тэрхүү чухал мэдээллээ хэрхэн ашиглаж гаргах вэ? Жишээ нь: Кижаваны тухай эхний болоод 2-4 дүгээр цогцолборт ийнхүү бичсэн учраас төгсгөл хэсэгт би дараах байдлаар таамаглаж байна. Кижаван өөрөө ядуу мөртлөө бусдын төлөө гэх сэтгэлтэй учраас тагтаанууд түүнд тусалж байгаагаар төгсгөнө. Тэр “сайн санааны үзүүрт тос” гэдэг шиг сайхан амьдарна. Түүний сайхан амьдрах нөхцөлийг үлгэрийн эхлэл, гол хэсэгт зохиолч тодорхой өгүүлсэн учраас тийнхүү төгсгөж байна.	
Дараагийн үйл явдал бүрд баатрын үйл хөдлөл яаж өөрчлөгдөж байна вэ? Эхлэл хэсгийн мэдээлэл нь дараа дараагийн үйл явдлуудтай яаж холбогдож байна вэ?	Таамаглахдаа өмнөх үйл явдлуудтай яаж холбох вэ?	
Баатрын зан чанарыг уншигчдад мэдрүүлэхдээ зохиолч ямар үг хэрэглэсэн байна вэ?	Чи баатрынхаа зан чанарыг ямар үгээр илэрхийлэн бичих вэ?	
Зохиолч ямар орчныг төсөөлсөн байна вэ? Энэ нь баатрын онцлогийг гаргахад хэр нөлөөлж байна вэ?	Харин та нар орчныг өөрчлөх үү, эсвэл үгүй юу?	

Тухайн хичээл дээр илэрч байгаа хүүхэд бүрийн үйл ажиллагаа нь өмнөх хичээл дээр эзэмшсэн чадвартай хэрхэн холбогдож байгааг анхаарна. Өмнөх хичээлийн агуулгаар эхийн бүтэц, тэдгээрийн утгын холбоог ойлгож тайлбарлаж сурсан байх учиртай. Хэрэв хүүхэд эхийн бүтэцээ (эхлэл, гол, төгсгөл) ялгаж сураагүй бол төгсгөл хэсгийг таамаглаж чадахгүйд хүрнэ. Иймээс сурах барилын ялгаа дараах байдлаар илэрч болно.

Хүүхдийн ялгаатай байдал		Багш хэрхэн зөвлөх вэ?	Гарах үр дүнг тооцоолоорой.
Өмнөх хичээл дээр эзэмших чадвар	“Таамаглан унших” чадвар		
Эхийн бүтэцэ тодорхойлж сураагүй бол	Төгсгөл хэсгээ таамаглахдаа эхлэл, гол хэсгийн утгатай холбож чадахгүй. Яагаад гэвэл “таамаглана” гэдэг нь уншсан зүйл дээрээ тулгуурлахыг хэлдэг учраас.	Эхлэл, гол хэсгийн үйл явдал, баатруудын мэдээлэл нь төгсгөл хэсэгтээ утгын хувьд холбоотой байх учиртай. Өөрөөр хэлбэл үндэслэлгүйгээр таамаглаж болохгүй.	
Эхлэл, гол, төгсгөл хэсэг бүр хэдэн цогцолбороос бүтэц байгааг тодорхойлж чадаагүй бол	Таамаглан зохиохдоо санаагаа хэдэн цогцолборт илэрхийлж болохоо төлөвлөж чадахгүйд хүрнэ. Хэрэв чадахгүй бол цэгцтэй ярьж бичиж чадахгүй.	Цогцолбор бүрт ямар санааг илэрхийлэн ярьж, бичиж сурна гэдэг нь цэгцтэй ярьж, бичиж сурахын эхлэл болдгийг зөвлөнө. Уншсан зохиолын эхлэл, гол, төгсгөл хэсгүүд нь хэдэн цогцолбороос бүтэж байгааг ажиглуулна.	

Таамаглан бичихийн тулд юу хийх вэ?

1. Таамаглан ярьснаа бичихэд бэлдэнэ. Сайн ярьсан бол сайн бичнэ.
2. Бичих санаагаа, таамаглалаа эргэцүүлэн бодож, бусадтай санал солилцъя.
3. Бичих төлөвлөгөө, ерөнхий зураглалаа гаргая. Хэдэн цогцолбор байхаа төлөвлөө. Цогцолбор бүрт ямар санаа илэрхийлэх вэ, баатруудаа яаж зохиох вэ, тэдний үг хэл яриаг яаж зохиох вэ, хөдөлгөөн, харц, дохио зангаа хэрхэн зохиох вэ гэх мэтээр төлөвлөө. Цогцолбор бүрээ утгаар нь хэрхэн холбохоо бодъё.
4. Ноороглон бичье.
5. Таамаглан зохиосон нь эхлэл, гол хэсгийн үйл явдлаас ургуулан зохиосон уу, нягталъя.
6. Баатруудаа зохиохдоо уншигчдад нөлөөлөхөөр бичиж чадсан уу?
7. Зөв бичих дүрмийн алдаа байна уу? Яаж засах вэ гэдгээ хэлэлцье.
8. Цэг, таслалыг зөв хэрэглэсэн үү?
9. Том үсгийн дүрмийг мэдэж байна уу?
10. Үг илүүдсэн үү, үгийг олон давтсан байна уу?
11. Дахин сийрүүлж бичье.
12. Ангийнхандаа уншиж өгье. Бие биеэ дэмжье.

ХОЁР. БИЧИХ ЧАДВАР

4 дүгээр ангийн сурагчдын бичих чадварт тавигдах шаардлага: **Үг холбон, өгүүлбэрийг, оноосон нэрийг том үсгээр эхлэн, эхийг догол мөрөөр зааглан, холбох үг хэрэглэн дэгийн дагуу хичээнгүй, алдаагүй зөв бичих**

Энэ хэсэгт бичих үйл явцыг бага ангийн сурагчдад хэрхэн заах талаар танилцуулсан. Бүтээлчээр бичиж сургах нь сэтгэн бодох, үр дүнтэй харилцах, тайлбарлах, таамаглах, төсөөлөх, асуудлыг шийдвэрлэх, эргэцүүлэх зэрэг үйл явцыг танин мэдэх үр дүнтэй арга юм. Өөрөөр хэлбэл сурагчдын сэтгэлгээний цар хүрээ, хэлний ерөнхий чадвар, өөрийгөө зөв илэрхийлэх чадвар нь бичих чадвараар илүүтэй илрэн гардаг. Жеймс Моффетт хэлэхдээ “Бичнэ гэдэг нь хэн нэгэнтэй ярьж байгаа гэсэн үг” гэжээ. Энэ утгаараа бичих үйл ажиллагаа гэдэг нь тухайн сэдвийнхээ талаар уншигчдад өөрийн санаа бодлоо зөв

ойлгуулна гэсэн үг. Моффетт бичих үйлийн талаар дараах бүдүүвчийг гаргасан байна.



Бичих үйл ажиллагааны зарим давуу тал нь:

- Өөрийн гэсэн үзэл бодол, арга туршлага бүрэлдэхэд тусална.
- Аливаа зүйлийг гүн гүнзгий сэтгэх чадвартай болно.
- Бичих үйлд зөв сурах нь асуудалд буурь суурьтай ханддаг болоход тус болно.
- Өөрийнхөө үзэл бодлыг бусдаар үнэлүүлэх, өөрөө өөртөө үнэлгээ өгөхөд боломж олгоно.

Тус ангид өгүүллэг, үлгэр, шүлэг зэрэг уран зохиолын эхийг дуурайн эсвэл зохиож бичихээс гадна номын танилцуулга, урилга, уриалга, захидал, сонины мэдээ зэрэг хэрэглээний эхийг зохиож бичих чадвар эзэмшинэ. Эдгээр эхийг зохиож бичихдээ дараах бичих арга барилын дарааллаар бичиж сурахыг анхаарна уу.

Бичих арга барил эзэмшүүлэх үйлийн алхмууд	
Зөв бичих	- Өгүүлбэр, эхийг дэгийн дагуу бичих - Дуудлага ижил үгийг ялгаж бичих (хүргэ-хүрэг) - Эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэх, зөв бичих - ж,ч,ш-ийн дараа “и” бичдэгийг мэдэх, хэрэглэх - Хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэх, хэрэглэх - Ном, сонин, сэтгүүлийн нэрийг том үсгээр эхлэн бичих
Бичих санаагаа олох, төлөвлөх	- Бичих сэдвээ сонгох - Бичих санаагаа эргэцүүлэн бодох, бусадтай хэлэлцэх - Бичих төлөвлөгөө, ерөнхий зураглал, бүдүүвч гаргах, санаагаа холбох, тэмдэглэл хийх, хэлэлцэх - Бичихдээ ашиглах баримт, мэдээллээ олж, төлөвлөх
Санаагаа зохиож, байрлуулан бичих	- Төлөвлөсний дагуу ноороглон бичих - Эхийн хэсгийг холбон бичих (холбох хэрэглүүр ашиглах) - Санааг холбож үргэлжлүүлэхдээ ба, бөгөөд, бас, түүнчлэн гэсэн холбоосыг солин найруулах
Бичсэнээ хянах сайжруулах	- Бичсэн зүйлийнхээ утгыг нягталж дахин унших - Зөв бичгийн дүрмийн болон найруулгын алдааг хянаж, засах - Хэн нэгэн уншиж, зөвлөгөө авах - Бичсэнээ нягталж дахин сайжруулах (үг, өгүүлбэр, хэсэг нэмэх, хасах, өөрчлөх) - Эцсийн байдлаар бичиж дуусгах

Бичих санаагаа олж, төлөвлөсний дараа ноороглуулж сургах хэрэгтэй. Нооргийг хүүхдийн дэвтэрт хийлгэнэ. Ноороглосны дараа найруулгын болон зөв бичгийн дүрмийн засвар хийнэ. Найруулгын засвар хийхдээ дараах шалгуурыг хэрэглээрэй.

1. Бичсэн эхийг уншихад ойлгомжтой байна уу?
2. Үг, өгүүлбэр нэммээр байна уу? Ямар үг өгүүлбэр нэмэхээ бодоорой
3. Үг, өгүүлбэр хасмаар байна уу? Ямар үг өгүүлбэр хасахаа бодоорой
4. Үгийн байрлалыг солимоор байна уу?
5. Үгийг солих уу?

Зөв бичгийн дүрмийн засвар хийхдээ дараах байдлаар хийж болно. Багш та өөрийнхөө арга зүйгээр нэмж ажиллаж болно.

1. Бичих гэсэн зорилготой ээлжит хичээл бүр дээр хүүхдийн зохион бичсэн, найруулж бичсэн байдлаас нь алдсан үгийг **ИЛРҮҮЛНЭ**.
2. Илрүүлсэн үгээ **ОНОШИЛНО**. Ямар дүрэмтэй холбоотой болохыг оношилно гэсэн үг.

3. Буруу бичсэн үгийг зөв болгон, холбогдох зөв бичгийн дүрмийн утга учрыг сурагчдын оролцоотойгоор **ТАЙЛБАРЛУУЛНА**. Тухайлбал, зөв болон буруу бичсэн үгсийг харьцуулж яагаад зөв болох, яагаад буруу болох, аль үсэг зөв бичихэд нөлөөлж байна /явахын, явхын/ гэх мэтээр ажиглах, харьцуулах чадварыг хөгжүүлэх зэргээр сурагчийн оролцоо, үйл ажиллагааг идэвхжүүлэх арга зам хайхыг зөвлөж байна.
4. **ТАЙЛБАРТАЙ ДАСГАЛЫН АРГА**⁷ хэрэглэж, сурагч дүрмийн зүй тогтлыг тайлбарлах нь чухал тул багш чиглүүлэх асуултаа тодорхой, оновчтой боловсруулах шаардлагатай юм. Жишээ нь,
Буруу бичсэн үгийг яаж зөв болгосон байна вэ? Сурагч Батын бичсэн нь зөв юм. Яагаад зөв бэ? Буруу хувилбарыг яагаад буруу байгааг тайлбарлана уу. Дүрмийг уншаад тайлбараа нягтална уу. Тайлбарласан дүрмээ бусдад ойлгомжтой болгохын үүднээс найруулж бичиж үзнэ үү гэх мэт асуултын хувилбар байж болно. Нэг ангид 14 нэгж хичээлийг судална гэвэл 14 удаагийн давтамжтай бичих зорилготой хичээл төлөвлөх тул тэр бүрд нь тухайн ангид эзэмших ёстой зөв бичгийн дүрмийн чадваруудыг дахин дахин давтан ярилцах, сурагчдыг өөрсдөөр нь үнэлүүлэх зэргээр ажиллуулж болно. /Мэдээж, нийтлэг алддаг дүрэм бүхий үгсийг сонгож ажиллах нь зүй/ Жишээ нь, Батын бичсэн эхийг 5 хүүхэд шалгана уу. Шалгахдаа бидний үзэж байсан “Гээгдэх эгшгийн дүрэм”-ээр бичсэн үгийг сонгоно уу. Яагаад зөв гэж үзэв? гэх мэтээр бичих арга барилыг дэмжсэн асуултыг хэрэглэхийг санал болгосон. Бага боловсролын зорилго бол сурах арга барил эзэмших явдал юм.
5. Тайлбартай дасгалын аргыг хэрэглэн дүрмийн зүй тогтлыг тайлбарлуулсны дараа **АЛДСАН ҮГИЙГ ОРОЛЦУУЛЖ, ӨГҮҮЛБЭР ЗОХИОЛГОХ** дасгал ажиллаж, дүрмийн бататгалыг хийнэ.
6. **АЛДСАН ҮГИЙГ ОРОЛЦУУЛЖ**, цээж бичиг хийх дасгал ажиллана.
7. **АЛДСАН ҮГИЙГ ОРОЛЦУУЛЖ**, дүрмийн бататгал дасгал хийлгэнэ. Ангийнхаа сурагчдын ямар дүрмийг алдаж байгааг судлах нь чухал. Сурагч өөрийн алддаг дүрэмтэй холбоотой дасгалыг сонгож ажиллахад багш бүр анхаараарай. Энэ нь сурагчийн хэрэгцээн дээр суурилсан хөтөлбөрийн үзэл баримтлалтай холбоотой билээ.

Тухайн дүрэмтэй холбоотой үгсийг бүлэглэж, нүдлэх тогтоолгох аргыг хэрэглэх нь бага ангид үр дүнтэй. Хэрэв унших болон сонсох-ярих чадвар нь даасан ангийн хүүхдэд тодорхой хэмжээгээр илэрч, зохих хэмжээний үр дүн гарч байвал дараа дараагийн нэгжийн хичээлийг зохион байгуулахдаа бичих чадварыг хичээлийнхээ цагийг ихэсгэж, унших, сонсох-ярихын чадварыг багасгаж болох юм. Бүтэн жилд эзэмших чадварыг бүхлээр нь харах нь чухал тул хүүхдийнхээ хурд, хүлээн авах чадвар, суралцах явцыг ажиглаад, нэгж бүр дэх унших, сонсох-ярих, бичих зорилго бүхий хичээлийнхээ цагийг багш зохицуулж болно гэсэн үг. Тиймээс дүрэм дээр тогтож ажиллах шаардлагатай гэж үзэж байгаа бол “бичих зорилготой” хичээлийн дараа 1-2 цаг дан дүрмийн дасгалыг ажиллуулж, нүдлүүлэх ажил өгч болох юм. Хамгийн гол нь нүдэлсэн үгс юугаараа төстэй, ямар дүрмийн дагуу бичигдсэний утга учрыг тайлбарлаж чаддаг байх нь хичээлийн үр дүн болох учиртай.

⁷ “Тайлбартай дасгалын арга, 50 жил”, ред.С.Жагдал, Уб., 2016 он

ЗӨВ БИЧИХ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
4.2а. Дуудлага ижил зарим үгийг утга, бичлэгээр нь ялгаж, өгүүлбэрт зөв хэрэглэх (буурь-буйр, хууль-хуйл, тууль-туйл)	Ойролцоо дуудагдаж, ялгаатай бичдэг үгс байдгийг мэдэхийн тулд - Дуудлага ойролцоо бичлэг өөр үгийн /бага-баг, хана-хан, тана- тан, тууль-туул-туйл, хууль- хуйл- хуул, даахь-даах-дайх, нийтлэлээ-нийтэллээ, аргалын-аргалийн, тараг-тарга/ жагсаалтыг ажиглах - Дээрх үгсийн дуудлага, бичлэгт ямар ялгааг байгааг тодорхойлж, утга ялгаж байгаа авианы доогуур зурах эсвэл тодруулж тэмдэглэх - Дуудлага ижил үгийг ялгаж бичиж сурахын тулд - Ижил дүрэм бүхий үгийг бүлэглэх - Үгийн үндсэн дээр залгавар залгаж бичих \Залгаж бичих залгаврын жагсаалтыг багш өгөх\ - Үгсийг зөв бичих дүрмийн бүртгэлийн дэвтэр дээрээ бичиж тэмдэглэх - Карт зөөж наах аргаар тоглох. Эдгээр нь эргэн санахад дөхөмтэй. Утгыг ялгаж хэрэглэж чадаж байгаагаа харуулахын тулд - Өгүүлбэр, эхэд цэгийн оронд утга тохирох үгийг нөхөж бичих - Өгүүлбэр зохиох - Хэл зүйн таавар зохиох	- “Зөв бичих учиг” УБ, 2008 - “Монгол үсгийн дүрмийн толь” УБ, 1983 - “Сурагчийн тайлбар толь” УБ, 2011 - Ижил нэрийн толь - Цахим болон биет үзүүлэн - Дуудлага ижил, төстэй үгийг харуулсан үзүүлэн, карт
4.2б. Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэх, зөв бичих	Эгшиг үсгийн ангиллыг сэргээн санахын тулд - Үгийн өргөлтөт ба балархай эгшгийг өнгөөр /зураасаар ялган тэмдэглэх - Балархай эгшиг нь ямар гийгүүлэгчийг эгшигжүүлснийг ажиглах - Ямар тохиолдолд эгшигтэй ямар тохиолдолд эгшиггүй бичигдсэнийг тайлбарлаж бичих, ярих - Дараа нь хариултаа зөв эсэхийг шалгах - Бичихэд төвөгтэй үгсийг зөв бичих дүрмийн бүртгэлийн дэвтэр дээрээ бичнэ. Мэдлэг ойлголтоо бататгахын тулд - Алдаатай бичсэн үг, өгүүлбэр, эхийг зөв болгох - Ижил дүрэм бүхий үгийг бүлэглэх - Цэгийн оронд тохирох эгшиг үсэг нөхөх - Дүрэм зөрчдөг үгийг толь бичгээс түүх - Өвөрмөц \дүрэм зөрчдөг үг\ дүрэмтэй үгийг эхээс олох, учрыг асууж мэдэх - Цээжээр бичих дасгал ажиллах - Өвөрмөц дүрэм бүхий үгээр ханын плакат хийх - Дүрэм шалгагч болж тоглох - Ижил жишээ, ижил дүрэм бүхий үгсээр бинго тоглох, карт тоглох - Үгийн сүлжээ, үгийн сүлжээн таавар хийх зэргээс сонгож хийнэ.	- Эгшгийн эгшигжүүлэх дүрмийг мэдэж болохуйц үг, түүвэр өгүүлбэр, богино эх - Ханын зураг плакатны загвар - Үгийн сүлжээ болон үгийн сүлжээн тааврын жишээ загвар - Бинго тоглох хүснэгт
4.2в. Ж, Ч, Ш-ийн дараа "и" бичдэгийн учрыг мэдэх, зөв бичих	Мэдлэг бүтээхийн тулд эхлээд: - Ж, ч, ш-ийн дүрэм бүхий цээж бичиг бичих эсвэл алдаатай бичсэн үг өгүүлбэрийг засах - Алдаагаа сайн хянах - Сурагч бүр алдсан үгсээ жагсаан бичиж, зөв болгох	

	- Хамгийн олон алдсан үгийг зөв бичих дүрмийн бүртгэлийн дэвтэр дээрээ бичнэ. - ж, ч, ш-ийн дараах цэгийн оронд “И”-г нөхөөд тодруулах, үсгийн хэмжээг томруулах, доогуур нь зурах зэргээр тэмдэглэх нь эргэн санахад дөхөмтэй. Мэдлэг ойлголтоо бататгаж, гүнзгийрүүлэхийн тулд: - Алдаа бүхий үгийг түүж, зөв болгох - Ижил дүрэм бүхий үгсийг ангилах, ялгах, бүлэглэх - Эхний болон эцсийн үсгийг сольж өөр үг бүтээх /бүжиг, жүжиг, сүжиг / /бүжиг-бүжин, сүжиг- сүжир/ - Үзсэн дүрэм бүхий үгээрээ ханын плакат /үзүүлэн хийх - Эх зохион найруулж бичихдээ зөв хэрэглэх - Үгийн сүлжээ, үгийн сүлжээн таавар хийх - Ижил дүрэм бүхий үгсээр бинго тоглох	- Зөв бичих дүрмээр хийсэн хэлзүйн тааврын жишээ - Тухайн дүрэмтэй холбоотой үгийн сүлжээ
4.2г. Хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэх, зөв бичих	Мэдлэг бүтээхийн тулд эхлээд: - Ъ, Ъ тэмдгийн дүрэм бүхий үгс орсон цээж бичиг бичих эсвэл алдаатай бичсэн үг өгүүлбэрийг засах эсвэл зөөлөрсөн эгшигт гийгүүлэгчээр \барь ...гэх мэт\ болон зөөлөрсөн заримдаг гийгүүлэгчээр \захь... гэх мэт\ төгссөн үгэнд тохирох залгаврыг залгаж бичих \багш залгаж бичих залгавруудыг өгсөн байна\ - Залгаж бичсэн үгсээ “Ъ” тэмдэг и болох эсэхээр нь ангилж бичих - Бичсэнээ хянаж, шалгах \багш зөв хариултыг РРТ-оор, тараах материал ... гэх мэтээр дамжуулж харуулах\ - Сурагч бүр алдсан үгсээ жагсаан бичиж, зөв болгох - Хамгийн олон алдсан үг болон өвөрмөц бичдэг үгийг \уяа, оёё гэх мэт\ зөв бичих дүрмийн бүртгэлийн дэвтэр дээрээ бичнэ. - Цэгийн оронд “Ъ”, “Ъ” тэмдэг нөхөөд тодруулах, үсгийн хэмжээг томруулах , доогуур нь зурах зэргээр тэмдэглэх нь эргэн санахад дөхөмтэй. Мэдлэг ойлголтоо бататгаж, гүнзгийрүүлэхийн тулд: - Алдаа бүхий үгийг түүж, зөв болгох - Ижил дүрэм бүхий үгсийг ангилах, ялгах, бүлэглэх - Ъ, Ъ тэмдэг үсгийг сольж өөр үг бүтээх (больё, больё, сорьё, сорьё) - Үзсэн дүрэм бүхий үгээрээ ханын плакат /үзүүлэн хийх - Эх зохион найруулж бичихдээ зөв хэрэглэх - Үгийн сүлжээ, үгийн сүлжээн таавар хийх - Дүрэмтэй холбоотой хэлзүйн таавар зохиох, таах - Ижил дүрэм бүхий үгсээр бинго тоглох - Хэлзүйн таавар зохиох, таах	- Цагаан самбар, самбарын үзэг, эсвэл Ъ, Ъ бүхий карт - Барь, захь мэтээр зөөлөрсөн гийгүүлэгч бүхий үг карт + залгавар \ц, дал, в, жээ, аа ... \ бичсэн картууд бүхий цахим эсвэл биет үзүүлэн - Цээж бичгийн эх, түүвэр өгүүлбэр “Зөв бичих учиг” УБ, 2008 - “Монгол үсгийн дүрмийн толь” УБ, 1983

Багшийн анхаарах зүйл:

Зөв бичгийн дүрмийг багш өөрөө хэлж заахаасаа илүү дүрмийн зүй тогтлыг сурагчдаар ажиглуулж, тайлбарлуулах арга зүйг голлон хэрэглэнэ. Ингэхдээ үгийн бүтцийг задлах үйл дээр тулгуурлан ажиллахыг зөвлөмжилж байна. Практикаас харахад үгийн бүтцийг заах, язгуур гэж ангилуулах зэргээр хэт хэлзүйжсэн хандлагаар зөв бичих үйлийг удирдаж байгаа нь учир дутагдалтай байна. Идэвхтэй язгуур, идэвхгүй язгуур гэдэг ойлголтыг хүүхэд мэдэх ёстой гэхээсээ илүү үгийн бүтцийн дагуу зөв бичгийн дүрмийг ТАЙЛБАРЛУУЛАХыг анхаарна уу. Жишээ нь, амжилт гэдэг үгийн язгуур нь амж уу, ам уу гэж асуух нь гол болохоос амж гэдэг нь идэвхтэй язгуур юм гэж заахгүй юм. Амж гэж хариулж байгаа хүүхдээс яагаад ингэж хариулсныг эргэцүүлж тунгаан бодуулах хэрэгтэй. Тухайн үгийн үндсэн утга нь мөн үү гэсэн чиглүүлгээр үгийн язгуур утган дээр ажиллана. Зөв бичүүлж сургахад бас нэг асуудал бол оноосон нэрийг том үсгээр бичих явдал юм. Дараах аргачлалаас “Том үсгээр бичнэ” гэж багш зааж, цээжлүүлэх биш мэдлэг бүтээлгэх аргаар хэрхэн ажиллаж болохыг анзаарч харна уу.

Ном сонин, сэтгүүлийн нэр гарчигтай эх сонгон уншуулна.

- Эхний үсгийг том үсгээр бичсэн үгийг ажиглуулна.
- Яагаад том үсгээр бичсэнийг сурагчид өөрсдийн таамгаар ярилцана.
- Өөр өөр юу юуны нэрийг том үсгээр бичиж болохыг таамаглан ярилцана.
- Дүрмээ уншуулж, яагаад ингэж дүрэмлэснийг яриулна.
- Том үсгийн дүрмийг яаж хэрэглэхээ дүгнэнэ.
- Том үсгийн дүрмийг алдаж бичсэн эхээс алдааг олж, багаар харилцан ярилцана.
- Дүрмийн тодорхойлолтыг хэрэглэн алдаатай болсныг батална.
- Зөв болгож бичсэнээ бусдадаа тайлбарлан ярина.

Мэдлэг ойлголтоо бататгахын тулд

- Цээж бичиг бичих, алдаатай бичсэн үгийг засах
- Ижил дүрэм бүхий үсгийг ангилах, ялгах, бүлэглэх
- Ижил дүрэм бүхий үсгээр бинго тоглох

Зөв хэрэглэж чадаж байгаагаа харуулахын тулд

- Өгүүлбэр эхэд оруулан зохиох
- Ямар ч тохиолдолд зөв хэрэглэх. Үүнийг шалгахын тулд бусад хичээлийн дэвтрийг сольж дүгнэлт, зөвлөгөө өгөх
- Сонин, сэтгүүлийн хавтас хийх

Эх, өгүүлбэрийг дэгийн дагуу бичих

Ер нь багш эх хэлнийхээ бичгийн соёлыг сайн эзэмшихийн чухлыг таниулж, ухуулж байвал сайн. Өөрөөр хэлбэл бичгээр үйлдсэн бүхэн баримт болон хадгалагддаг. Тиймээс харилцааны чухал элемент болно. Тиймээс сурагчдын бичгийн соёлд анхаарах нь зүй.

Хүүхэд бүрийг дэгийн дагуу хичээнгүй, хурдан, сайхан бичиж байгаа эсэхийг багш ажиглаад тэгж бичиж чадахгүй байгаа сурагчдыг хичээнгүй бичүүлж сургахын тулд дараах аргуудыг хэрэглэж үзээрэй.

1. Тодруулан бичих арга: Бичгийн хэлбэр сайн биш байгаа бол дэвтэрт нь үсэг, үг, өгүүлбэрийг цэглэх буюу балын харандаагаар бичиж өгөөд түүнийхээ дээгүүр дагуулан бичдэг арга юм.
2. Төрөлжүүлэн бүлэглэх арга: Үсгийн зурлагын ижил төстэй байдлаар төрөлжүүлж хөнгөнөөс хүндрүүлэх замаар ялган хуваагаад бичиг сайжруулах дасгал хийлгэх арга юм.
3. Баримжааллын арга: Дэвтэрт бичүүлэхийн өмнө агаарт бичих хөдөлгөөн хийлгэсний эцэст бичүүлнэ гэсэн үг. Энэ аргуудыг зөв үед нь оновчтой хэрэглэснээр бичүүлэх ажил үр дүнд хүрнэ.

Цэг тэмдгийг зөв хэрэглэх, догол мөрийг зөв гаргах

Өгүүлбэр эхийг дэгийн дагуу бичих гэсэн чадварын дор хичээнгүй сайхан бичихээс гадна цэг тэмдгийг зөв хэрэглэх, догол мөрийг зөв гаргаж бичиж сурах нь цаашид эхийг төлөвлөх, төлөвлөснийхөө дагуу бичиж сурах, утгыг хэрхэн ухаарч байгаагаа харуулахад тусална.

Цэг тэмдгийг бусад чадваруудтай холбож заахдаа багш тодорхой нөхцөлийг өгөөд харилцан яриа зохион бичүүлж болно. Тэгэхдээ цэг тэмдгийн хэрэглээнд анхаарах хэрэгтэй. Жишээ нь: Чи өөрийгөө хамгийн унших дуртай зохиолынхоо зохиогчтой уулзаж байна гэж төсөөл. Тэгвэл чи түүнтэй хэрхэн ярилцах вэ? гэх зэргээр нөхцөл өгч бичүүлж болно.

Харин өгсөн нөхцөлийн дагуу өөрөө төсөөлөн бодож бичиж чадахгүй бол зөвхөн цэг тэмдгийг хэрхэн хэрэглэж байгааг харахын тулд янз бүрийн тавилтай даалгавар өгч болно.

- Өгсөн зохиолыг уншаад онцолсон хэсэгт цэг тэмдгийг нөхөж бичих
- Зохиолыг харилцан ярианы хэлбэрт оруулан хувиргаж бичих

Ямар цэг тэмдэг нөхөж бичсэнийг ярилцахдаа багш шууд хэлж өгөхөөс илүүтэй онол бүхий үзүүлэн слайд харуулж өөрсдөөр нь эхэлж засуулахыг хичээвэл зүйтэй.

Зөв бичих дүрмийг мэдэх, зөв бичих

Зөв бичих дүрмийн мэдлэг олгохдоо багш зөв бичих дүрмийг шууд хэлж өгөхөөс татгалзах хэрэгтэй. Аль болохоор мэдэхгүйгээс мэдэх хүртэл сурагчид өөрсдөө мэдлэг бүтээх замаар ажиллуулбал хүүхдийн сурах арга барил эзэмших явц сайжирна. Мэдлэг бүтээлгэхдээ доогуур нь зурах, өнгөөр тодруулах, дугуйлах, ангилж бичих, үсгийг томоор бичих зэргээр энгийн зүйлийг хийлгэхээс эхлээд алхам алхмаар өөрсдөө учрыг олж сурах барилд сургах хэрэгтэй.

Мэдлэг ойлголтыг бататгахын тулд уг мэдлэг чадвартай холбоотой төрөл бүрийн энгийн даалгавруудыг гүйцэтгэнэ. Үүний тулд сурах үйл ажиллагааны хэсэгт хэд хэдэн хийж болох үйл ажиллагааг бичсэн байгаа.

Түүнээс тухайн нөхцөл байдалдаа тохируулан сонгож хэрэглэнэ. Гэхдээ нэг биш хэд хэдэн үйл ажиллагааг сонгож хэрэглэх бөгөөд аль болохоор өөр өөр байдлаар хийлгэхээр сонговол хүүхдэд сонирхолтой байх болно. Жишээ нь: доогуур нь зурах, тодруулах, карт, өргөх наах, тоглох, бинго тоглох, үгийн сүлжээ таах гэх мэт

Зөв бичих дүрмийг ойлгуулахдаа:

- Аливаа хэл зүйн ойлголт дүрмийг багцлан ойлгуулах
- Тэдгээрийг хэрэглээ болгох, үгсийг хувиргах явцад суралцагч дүрэм бодохгүйгээр зөв бичих, дадал хэвшлийг олж авах нь чухал гэдгийг анхаарна. Зөв бичиж сурах нь дахин давтан үйлийн явцад суралцах үйл ажиллагаа мөн юм.

Суралцагчдад өгч байгаа ажлууд нь тэдний нөөц бололцоог дайчилсан бас багшаас дэмжлэг авахаар ялгаатай байдлаар боловсруулагдсан байх ёстой. Хэрэв суралцагчдад нөөц бололцоог нь шаардсан ажлуудыг түвшинд нь тохируулан өгвөл тэд сурах үйл ажиллагаанд илүү их оролцдог. Ялгаатай даалгавар гэдэг нь суралцагчдын чадварт тохирсон даалгавар өгнө гэсэн үг. Нэг чадварыг эзэмшүүлэхийн тулд энгийнээс хүнд рүү чиглэсэн хэд хэдэн даалгаврыг боловсруулж ажиллуулна гэсэн үг.

- Даалгаврыг агуулгын хувьд (тухайлбал тэдэнд сонголт бүхий даалгавар өгөх эсвэл тодорхой зорилго бүхий зорилтот асуултууд асуух байж болно)
- * Бүтцийн хувьд (даалгаврыг ялгаатай хэлбэр загвараар боловсруулах) ялгаатай байдлаар боловсруулж болно. Ингэхдээ танин мэдэхүйн түвшний хүрээнд хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн байдалтай хийвэл сайн. Тэгвэл багш сурагч сэтгэх чадварын аль түвшингийн даалгаврыг сайн хийж чадаж байгааг ажиглах боломжтой. Энэ нь сурагчийн ахиц амжилтыг тодорхойлоход тус болно.

Даалгаврын сонголт

Сонголт бүхий даалгавар нь ялгаатай хандах сургалтын хамгийн энгийн арга юм. Хэрэв суралцагч тухайн даалгаврыг хийж чадна гэсэн итгэл үнэмшилтэй байвал илүү хүнд даалгаврыг сонгодог. Хэрэв тийм биш бол илүү суурь буюу анхан шатны даалгаврыг сонгодог.

Хамгийн хүнд даалгаврууд нь асуудал шийдвэрлэх эсвэл сурсан мэдлэг чадвараа танил бус нөхцөлд хэрэглэх даалгавар байж болно. Багш суралцагчдад аль асуудлыг шийдэх вэ гэдгийг тодорхойлоход удирдан чиглүүлж болно. Үүний тулд сурах үйл ажиллагааны хэсэгт байгаа үйл ажиллагаанаас сонгон хийлгэж болно. Үлгэрлэвэл:

Асуулт бүхий карт

Тухайн суралцагчид чиглэсэн асуултыг хэрэглэх нэг арга нь асуулт бүхий карт ашиглах явдал. Картны асуултын хүнд хөнгөнийг өнгөөр ялгаж өгч болно. Илүү хүнд асуулт бүхий карт нь илүү өндөр түвшний байна.

Эдгээр картуудыг суралцагч мэдлэг, чадварынхаа түвшинд тохируулан авна. Жишээ нь: Ногоон өнгийн картан дээр хамгийн энгийн хялбар сэрэгэн санах асуулт \ зөвхөн ямар дүрмээр бичигдсэнийг хэлэх\, цэнхэр өнгийн карт дээр дүрэмд тохирох жишээ хэлэх, ягаан өнгийн карт дээрх адил төстэй үгийг ялгааг олох, шар өнгийн карт дээр ялгааг олох өөр шинэ арга замыг эрэлхийлсэн асуулт байж болно. Өөрөөр хэлбэл гүйцэтгэх үйл ажиллагааны хувьд хөнгөн, дунд зэрэг, хүнд, маш хүнд байх, сэтгэх чадварын доод, дунд, дээд чадварыг илрүүлэх асуултууд байна гэсэн үг.

Жишээ нь:

Хожил, жүжиг, жишиг, ачилга гэх мэт үгс ямар дүрмээр бичигдэх вэ?	Дал, сонин, Зар мэдээ, нар, Хүмүүн бичиг, сурлага, Гялбаа, онгоц, Тунгалаг тамир дээрх үгсийн заримыг яагаад томоор бичсэн байна вэ?
барья, баръя, харья, харъя, больё, больё Аль аль үг тусгаарлах үүргээр орсон байна вэ?	Дуудлага ижил үгийг ялгаж бичих ямар арга байж болох вэ?

Даалгаврын загвар, хэлбэрүүд

Нэг энгийн сурагчдад гүйцэтгэх даалгаврууд өөр өөр байж болно. Тухайлбал:

- Сэдвийг бүрэн ойлгож чадахгүй байгаа суралцагчдад дутуу зүйлийг / диаграмм, схем, загвар, цэгийн оронд / гүйцээж нөхөж бичих даалгавар өгч болно. Хэрэв суралцагчдад нэмэлт дэмжлэг хэрэгтэй бол нөхөх үгсийн жагсаалтыг гаргаж өгч болно. Жишээ нь: монгол хэлэнд зүй тогтол олуулдаг ийм төрлийн даалгаврууд байдаг. Жишээ нь: жижиг, сольё, Гялбаа, сүжиг, больё

Үр дүн нь ялгаатай байдгийг анхаарах нь зүй. Учир нь суралцагчдад нэгэн ижил нээлттэй даалгавар өгөхөд тэдний чадвараас шалтгаалан даалгаврыг ялгаатай байдлаар гүйцэтгэдэг.

Эндээс сурагчдын сурах арга барил, сэтгэхүйн цар хүрээ харагддаг.

Сэдвийг хялбархан ойлгож байгаа сурагчдын чадварыг бүрэн дайчлах

Тухайн ангид даалгаврыг маш амархан ойлгоод хийчихдэг, ажиглаад дор нь ойлгочихдог хүүхдүүд байдаг. Гэтэл зарим нь ажиглаж ойлгох чадвар сул байдаг ийм хүүхдүүдтэй багш тулж ажиллах хэрэг гардаг. Энэ үед ойлголт сайтай, хурдтай хүүхдүүдэд

- Асуудал шийдвэрлэх: Суралцагчдад илүү өндөр түвшний сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх элемент эсвэл шинэ мэдлэгээ танил бус нөхцөлд хэрэглэхийг шаардсан нэмэлт даалгавар өгч болно. Жишээ нь үгийн сүлжээ хийлгэх, бөглөх, хэл зүйн таавар зохиох, таах гэх мэт
- Хичээлийн зарим хэсгийг удирдах: Суралцагчдад хичээлийн аль нэг хэсгийг удирдах үүрэг өгч болно.
- Эсвэл дүрэм шалгагч болгож өөр бусдын хийснийг хянах, зөвлөгөө өгөх зэргээр ажиллуулах хэрэгтэй. Эс тэгвээс хүүхдэд хичээл уйтгартай санагдаж, магадгүй дургүй болж болзошгүй. Ялангуяа анги дүүргэлт ихтэй тохиолдолд багш бүх суралцагчдад хүрч ажиллахад бэрхшээлтэй байдаг. Тиймээс сэдвийг бүрэн ойлгохгүй байгаа болон сайн ойлгож байгаа суралцагчдын аль алинд нь нэгэн зэрэг туслах арга бол сурагчид бие биедээ зөвлөх арга юм.

Хоёр од нэг хүсэл

Үүнийг сурагчид дан дангаараа, хоорондоо хийх, мөн багшаараа хийлгэж болно. Дараах зүйлсийг багтаасан байна.

- * Сурагчийн хийсэн хоёр сайн зүйл (хоёр од)
- * Сурагч сайжруулж хэрэгтэй нэг зүйл (хүсэл)

Жишээ

2 од нэг хүсэл	Сурагчийн санал бодол	Багшийн санал бодол
	Өнөөдрийн заасан дүрмийг би зөв хэрэглэж сурсан.	Дүрэмд тохирох жишээ үг олж, тайлбарласан нь сайн болов.
	Би эгшгийн зөөлрүүлэх, эгшигжүүлэх үүргийг мэддэг болсон.	Эгшгийн эдгээр үүргийг маш сайн ялгадаг болсон байна.
	Би дуудлага ижил үгийг алдаагүй бичиж сурмаар байна.	Дараагийн удаа дуудлага ижил үгийг алдаагүй бичиж сурахын тулд нүдлэн тогтоох аргуудаас сайн хэрэглээрэй.

Алдааг засах

Сурагчдад алдаатай, буруу хийсэн хяналтын ажил эсвэл тараах материал өгнө. Сурагчид энэ ажилд дүн тавьж цаашид хэрхэн сайжруулах талаар бүтээлч саналаа хэлнэ. Ингээд ангийн сурагч нэг бүрийн санааг хураан авна. Ингэснээр нэгэн сайн ажлын жишээ бий болно. Иймэрхүү ажлыг хийснээр сурагчид сайн муу ажлыг тодорхойлж, сайжруулах хэрэгтэй зүйлсийг илрүүлж чаддаг болно.

Жишээ нь: Багш дүрмийн болон цэг тэмдгийн алдаатай материал өгөн, сурагчдаар засуулж, дүгнэлт хэлүүлнэ. Өөрөөр хэлбэл ямар дүрмийг хэрхэн хэрэглэж чадаж байгааг анхаарна. Үүний жишээг эхийг дэгийн дагуу агуулгын бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд цэг тэмдгийг зөв хэрэглэх гэсэн хэсгээс үзнэ үү.

Үнэлгээний схемийн дагуу оноо тавих

Сурагчдад тодорхой даалгаварт зориулсан үнэлгээний шалгуурыг багш өөрөө бэлтгэж өгсөн байна. Үнэлгээний шалгуур нь, ямар ажилд хэдэн оноо өгөхийг нарийн заасан байна. Ийм шалгуурын дагуу сурагчид өөрийнхөө болон бусад нөхдийнхөө ажилд үнэлгээ өгч болно. Үүнийг хийхдээ рубрикийн аргаар хийнэ.

Сурагчийн нэр

Шалгуур буюу чадвар	4 оноо	3 оноо	2 оноо	1 оноо	0 оноо
Дэгийн дагуу зөв сайхан бичсэн эсэх Том жижиг үсгийн хэлбэрийг зөв бичих, зөв холбох					
* Үсгүүдийн өндрийг жигд бичих					
* Үг ба үсгийн хоорондын зайг ижил хэмжээтэй бичих					
* Үг, үсгийг дэвтрийн шугаман дээр тэгш бичих					
* Үзэгний даралт, жигд хөнгөн байх					
Анхаарах зүйл	Үсгийн өндрийг тохируулаагүй учир 3 оноо авав.				

Өөрийн үнэлгээний схемийг зохиох

Тодорхой асуултуудад хариулахын тулд сурагчид өөрсдөө үнэлгээний шалгуур зохионо. Уг журам нь ямар хариултад хэдэн оноо өгөх зэргийг нарийн тусгаж, бүрэн хариултыг тайлбарын хамт хийсэн байх ёстойг багш анхааралдаа авна. Дээрх маягаар хүснэгт хийх бөгөөд багш бэлтгэх биш, хүүхдүүд өөрсдийнхөө юу сурсан, мэдсэн, чадсанаа хүрээнд хийнэ. Энд хүүхэд өөрсдийнхөө чаддаг болсон зүйлийг ихэвчлэн шалгуур болгож гаргах тул багш юуг сайн чадахгүй байна гэдгийг илрүүлж дараагийнхаа үйл ажиллагааны төлөвлөлтөд тусгана гэсэн үг. Хийх арга нь дээрхтэй ижил. Харин шалгуурыг багш биш сурагчид хийнэ гэсэн үг.

Нүдлэн тогтоолгох арга

- I. Багш суралцахуйн үйл ажиллагааны хүрээнд тодорхой даалгавруудыг төлөвлөөд, түүний дагуу хичээлээ зохион байгуулсан ч хүүхэд бүрийн эзэмшсэн мэдлэг чадварын түвшин харилцан адилгүй, ойлгож мэдэж авсан арга нь ч өөр өөр байдаг. Зарим хүүхдүүд хэрхэн дуудагдаж байгаагаар нь бичээд маш удаан хугацаанд дүрмийн дагуу зөв бичиж сурдаг. Ийм хүүхдүүдтэй ажиллахын тулд нүдлэн тогтоох аргыг хэрэглэж болно. Үүний тулд номны хавчуурга хийх, наадаг цаасан дээр бичиж суудаг ширээ сандал, компьютерийн дэлгэц хавьд, хаалга цонхны орчмын газарт наах, ангийн хананд зөв бичих дүрмийн самбар байрлуулж наах, халаасны тэмдэглэлийн дэвтэрт бичих, дэвтрийн хавтсыг өнгийн цаасаар хийж, түүнийгээ нүдлэн тогтоох үг бичих зай, шугам гаргаж чимэглэх зэргээр ажиглуулах хэрэгтэй. Доор номын хавчуурга хийх аргыг толилуулав.

Сурагчийн бэлтгэх материал: хайч, цавуу, өнгийн цаас, багахан хэмжээний утас, шугам, өнгийн маркер

Багшийн бэлтгэх зүйл: Тухайн сурагч ямар дүрмээр бичигдэх үгийг их алдаж байна, ямар үгийг дуудлагаараа бичээд байна гэдгийг багш тогтоосон байна. Эсвэл сурагчдаар аль үгийг, ямар дүрмээр бичигдэх үгийг илүүтэй алдаж байгааг тодорхойлуулсан байна. Тэгээд номын хавчуургаа хийнэ.

- II. Сурагчид өнгийн цаасаа давхарлаж нугалаад, дээр нь өөрийн сонирхсон зүйлээ \ жимс, аяга, гурвалжин, дугуй, жааз хүрээ... гэх мэт \ зураад тойруулан хайчилна. Тэгээд 5-7 см орчим утас тасдан авна.
- III. Бэлэн болсон утасныхаа нэг үзүүрийг аяганыхаа амсарт хийж хоёр цаасаа нийлүүлэн наана. Наасан цаасныхаа хоёр талд нүдлэх үгээ бичнэ.
- IV. Өнгийн цаасны өөдөснөөсөө жижиг хэмжээтэй хайчилж аваад мөн дуртай дүрс болгон хайчилна. Нэг талд нь судалж байгаа зөв бичих дүрмээ бичээд цаасаа нугална. Утасныхаа нэг үзүүрийг бэлэн болсон цаасан дундаа хийж наана.
- V. Хайчилж бэлтгэсэн цаасан дээрээ сурагчид өөрсдийнхөө хамгийн их алддаг үсгийг бичих, дүрэм зөрчдөг үгийг бичих зэргээр ашиглаж болно.

больё – больё
халья – халья
хэлье

Уяя
Оёё

Тоглоомын аргаар нүдлүүлэх

Энэ нь нүдлэн тогтоолгох нэг арга төдийгүй хүүхдийн ой тогтоолтыг шалгах бас нэг арга болно.

Багш урьдаар дуудлага ижил болон төсөөтэй бичлэг өөр үгсийг тусгай хүснэгт болгон дараах байдлаар бэлтгэсэн байна. Маш олон үгийг ингэж доорх байдлаар хийвэл илүү сонирхолтой байна.

Тоглоомын заавар

- * Энэ хүснэгтийг PPT программ дээр бэлтгэх юм уу эсвэл том ватум цаасан \ватум байхгүй бол бичгийн, дэвтрийн цааснуудыг нааж болно\ дээр зураад самбарт хадна. PPT дээр бэлтгэвэл хэдэн янзаар сольж ажиглуулах боломжтой. Жишээ нь:

баг	хуйл	бага	булаг
хууль	тараг	туйл	тайр
буурь	таар	буйр	хүрэг
тарь	хүрэг	туул	буур
хуул	тууль	булга	тарга

бага	хуул	баг	булга
хуйл	тарга	тууль	таар
буйр	тайр	буурь	хүрэг
тарь	хүрэг	тууль	буур
хууль	туул	булаг	тараг

- * Сурагч бүрт хүснэгтэд байгаа үгийг тус тусад нь бичсэн цаасыг тараан өгөх \сурагчдаар өөрсдөөр нь хийлгэж болно.

баг

бага

хуул

хуйл

хууль

- * Сурагчдад 30 секундын, 1 минутын дотор гэх мэтээр заасан хугацаанд хүснэгтэд байгаа үгсийг дараалал, байраар нь нүдлэн тогтоох даалгавар өгнө. Хугацаа дуусангуут багш PPT дээр бэлтгэсэн слайдаа хаана.

- * Хугацаа дууссаны дараа сурагчид ширээн дээрээ ажиглаж тогтоосноо байрлуулна. Бүх сурагчийг байрлуулж дууссаны дараа багш слайдыг дахин харуулж хэдэн үгийг зөв тогтоосныг өөрсдөөр нь эсвэл хажуу дэргэд суусан хүүхдээр нь үнэлүүлж болно. Энэ мэтээр энэ дасгалыг янз бүрээр өөрчлөн хийлгэж болно. Эсвэл дуудлага төстэй бичлэг өөр үгсийг ялган зөв хэрэглэж байгааг ажиглахын тулд сурагчдад хүснэгтэд байгаа үгийг бус утга ялгах холбоо үгийг өгч болно.

хамт олон

нас

бичих

цаас

дүрэм

Энэ нь тухайн нөхцөлд зөв утгаар, зөв бичих дүрмийн хувьд алдаагүй байгааг харуулахад нэг алхам болох юм.

Тайлбартай дасгалын арга

Тайлбартай дасгалын арга нь олон жил сургалтад хэрэглэгдэж үр дүнгээ өгсөн хийгээд мэдэхгүй багш байхгүй учраас энэ аргаар зөв бичих дүрмийн ойлголтыг бататган эзэмшүүлэхэд тохиромжтой.

ЗОХИОН НАЙРУУЛЖ БИЧИХ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
4.2д. Үйл явдлыг өрнүүлэн, утгын уялдаа холбоотой, богино өгүүллэг зохиох	- Өгөгдсөн эхийн эхлэл хэсгийг уншиж ойлгох - Гол, төгсгөл хэсгийг өрнүүлэн бичихээс өмнө төсөөлөн бодох, дараах асуултыг хэрэглэх - Баатруудад юу юу тохиолдож болох вэ? - Баатруудад ямар ямар бэрхшээл таарсан байж болох вэ? - Баатруудад боломж гарсан болов уу? Боломжийг яаж ашигласан байж болох вэ? - Баатрууд хоорондоо юу гарсан бол? Юу гэж хэлсэн бол? Юу гэж ярилцсан бол? Ямар зан гаргасан бол? - Хэлсэн үг, хийсэн үйлдлүүд, дотоод бодлыг төсөөлөх - Ямар ямар шийдвэр гаргаж, яаж даван туулсан юм бол? - Ямар нэгэн зан чанарыг гаргахад өөр хэн нэгэн нөлөөлсөн байж болох уу? гэх мэт - Гол хэсгийн үйл явдлын дэс дарааг төлөвлөж, байршуулах - 1-2 цогцолбороор санаагаа илэрхийлэх дасгал ажиллах Төлөвлөлт хийж сурахын тулд эхлээд төлөвлөлт хийх аргад суралцана. - Оюуны зураглал хийх, схемчлэх \загварчлах\ - Эхлээд юу болов? Дараа нь юу болов? Төгсгөлд нь юу болов? гэж дарааллуулан байрлуулах - Гол утгыг илэрхийлсэн тулгуур үгээр, гол утгыг агуулсан өгүүлбэрээр, - Цаг хугацааны шулуунаар ... гэх мэт. Төлөвлөлт хийх аргыг хэрхэн ойлгосноо бататгахын тулд - Сурагчид хосоор ажиллаж, цуглуулсан санаанууддаа тохируулж төлөвлөлтийн аргаа сонгоно. Сурагчид загварт оруулан холбоо хамаарлаар нь сумаар заах, дугаарлах, хэрэгтэй санаагаа хаалтад хийх, зурах жагсаалт гаргах, наадаг цаасан дээр бичиж шилжүүлж зөөх зэргээр тэмдэглэнэ. - Сурагчид төлөвлөлтөө өөр хостой солилцон хэлэлцэх, санал зөвлөгөө бичих Санал зөвлөгөөний дагуу сайтар ярилцаад төлөвлөлтөө сайжруулах - Төлөвлөсний дагуу ноороглох - Нооргоо засах - Найруулгын засвар хийх - Зөв бичгийн дүрмийн засвар хийх - Дахин сайжруулж бичих, хичээнгүй бичих - Бусдад уншин өгч, зөвлөгөө авах	- Тодорхой нэг сэдэвт тохируулан цуглуулсан материал буюу төрөлжсөн эх - Сэдвийн жагсаалт - Сурагчдын зохиосон өгүүллэгийн жишээ

Багшийн анхаарах зүйл:

Үйл явдлыг өрнүүлнэ гэдэг нь эхийн эхлэл хэсгээс хойших үйл явдлыг нэмж зохионо гэсэн үг юм. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийн заагийг тодруулан бичихдээ **ХОЁР.УНШИХ ЧАДВАР** гэсэн хэсэгт буй “4.1в. Уншсан эх, үлгэр, өгүүллэгийн бүтцийн хэсгүүдийн учир шалтгааныг тайлбарлах” суралцахуйн зорилттой холбохыг анхааруулж байна. Гол хэсэгт баатруудад тохиолдсон тохиолдол, тохиолдсон бэрхшээл, боломж, баатруудын хоорондын харилцан яриаг хэрхэн бичсэнийг ажиглан уншуулсны дараа дуурайлгах аргаар үйл явдлыг өрнүүлж бичих даалгаврыг эхлэх хэрэгтэй. Төгсгөл хэсэгт дүгнэлт, уншигчдад хэлэх гэсэн санаагаа бичүүлж сургахад чиглүүлнэ. Цогцолбороор санаагаа илэрхийлж бичих ажил 4 дүгээр ангиас эхэлж, 5 дугаар ангид үргэлжлүүлэн орно. Нэг цогцолборт нэг санаа гаргаж бичихийг багш анхаарна. Гол хэсэгт баатруудад тохиолдсон тохиолдол, тохиолдсон бэрхшээл, боломж, баатруудын хоорондын харилцан яриаг зохиож бичихдээ 1-2 зарим тохиолдолд 3 цогцолборт санаагаа гаргаж бичүүлэхэд багш анхаарна.

Өрнүүлэн бичихэд сургахын тулд эхлээд сурагчдын уншаад ойлгох чадвар сайн байх хэрэгтэй. Учир нь өрнүүлэн бичихэд өмнөх үйл явдлын утга учрыг алдагдуулахгүйгээр цааш үргэлжлүүлэх тул эхлээд ямар үйл явдал дүрслэгдэв?, ямар ямар дүр гарч байна? гэдгийг бичиж ярилцсаны эцэст сурах үйл ажиллагаа хэсэгт байгаа асуултын дагуу өрнүүлэн бичүүлэх хэрэгтэй. Ер нь бага ангийн сурагчдад сурах арга барил эзэмшүүлэхийн тулд дагуулан хийх, өмнө уншсан эх дээр суурилан дуурайн хийх, асуултаар хөтлөх зэргээр дадалд сургана. Мөн өрнүүлэн бичнэ гэдгийг ойлгохгүй сурагчид байвал хичээлийн зохион байгуулалтаа өөрчилж, хосоор хийх, багаар ажиллах арга зүйг сонгож ажиллавал илүү үр дүнтэй.

Марафон бичлэгийн аргаар богино өгүүллэг бичих

Энэ нь өгүүллэгийг бусдын санаа бодлоос ургуулан бичих арга юм. Логик сэтгэлгээг хөгжүүлэх, мэдээллийг ойлгож хүлээн авах, мэдээллийг ойлгомжтойгоор дамжуулах, хамтран ажиллах чадварыг хөгжүүлнэ.

Багш бичих сэдвүүдийг бэлтгэсэн байна. Багш сэдвийн жагсаалтуудаас сурагчдаар хэлэлцүүлээд аль сэдвээр бичихээ сурагчид шийдсэн байна.

Тэгээд ангийн ширээнүүдийг дамжуулахад амар буюу дөрвөлжин ☐ хэлбэрээр засна.

Тэгээд багш үйл ажиллагааны дүрмийг танилцуулна. Дүрэм нь:

- * Хугацаа эхлэнгүүт бүх сурагч сэдэвт тохируулан зохион бичлэгийнхээ эхлэл хэсгийг бичнэ. Энэ нь цааш амархан үргэлжлэх боломжтой байна гэдгийг багш анхааруулна.
- * Багшийн дохиогоор дуусган дараагийн сурагчдадаа нар зөв тойруулан дамжуулах замаар өөрийн материал өөр дээрээ эргэн иртэл бичвэр үргэлжлүүлнэ. Гэхдээ хүүхдүүд ирсэн зохион бичлэгийг уншиж байж үргэлжлүүлэн бичнэ. Хэтэрхий олон сурагчтай бол багаар ажиллуулж болно.
- * Сурагч өгүүллэгээ уншаад төгсгөлийг гүйцээх, гарчиг өгөх зэргээр бүтээлчээр ажиллана.

Багш бичиж эхлэхээс өмнө дараах зүйлийг бүх сурагчдад анхааруулах ёстой.

- ✓ Шилжүүлэх дохиогоор дараагийн сурагчдаа өгөх
- ✓ Ирсэн зохион бичлэгийг хүүхэд бүр заавал уншиж байж үргэлжлүүлэн бичнэ.
- ✓ Бусдын санаа бодлыг хүндэтгэн хүлээн авч үргэлжлүүлэх
- ✓ Цэвэр гаргацтай бичих
- ✓ Асуух тодруулах зүйл гарвал гараа өргөнө.

Бүх сурагч өөрийн материалаа авч хянаж, зассаны дараа хананд байрлуулах, бүтээлийн үзэсгэлэн гаргах зэргээр сольж унших боломж гаргана.

4.2е. Өгсөн бүтцийн дагуу утгын уялдаа холбоотой бахархсан утгатай захидал бичих	1. Бахархсан утгатай захидал уншин, бүтцийг ажиглах 2. Бахархаж байгаагаа илэрхийлж ямар үг сонгож бичсэнийг ажиглан, тэмдэглэх 3. Эхлэл хэсэгт ямар үг хэрэглэн мэндчилж болохоо төлөвлөх 4. Гол хэсэгт хэн? хэзээ? ямар зорилгоор? хэнд хандаж, ямар өнгө аясаар (бахархсан, талархсан, уншсан зүйлээсээ мэдэрсэн, сэтгэл нь хөдөлснөө гэх мэт) бичихээ төлөвлөх, эсвэл оршин байгаа газрын цаг улирлын байдал, өөрийн тухай сонин сайхан, өгүүлэх гэж буй гол зүйлээ бодож төлөвлөх, гол хэсэгт хэдэн цогцолбороор бичихээ төлөвлөх 5. Төгсгөл хэсгээ төлөвлөх (баяр талархал, ерөөлийн үг, огноо, хэнээс) 6. Төлөвлөсний дагуу ноороглон бичих 7. Нооргоо засах Найруулгын засвар хийх Зөв бичгийн дүрмийн засвар хийх 8. Дахин сайжруулж бичих, хичээнгүй бичих 9. Бусдад уншин өгч, зөвлөгөө авах Бүтээлч үйл ажиллагаа: - Багшийн өгсөн өгөгдөл, нөхцөлийн дагуу бичнэ. Жишээ нь: Танай хөрш чинь хөгжмөө маш чанга тоглоод л байдаг. Танай аав чинь, маш их шуугиантай үнэхээр төвөгтэй байна гэлээ. Чи хөршдөө энэ их чанга дуу чимээгээ багасгах хүсэлт тавилаа гэж бодъё.	- Талархаж, бахархаж, мэдэрч, цаг улирал, сонин сайхнаа өгүүлсэн захидлын жишээнүүд - Захидал бичихид шаардагдах үгийн нөөц
--	--	--

	Тэгвэл чи захиагаа хэрхэн эхэлж, хэрхэн өрнүүлж, хэрхэн төгсгөх вэ? ... гэх мэт - Өгсөн эхлэл, гол, төгсгөл хэсгийн аль нэгийг гүйцээн бичих - Бичсэн захианаас зорилгыг тодорхойлж бичих - Зорилгод тохируулан үгээ хэрхэн сонгосон талаар санал дүгнэлт бичих	
Багшийн анхаарах зүйл: 3 дугаар ангид эхлэл, гол, төгсгөл хэсэг бүхий талархсан утгатай захидал бичиж сурсан гэж үзнэ. Харин 4 дүгээр ангид гол хэсгээ цогцолбороор зааглан санааг илэрхийлж, захидал бичүүлэхэд анхаарна. 5 дугаар ангид цогцолбороор бичихдээ бусдын санал бодлыг дэмжсэн болон эсэргүүцсэн утгатай захидал бичнэ. Цогцолбороор зааглан бичүүлэхийн тулд уншсан зохиол, захидалд цогцолбороор яагаад утгаар нь заагласныг ажиглуулан уншуулах үйлтэй холбох хэрэгтэй. “Бичихийн тулд унших” гэсэн гол зарчим монгол хэлний хичээлийн нэгжийн төлөвлөлтөд хамаатай ойлголт юм. Сурагч уншихдаа “цогцолбор бүрд нэг утга санааг гаргадаг юм байна, түүнийгээ догол мөрөөр заагладаг юм байна” гэсэн ойлголттой болсны дараа бичихдээ санаагаа цогцолбороор илэрхийлэн бичих учиртай. Иймд багш унших, бичих үйлийг холбож, чиглүүлээ зөв өгөх хэрэгтэй.		
4.2ж. Бусдыг сайн сайхан зүйлд уриалж бүтцийн дагуу уриалга бичих	Мэдлэг бүтээхийн тулд 1. Олон янзын үйл ажиллагааны уриалга унших 2. Юунд хэрхэн уриалсныг бодож унших 3. Эргэн тойронд болж байгаа сөрөг үйл ажиллагааны тухай ярилцах 4. Тэрхүү үйл ажиллагаанаас сайн сайхан зүйлд яаж уриалахыг эргэцүүлэн ярилцах 5. Уриалахдаа ямар үг сонгож хэрэглэхээ төлөвлөх 6. Төлөвлөсний дагуу ноороглон бичих 7. Нооргоо засах Найруулгын засвар хийх Зөв бичгийн дүрмийн засвар хийх 8. Дахин сайжруулж бичих, хичээнгүй бичих 9. Бусдад уншигн зөвлөгөө авах Дэмжих үйл ажиллагаа: - Ямар ч нөхцөлд бичиж сурахын тулд багшийн өгсөн сэдвийн дагуу бичих - Загварт тохируулан нөхөж бичих Бодитоор урилга, уриалга, талархал бичиж, хийх /төрсөн өдрийн, эрдмийн баярын ... гэх мэт /	- Уриалгын загварууд - Уриалга бичсэн эхүүд
Багшийн анхаарах зүйл. Хэрэглээний бичвэрүүдийг бичүүлж сургахын тулд загвар жишээнүүдийг уншуулж ажиглуулахаас эхлээд бичих загварыг өгч нөхүүлж бичүүлэх замаар үйлийн баримжаа эзэмшүүлнэ. Тэгэхдээ өөрсдийнх нь мэддэг зүйлээс эхэлж хийлгүүлээд дараа нь багшийн өгсөн нөхцөлийн дагуу бичих зэргээр ойлголтыг гүнзгийрүүлж, өөрсдөөр нь зуруулж, загварыг гаргуулж, хайчлуулах зэргээр бэлтгүүлж чадварыг өөрийн болгон хөгжүүлнэ. Багш энэ хэсэгт дээрх янз бүрийн нөхцөл өгч бодуулж, төсөөлүүлж, сэтгүүлж бичүүлэхэд анхаарна. Учир нь хүүхэд янз бүрийн үйл ажиллагаанд оролцсон туршлага багатай байдаг. Ийм үед нь багш өөрөө мэдээд урилга хийгээрэй, өөрөө шийдээд хэрхэн талархсанаа бичээрэй гэвэл тэд ихэвчлэн төрсөн өдөр, хурим найрнаас өөр тохиолдолд урилга бичиж бараг мэдэхгүй. Тиймээс ирээдүйд тулгарч болох янз бүрийн үйл ажиллагааг нөхцөл болговол хүүхдийн зорилго чиглэлтэй бичиж сурах үйлд хөтлөх алхам болно.		
4.2з. Өгсөн асуултын хүрээнд үйл явдлын товч мэдээ бичих	Мэдээг хэрхэн бичдэг болохыг мэдэхийн тулд 1. Сонины мэдээ унших, телевизийн мэдээ үзэх 2. Уншсан, үзсэн мэдээгээ хэн, хаана, хэзээ, юуг, яагаад хэрхэн? гэсэн асуултад хариулж хурааж бичих 3. Өөрсдөө сэдэв сонгон мэдээ бичих \багш сэдвийн жагсаалтыг өгсөн байна\	- Хүүхдийн уншдаг сонины дугаарууд

	4. 6 асуултын дагуу бичиж чадаж уу? гэдгээ хянах, дутуу байвал сайжруулж бичих 5. Нооргоо засах Найруулгын засвар хийх Зөв бичгийн дүрмийн засвар хийх 6. Дахин сайжруулж бичих, хичээнгүй бичих 7. Бусдад уншин өгч, зөвлөгөө авах Мэдээг сайн бичиж сурахын тулд дараах үйл ажиллагаанаас сонгон хийх - Бинго тоглох - Карт тоглуулах /эвлүүлэх/ - Асуултын самбарт бичих - Мэдээллийг зөв бүтэцтэй болгох - Асуух үгийн оронд үг нөхөх замаар мэдээг бичих - Мэдээнд гарчиг өгөх Мэдээг гарчигтай тохируулах	- Сонины мэдээ бичсэн хувилбарууд						
Багшийн анхаарах зүйл: Мэдээ бичихэд хамгийн гол нь асуултын дагуу бичүүлж сургахад анхаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл Хэн? Юу? Хэрхэн, Яаж? Хаана? Хэзээ? Яагаад, Ямар учраас? гэсэн асуултын дагуу мэдээ мэдээллийг бэлтгээгүйгээс мэдээ тодорхой бус болдог. Тиймээс мэдээг бичүүлж сургахдаа эхлээд уншсан, сонссон, үзсэн мэдээллээ дээрх асуултын дагуу ангилуулах, бичсэн мэдээгээ дээрх 6 асуултад хариулагдаж байна уу гэдгээр шалгуур болгон тодорхой бичүүлж болно. Мөн тоглоомын аргаар мэдээг 6 асуултын дагуу ялган ойлгож чадаж байгаа эсэхийг харахын тулд бинго тоглоом тоглуулж болно. Гэхдээ доор арай хялбар болгож хувирган бичлээ. * Бингог тоглуулахдаа эхлээд дараах хүснэгтийг сурагч бүрт тараасан байна. <table border="1" data-bbox="213 1064 1376 1261"> <tr> <td>1. Хэн ?</td><td>2. Юу? </td><td>3. Хэзээ?</td></tr> <tr> <td>4. Хаана?</td><td>5. Ямар учраас</td><td>6. Яа..(в, сан ..)?</td></tr> </table> ➤ Багшийг мэдээ унших үед сурагчид мэдээллээс асуултад тохирох утгаар нь хүснэгтэд нөхөж бичнэ. ➤ Бүх сурагчийг бичиж дууссаны дараа багш мэдээллийг зөв хийсэн эсэхийг эргэж мэдээлнэ. Өөрөөр хэлбэл зөв хариултыг хэлнэ. Сурагч бүр өөрийнхөө хийснийг тулгаж шалгана. Бүгдийг зөв хийсэн сурагч “Бинго” гэж хэлээд босно. ➤ Багш зөв хийсэн сурагчид урамшууллын оноо өгөх, инээмсэглэсэн дүрс (смайл) наах, зэрэг янз бүрийн арга хэрэглээрэй. Эс тэгвээс сурагчдын идэвх нь суларна гэдгийг анхаараарай. Мэдээг ингэж асуултын дагуу ялгуулах нь дараагийн үгийн аймгийн хичээлийг заах суурь болох, нөгөө талаар мэдээг үгийн аймгийн хичээлтэй холбон интеграцичилж зааж болно.			1. Хэн ?	2. Юу?	3. Хэзээ?	4. Хаана?	5. Ямар учраас	6. Яа..(в, сан ..)?
1. Хэн ?	2. Юу?	3. Хэзээ?						
4. Хаана?	5. Ямар учраас	6. Яа..(в, сан ..)?						
4.2и. Хүндэтгэлийн үг хэрэглэн, бүтцийн дагуу урилга бичих	Мэдлэг бүтээхийн тулд 1. Олон янзын үйл ажиллагааны урилга унших 2. Бүтэц, үг сонголтыг ажиглаж, юунд урьсныг ярилцах 3. Урилган дээр юу юу бичсэнийг ажиглах Жишээ нь: Нэр, ямар үйл явдалд зориулсан байна?, Хаана болох юм байна?, Хэзээ болох? зэрэг нийтлэг бүтцийг харж мэдэхээс гадна магадгүй ямар хувцастай ирэх, тусгай ямар зочид ирэх зэрэг өвөрмөц зүйлийг тэмдэглэсэн байж магадгүй. Энэ бүгдийг ажиглаж, учрыг олох, загварын дагуу бичих 4. Төлөвлөсний дагуу ноороглон бичих 5. Нооргоо засах Найруулгын засвар хийх Зөв бичгийн дүрмийн засвар хийх	- Урилгын загварууд - Урилга бичсэн эхүүд						

	6. Дахин сайжруулж бичих, хичээнгүй бичих 7. Бусдад уншин өгч, зөвлөгөө авах Дэмжих үйл ажиллагаа: - Ямар ч нөхцөлд бичиж сурахын тулд багшийн өгсөн сэдвийн дагуу бичих - Загварт тохируулан нөхөж бичих	
Багшийн анхаарах зүйл: Урилгаа бичүүлэхдээ тодорхой нөхцөл өгч, хэрэглэх үгийн нөөцийг хэрэглүүлэхийг зорино. Тусгаарлах үүрэгтэй “-я”, “-е”, “-ё”-г зөв бичүүлэхэд анхаарна. - Чиний дүү чинь “Гэгээн алсын одод” тэмцээнд түрүүлжээ. Энэ баяраа гэр бүлээрээ ярилцаад ах дүү хамаатан садангийнхаа хүрээнд тэмдэглэхээр болов. Тэгээд гэр бүлээрээ ярилцаад чамайг дүүгийнхээ амжилтыг тэмдэглэх баярын урилга хий гэлээ. Чи тэгвэл урилгаа хэрхэн бичиж, хийх вэ? - Ирсэн ах дүү, хамаатан садан төрөл төрөгсөд, найз нөхдөдөө баярласан талархсанаа хэрхэн илэрхийлэх вэ? Бичээрэй. гэх мэтээр хийх чиглэлийг нь тодорхой болговол зорилготой, нөхцөл байдалд тохируулан үг хэлээ сонгон бичиж сурахад дөхөм болно.		
4.2к. Бүтцийн дагуу үлгэр зохиохдоо баатрын гадаад дүр байдлыг дүрслэн бичих	1. Үлгэр сонсоод, утгыг ярилцах 2. Сонссон үлгэрийнхээ баатруудын гадаад дүр байдлыг дүрслэн бичих Гадаад дүр байдлыг бичихийн тулд: - Хөрөг дүр бүхий эх унших - Эсвэл зураг харж ажиглах . Ингэхдээ: - Бусдаас ямар онцлогтой байна? - Гадаад дүр төрх нь ямар байна ? - Хувцас хэрэглэл нь ямар байна? - Ямар хөдөлгөөн хийж байна? - Ямар орчинд амьдарч байна? - Ямар зан араншинтай байна? - Хэнтэй юутай адилхан байна? - Өгүүлэгч уг байдлыг хэрхэн мэдэрсэн байна? гэдгийг анхаарч тэмдэглэх, загварчлах \Оюуны зураглал хийх\ 3. Зурагласнаа ноороглох 4. Нооргоо засах, зөв бичгийн дүрмийн алдааг, найруулгаа засах 5. Дахин засаж хичээнгүй бичих 6. Хэн нэгэнд уншин, зөвлөгөө авах Мэдлэг ойлголтоо бататгахын тулд - Уншсан зүйлээсээ гадаад дүр байдлыг ялган бичих - Зураг хараад гадаад байдлыг дүрслэн бичих - Бусдынхаа хөргийг дүрслэн бичих. Дүрслэн бичсэнээ уншиж, хэн болохыг таах - Карт эвлүүлэн тоглох / хүний зураг, түүнийг хөрөглөж бичсэн картууд/ - Ямар нэг танихгүй хүний тухай бусдын ярьснаас ямар хүн болохыг төсөөлөн, дүрсэлж бичих Бүтээлч үйл ажиллагаа: - Хөрөг дүрийг бичиж сурч байгаагаа харуулахын тулд Хамгийн хайртай дотно хүмүүсийнхээ талаар гадаад дүр байдлыг дүрслэн бичих	- Сонсох үлгэр - Баатрын гадаад дүр байдлыг дүрсэлсэн үлгэрүүд
Багшийн анхаарах зүйл: Баатрын гадаад дүр байдлыг бичихээс өмнө сурагчдаар бичих хүнийг сонгуулах ➤ Шууд бичихэд хэцүү учир эхлээд гадаад дүр байдлыг дүрсэлсэн эх зохиол уншуулж өмнөх мэдлэгийг сэргээн сануулна. Тэгээд ямар онцлогтой байгааг ажиглуулна. Дараа нь гадаад, дотоод шинжийг ялгуулан бичүүлнэ. Эсвэл хөрөг дүрийг уншаад дүрслэлийн дагуу зураг зуруулж болно.		

- Мөн хөрөг зураг харуулж бичүүлж болно. Энэ үед сурагчид анги нийтээр ижил зүйлийг хийх тул дууссан сурагчдыг уншуулах явцад сурагчид биенээсээ суралцах, санаа авах, хэнийх нь сайн болсныг дүгнэх зэргээр сурах арга барил олж авахад тустай. Гэхдээ зургийг өнгөтөөр харуулбал сурагчид дүрслэн бичихэд тус дөхөм болно. Учир нь царайны төрх байдал нарийн сайн ажиглагдана. Сурагчдад сонин сэтгэгдэл, санаа төрүүлнэ.



Энэ суралцахуйн зорилт нь сурагчдын сэтгэлгээг хөгжүүлэх, ажиглах, нэгтгэн дүгнэх, дүрслэн бичих, сонсоод ойлгох, тогтоох чадваруудыг хөгжүүлдэг онцлогтой. Энэ аргаар бичихэд:

- Багш самбарт хэд хэдэн хүний зургийг байрлуулсан байна.
- Сурагчид зургуудыг анхааралтай ажиглаад сонголтоо хийж, түүнийгээ нууцална. Өөрөөр хэлбэл аль зургийг сонгосноо нууна гэсэн үг.
- Сонгосон хүнийхээ тухай бичнэ. Тэгэхдээ тухайн хүний гадаад шинжийг дүрслэн бичнэ.
- Бичиж дуусгаад өөрийнхөө бичсэнээ уншина. Бусад нь анхааралтай сонсоод хэн болохыг таана.
- Хэрэв харуулах зураг байхгүй бол сурагчдыг хоёр хэсэгт хуваан өөд өөдөөс нь харуулан суулгана. Тэгээд эсрэг багийн хэн нэгнээс сонгож бичүүлж болно. Гэхдээ бусдыг үл хүндэтгэсэн ямар нэг байдал гаргаж болохгүйг анхааруулна.
- Бичиж дууссаныхаа дараа баг бүрийн гишүүд ээлж ээлжээр уншиж, эсрэг талын хүүхдүүд таана. Аль баг хамгийн олон хүнийг тааснаар нь шалгаруулалтыг хийж болно.

Багш бидний алдаа бол ямар нэгэн сэдэл, санаа өгөхгүйгээр шууд л “За бич, төлөвлө” гэх мэтээр өгдөг нь зарим нэг сул талыг дагуулдаг. Тухайлбал:

- Шууд ингэж өгөхөөр хүүхэд мэддэг зүйлээ бичдэг тул сэтгэх шаардлага гарахгүй.
- Магадгүй нэг зүйлийг хэд хэдэн хичээл дээр бичиж, улмаар залхуутай, сонирхолгүй санагдаж болох
- Багшийн өөрийн үнэлэмж буурах. Өөрөөр хэлбэл нэг л юмаа хийлгүүлээд байдаг гэх өрөөсгөл ойлголт байдаг.
- Мэдэхгүй болон тохиолдож болох зүйлтэй тулгаруулахгүй байгаа учраас асуудлыг шийдвэрлэхэд идэвхгүй байх магадлалтай.
- Танин мэдэхүйн хувьд ч хэрэгцээтэй зүйлээ олж авч чадахгүй байх

Өөрөөр хэлбэл зөвхөн төлөвлөж сурах нь чухал уу? Эсвэл бичихийн хамт сэтгэлгээ нь хөгжих, амьдрах арга ухаанд суралцах, юмыг янз бүрийн аргаар танин мэдэх нь чухал уу? гэдгийг багш давхар бодолцож, хүүхдийг сургахад анхаарна.

4.2л. Шүлгийн хэлбэрийг дуурайж зохион бичих	1. Дуурайн бичих аман зохиолын төрлүүдээс сонгох 2. Дуурайн бичих хэлбэрээ сонгох 3. Үг бүрийг /үгийн аймаг үзээгүй бол багшийн зааврын дагуу ялгах/, асуултын дагуу ялгах 4. Асуултын дагуу зохиож турших 5. Сонгосон сэдвийнхээ дагуу үгээ зөв сонгон бичих, ноороглох 6. Бичсэнээ сайжруулахын тулд хянах шалгах. Тэгэхдээ доорх шалгуурыг үндэс болгоно. - Асуултын дагуу бичиж чадаж уу? - Сэдэв нь өөр байж чадаж байна уу? - Хэлбэр нь төстэй болж чадсан байна уу? - Найруулгын ямар нэгэн алдаа байна уу? - Зөв бичих дүрмийн алдаа байна уу? 7. Дахин сийрүүлж бичих	- 8 мөрөөс хэтрэхгүй, мөр бүр дэх үгийн тоо 3-4 байхаар зохиосон шүлэг
---	---	--

	8. Бусдаас суралцахын тулд бусдын зохиосон зохиолтой танилцах - Бичсэнээ сольж унших - Зарим сурагч өөрсдийн хүсэлтээр өмнө гарч унших - Бүтээлийн үзэсгэлэн гаргах зэрэг	
--	---	--

Багшийн анхаарах зүйл:

Дуурайн бичүүлж сургахын тулд эхлээд аман зохиолын богино хэлбэрийг дуурайсан болон шүлэг, богино өгүүллэгийг харьцуулан уншуулна. Эндээс сурагчдаар ажиглуулах, ялгааг тайлбарлуулна. Жишээ нь:

Эх зохиол: Жигмэд Тогмид хоёр	Дуурайн зохиосон нь: Очироо Дариа хоёр
Жигмэд Тогмид хоёр Жимсэнд хамт явжээ. Уулын модонд очоод Уралдаж түүхээр болжээ. Том савтай Тогмид нь Сүүлдэнэ гэж сүрджээ. Жигжиг савтай Жигмэд нь түрүүлнэ гэж барджээ. Түүсээр байгаад Тогмидын Сав нь дүүрээд иржээ. Идсээр байгаад Жигмэдийн Гэдэс нь цадаад иржээ.	Очироо Дариа хоёр Олимпиадад орохоор болжээ. Орох газраа очихоороо Уралдаж бодохоор шийджээ. Онцгой ухаантай Очироо нь Оройд нь гарна гэж боджээ. Даамай сэргэлэн Дариа нь Давтлага авахаа мэджээ. Сандарснаасаа болоод Очироо Санамсаргүй хожигджээ. Арай сэргэлэн Дариа нь Алдар хүндтэй болжээ.

Венийн диаграммын аргаар ижил ба ялгаатай талыг бас гаргуулж ч болно. Гэхдээ энд өгүүллэг, үлгэр зохиох талаас нь хүснэгтээр ялгуулсныг харуулав.

Ижил тал Зохиолуудын хэлбэр нь ижил	Ялгаатай тал Дүрүүд нь өөр өөр.
.....	
.....	

Ингэж ажиглуулсны дараа багш дуурайн бичих шүлэг, өгүүллэг, аман зохиолын богино хэлбэрийн зохиолыг өгнө.

Богино үлгэрийг дуурайн бичүүлэхдээ хуулан бичүүлнэ. Тэгэхдээ нэг мөрийг алгасаж бичүүлнэ. Тэгээд дуурайн бичүүлэхдээ өөр өнгийн балаар хоосон орхисон мөрөнд дээрх мөрний үг бүрийн доор харгалзах байдлаар бичүүлж болдог. Ингэж бичүүлэх нь эх зохиол, дуурайн зохиосон хоёроо харьцуулан ямар ялгаатай болсныг харж, өөртөө болон бусдад үнэлгээ дүгнэлт өгөхөд амар байдаг.

Шүлэг, аман зохиолын богино хэлбэрийг дуурайхдаа дээрх байдлаар зэрэгцүүлэн бичүүлнэ.

Тэгэхдээ шүлгийн толгой сүүл холболтыг ажиглаж, мөрөн дэх үгийн тоо зэргийг алдагдуулахгүйгээр дуурайн бичвэл бие даан шүлэг зохиох чадварт суралцахад дөхөм болно.

4.2м. Уншсан номыг танилцуулж бичихдээ сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэх	1. Хэрхэн бичдэгийг мэдэхийн тулд - Зорилгыг ойлгохын тулд танилцуулгуудыг уншиж ажиглалт хийх - Танилцуулга хийх ямар арга нь ойлгомжтой санагдав? 2. Танилцуулга бичиж сурахын тулд бичих зорилгоо тодорхойлох. Хэнд хаана /уншигч/ зориулж, ямар учраас /шалтгаан зорилго/ /хэрхэн/ /өнгө аяс, үг сонголт/ танилцуулахаа төлөвлөх. - Бичих бүтцээ төлөвлөнө. - Танилцуулгаа өөрсдөө зохиомжилж бичих - Бичих дарааллыг өгсний дагуу танилцуулга бичих Мэдлэг ойлголтоо гүнзгийрүүлэхийн тулд дараах үйл ажиллагаанаас сонгож хийх - Зурагт самбар хийх - Схем диаграм хийх - Зураглал хийх	- Номын танилцуулгын загварууд
--	--	--------------------------------

	- Хүснэгт бөглөх - Хэсгүүдийг гүйцээн бичих - Оюуны зураглал хийх - Номоо хураангуйлж комик ном хийх 3. Сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэхийн тулд: 1. Уншсан, сонссон, харсан зүйлээсээ сэтгэл хөдөлгөсөн үг, өгүүлбэр, хэсэг, үйл явдлыг сонгох 2. Яагаад сонгосон шалтгаанаа тайлбарлах Мэдрэмжээ илэрхийлж бичихдээ: - Зохиолоос ямар нэг дуу чимээ сонсогдсон. Яагаад гэвэл ингэж бичсэн учраас тийм чимээ сонсогдох шиг болсон. - Баатруудын хоорондох ярианаас их чанга дуугарах шиг болсон. Яагаад гэвэл өвгөний дүр барын бамбарт уурласан учраас - Зохиолд шар тос зам дээр хэвтсэн гэж бичсэн учраас шар мөртлөө нялцайж урссан юм харагдсан. Би тийм л юм мэдэрсэн гэх мэтээр ярьсны дараа бичих Сэтгэгдлээ илэрхийлж бичихдээ: - Зохиолын баатрын хэлсэн үгээс бахархах сэтгэл төрсөн - Зохиолын тэр хэсгийг, тийм үйл явдлыг уншаад их гайхаж байлаа гэх мэтээр бичих 4.Ярьсны дараа ноороглон бичих 5.Нооргоо засах Найруулгын засвар хийх Зөв бичгийн дүрмийн засвар хийх 6.Дахин сайжруулж бичих, хичээнгүй бичих 7.Бусдад уншин өгч, зөвлөгөө авах	
--	---	--

Багшийн анхаарах зүйл:

Мэдрэмжээ илэрхийлэх, сэтгэгдлээ илэрхийлнэ гэдэг нь хоёр өөр чадвар юм. Мэдрэмж нь харах, сонсох, үнэрлэх, амтлах, хүртэх 5 мэдрэхүйгээр дамжин илрэх онцгой чадвар. Юу мэдрэв? гэсэн асуулт чухал. Сэтгэгдэл гэдэг нь ямар нэг мэдээлэл, харилцаанд хариу үйлдэл илэрхийлэх сэтгэлийн олон өнгө аясыг хэлнэ. Ямар санагдаж байна вэ? Тэр хэсгийг уншихад гунигтай байсан уу? Тэр дүрийг өрөвдсөн үү? гэх мэтээр сэтгэлийн олон өнгө аясаар санааг илэрхийлж сургахад анхаарна. Мэдрэмжийг илэрхийлж яриулахдаа “Ямар үгээс чи юу мэдрэв? Яаж бичсэн болоод тийм дуу сонсогдсон бол?” гэх мэтээр үгийн хэрэглээн дээр тулгуурлан мэдрэмжийг нь хөгжүүлээрэй. Мэдэрснийг нь ярилцахын тулд дараах асуултыг хэрэглэж болно.

- Уншиж, үзэж, харж, сонсож байхад оюун ухаанд чинь ямар дүр зураг буув?
- Уншиж, үзэж, харж, сонсож байхдаа цааш юу болох бол гэж таамаглав?
- Тухайн үйл явдлын талаар өөрсдөд ямар санаа бодол төрөв?
- Уншиж, сонсож, харж байхад санаанд чинь өөр ямар нэг үйл явдал тохиолдсон зүйл, болсон явдал, сонссон дуулсан юм санаанд чинь оров уу?
- Ямар мэдрэмж төрөв? / ... юм шиг, ...юмтай адилхан, ... юм болж байсан шиг гэх мэт /

Үгийг сэдэв буюу зорилгодоо нийцүүлэн зөв сонгоно гэдэг ялангуяа бага ангийн сурагчдын хувьд амаргүй. Зарим эцэг эхчүүд монгол хэлээр ярьж л байвал судлах шаардлагагүй гэж үзээд гадаад хэлэнд анхаардаг тал бий. Тиймээс зарим сурагч “орчуулгын” монгол хэлээр ярьдаг. Ялангуяа үгийн сонголтыг нь ажиглахад хот хөдөөгийн ахуй хэвшлийн ялгаа заагаас болоод үг хэлний сонголт өөр өөр байгаа нь ажиглагддаг. Ийм нөхцөлд багш та л монгол хэлээр зөв ярьж бичиж сургахад маш их анхаарна.

Үгийг зөв сонгон хэрэглэж сурахад хүүхдээс үгийн баялаг сантай байхыг шаардана. Үгээ буруу сонгон хэрэглэж байгаа тохиолдолд заавал засаж залруулах, ойлгуулж тайлбарлах хэрэгтэйгээс гадна ойролцоо үгийн эгнээнээс тохиромжтой үгийг тохиромжтой газар нь хэрэглэхэд анхаарах зэргээр боломжийг хайх хэрэгтэй. Жишээ нь: Сайхан гэсэн санааг гаргахын тулд доорх үгсийг ямар тохиолдолд \хүн, юм, үзэгдэл\ хэрэглэх вэ? гэдгийг анхаарна. Сэтгэл татам, хайр булаам, үзэсгэлэнтэй, царайлаг, нүдэнд дулаахан, ялдам, хараа булаам, гуа сайхан, зүс сайтай, өнгө төгөөлдөр, хөөрхөн, нүд булаам, үзэмжтэй, гайхамшигтай, нүд дүүрэн ... гэх мэт.

Мөн утгын ямар ялгаа байгааг анхаарч хэрэглэх хэрэгтэй. Үгийг зөв сонгоход сургах нь хүүхдийг юманд ул суурьтай хандахад сургадаг тул дараах зүйлд анхаарлаа хандуулаарай.

- Үгийг онож сонгох үед хүүхдээс маш их тэвчээр шаардана. Учир нь тэд үгийг хайх, утгаар нь зэрэглэх, сонгох зэрэг оюуны олон үйл хийх учраас тэр.
- Толь бичигтэй сайн ажиллуулах
- Тухайн үг өөр нөхцөлд ямар утга илэрхийлж байгааг шүүн тунгаах
- Өдөр тутмын хэлний үг, хэлний уран дүрслэл хоёр өөр гэдгийг ойлгуулах. Өөрөөр хэлбэл үндсэн утга шилжсэн утга хоёр өөр гэдгийг таниулах
- Бичих зүйлээ хэнд зориулж байгааг сайн бодуулах
- Ямар өнгө аясаар бичих вэ гэдгээ тооцоолохыг байнга сануулаарай.

ГУРАВ. СОНСОХ- ЯРИХ ЧАДВАР

Нэгж хичээл бүрд эхийг уншаад ярих дасгалуудтай уялдуулан ойлгомжтой ярих, цэгцтэй ярих, өөртөө итгэлтэй ярих, өгүүлбэрийн зөв бүтэцтэй ярих шаардлагыг багш тавина.

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
4.3а. Сэдвийн хүрээнд яриагаа төлөвлөж, бэлтгэн, ойлгомжтой, цэгцтэй илэрхийлэн ярих	- Өөрийгөө танилцуулсан хоёр өөр эхийг харьцуулах - Яаж танилцуулж ярьж байгааг судлах <u>Судлахдаа:</u> - Юуг, яаж танилцуулж байгааг судлан унших - Хэн нь тодорхой, ойлгомжтой танилцуулж байгааг ажиглах - Хэн нь өөрийгөө хэн бэ гэдгийг тодруулж чадсан эсэхийг нягтлах - Өөрийн танилцуулах зүйлээ, сэдвээ сонгох - Жишээ нь, хүсэл мөрөөдөл -Яаж танилцуулж ярихаа төлөвлөх <u>Төлөвлөхдөө:</u> - Танилцуулах яриагаа бэлтгэх, үгээ сонгох - Өөрийнхөө сонирхдог зүйлийг илэрхийлэх, өөрийгөө бусдад сонирхолтой танилцуулах - Төлөвлөсний дагуу ойлгомжтой, цэгцтэй ярихад бэлтгэх - Хэрхэн төлөвлөж, танилцуулснаа үнэлэх	- Хүүхдийн зохиосон өөрийн танилцуулга - Хүсэл мөрөөдлөө танилцуулсан хүүхдийн зохиосон эх

Багшийн анхаарах зүйл:

Зөв ярьж сурахын тулд яриагаа төлөвлөж, бэлтгэсний дараа өөрийгөө бусдад ойлгомжтой илэрхийлэх дасгалыг тогтмол хийх шаардлагатай. Тус ангийн эхний бүлгээс эхлээд ярих чадварыг эзэмшүүлэхээр төлөвлөсөн бөгөөд бүлгээс бүлэг рүү ахих тусам ярих чадварын ахиц дэвшлийг сайжруулахыг багш анхаарна. Эхний бүлэгт суралцахуйн зорилт болж байгаа “Яриагаа төлөвлөх, бэлтгэх, илэрхийлэх” чадварыг хүүхэд бүр эзэмшиж байна уу гэдэгт хяналт тавиад, хэрвээ тухайн чадварыг эзэмшээгүй хүүхэд байвал дараагийн бүлэгтээ давтахыг санал болгож байна. Хүүхэд бүр хэрхэн зөв ярьж байгааг үнэлэхийн тулд ангийн хүүхдүүдтэй хамтран бие биеэ үнэлэх, өөрийгөө үнэлэх зэрэг хэлбэрээр зохион байгуулна. Ингэхдээ суралцахуйн зорилт бүрийг тодорхой шалгуур болгон төлөвлөөд, түүнд хүрэхийн тулд хүүхэд бүр яаж зөв ярихаа урьдчилан тооцож бэлдэж сурахыг зөвлөнө. Тухайлбал:

Би өөртөө итгэлтэй ярихын тулд юу хийх вэ?

1. Бусдад ойлгомжтой ярих шаардлагыг өөртөө тавина.
2. Харин ойлгомжтой ярихын тулд ярих зүйлээ цэгцэлнэ.
3. Цэгцлэхийн тулд эхлэл, гол, төгсгөл хэсгээр яриагаа бэлтгэнэ.
4. Дахин дахин өөртөө ярьж дадна.
5. Ямар үг хэрэглэвэл илүү оновчтой байх вэ гэдгээ тооцож бэлтгэнэ.
6. Өгүүлбэрийн бүтцээ зөв сонгох, ярихаасаа өмнө ноороглож бичих гэх мэтээр суралцах аргаа төлөвлөхийг багш удирдан чиглүүлнэ.

4.36. Хэлэлцүүлэгт шинэ санаа нэмж оролцох, бусдын яриаг дуустал хүлээцтэй сонсох	1. Юуг хэлэлцэхээ тодорхойлох Уншсан зохиолоос ургуулан шинэ баатар, шинэ орчин, шинэ үйл явдал нэмж хэлэлцэх 2. Хэлэлцэхийн тулд юу хийхээ төлөвлөх, тухайлбал, - Уншсан эхийн үйл явдал, гол санааг дахин эргэцүүлэх - Ямар зорилгоор шинэ баатар, шинэ орчныг нэмэх болсноо бодох, бусдад илэрхийлэх 3. Хэлэлцүүлгийг өрнүүлэх. - Шинэ баатар, шинэ орчин нэмснээр зохиолд ямар шинэ санаа илэрч байгааг тайлбарлан ярих - Бусдын зохиосон шинэ санаа бүхий баатар, орчин нь зохиолыг сонирхолтой болгож байгаа эсэхэд хэлэлцүүлэг хийх - Шинэ баатар, шинэ орчин нь уншигчийн сонирхолд нийцэж байгаа эсэхийг эргэцүүлэх Жишээ нь: Шинэ баатрыг яаж бичвэл үнэмшилтэй болох вэ? - Шинэ баатар шинэ орчин нь бусад баатартай хэр холбогдож байгааг нягтлах 4. Хэлэлцүүлгийг дүгнэх - Ямар зорилгоор яаж зохиосноо тайлбарлан хэлэлцэх, баатрын зан төрх, үзэл бодол, үйл хөдлөлийн учир шалтгааныг хэлэлцэх 5. Хэлэлцүүлгийг үргэлжлүүлэхдээ бусдын яриаг хүндэтгэж, дуустал сонсох 6. Бусдыг ярьж дууссаны дараа саналаа хэлэх 7. Хүлээцтэй сонссоноо урамшуулж үнэлэх	- Монголын болон дэлхийн аман зохиол, бичгийн зохиолоос
--	--	---

Багшийн анхаарах зүйл:

Хүлээцтэй сонсож сураагүй хүүхдийн сонирхлыг судлан ажиллаж болно. Юуг сонсох дуртай болохыг судалсны үндсэн дээр тэдэнд хүлээцтэй байхыг хүсэж болно.

Багш хичээл бүрийн төлөвлөлтөд хүлээцтэй сонсож байгаа эсэхийг тодруулах шалгуур гарган ажиллахыг санал болгоё.

- Хүлээцтэй, тогтож сонсох чадвар нь хүүхэд бүрд хэрхэн илэрч байгааг багш тэмдэглэж, сурагчидтайгаа давуу болон сайжруулах талаас нь ойлголцож ярилцах арга зүйг тогтмол болгох
- Юуг сайжруулах вэ гэсэн асуудалд багш хүүхэд харсан сонссоноо баримтаар баталж чадаж байна уу, хүлээцтэй сонсож чадаж байна уу гэсэн шалгуурыг гол болгоод, яаж сайжруулах вэ гэсэн асуудалд багш хандахдаа эцсийн зорилгодоо хүрэх тэрхүү чадварыг эзэмшихийн тулд юу хийх ёстойг сурагчидтай харилцан ярилцах
- Цахим ертөнцийн орчинд ажиллах хүсэл сонирхлыг хичээл дээр эзэмших чадвартай холбон, юуг сонирхож үзсэнийг лавлан, үзэл бодлыг нээлттэй яриулан, цаашлаад баримтжуулах даалгавар өгч болно.

Сурагчдад хамтран ажиллах арга барил эзэмшүүлэхийн тулд бусдын яриаг сонсож сурах, сонссоноо дүгнэх, дүгнэхдээ бусдын үзэл бодлыг олон талаас нь бодож сурах, өөрийнхөө санаа бодлоо илэрхийлэхдээ жишээгээр батлан ярих, аливаа асуудлыг хэлэлцэхдээ шинэ санаа нэмж, хэлэлцүүлгийг өрнүүлж, санаа бодлоо солилцох нөхцөлийг бүрдүүлнэ.

Ярих сонсох чадварыг хөгжүүлэхдээ сурагчдад ямар бэрхшээл тулгарч байгааг асууж, багш сурагчдын хамт “Яаж яривал сайн болох вэ? Яаж хэлэлцүүлгийг үргэлжлүүлэх вэ? Ямар санаа тусгах вэ?” зэргээр хамтран зорилгоо тодорхойлно. Учир нь сурагчид өөрийнхөө хийсэн зүйлийг бусдын хийсэнтэй харьцуулж өөрийн давуу ба сул талаа олж харж, дараа нь яаж хийх аргаа бусдынхтай харцуулан олж авдаг.

Ямар ахиц гарах ёстой вэ?	Хэрэв гарахгүй бол юу саад болж байна вэ?	Цаашид юу хийх вэ? Юуг яаж засаж сайжруулах вэ?
Бусдын яриаг хүлээцтэй сонсож сурсан бол бусдын ярьсан зүйлээс үзэл бодлыг дүгнэж сурах	Хүүхэд тодорхойлно.	Хүүхдийн ярьсан бэрхшээлээс багш хүүхэдтэй хамтдаа тодорхойлно.

Багшийн чиглүүлэг:

- Хамтран ажиллахад ямар бэрхшээл гарч байна вэ?
- Хамтран ажиллахын тулд бусдын саналыг сонсох нь хэр чухал вэ?
- Бусдын саналыг сонсоод яаж дүгнэж сурах вэ?
- Дүгнэлт нь үндэслэлтэй байж чадаж байна уу?
- Хэлэлцэх явцад шинэ санааг зохион хэлснээр хэлэлцэж буй зүйлээ сонирхолтой болгож чадаж байна уу?
- Хэр үр дүн гарах бол?

Хамтран ажиллах чадварыг хөгжүүлэхийн тулд хичээл бүрд тухайн чадварыг зорилгоо болгон, шалгуур гарган дүгнэж болно. Хэд хэдэн цагийн хичээл дээр дээрх чадваруудыг эзэмшүүлэхийг зоривол хүүхдийн чадварт ахиц гарах боломжтой юм.

Дараах хүснэгтийг ашиглана уу.

Чадвар	Илрүүлэх шалгуур	Хааяа	Ихэвчлэн	Үргэлж
Хамтран ажиллаж, саналаа солилцох	Хамтран ажиллахын тулд бусдын яриаг хүлээцтэй сонсдог			
	Бусдын яриаг сонсохдоо санаа бодлыг дүгнэж чаддаг			
	Хэлэлцүүлэгт саналаа хэлдэг			
	Саналаа хэлэхдээ жишээ баримтаар баталдаг			
	Хэлэлцэхдээ шинэ санаа нэмдэг			

4.3в.

Хэлэлцүүлгийн явцад бусдын санаа бодлыг анхааралтай сонсож, дүгнэх

1. Хэлэлцүүлгийн үед бусад сурагчдын төсөөлөн зохиосныг эргэцүүлэн сонсох
2. Яагаад ийнхүү төсөөлснийг лавлан асуух
Тухайлбал: яагаад, юуны учир, ямар учраас, ямар зорилгоор, яах гэж гэсэн асуултыг хэрэглэх
3. Төсөөлөн ярьснаас бусдын үзэл бодлыг дүгнэх
Тухайлбал: “Би түүний төсөөлөн ярьснаас үзэл бодолтой хүн юм байна гэж дүгнэлээ” гэх мэт өгүүлбэрийн бүтцээр ярих
4. Яагаад ийнхүү илэрхийлснээ баримтаар нотлох
Баримтаар нотлохын тулд:
 - “Энэ эхийг сонсоод, үүнийг хараад ингэж бодогдож байна. Энэ нь зөв юм. Яагаад гэвэл ийм учраас. Энэ эхэд ингэж өгүүлсэн учраас зөв гэж бодож байна” гэх мэт өгүүлбэрийн дэс дараагаар ярих
 - Миний сонгосон баримт миний ингэж үзсэнийг баталж чадна. Яагаад гэвэл өгүүлэгч нь ийм зорилгоор ярьсан, бичсэн учраас...” гэх мэт ярьж дадах

- Хүсэл тэмүүлэлтэй, зорилготой хүний тухай өгүүлсэн ярилцлага
- Зохиомол тохиолдол бүхий эх

Багшийн анхаарах зүйл:

Зөв ярьж сурахын тулд яриагаа төлөвлөж, бэлтгэсний дараа өөрийгөө бусдад ойлгомжтой илэрхийлэх, харснаа баримт болгон бичигт буулгах, сонссоноо ярианыгаа үндэслэл, нотолгоо болгон ярих чадварыг хөгжүүлэхийг зорихдоо багш харсан, сонссон зүйлийн талаарх үзэл бодол, санал сэтгэгдэл, итгэл үнэмшлийг судлах, хөгжүүлэх шаардлагатай. Хүүхэд баримт болохоор зүйлийг харж, сонсож байгаа тул тухайн зүйлд яаж хандаж, ямар сэтгэгдэлтэй байгааг лавлан тодруулахыг зорих нь зүйтэй.

Тэдний сэтгэгдэл, үзэл бодлоо илэрхийлж байгаа ярианаас ямар хүн болж төлөвшиж байгааг харах боломжтой тул дэмжиж, асуултаар баяжуулан яриулахад анхаарна. Хамгийн гол нь “Яагаад ингэж ярьж байна вэ? Яагаад чамд тийм сэтгэгдэл төрөв? Ямар учраас та нар тийнхүү бодсон бэ?” гэх мэт нотолгоо, үндэслэлтэй ярьж сургахад чиглүүлээрэй.

Харсан сонссон зүйлээ үндэслэлгүй яриулж сургах нь хүүхдийн бусадтай харилцах харилцаанд таагүй сэтгэгдэл үлдээх, бусдад итгэхэд саад учруулах гэмтэй тул аливаад учир утгатай хандаж сургахад дээрх чадварууд туслах юм.

4.3г. Зохиолын баатруудын харилцан ярианы утгыг ойлгосноо жүжиглэн үзүүлэх	1. Эхийн утгыг ойлгож унших, ярилцах 2. Ярилцахдаа бусдын яриаг анхааралтай, хүлээцтэй сонсон, зарим зүйлийг тодруулж асуух <u>Уншихдаа:</u> - Баатрууд хоорондоо юуг, яаж ярьсныг бодож унших - Баатруудын харилцан ярианаас ямар зан чанартай, ямар үзэл бодолтой хүн болохыг ажиглаж унших - Харилцан ярианы сонирхолтой хэсгийг сонгож тэмдэглэх, яагаад сонгосноо тайлбарлан ярихад бэлдэх 3. Харилцан ярианаас аль нэг баатрыг сонгох 4. Сонгосон баатрынхаа ааш зан, байдал төрх, харилцан яриа, дотоод бодол, хувцаслалт, царай зүс, хүсэл мөрөөдөл зэргийг тодорхойлж ярих 5. Баатрынхаа зан чанарыг тодорхойлон ярих 6. Баатрын зан чанарыг дүгнэж ярилцсаны дараа жүжиглэж үзүүлэх <u>Жүжиглэхдээ:</u> - Баатрын зан чанарт тохируулан дууны өнгийг өндөр, нам болгох - Нүүрний хувирал, нүдний харц хөдөлгөөнийг тохируулах - Биеийн хөдөлгөөнийг яаж илэрхийлэхээ бодох - Гарын дохио зангаагаа тааруулах Жишээ нь: - “Зунжин дуулсан юм чинь өвөлжин бүжиглээд өнгөрөөхгүй юү” гэсэн өгүүлбэрийг хэлж байхдаа яаж хөдлөх вэ? - Гарын дохио зангаа ямар байх вэ? - Нүдний харц, нүүрний хувирал ямар байх вэ? - Дуу хоолойны өнгөө яаж өөрчлөх вэ? • Бусад дүрд өөрийгөө танилцуулж, өөрийн / дүрийн/ санаа бодлыг илэрхийлж, дүрд тоглох 7. Даалгаврын хувилбараас сонгон ажиллах Жишээ нь: - Сонгосон хэсгээ харилцан яриа болгон дэлгэрүүлж ярих, бичих - Харилцан яриа бүхий хэсгийг хүүрнэн ярих, бичих - Сонирхолтой харилцан яриа бүхий, тодорхой утга санаатай үлгэр зохиох дасгал ажиллах Бүтээлч үйл ажиллагаа: Үзсэн кино болон уншсан өгүүллэг, үлгэр, домгийн үйл хөдлөлийг мэдрэмжээ илэрхийлж ярих <u>Мэдрэмжээ илэрхийлж ярихдаа:</u> - Уншсан үлгэрээс, баатрын зан чанараас юуг мэдэрснээ илэрхийлэх	- Үнэнч шударга байх нь бүхнээс хүчтэй гэсэн утга бүхий эх - Эхийн эхлэл, гол, төгсгөл нь тодорхой ялгарахуйц эх
---	---	---

	Жишээ нь: - Баатруудын харилцан ярианаас ямар дүр төрхийг мэдэрч байсан бэ? - Баатрын хэлсэн үгээс айсан уу, эсвэл өрөвдсөн үү? гэх мэт Баатруудын дэргэд байсан бол сэтгэл чинь яаж хөдлөх байсан бэ?	
Багшийн анхаарах зүйл: Зөв ярьж сурахын тулд хүүхэд бүрийг хөгжүүлэхийн тулд тэдний сурах хүслийг төрүүлэх зорилго багш тавих хэрэгтэй. Ялангуяа сургалтын явцад тухайн бүлгийн зорилтот хичээл эхлэхээс өмнө юуг сурвал чамд хэрэгтэй вэ гэдгийг ярилцах нь хүүхдийн сурах үйл ажиллагааг дэмжээд зогсохгүй үр дүнд хүрэхийн тулд яаж хийхээ, яаж сурахаа төлөвлөхөд нь тус болох юм. Тухайлбал: - Жүжиглэн тоглож сурснаар чиний юуг өөрчилнө гэж бодож байна вэ? - Дуу хоолойны өнгө тохируулж ярьж сурах нь чамд яагаад хэрэгтэй вэ? - Бусадтай санал нийлэхгүй байгаагаа соёлтой илэрхийлж сурах нь чамд хэрэгтэй юу? “Жүжиглэн үзүүлэх” суралцахуйн зорилтын хүрээнд сурагчдын ялгаатай байдал тод илрэх тул ичимхий, бүрэг сурагчдад дүрийн гадаад төрх болон дотоод санаа бодлыг хэрхэн дүрсэлснийг сайтар төсөөлүүлсний дараа дүрд тоглохыг санал болгох шаардлагатай. Өөрөөр хэлбэл зохиолоо, дүрээ сайн мэдэрсэн сурагч дүрд тоглох сэтгэлзүйн бэлтгэлтэй болдог. Багш сурагчдыг уншсаны дараа дүрийн мөн чанарыг ойлгож мэдэрч чаддаг болгохын тулд яагаад, ямар учраас, яаснаас болж, яагаад ийм болов гэх мэт учир шалтгааны асуултыг тавьж, дүрд тоглохыг дэмжээрэй. Жүжиглэн тоглохоо илүү сайн аргаар яаж хийж үзүүлэх вэ гэсэн асуултаар хөтлөн сурах арга барилыг эзэмшүүлэхийг санал болгож байна. Өгүүллэг, үлгэр, домгийн үйл хөдлөлийг сэтгэлийн хөдөлгөөнтэй илэрхийлж яриулж сургахын тулд тухайн эх зохиолын чухам аль хэсэгт сэтгэл хөдөлснийг асуух, яагаад хөдөлснийг тодруулан ярилцах боломжтой. Тухайн үед тайзнаа тавигдаж буй жүжгийн зохиолыг үзэж, дүрүүдийн харилцан яриаг ажиглах дасгал ажиллаж болох юм.		

ДӨРӨВ. ХЭЛ ЗҮЙ, ҮГИЙН САН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
4.4а. Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд зэрэг холбох үгсийг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох	1. Холбоосуудыг эхэд хэрхэн хэрэглэснийг ажиглах, дүгнэн ярилцах 2. “Ба”, “бөгөөд” холбоос үгийг өгүүлбэр холбохдоо хэрэглэх 3. “Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж” зэрэг холбоосыг цогцолборуудыг, эхийн бүтцийг холбохдоо хэрэглэх 4. Хэрхэн хэрэглэснээ ярилцах	- Сурах бичиг - Богино, үлгэр өгүүллэгүүд - Хүүхдийн шүлэг яруу найраг - Асуулт бүхий карт болон жишээ үг бүхий карт
4.4б. Уриалсан, зөвлөсөн өнгө аясыг илтгэх үг хэллэгийг оновчтой хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох	1. Уриалсан, зөвлөсөн өнгө аястай эх унших 2. Эхээс уриалсан утгатай үг хэллэгийг таньж тайлбарлах, яагаад уриалсан болохыг хэлэх 3. Эхээс зөвлөсөн утгатай үг хэллэгийг таньж тайлбарлах, яагаад зөвлөсөн болохыг хэлэх 4. Эхэд хэрэглэсэн уриалсан өнгө аясыг илтгэх үгийг сонгох, ижил төстэй хэл зүйн хэлбэржилтийн жишээ гаргах, өгүүлбэр зохиох 5. Эхэд хэрэглэсэн зөвлөсөн өнгө аясыг илтгэх үгийг сонгох, ижил төстэй хэлзүйн хэлбэржилтийн жишээ гаргах, өгүүлбэр зохиох	- Үгийн сүлжээ

4.4в. Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох	Өмнөх мэдлэгээ сэргээн санахын тулд - Эсрэг ба ойролцоо утгатай хос үгийг олж бичих - Эх, өгүүлбэрээс эсрэг ойролцоо үгийг ялгаж бичих, өнгөөр тодруулах - Цэгийн оронд нөхөх - Эсрэг болон ойролцоо үгийн эгнээ үүсгэх Мэдлэгээ хэрэглэж сурахын тулд - Өгүүлбэр зохиох - Эсрэгцүүлэх болон ижилсүүлэх холбоосоор холбож ойролцоо эсрэг утгат өгүүлбэр болгох - Өгүүлбэрийг дуусгах	- Найруулгын жишээ өгүүлбэрүүд
4.4г. Эх, өгүүлбэр зохиохдоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэх	Өмнөх ангид үзсэн мэдлэг ойлголтоо бататгахын тулд - Өмнөх ангид үзсэн хэлц үгүүдийг тохирох газарт нөхөх - Хэлц үгийг ялгаж бичих - Хэлц үгийн утгыг тайлбарлаж бичих - Хэлцийг тайлбарласан эх зохиох - Үгийг хэлц үгээр солин найруулах Хэлц үгийн утгыг тайлбарлаж сурахын тулд - Хэлц үгийн толь хийх - Хэлц үгээр үгийн утгаар үгийн сүлжээ хийх - Хэлц үгийн утга тайлбарлах арга хайж ярилцах - Хэлц үгийн ойролцоо эсрэг хэлцийг олох - Хэлцийн утгыг тайлбарласан эх зохиох - Эх, өгүүлбэр зохиохдоо хэлц, түүний тайлбарыг оновчтой хэрэглэх	- Хэлц үгийн толь - Үгийн сүлжээ - Хэлцийн утгыг тайлбарласан эхийн жишээ
Багшийн анхаарах зүйл: Хэлц үгийг мэдэж байна уу гэдэг нь бага ангид чухал биш юм. Багш та хэлц үгийг, тайлбартай нь уншуулж, цээжлүүлэхэд анхаарна уу. Тайлбарыг мэддэг сурагч л эх зохиохдоо хэрэглэх учиртай. Практикаас харахад хөндлөнгийн шалгалтад “... хэлц үгийг тайлбарлаарай” гэсэн даалгавар тавигдсан нь хэлц үгийн тухай мэдлэг шалгах даалгавар болж байна. Энэ нь сурагчдад хүнд юм. Харин анги ангид яг хэдэн хэлц болоод түүнийг тайлбарыг мэдэж цээжилснийг шалгах, улмаар тайлбарыг мэдсэний дараа оновчтой хэлцийг өгүүлбэр эх зохиохдоо хэрэглэж байна уу гэдгийг шалгах нь зүйтэй. Жишээ нь, “Сайн сурсанд минь аав минь ихэд баярлав” гэсэн өгүүлбэрийн ихэд гэдэг үгийг тохирсон хэлц үгээр илэрхийлж бичээрэй. Дараах хэлцээс сонгоорой” гэх мэт. Сурагчдын үгийн санг баяжуулах арга бол ойролцоо утгатай үгийг ажиглуулж, улмаар хэрэглүүлж сургах явдал юм. Иймээс багш өөрөө ойролцоо үгийн сангийн нөөцтэй байх, ойролцоо үгийн санг нөөцлөх хэрэгтэй. Учир нь бага ангийн сурагч аливаа эхийг зохиож бичихдээ үгийг их давтдаг алдаа гаргадаг. Иймээс ямар үгийг их давтаж байгаа талаар судалгаа хийж, тухайн давтаад байгаа үгийг нь ойролцоо үгээр солин найруулах арга замыг багш та эрэлхийлээрэй. Эсвэл давтаад байгаа үгний оронд төлөөний үг хэрэглэж болно гэж зааж болно. Төлөөний үг гэж юу вэ гэж та заахгүй, “ах” гэж бичээд, дахиад “ахын” гэж бичиж байгаа тохиолдолд түүний гэж бичиж болно гэж чиглүүлэхийг санал болгож байна.		

ТАВДУГААР АНГИ

Танилцуулга

Энэ нь тавдугаар ангийн монгол хэлний хичээлийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэл болох үлгэрчилсэн төлөвлөлтийн нэгэн хувилбар юм. Тухайн ангийн сургалтын зорилтуудыг унших, бичих, сонсох, ярих чадвар болон хэлзүй, үгийн санг хэрэглэх чадварт хувааж тухай бүрд эзэмших мэдлэг чадварыг үйл ажиллагааны хувилбаруудаар баяжуулан төлөвлөлөө.

Эдгээрийг орон нутгийн онцлог, шаардлага, нөөцөөс хамаарч заах дараалал, арга аргачлал нь таны хувьд нээлттэй. Суралцахуйн удирдамж нь уян хатан тул суралцагчдын суралцах хурд, сургалтын цагтай уялдуулан агуулгыг судлах цагаа зохицуулах боломжтой. Суралцахуйн зорилтуудыг хэрэгжүүлэх явцыг зөв чиглүүлэх үүднээс боломжит үйл ажиллагаа, хэрэглэгдэхүүний зарим санааг оруулав.

НЭГ. УНШИХ ЧАДВАР

Унших чадварыг эзэмшүүлэхийн тулд уншихын чанар гэгддэг шаардлагуудыг харгалзахыг зөвлөж байна.

5 дугаар ангийн сурагчдын унших чадварт тавигдах шаардлага: **Бусдын дэмжлэггүй өөртөө унших /дуугүй, харааны/, зөв, хурдан, ойлгож унших, уншсанаа бусадтай хуваалцах, ярилцах.** Ямар ч төрлийн эхийг уншихдаа өөртөө уншиж, зөв хурдан уншихдаа эхийн агуулгыг ойлгож байна уу гэх зэргээр үнэлэхэд анхаарна.

Эхийн агуулгыг ойлгосноо харуулах

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
5.1a. Эхэд ашигласан зарим үг, хэллэгийг сонгож, эхэд хэрэглэсэн учрыг тайлбарлан дүгнэх	Зохиогч яагаад энэ эхэд, энэ үгийг сонгосон бэ? гэдгийг тайлбарлаж чаддаг болохын тулд: 1. Үлгэр, өгүүлэл, шүлэг, жүжгийн зохиолын утгыг ойлгож унших 2. Танил бус эсвэл содон өвөрмөц санагдсан анхаарал татсан үгийг олж тэмдэглэх 3. Зохиолч ямар учраас энэ үгийг сонгож хэрэглэснийг ойр орчмын үг өгүүлбэрийн утгаас таамаглан тайлбарлах - Энэ үгийг хэрэглээгүй байсан бол зохиолын утга хэр өөрчлөгдөх бол? Ямар утга алдагдах бол? 4. Дүгнэхдээ зохиолч ...ийм утга санааг илэрхийлэх гэж, ...ийм зан чанартай баатрыг харуулах гэж ...ийм үг хэрэглэсэн байна гэж хэлэх	- Төрөл бүрийн уран зохиолын богино эх, зүйр цэцэн үг, оньсого, үлгэр гэх мэт - Шүлэг - Бодит явдал, уран сэтгэмж холилдсон эх - Баримтын эх

Багшийн анхаарах зүйл:

Шүлэг, зохиолыг уншсаны дараа хүүхдүүдтэйгээ харилцан ярилцаж тэдний мэдэхгүй үгийн утгыг хэрхэн ойлгож байгаа санал бодлыг нь сонсохдоо аль болох тухайн эхийн хам сэдэв (ойр орчмын үг, өгүүлбэр) тэй холбож тайлбарлуулаарай. Тухайлбал: Доорх “Би монгол хүн” шүлэгт “Цэнхэр манан суунагласан алсын барааг ширтээд” гэсэн мөрийн “Цэнхэр манан суунагласан” гэсэн үгийг яагаад сонгосны учрыг тайлбарлуулж болно. Энэ нь “Миний эх орон бол цэлгэр уудам хөдөө талд гарахад цэнхэр манан суунагласан мэт уужим тэнүүн сайхан сэтгэгдэл төрүүлдэг учраас ийнхүү дүрсэлсэн гэдгийг ойлгохын тулд “цэнхэр манан” гэдэг нь “цэнхэр униар” буюу газрын чийгт уур дээш дэгжиж утааны адил хөөрөн тархах, цэнхэр униар татах, хөх униар татах, хөх униар суунаглах, цэнхэр униар суунаглах гэдгийг шүлэгт дүрслэхдээ униар ба мананг адилтган үзэж “цэнхэр манан суунагласан” гэдгийг сонгосон байна. Зохиогчийн үг сонголтын шалтгааныг тайлбарлан дүгнэх чадварыг эзэмшүүлэхдээ үндэстний уламжлалт соёл, монгол зан заншлыг тусгасан зохиол сонгох хэрэгтэй. Яруу найрагч Ч.Чимид “Би монгол хүн” гэж шүлгээ нэрлэсний учрыг ухааруулж болно. Адуу малын захад явж, аргал хорголын дунд өсөж торнисон нүүдэлч малчны удамт монгол хүн билээ, бид.

Тал нутгийн монгол хүнд гал гэхлээр мод биш, нүүрс биш, аргал бодогддог аж. Аргалын утаа үнэрлээд, турж эцсэн мал, ядарч туйлдсан хүн тэнхээ ордог гэдэг. Иймээс ч Төрийн шагналт зохиолч Д.Нямаа:

Эсгий гэрт минь анхилсан

Аргалын утааны үнэр

Эрийн тэнхэл оруулсан

Хүж дэлхийн үнэр юм. (1961) гэж шүлэглэсэн.

Нүүдэлчин монголчууд бол ямар аргалаар юу хийх, хэзээ, яаж хэрэглэхээ ч таньж мэдсэн амьдралын тийм туршлагатай ард түмэн. Адууны хөх хомоолын зөөлөн галаар сүү хөөрүүлэх, үхрийн сайхан халтар аргал, хөх аргалын дөлөн дээр тогоо нэрэх, адууны шар хомоол, дүлий хар хомоолоор май тавьж, ялаа шумуул үргээх, нэг хоёр жилийн өнжмөл төмөр мэт хатуу хөх хомоолоор гал манах, хоргол хөрзөн цогшуулж толгой шийр чанах, эззгий буцалгах гээд л... Аргал хомоолын утаагаар сая төхөөрсөн малын махыг утдаг, муудаж хуучрахаас нь сэргийлдэг, гургалдай, гүзээ тэргүүтэнг “утаанд өгдөг” арга манай нүүдэлч малчдын дунд дэлгэрсэн байдаг бөгөөд ингэж хомоолын утаагаар мах утах нь, нүүдэлчдийн мах шүүсийг ариусгах, хамгаалах арга, монгол ухаанаас гарчээ.

Тэгээд ч энэ нь “утсан хиам”-наас урьдын зүйл бөгөөд махыг утаж хэрэглэх нь их л эртний соёлын зүйл бололтой. (Б.Пүрэв -Очир) Үгийн тайлбар:

Хомоол – Адууны хатсан баас

Адууны хөх хомоол – Нар салхинд удаж өгөршсөн хомоол

Үхрийн сайхан халтар аргал – Сайтар хатсан хар аргал

Хөх аргал – Нэг жил өнжиж хатахдаа хөх өнгөтэй болсон хатуу аргал

Адууны шар хомоол – Бутарсан шар хомоол

Дүлий хар хомоол - Нар салхинд сайтар хатсан түлэхэд тохиромжтой хомоол

Май тавих – Ялаа шумуулаас сэргийлж утаа тавих

Нэг хоёр жилийн өнжмөл төмөр мэт хатуу хөх хомоол – Нэг хоёр жил сайтар хатаж, хөх өнгөтэй болсон хомоол

Хоргол – Тэмээ болон бог малын баас

Хөрзөн – Малын өтөг баас олон хоногоор дагтаршиж хатуу болох

5.16. Нэг сэдэвтэй хоёр эхийн утгыг харьцуулах замаар эхийн агуулгыг ойлгосноо харуулах

Нэг сэдэвтэй хоёр эхийг харьцуулахын тулд:

1. Мэдээлэх зорилготой эх, ятган итгүүлэх зорилготой эхийн агуулгыг ойлгож унших, утгыг ярилцах
2. Хоёр эхийг уншаад төсөөтэй болон ялгаатай талуудыг “Венийн диаграмм” ашиглан гаргах
 - Зорилгоороо ятгасан, мэдээлсэн аль нь болохыг хэлэх
 - Хэмжээний хувьд ямар ялгаа байгааг хэлэх
3. Янз бүрийн өвөрмөц, анхаарал татсан илэрхийллийг аль эх нь ашигласныг ажиглах, жишээ татан тайлбарлах
4. Эхэд ашигласан зураг, дүрсийн хувьд ялгаа байгаа эсэх талаар ажиглах, дүгнэх
5. Зар сурталчилгааны эхэд эх зураг, фото зураг, дуу зэргийг ямар зорилгоор ашиглаж байгааг хэлэлцэх

- Нэг сэдэвтэй төрөл бүрийн эхүүд

- Нэг сэдэвтэй мэдээлсэн эх ба зар сурталчилгаа буюу ятгаж итгүүлэн бичсэн эхүүд

- Төрөлжсөн эхийн сан

Багшийн анхаарах зүйл:

Энэхүү суралцахуйн зорилт нь “Бусдын анхаарлыг таттал ятган бичих” (зар сурталчилгааны хэв маягтай гэсэн үг), мэдээлэх зорилгоор “Мэдээлэл бичих” чадвартай холбоотой юм. Учир нь зар сурталчилгааны эх болон мэдээллийн эхийн зорилго, хэмжээ, утга санаа, онцлогийг мэдсэн сурагч дуурайх аргаар зар сурталчилгаа эсвэл мэдээ бичнэ гэсэн үг юм. Тиймээс багш та сурагчийг ятган итгүүлэх зорилгоор богино хэмжээтэй, зураг, дүрс ашиглаж бичих аргатай болгоё гэвэл зар сурталчилгааны эхийг, мэдээллийн эхтэй харьцуулан уншуулахад анхаарна гэсэн үг юм. Нэг сэдвийн талаар олон талаас олон хэлбэрээр бичдэг гэдгийг ойлгуулахад үйл ажиллагаагаа чиглүүлнэ. Мөн аливаа зүйлийг харьцуулах, ижил болон ялгаатай талыг дүгнэн гаргах чадварыг хөгжүүлэхэд анхаарна.

Энэхүү чадварыг үнэлэхдээ дараах асуултыг хэрэглэж болно.

1. Мэдээллийн эх, ятган итгүүлэх зорилготой эх хоёрын хэмжээг ялгаж хэлж байна уу?

2. Энэ хоёр эхийн үг сонголтыг ажигласан уу?
3. Ятгахын тулд ямар үг хэрэглэв? Үнэхээр сонгосон үг нь ятгаж чадаж байна уу?
4. Ялгаа нь юунд байна вэ?

5.1в. Уншсан жүжгийн зохиолын гол санааг тайлбарлах	1. Жүжгийн зохиолын хэсгээс сонгон, утгыг ойлгож унших 2. Ойлгосноо ярилцах, асуулт зохион ярилцах 3. Зохиолч ямар сэдвийн хүрээнд бичсэнийг ярилцах Тухайлбал, хүний сайн зан чанарын тухай тухай юу, ээжийн хайрын тухай юу, эх орноо хайрлах тухай юу гэх мэтээр ярилцах 4. Яагаад ...ийм сэдэвтэй зохиол гэж үзсэнээ ярилцаж болно. 5. Зохиолч уншигчдад юу хэлэхийг хүссэнийг ярилцах, яагаад ингэж үзсэнээ жишээ татан тайлбарлах 6. Хэрхэн тайлбарласнаа бусдад ойлгогдохоор хэлснээ үнэлэх	- Цөөн хэдэн дүртэй жүжгийн хэсгээс
--	---	-------------------------------------

Багшийн анхаарах зүйл:

Жүжгийн зохиолыг уншуулахдаа баатруудын хоорондын харилцаа, зөрчлийг ажиглуулаарай. Гол санааг тайлбарлах чадвар эзэмшсэн сурагч нь зохиолчийн уншигчдад хэлэх гэсэн санааг ухааран, зохиолоос жишээ татаж байвал хангалттай үнэлгээг авна.

5.1г. Уншсан эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгүүдийн утгын холбоо хамаарлыг тайлбарлах	1. Эхийн агуулгыг ойлгож унших, ойлгосноо ярилцах 2. Хүүрнэл эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг зааглах 3. Зохиолын эхэнд, эсвэл гол хэсэг дэх үйл явдал, юунаас болж хэрхэн өрнөснийг, хэрхэн төгсөж байгааг ярилцах, ямар үр дүнд хүрснийг дүгнэх 4. Баатруудын хийсэн үйлдлийн учир шалтгааныг тодруулах, хийсэн үйлдлийн зөв бурууг дүгнэх, аль цогцолборт учир шалтгаан нь илэрснийг ярилцах, Жишээ нь: - Эхлэл хэсэгт гол баатрыг ингэж бичээгүй бол гол хэсэгт үйл явдал ийнхүү өрнөхгүй байх байсан... - Гол хэсэгт баатруудад ийм ийм үйл явдал тохиолдож, түүнийг тийнхүү даван туулсан тул төгсгөл хэсэгт үйл явдал ингэж төгсөхөөр болжээ гэх мэтээр ярих Утгын холбоо хамаарлыг тайлбарлан дүгнэхдээ: - Уншсан эхийнхээ учир шалтгааныг тодруулахдаа “яагаад”, “ямар учраас”, “юуны тулд”, “яха гэж” гэх мэт асуулт хэрэглэн, “...үүнээс болж үйл явдал ингэж дуусчээ, үүнээс шалтгаалж, дүр ийм үйлдэл хийжээ” гэх мэтээр дүгнэх Бүтээлч үйл ажиллагаа: - Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг зөв дарааллуулах, үлгэр ба өгүүллэгийн үйл явдлыг учир шалтгааны хувьд зөв дарааллуулах	Учир шалтгааны холбоо хамаарал бүхий үйл явдалтай эх зохиол, баатруудын хийсэн үйл нь ямар нэгэн нөхцөлөөс болж өөрчлөгдсөн эх зохиол
--	---	---

Багшийн анхаарах зүйл:

ТАЙЛБАРЛАХ чадвар гэдэг бол уншсан эхээсээ жишээ татахыг хэлнэ. Хүүрнэл эх гэдэгт өгүүллэг, үлгэр зэрэг үйл явдлын дэс дараатай, баатруудын зан чанарын өөрчлөлтийг эхнээс нь дуустал хүүрнэсэн эх орно. Энэ тодорхойлолтыг зөвхөн багш мэдэх ёстой юм. Хүүхдэд заах шаардлагагүй. Энэхүү суралцахуйн зорилтын хүрээнд багш эхийн бүтцийн хэсэг болох эхлэл, гол, төгсгөл гэж юуг хэлэх, учир шалтгааны холбоо хамаарал гэж юуг хэлэхийг мэддэг байх хэрэгтэй. 4 дүгээр ангидаа сурагч эхлэл, гол, төгсгөл хэсгийг ялгаж сурсан байна гэж үзнэ.

- Эхлэл бол танилцуулга хэсэг.
- Гол бол өрнөл хэсэг.
- Төгсгөл бол дүгнэлт хэсэг юм. Эхлэл, гол, төгсгөл хэсэг бүрд хэчнээн цогцолбор байгааг тодруулж болно.

<i>Аль цогцолборт нь учир шалтгаан, үр дагаврыг бичсэнийг ярилцуулна.</i> <i>Учир шалтгааны холбоо хамаарал гэдгийг ойлгохдоо аливаа хэрэг явдал үүсэх шалтгаан, түүний үр дагавар гэж үзнэ. “Яагаад, ямар учраас, юуны тулд, яах гэж” гэсэн асуултаар хөгжүүлж, учир шалтгааныг тодруулж уншуулж сургах нь зүйтэй.</i> <i>Сурагчийг үнэлэхдээ дараах асуултыг хэрэглэж болно.</i> <i>1. Эхлэл, гол, төгсгөл хэсгийг яаж ялгасан бэ?</i> <i>2. Эдгээр хэсгүүд утгаараа яаж холбогдов?</i> <i>3. Бэрхшээл юу байв? Багаараа ярилцаж үзсэн үү?</i>		
5.1д. Эхээс хүншүүлсэн, хэтрүүлсэн дүрслэлийг тайлбарлах замаар үлгэрийн утгыг ойлгосноо харуулах	1. Ан амьтны дүртэй үлгэр, өгүүллэгийн утгыг ойлгож унших, утгыг харилцан ярилцах 2. Хүншүүлэн дүрсэлсэн ан амьтны дүрд тоглож урнаар унших 3. Уншихдаа амьтдын цаана хүний ямар зан чанарыг илэрхийлж байгааг бодож унших 4. Хүншүүлсэн дүрслэлийг тайлбарлахдаа: - Баатрын үйл хөдлөлийг амьтны хийдэг ба, хүний хийдэг гэж ангилах - Үлгэрт яагаад амьтад хүний хэлээр ярьж, хүний хийдэг үйлдлийг хийж, хүний гаргадаг зан чанарыг гаргаж байгаа талаар ярилцах - Юуг ямар шинжээр нь хүншүүлснийг тайлбарлах - Уран зохиолын эхэд дүрсэлсэн хүншүүлсэн юмсын дүрслэлийг харуулж зурж үзүүлэх, үзэсгэлэн гаргах (Жишээ нь: Үнэгийг хүн шиг зурах, нарыг инээж буй хүүхэд шиг зурах г.м.) Хэтрүүлсэн дүрслэлийг тайлбарлахдаа: 1. Ямар нэгэн зүйлийг байгаа хэмжээнээс ихэсгэж, эсвэл багасгаж бичсэн хэсгийг зохиолоос олох, ихэсгэсэн гэж үзсэнээ жишээ татан тайлбарлах	- Хүншүүлэх арга хэрэглэсэн сургамжит үлгэрүүд - Хүншүүлэл, хэтрүүллийн аргаар бүтсэн үлгэр, өгүүллэг, оньсого, - “Ертөнцийн гурав” хэлц үгийн сан - Хүншүүлсэн зураг - Бодит хэмжээнээс нь ихэсгэж, багасгаж дүрсэлсэн төрөл бүрийн харьцуулсан зургууд
Багшийн анхаарах зүйл: <i>Багшийн хэрэглэх асуулт: Хүн шиг ярьж хүн шиг бодож, хүн шиг хөдөлж байгаа ямар амьтад байна вэ? Үлгэр дэх амьтдаар хүний ямар зан чанарыг харуулсан байна вэ? Ямар амьтнаар ямар хүнийг дүрсэлсэн бол? Амьдралд байдаг зүйлээс хэмжээнээсээ хэт том болсон ямар нэгэн зүйлийн тухай өгүүлсэн зохиол уншиж байсан уу? Эсвэл байгаа байдлаасаа хэмжээгээр жижгэрсэн ямар нэгэн зүйлийн тухай төсөөлж бодож байсан уу? гэх мэтээр энэхүү суралцахуйн зорилт бүхий ээлжит хичээл дээр сэдэлжүүлж болно.</i> <i>Багш та хүншүүлэл гэж юу вэ? хэтрүүлэл гэж юу вэ? гэж тодорхойлолт бичүүлж цээжлүүлж заахгүйгээр хүншүүлэл, хэтрүүллийн баялаг жишээтэй уншиж танилцуулсны дараа яаж дүрсэлснийг нь батлан тайлбарлах арга эзэмшүүлэхэд анхаарна. Сурах бичгээс нь уг хоёр аргын онцлогийг нь уншуулж яагаад яагаад хүншүүлэл, хэтрүүлэл гэж нэрлэсэн юм бол гэдгийн учрыг нь сурагчдаар олуулах бүтээлч үйл ажиллагааг хийлгэж болно. Мөн чанар, онцлогийг сайн ойлгосон үед нь өөрсдөөр нь зохиолгох даалгаврыг хийлгэх нь яваандаа сурагчид зохион бичихдээ уран дүрслэлийн аргыг хэрэглэж сурахад нь тустай байх болно.</i>		
5.1е Үлгэрт амьдралын бодит байдлыг тусгасан эс тусгасан шинжээр нь бодит байдал ба уран сэтгэмжийг ялгах	1. Уран сэтгэмжээр бичсэн үлгэр, өгүүллэгийн утгыг ойлгож унших, уншсанаа ярилцах 2. Амьдрал дээр байдаггүй боловч өөрийн хүсэж байгаа ид шидийн зүйлсийн тухай ярилцах. Хэрвээ шидтэн ирээд чиний хүслийг асуувал чи яах вэ? 3. Уншсан эхүүдээс амьдралд тохиолддог бодит үйл явдалтай хэсгүүд эсвэл бодит амьдрал дээр байдаггүй, харж сонсоогүй зүйлийг ялган тэмдэглэх Бүтээлч үйл ажиллагаа: - Уран сэтгэмжээр зохион ярих - Жишээ нь: Хэрвээ би далдыг хардаг байсан бол?	- Уран сэтгэмжээр бичигдсэн монголын болон дэлхийн шилдэг зөгнөлт өгүүллэгүүд Жишээ нь: Л.Түдэв “Мөнхийн ус, Лувсанцэрэн “Усын эргүүлэг буюу

	- Цаг хугацааны машинаар аялах боломж гарвал яах вэ? гэх мэтээр төсөөлөн ярьж, түүнийгээ бичиж, илэрхийлэх	Борзооны явдал”, Нарниагийн түүх, Харри Поттер ба шидэт чулуу гэх мэт
Багшийн анхаарах зүйл: Уран сэтгэмж гэдэг бол бодит амьдралд тохиолдох боломжгүй юмсыг дүрсэлснийг хэлнэ. Энэ суралцахуйн зорилтын хүрээнд сурагчдын аливаа юмсыг өвөрмөцөөр, сонин содон байдлаар харах буюу төсөөлөн бодох, урнаар сэтгэх чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм. Уран зөгнөлт зохиол уншихын зэрэгцээ сурагчдын сайн мэдэх уран зөгнөлт хүүхдийн киноны талаар ярилцаж, уран сэтгэмжийн талаарх ойлголтыг нь гүнзгийрүүлж болно. Уран сэтгэмж бүхий зохиолуудыг сонгон уншуулах юм бол сурагчдын төсөөлөн бодох, ургуулан бодох сэтгэмж хөгжинө. Уншсанахаа хэрээр уран сэтгэмжээр бичих чадвар сайжирна. Ер нь сургалтын хөтөлбөр дэх унших зорилготой суралцахуйн зорилтууд нь “бичих” зорилготой суралцахуйн зорилттой холбоотой юм. Ямар эх зохиол уншина, түүнийг дуурайж бичих асуудал нь багш таны нэгжийн төлөвлөлтөд тусах учиртай билээ.		
5.1ж. Уншсан эхийн баатруудын харилцан ярианаас тэдний зан чанарыг дүгнэх	1. Уран зохиолын эхийн агуулгыг ойлгож унших, том хэмжээний эхийг хэсэглэж унших 2. Зохиолын баатруудын зан араншин, сэтгэл санааны байдлыг тэдний хэл яриа, үйл хөдлөлөөс ургуулан бодож төсөөлөх 3. Зохиолын баатруудын үйл хөдлөлийг жагсаан бичих 4. Баатруудын холбоо хамаарлыг илэрхийлсэн оюуны зураглал хийх 5. Баатрууд хоорондоо юу ярьж, хэлэлцсэнийг хэлэх, зохиолоос жишээ татах 6. Харилцан ярианаас нь ямар зан чанартай болохыг нь дүгнэх Дүгнэхдээ: “...Тэр баатар ...ингэж ингэж хэлсэн учраас сайн дүр гэж үзэж байна. Харин ...тэр дүрийг миний хувьд буруутган шүүн дүгнэж байна. Учир нь тэр баатар ...тийм үйлдэл хийж, тийм нөхцөлд тийм үг хэлсэн нь маш буруу гэж үзэж байна” гэсэн найруулгаар ярих, бичих Бүтээлч үйл ажиллагаа: - Уншсан зохиолоос баатраа сонгох - Баатрын хийсэн үйл хөдлөлийг жагсаан бичих - Тэдгээр үйл хөдлөлийг хийж байх үедээ тэр баатрын сэтгэл санаа нь ямар байсныг тодорхойлж бичих - Зохиолын баатрын сэтгэл санааны байдал зохиолын эхлэл, өрнөл хэсэг, төгсгөл хэсэгт хэрхэн өөрчлөгдснийг зураглалаа харж тайлбарлах, дүгнэх - Ингэж өөрчлөгдөх болсон шалтгаан нь юу байсныг зохиолын баатрын үйл хөдлөл болон, бусад баатартай холбон тайлбарлаж дүгнэлт гаргах	- Ц.Мөнх “Сонгино, “Шуурга” гэх мэт өгүүллэг, С.Эрдэнэ “Шувуунд хайртай хүү” өгүүллэг Тео хуат “Асар шиг том шүхэр”, “Арван мянган мөхөөлдөс” өгүүллэг, - Зохиолын үйл явдал болон баатруудын холбоог харуулсан тулгуур бичиглэл болон оюуны зураглалын жишээ, загварууд  - Дэлхийн хүүхдийн хүүрнэл зохиолын дээж II боть. УБ., 2012. Монголын хүүхдийн уран зохиолын дээж I, II боть. 

Багшийн анхаарах зүйл:

Энэхүү суралцахуйн зорилтын агуулгын залгамж холбоог дараах байдлаар харж болно.

1 дүгээр анги-Уншсан эхийн баатрын хийсэн зүйлийг тоочих

2 дугаар анги-Уншсан эхийн баатруудын сайн, муу үйлийг жишээгээр тайлбарлах

3 дугаар анги-Уншсан зохиолын баатруудын зан чанарыг эхээс жишээ татаж тайлбарлах

4 дүгээр анги-Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэгт баатруудын зан чанар, үзэл бодолд гарсан өөрчлөлтийг харьцуулах. Энэхүү залгамж холбооноос “**ТООЧИХ, ТАЙЛБАРЛАХ, ХАРЬЦУУЛАХ, ДҮГНЭХ**” чадваруудыг анги ахих тусам ахиулж үнэлэхийг багш анхаарна.

Дүгнэх үйлийг хөгжүүлэхдээ “Шийдвэрлэх, шүүн дүгнэх, чанарын үнэлгээ өгөх, үнэлж дүгнэх, дүгнэж шийдвэр гаргах, зөвтгөх, шүүх” гэсэн үйл үгийг ээлжит хичээлийнхээ төлөвлөлтөд тусган “**шийдвэр, ач холбогдлыг тодорхойлох, багийн хэлэлцүүлэг, зөвлөмж, судалгаа**” зэргээр сурагчдын бүтээл хийлгэн ажиллаж болно. Баатруудын харилцан ярианаас зан чанарыг үнэлүүлж дүгнүүлэхдээ ангийн сурагчдын хандлагад нөлөөлөх талаар анхаарах хэрэгтэй.

Өөрөөр хэлбэл үлээр, өгүүллэг уншихаар хязгаарлахгүйгээр бодит амьдрал дунд нь бусад найз нөхдийн харилцан ярианаас зан чанарыг дүгнэх, гэр бүлийн гишүүдийн харилцан ярианаас зан чанарыг дүгнүүлж, хэрвээ чи оронд нь байсан бол гэх зэргээр хэрэглээний асуулт тавьж хөгжүүлэхийг санал болгож байна.

5.13. Захидлаас нэг сэдвийн талаар ялгаатай үзэл бодлыг харьцуулж дүгнэх	1. Нэг сэдвийн талаарх мэдээ, мэдээллийг цуглуулах 2. Цуглуулсан мэдээллээс ялгаатай үзэл бодлыг гаргах Нэг сэдвийн талаарх хүмүүсийн дэмжсэн болон эсэргүүцсэн үзэл бодол, түүндээ ашигласан баталгаа нотолгоо уншиж, судлах - Дэмжсэн болон эсэргүүцсэн үзэл бодлоо илэрхийлэхдээ ямар баримт нотолгоо ашигласныг ялгах - Баримт ба үзэл бодлыг ялган тэмдэглэх, тайлбарлах - Тэрхүү ялгаатай үзэл бодлоос дүгнэлт хийж оновчтой шийдвэр гаргах - Дэмжсэн санааг илэрхийлэхдээ дэмжиж байна, сайшаалтай байна, зүйтэй гэж бодож байна гэсэн үг хэрэглэдгийг мэдэх - Эсэргүүцсэн санаагаа илэрхийлэхдээ, зохисгүй гэж бодож байна, эсэргүүцэж байна, байх боломжгүй, таатай биш байна гэх мэт өнгө аяс оруулан илэрхийлэх - Эсрэг тэсрэг үзэл бодлын дундаас тэнцвэртэй ямар шийдвэр гаргаж болох талаар ярилцах Эдгээр ялгаатай үзэл бодлын талаар өөрийн байр сууриа илэрхийлэх	- Нэг сэдэвтэй боловч өөр өөр талаас нь ялгаатай үзэл бодол илэрхийлсэн зөрчилтэй сэдвүүд
---	---	---

Багшийн анхаарах зүйл:

5.2д. Бусдын үзэл бодлыг дэмжсэн, эсвэл эсэргүүцсэн утгатай захидал бичих гэсэн суралцахуйн зорилттой холбоотой. Энэ суралцахуйн зорилтын хүрээнд нэг сэдвийн талаар олон талаас нь харж ялгаатай үзэл бодлуудыг уншиж, өөрөө тэдгээр үзэл бодлуудаас алийг нь дэмжиж байгаагаа илэрхийлэх, аливаа юмыг олон талаас нь харж, тэнцвэртэй зөв шийдвэр гаргах алхамд суралцана. Мэдээллийн эрин зуунд олон төрлийн мэдээллээс өөрийн дүгнэлтийг хийж, зөв шийдвэр гаргах чадвар чухал тавигдаж байгаа. Тиймээс багш эерэг болон сөрөг талаас үзэж болох сэдэв сонгон авч аливаа зүйлийг тэнцвэртэйгээр харж, ярьж, бичих сургахад үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

5.1и. Зохиолчийн санааг мэдэрч, уран унших	Шүлгийн утга санааг ойлгож, уран сайхныг мэдрэхийн тулд: 1. Шүлгийг чанга дуудан дахин дахин унших 2. Уншихдаа өөрийнхөө дуу хоолойг сонсох 3. Нүдээ аниад шүлгийн агуулгыг дүрслэн бодох 4. Дүрслэн бодсоноо зургаар илэрхийлэх 5. Зурсан зургаар дамжуулан өөрт юу мэдрэгдсэн, тэрхүү мэдрэмж нь шүлгийн	- Хүүхдэд зориулсан, уран хэллэг сайтай, ойлгоход амар шүлгүүд - Сурагчдын цуглуулсан шүлгийн сан
--	---	--

	ямар ямар үг, хэллэгтэй холбоотой болохыг тайлбарлан ярих 6. Шүлэгт байгаа өөрийн анхаарлыг татсан, сонирхолтой үг хэллэг, дүрслэлийг зурж тэмдэглэж, ямар утга илэрхийлж байгааг ярилцах, тайлбарлах 7. Зохиолч энэ шүлгийг яагаад бичсэн юм бол? 8. Энэ шүлгээрээ дамжуулан бидэнд юуг мэдрүүлэхийг хүссэн юм бол гэдгийг эргэцүүлэн бодож, таамаглах Сонгосон шүлгээ цээжлэн тод, уран яруу уншиж сурахын тулд: 1. Цээжилсэн шүлгээ бусдад уншиж өгөхийн тулд олон давтан уншиж бэлтгэх 2. Найз нарынхаа өмнө шүлгээ уншихдаа утгыг ойлгосны үндсэн дээр дуу хоолойны өнгө, биеийн хөдөлгөөн, нүүрний хувирлаа тохируулах 3. Бусдыгаа шүлэг уншиж байхад нүдээ анин сонсож, утга санааг нь ойлгохыг хичээх 4. Бусдын уншсан шүлгийн талаар мэдрэмжээ илэрхийлэх, асуулт асуух, үнэлгээ өгөх 5. Зохиолчдын болон нэрт жүжигчдийн уншсан шүлгийг сонсож, шүлэг унших аргаас суралцах 6. Шүлгийг бүтнээр унших, найзтайгаа хамтран бадаг бүрээр хэсэглэн унших	- Монголын болон дэлхийн шилдэг яруу найргаас - Монголын шилдэг яруу найраг. Уб., 1981. - Дэлхийн хүүхдийн шилдэг яруу найргийн дээж I боть. Уб., 2012. - Шүлгийн утга санаа, уран дүрслэлийг буулгасан зураг 
--	--	---

Багшийн анхаарах зүйл:

Энэхүү суралцахуйн зорилт нь уншлагын 4 чанартай холбоотой юм. Бага ангид “ЗӨВ УНШИХ, ХУРДАН УНШИХ, ОЙЛГОЖ УНШИХ, УРАН УНШИХ” гэсэн шаардлага бүхий чадваруудыг цогцоор нь эзэмшүүлэхийг зорихдоо дарааллыг харгалзаж байгаа билээ. Өөрөөр хэлбэл уран уншихын тулд ойлгож уншсан байх хэрэгтэй, ойлгож уншихдаа хурдан унших арга барилтай болсон байх, хурдан ойлгож уншихын тулд авиа, үсгээ зөв дуудан унших шаардлагатай юм. Тиймээс уран уншиж байгаа чадварыг үнэлэхдээ шүлэг дэх үгээ зөв дуудаж байна уу, үг бүрийн утгыг ойлгож байна уу, зохиолчийн санааг мэдэрсэний үндсэн дээр уран уншиж байна уу гэсэн шалгуурыг хичээлийн зорилго болгох учиртай.

Сурагчдаар олон шүлэг цээжлүүлэх гэж зорихоос илүүтэй шүлгийнхээ утга санааг ойлгох, өвөрмөц дүрслэл, үг хэллэгээр дамжуулан ямар утга санаа илэрхийлснийг ойлгох арга барилд сургах нь чухал юм. Утга санааг нь ойлгохгүйгээр цээжлэх нь сурагчдад бодитой чадвар болж буухгүй, тухайн үедээ багшдаа шалгуулж дүн авах төдийхнөөр өнгөрөх нь элбэг байдаг. Уран сайхныг илэрхийлж унших гэдгийн хүрээнд шүлгийнхээ утга санааг бүрэн ойлгосны дараа түүнийгээ бусдад ойлгогдтол уншиж, илэрхийлэх гэдгээ ойлгоно. Нэгэнт шүлгээ сайн ойлгосон хүүхэд аяндаа шүлгийн хэмнэл, өргөлт, зогсоцыг тохируулан хийж, тэр ч бүү хэл биеийн хөдөлгөөнөө аяндаа тохируулан хийж уншдаг. Тиймээс хүчээр нэг төрлийн хөдөлгөөн хийлгэж, нэг хэмнэлээр уншуулах биш, хүүхэд бүр өөрийн ойлгож, мэдэрснээ бусдад өөрийн арга барилаар илэрхийлэх боломжийг бүрдүүлэхийг чухалчлаарай. Бас сурагчдад сонирхсон шүлгээ сонгон цээжлэх, сонгон унших боломжийг бий болгож, сурагчдаар шүлгийн сан бүрдүүлэх хэрэгтэй. Сурагчид бусдын өмнө уншихаас ичих, цээжилснээ мартаж зэрэг тохиолдол элбэг тохиолддог бөгөөд энэ үед багш нь урам өгөх, дэмжих, ганцаарангаар нь уншуулах, өөрийг нь бусдын өмнө уншихад бэлэн болтол тодорхой хугацаа өгч, дэмжлэг үзүүлээрэй.

Эхийн далд утгыг бүтээлчээр ойлгох

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
5.1к. Үйл явдал хаана, хэзээ өрнөж байгааг ургуулан бодож төсөөлөх	1. Үлгэрийг сонсоод, үйл явдал болж буй газар орон, цаг хугацааг төсөөлөн бодож, төсөөлснөө илэрхийлэх 2. Үлгэр, өгүүллэг гэх мэт уран зохиолын эхийг уншихын өмнө, гарчгаас ургуулан ямар үйл явдал болох тухай төсөөлөн бодох. Ингэхдээ: - Зохиолын үйл явдал хаана өрнөх бол? - Үйл явдал, хэзээ, хэдийд өрнөх бол? - Цаг агаарын байдал нь ямар байх бол? гэсэн ерөнхий асуултын дагуу төсөөлөн бодох <i>Жишээ нь: “Асар шиг том шүхэр” гэсэн өгүүллэг уншихын өмнө дээрх асуултын дагуу сурагчид төсөөлөн бодож болох юм? Зохиолын үйл явдал бороотойд болох юм байна. Бороо орж байгаа болохоор зун юм уу, намрын улирал байх. Үйл явдал болсон газар нь жижигхэн тосгон, том хот уу, ууланд уу, далайд уу, хөдөө газар уу гэх мэтээс шалтгаалаад баатрууд нь ямар үйл хөдлөл хийх, ямар үйл явдал болохыг чөлөөтэй сэтгэн, төсөөлж болно.</i> 2. Уншихдаа зохиолд дүрслэгдэж байгаа орон байр, цаг хугацаа, цаг агаар, эд юмсыг нүдээ анин төсөөлөн бодох - Төсөөлөхдөө нүдэндээ юу харагдсаныг зургаар илэрхийлэх 3. Яагаад ийнхүү төсөөлснөө зохиолын үг хэллэг, өгүүлбэр, дүрслэлд үндэслэн тайлбарлах Бүтээлч үйл ажиллагаа: - Зохиолын орчныг бүрдүүлж байгаа дүрслэлүүдийг хэрхэн мэдэрч, хүлээж авч байгаагаа дараах асуултын дагуу тодорхойлох • Чамд юу харагдаж байна вэ? • Чамд юу сонсогдож байна вэ? • Чамд юу мэдрэгдэж байна вэ? • Чамд юу амтагдаж байна вэ? • Чамд юу үнэртэж байна вэ? - Зохиол эхлэхээс төгсөх хүртэл зохиолын орчин хэрхэн өөрчлөгдөж хувирч байгааг харьцуулах - Зохиолыг уншиж байхад ямар уур амьсгал (таатай, таагүй, баяртай, гунигтай, аймшигтай, хөгжилтэй, уйтгартай гэх мэт) мэдэрснээ ярьж илэрхийлэх	- Хот, хөдөө, гэртээ, сургууль дээрээ, дэлгүүрт, кино театрт, тоглоомын талбайд гэх мэт орон байрыг тодорхой дүрсэлсэн эх - Өглөө, өдөр, орой шөнө гэсэн өдрийн аль нэг хэсэг, өвөл, зун, хавар, намар улирал, шинэ жил, наадам, хичээлийн шинэ жил, цагаан сар, төрсөн өдөр гэх мэт цаг хугацааг тодорхой дүрсэлсэн эх - Цастай, бороотой, шуургатай, нарлаг, хүйтэн, халуун, сэрүүхэн гэх мэт цаг агаарын байдлыг дүрсэлсэн эх - Сурагчдын ургуулан төсөөлөн бодох, түүнийгээ үгээр илэрхийлэх чадварыг хөгжүүлэхэд туслах танил ба танил бус орчны зураг - Эхийн орчныг өөрчлөн бичихэд хэрэг болох түлхүүр үгс
Багшийн анхаарах зүйл: Төсөөлөх чадвар нь сурагч хэр зэрэг өөрийн оюун санаагаар хэр зэрэг ургуулан бодож байгаатай холбоотой оюуны үйл юм. Төсөөлөх, таамаглах оюуны үйл нь унших чадвар дотроо бүтээлч байдлаараа ялгарна. Учир нь хүүхэд өөрийнхөө ойлголт, өөрийн мэдрэмж, өөрийн хандлагаараа уншиж байгаа эх зохиолоо ойлгодогтой холбоотой. Эхийн орчин нь тухайн эхийг бүрдүүлдэг үндсэн хэсэг юм. Ерөнхийд нь эхийн цаг хугацаа, орон байрыг хамааруулан үздэг боловч зохиолыг хөгжилтэй, уйтгартай, өрөвдөлтэй, сонирхолтой болгоход орчны дүрслэл маш чухал юм. Зохиолыг уншаад орчныг төсөөлөн бодох тэгэхдээ ямар үгээр дамжуулан орчныг төсөөлснөө ярьж тайлбарлах нь зохиолын үг хэллэгийг задлан ойлгох, орчин бүрдүүлж бичих аргад сурахад чухал үүрэгтэй.		

Зохиолын орчныг төсөөлөн бодуулахын тулд зохиолын уншсан хэсгээ нүдээ анин дүрслэн бодох зохиолыг уншихад юу амтагдаж, сонсогдож, мэдрэгдэж, үнэртэж, харагдаж байгааг тодорхойлох, улмаар өөрөө орчин бүрдүүлж өөрчилж бичих үйл ажиллагааг хийх хэрэгтэй

5.1л. Онъсогоын далд утгыг үндэслэлтэй таамаглах	1. Онъсого унших 2. Онъсогоын хариунаас юмс үзэгдлийг ямар шинжээр нь адилтгаж онъсоголсныг ажиглах, дүрслэн бодох 3. Дүрслэн бодсоноо зургаар илэрхийлэх 4. Зурсан зургаа тайлбарлан ярих Онъсогоын далд утгыг таамаглахын тулд: - Онъсогод дүрслэгдсэн зүйлийг хариуг дүрсэлсэн зурагтай харьцуулан ажиглах - Онъсогод өнгө, хэлбэр, тоо, орон байр, үйл хөдөлгөөн гэх мэт юмсын ижил төстэй шинжийг дүрсэлдгийг ажиглаж олох - Онъсогоын хариулт байж болох хэд хэдэн зургаас хариуг таамаглаж, тайлбарлах Онъсогог таахдаа: - Онъсогоо анхааралтай уншина. - Үг үгээр нь эсвэл мөр мөрөөр нь ямар шинжтэй зүйлийг таалгаж байгааг бодох - Онъсогоын хариу юу юу байж болохыг таамаглах Аль нь хамгийн оновчтой хариулт болохыг сонгож, батлах	- Сурагчдын цуглуулсан төрөл бүрийн онъсого, хэлц үг, “Ертөнцийн гурав”-ын сан - Амьтны болон эд юмсыг өнгө, тоо, дүрсээр онъсоголсон онъсого - Нэг сэдэвтэй онъсогоуд болон онъсогоын хариуны онцлог шинжийг тусгасан мэдээллүүд - Онъсогоор хийсэн тулгуур бичиглэл ба оюуны зураглал Онъсоготой холбоотой зургууд
--	--	---

Багшийн анхаарах зүйл:

Далд утга гэдэг нь онъсогоын хариу юм. Хүүхэд онъсого таахдаа шууд хариу сонсоод өнгөрөх биш далд байгаа юмс үзэгдлийг онъсоголохдоо ямар шинжээр нь адилтган, далдлан онъсоголсныг таамаглаж ярилцах нь хичээлийн гол үйл ажиллагаа.

Сурах үйл ажиллагаа хэсэгт зөвлөсөн үйл ажиллагааг сурагчдаар дахин дахин нухацтай хийлгэх хэрэгтэй. Энэ нь онъсого таахдаа үг өгүүлбэр бүрээр нь задлан шинжилж, учир утгыг нь тайлж сурахад чиглэгдсэн. Эхний ээлжинд онъсогог хариутай нь өгч яагаад үүнийг ингэж онъсоголсон юм бол гэдгийг нь тодорхой тайлбарлаж сурах хэрэгтэй. Дараа нь онъсого таахдаа олон хувилбар дундаас хариуг сонгож батлах, цаашлаад онъсогог сонсоод эсвэл уншаад хариуг таамаглах гэх мэтээр үйл ажиллагааг хөнгөнөөс хүнд рүү нь чиглүүлэн хийгээрэй. Монгол ардын зарим онъсогоуд дүрслэл нь тодорхой биш зохиомол үг ихтэй байдаг болохоор таахад хүндрэлтэй байдаг тул аль болох дүрслэл сайтай сурагчдад таах боломжтой хялбар онъсогог сонгох хэрэгтэй. Анхнаасаа хүнд онъсого тааж эхэлвэл сурагчдын сонирхол буурч, идэвхгүй болох талтай байдаг. Багш сурагчдаар онъсогоын сан бүрдүүлэх нэг зүйлийн тухай олон онъсогог харьцуулан ярилцах, онъсогог зургаар илэрхийлэх, оюуны зураглал хийх гэх мэтээр бүтээлч, сурагчдын сэтгэн бодох чадварыг хөгжүүлсэн үр дүнтэй сургалтыг зохион байгуулаарай.

ХОЁР. БИЧИХ ЧАДВАР

5 дугаар ангийн сурагчдын бичих чадварт тавигдах шаардлага: Үг холбон, өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих, өгүүлбэр, эхийг догол мөрөөр зааглан, дэгийн дагуу хичээнгүй алдаагүй зөв бичих

Энэхүү шаардлагыг бичих чадвар эзэмшүүлэх ээлжит хичээл бүрд хэрэглэнэ.

Тус ангид өгүүллэг, үлгэр, шүлэг, онъсого зэрэг уран зохиолын эхийг дуурайн эсвэл зохиож бичихээс гадна захидал, өдрийн тэмдэглэл, зар сурталчилгаа, мэдээ зэрэг хэрэглээний эхийг зохиож бичих чадвар эзэмшинэ. Эдгээр эхийг зохиож бичихдээ дараах бичих арга барилын дарааллаар бичиж сурахыг анхаарна уу.

Бичих арга барил эзэмшүүлэх үйлийн алхмууд	
Зөв бичих	- Залгавар залгахад эгшиг гээгдэх, гээгдэхгүйг мэдэж, бүлэглэх, тайлбарлах - Эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэх, зөв бичих - Үйл үг үүсгэх "-л" дагаврын дүрмийг мэдэж, зөв бичих
Бичих санаагаа олох, төлөвлөх	- Бичих сэдвээ сонгох - Бичих санаагаа эргэцүүлэн бодох, бусадтай хэлэлцэх - Бичих төлөвлөгөө, ерөнхий зураглал, бүдүүвч гаргах, санаагаа холбох, тэмдэглэл хийх, хэлэлцэх - Бичихдээ ашиглах баримт, мэдээллээ олж, төлөвлөх
Санаагаа зохиож, байрлуулан бичих	- Төлөвлөсний дагуу ноороглон бичих - Эхийн хэсгийг холбон бичих (холбох хэрэглүүр ашиглах) - Санааг холбож үргэлжлүүлэхдээ ба, бөгөөд, бас, түүнчлэн гэсэн холбоосыг солин найруулах
Бичсэнээ хянах сайжруулах	- Бичсэн зүйлийнхээ утгыг нягталж дахин унших - Зөв бичгийн дүрмийн болон найруулгын алдааг хянаж, засах Хэн нэгэн уншиж, зөвлөгөө авах - Бичсэнээ нягталж дахин сайжруулах (үг, өгүүлбэр, хэсэг нэмэх, хасах, өөрчлөх) - Эцсийн байдлаар бичиж дуусгах

Бичих санаагаа олж, төлөвлөсний дараа ноороглуулж сургах хэрэгтэй. Нооргийг хүүхдийн дэвтэрт хийлгэнэ. Ноороглосны дараа найруулгын болон зөв бичгийн дүрмийн засвар хийнэ. Найруулгын засвар хийхдээ дараах шалгуурыг хэрэглээрэй.

- Бичсэн эхийг уншихад ойлгомжтой байна уу?
- Үг, өгүүлбэр нэммээр байна уу? Ямар үг өгүүлбэр нэмэхээ бодоорой
- Үг, өгүүлбэр хасмаар байна уу? Ямар үг өгүүлбэр хасахаа бодоорой
- Үгийн байрлалыг солимоор байна уу?
- Үгийг солих уу?

Зөв бичгийн дүрмийн засвар хийхдээ дараах байдлаар хийж болно. Багш та өөрийнхөө арга зүйгээр нэмж ажиллаж болно.

- Бичих гэсэн зорилготой ээлжит хичээл бүр дээр хүүхдийн зохион бичсэн, найруулж бичсэн байдлаас нь алдсан үгийг **ИЛРҮҮЛНЭ**.
- Илрүүлсэн үгээ **ОНОШИЛНО**. Ямар дүрэмтэй холбоотой болохыг оношилно гэсэн үг.
- Буруу бичсэн үгийг зөв болгон, холбогдох зөв бичгийн дүрмийн утга учрыг сурагчдын оролцоотойгоор **ТАЙЛБАРЛУУЛНА**. Тухайлбал, зөв болон буруу бичсэн үгсийг харьцуулж яагаад зөв болох, яагаад буруу болох, аль үсэг зөв бичихэд нөлөөлж байна /явахын, явхын/ гэх мэтээр ажиглах, харьцуулах чадварыг хөгжүүлэх зэргээр сурагчийн оролцоо, үйл ажиллагааг идэвхжүүлэх арга зам хайхыг зөвлөж байна.
- ТАЙЛБАРТАЙ ДАСГАЛЫН АРГА**⁸ хэрэглэж, сурагч дүрмийн зүй тогтлыг тайлбарлах нь чухал тул багш чиглүүлэх асуултаа тодорхой, оновчтой боловсруулах шаардлагатай юм. Жишээ нь,
Буруу бичсэн үгийг яаж зөв болгосон байна вэ? Сурагч Батын бичсэн нь зөв юм. Яагаад зөв бэ? Буруу хувилбарыг яагаад буруу байгааг тайлбарлана уу. Дүрмийг уншаад тайлбараа нягтална уу. Тайлбарласан дүрмээ бусдад ойлгомжтой болгохын үүднээс найруулж бичиж үзнэ үү гэх мэт асуултын хувилбар байж болно. Нэг ангид 14 нэгж хичээлийг судална гэвэл 14 удаагийн давтамжтай бичих зорилготой хичээл төлөвлөх тул тэр бүрд нь тухайн ангид эзэмших ёстой зөв бичгийн дүрмийн чадваруудыг дахин дахин давтан ярилцах, сурагчдыг өөрсдөөр нь үнэлүүлэх зэргээр ажиллуулж болно. /Мэдээж, нийтлэг алддаг дүрэм бүхий үгсийг сонгож ажиллах нь зүй/ Жишээ нь, Батын бичсэн эхийг 5 хүүхэд шалгана уу. Шалгахдаа бидний үзэж байсан “Гээгдэх эгшгийн дүрэм”-ээр бичсэн үгийг сонгоно уу. Яагаад зөв гэж үзэв? гэх мэтээр бичих арга барилыг дэмжсэн асуултыг хэрэглэхийг санал болгосон. Бага боловсролын зорилго бол сурах арга барил эзэмших явдал юм.

⁸ “Тайлбартай дасгалын арга, 50 жил”, ред.С.Жагдал, Уб., 2016 он

5. Тайлбартай дасгалын аргыг хэрэглэн дүрмийн зүй тогтлыг тайлбарлуулсны дараа АЛДСАН ҮГИЙГ ОРОЛЦУУЛЖ, ӨГҮҮЛБЭР ЗОХИОЛГОХ дасгал ажиллаж, дүрмийн бататгалыг хийнэ.
6. АЛДСАН ҮГИЙГ ОРОЛЦУУЛЖ, цээж бичиг хийх дасгал ажиллана.
7. АЛДСАН ҮГИЙГ ОРОЛЦУУЛЖ, дүрмийн бататгал дасгал хийлгэнэ. Ангийнхаа сурагчдын ямар дүрмийг алдаж байгааг судлах нь чухал. Сурагч өөрийн алддаг дүрэмтэй холбоотой дасгалыг сонгож ажиллахад багш бүр анхаараарай. Энэ нь сурагчийн хэрэгцээн дээр суурилсан хөтөлбөрийн үзэл баримтлалтай холбоотой билээ.

Тухайн дүрэмтэй холбоотой үгсийг бүлэглэж, нүдлэх тогтоолгох аргыг хэрэглэх нь бага ангид үр дүнтэй. Хэрэв унших болон сонсох-ярих чадвар нь даасан ангийн хүүхдэд тодорхой хэмжээгээр илэрч, зохих хэмжээний үр дүн гарч байвал дараа дараагийн нэгжийн хичээлийг зохион байгуулахдаа бичих чадварыг хичээлийнхээ цагийг ихэсгэж, унших, сонсох-ярихын чадварыг багасгаж болох юм. Бүтэн жилд эзэмших чадварыг бүхлээр нь харах нь чухал тул хүүхдийнхээ хурд, хүлээн авах чадвар, суралцах явцыг ажиглаад, нэгж бүр дэх унших, сонсох-ярих, бичих зорилго бүхий хичээлийнхээ цагийг багш зохицуулж болно гэсэн үг. Тиймээс дүрэм дээр тогтож ажиллах шаардлагатай гэж үзэж байгаа бол “бичих зорилготой” хичээлийн дараа 1-2 цаг дан дүрмийн дасгалыг ажиллуулж, нүдлүүлэх ажил өгч болох юм. Хамгийн гол нь нүдэлсэн үгс юугаараа төстэй, ямар дүрмийн дагуу бичигдсэний утга учрыг тайлбарлаж чаддаг байх нь хичээлийн үр дүн болох учиртай.

ЗӨВ БИЧИХ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
5.2а. Залгавар залгахад эгшиг гээгдэх, гээгдэхгүй тохиолдлыг мэдэж, бүлэглэх, тайлбарлах	1. Танил бус хүндэвтэр эхийг сонсоод, уншаад утга санааг бичихдээ зөв бичгийн дүрмийн алдаагүй бичих 2. Гээгдэх ба гээгдэхгүй эгшгийн дүрмээр үг бүлэглэх, хэрэглээний өгүүлбэр, эх дээр суурилан нүдлэн тогтоох 3. Ямар зүй тогтлоор гээгдэж байгааг тайлбарлах, жишээ татах, уг дүрмийн бичлэгтэй ижил үгийн сан бүрдүүлэх 4. Ямар зүй тогтлоор гээгдэхгүй байгааг тайлбарлах, жишээ татах, уг дүрмийн бичлэгтэй ижил үгийн сан бүрдүүлэх 5. Тайлбарлахдаа бүдүүвч диаграмм хүснэгтийг хэрэглэх	- “Зөв бичих учиг” УБ, 2008 - “Монгол үсгийн дүрмийн толь” УБ, 1983 - “Сурагчийн тайлбар толь” УБ, 2011
5.2б. Үйл үг бүтээх “-л” дагаврын дүрмийг мэдэж, зөв бичих	1. Нэр ба үйл үгийн утгын ялгааг ажиглаж сурах 2. Үгсийг утгаар бүлэглэж сурах 3. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг үүсгэх –л дагаврыг зөв бичиж сурах 4. Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд – л дагаврыг зөв бичих 5. Эгшгээр төгссөн үгэнд үйл үг үүсгэх – л дагаврыг зөв бичих	- Ижил нэрийн толь - Цахим болон биет үзүүлэн

Багшийн анхаарах зүйл:

Зөв бичгийн дүрмийг багш өөрөө хэлж заахаасаа илүү дүрмийн зүй тогтлыг сурагчдаар ажиглуулж, тайлбарлуулах арга зүйг голлон хэрэглэнэ. Ингэхдээ үгийн бүтцийг задлах үйл дээр тулгуурлан ажиллахыг зөвлөмжилж байна. Практикаас харахад үгийн бүтцийг заах, язгуур гэж ангилуулах зэргээр хэт хэлзүйжсэн хандлагаар зөв бичих үйлийг удирдаж байгаа нь учир дутагдалтай байна. Идэвхтэй язгуур, идэвхгүй язгуур гэдэг ойлголтыг хүүхэд мэдэх ёстой гэхээсээ илүү үгийн бүтцийн дагуу зөв бичгийн дүрмийг ТАЙЛБАРЛУУЛАХыг анхаарна уу. Жишээ нь, амжилт гэдэг үгийн язгуур нь амж уу, ам уу гэж асуух нь гол болохоос амж гэдэг нь идэвхтэй язгуур юм гэж заахгүй юм. Амж гэж хариулж байгаа хүүхдээс яагаад ингэж хариулсныг эргэцүүлж тунгаан бодуулах хэрэгтэй. Тухайн үгийн үндсэн утга нь мөн үү гэсэн чиглүүлгээр үгийн язгуур утган дээр ажиллана. Зөв бичүүлж сургахад бас нэг асуудал бол оноосон нэрийг том үсгээр бичих явдал юм. Дараах аргачлалаас “Том үсгээр бичнэ” гэж багш зааж, цээжлүүлэх биш мэдлэг бүтээлгээ аргаар хэрхэн ажиллаж болохыг анзаарч харна уу.

Зөв бичих дүрмийг мэдэх, зөв бичих

Зөв бичих дүрмийн мэдлэг олгохдоо багш зөв бичих дүрмийг шууд хэлж өгөхөөс татгалзах хэрэгтэй.

Аль болохоор мэдэхгүйгээс мэдэх хүртэл сурагчид өөрсдөө мэдлэг бүтээх замаар ажиллуулбал хүүхдийн сурах арга барил эзэмших явц сайжирна. Мэдлэг бүтээлгэхдээ доогуур нь зурах, өнгөөр тодруулах, дугуйлах, ангилж бичих, үгсийг томоор бичих зэргээр энгийн зүйлийг хийлгэхээс эхлээд алхам алхмаар өөрсдөө учрыг олж сурах барилд сургах хэрэгтэй.


Мэдлэг ойлголтыг бататгахын тулд уг мэдлэг чадвартай холбоотой төрөл бүрийн энгийн даалгавруудыг гүйцэтгэнэ. Үүний тулд сурах үйл ажиллагааны хэсэгт хэд хэдэн хийж болох үйл ажиллагааг бичсэн байгаа. Түүнээс тухайн нөхцөл байдалдаа тохируулан сонгож хэрэглэнэ. Гэхдээ нэг биш хэд хэдэн үйл ажиллагааг сонгож хэрэглэх бөгөөд аль болохоор өөр өөр байдлаар хийлгэхээр сонговол хүүхдэд сонирхолтой байх болно. Жишээ нь: доогуур нь зурах, тодруулах, карт, өргөх наах, тоглох, бинго тоглох, үгийн сүлжээ таах гэх мэт

Зөв бичих дүрмийг ойлгуулахдаа:

- Аливаа хэл зүйн ойлголт дүрмийг багцлан ойлгуулах

Тэдгээрийг хэрэглээ болгох, үгсийг хувиргах явцад суралцагч дүрэм бодохгүйгээр зөв бичих, дадал хэвшлийг олж авах нь чухал гэдгийг анхаарна. Зөв бичиж сурах нь дахин давтан үйлийн явцад суралцах үйл ажиллагаа мөн юм.

Энэ чадварын хувьд дүрэм цээжлүүлэх бус зөв бичих нь суралцагчийн дадлага чадвар болж, цаашид хэрэглээ болоход анхаарлаа хандуулна. Алдаагүй зөв бичиж сурах дадлага ажлыг сурагчдын ярианы болон зөв бичих дүрмийн алдаан дээр суурилан дасгал дадлага хийх нь зөв бичиж сургахын нэг үндэс болдгийг анхаарна. Бичиж байгаа зүйлийн утга, агуулга, учир холбогдлыг сайн ойлгосон байх ёстой. Зарим сурагчид уул үг буюу өгүүлбэрийн утга учрыг ойлгоогүй учраас буруу бичих, алдаатай бичихэд хүрдэг байна. Иймд хуулан бичих, цээж бичиг, бичгээр гүйцэтгэх дасгалын аль нь ч байсан үг нэг бүрийн утгыг ойлгуулах шаардлагатай байдаг. Хамгийн сайн үр дүнд хялбархан хүрч болох арга замыг хамтран эрж хайн сурагчдын сурах үйл ажиллагааны алхам бүрийг хэрхэн дэмжих шийдлүүдийг тунгаан бодож, хэрэглэгдэх материалуудыг бэлтгэн, хичээлийг төлөвлөх нь хичээлийн бэлтгэлийн мөн чанар юм.



Энэ зүй тогтлыг хүүхдэд багцалж өгвөл илүү үр дүнтэй юм. Тэгээд хүүхдийг хийх явцад нь сургахад голлон анхаарна.

Явцын үнэлгээ. Энэ чадварын хүрээнд багш явцын үнэлгээний үйл явцад суралцагчийг өөрсдийг нь оролцуулах аргыг түлхүү хэрэглэж болно. Үнэлгээний үйл явцад оролцсоноор, сурагчид тухайн сэдвийн хүрээнд мэдсэн, сурснаа хэрхэн үнэлүүлсэн болон өөрсдийн сурах үйл ажиллагааны талаар илүү гүнзгий ойлголттой болно. Энэ нь сурагчдад “сурах гэж юу вэ” гэдгийг ухамсарлахад туслах ба ингэснээр тэд өөрийгөө сайн суралцаж байгаа эсэхэд дүгнэлт хийх чадвартай болно. Зөв бичих чадварын үр дүн ихэвчлэн суралцагчийн бичсэн үгсийн зөв буруугаар хэмжигддэг тул, энэ чадвар дадал болсон эсэхээр хэмжигддэг. Зөв бичих чадварын хувьд амжилтын шалгуурыг гаргаж өгөх нь илүү ач холбогдолтой байдаг. Сурагчид нүдлэн тогтоох, зөв бичих дадал хэвшлийг олж авах түгээмэл хэрэглэгдэх үгс бол амжилтын шалгуурын эхний алхам байж болно.

Дараагийн шалгуур нь тэдгээрийг өгүүлбэр ба эхэд зөв хэрэглэж сурах чадвар дадлаар хэмжигдэнэ. Зөв бичиж сурах чадвар дэдлыг ээлжит хичээл бүрийн төгсгөлд хэмжих, ямар өөрчлөлт гарсан байхыг хүлээж байгаа буюу ямар хэсэг ажлыг гүйцэтгэвэл амжилттай байхыг нарийвчлан тогтоодог. Эдгээр нь суралцагчийн мэдлэг, ойлголт дээшилсэн гэдгийг харуулах хэмжигдэхүйц үзүүлэлттэй байна.

Амжилтын шалгууруудыг хичээлийн явцад болон төгсгөлд нэгдсэн хэлэлцүүлгийн үеэр дахин авч үзнэ. Дараах зүйлүүдийг мөрдлөг болгон хийж чадвал би даалгавраа амжилттай гүйцэтгэж чадна.

Эхийн түвшинд	- Эхийн хэсгүүд, түүний дотроос харилцан яриа, болон төрөл бүрийн дүрслэлд цэг тэмдгийг хэрхэн хэрэглэж сурах - Эхэд догол мөрийг зөв гаргаж бичих - Танил бус хүндэвтэр эхийг уншиж сонсоод зөв бичгийн алдаагүй бичих
Өгүүлбэрийн түвшинд	- Аль өгүүлбэрийг догол мөрөөс эхэлж бичихээ мэддэг байх - Өгүүлбэрт цэг тэмдгийг зөв хэрэглэх
Үгийн утгын түвшинд	- Нэр ба үйл үгийн утгын ялгааг гаргаж зөв бичиж сурах - Эхний үеэр товчилж бичих - Оноосон нэрийг товчилж бичих - Ямар үгийг хэдийд товчилж бичдэгийг мэдэх, хэрэглэх - Товчилсон нэр, дэлхийн зарим улс орны нэрийг бичиж сурах
Үгийг хувиргаж бичих	- Гээгдэх ба гээгдэхгүй эгшигтэй үгийг зөв бичиж дадах - Зөв бичгийн дүрмээр үг бүлэглэх - Үйл үг бүтээх – л дагаврыг зөв бичиж сурах

Эдгээр нь 5 дугаар ангийн сурагчдын хувьд зөв бичихийн хувьд эзэмших нэлээд ерөнхий чадвар болно. Эдгээрийг тодорхой ээлжит хичээлийн үед хэрхэн шалгуур болгож авч үзэх вэ? Тухайлбал:

Сургуулиа төгссөний дараа баяр бахдалын сэтгэлээр ээждээ захидал бичив.

Ном их уншсанаар мэдлэг нэмэгдэнэ.

Энэ хоёр түүвэр өгүүлбэрийн түвшинд заримдаг ба эгшигт гийгүүлэгч эгшигтэй бичигдэх тохиолдлыг сайн мэдэж байвал алдаагүй бичиж чадна. Сурагчид өөрсдийнхөө эсвэл өөр сурагчийн гэрийн даалгавар эсвэл даалгаварт хийсэн үнэлгээг засна. Засалтыг хос хосоороо эсвэл ганцаараа, зөв бичгийг хэрхэн хянах тухай сурагчдын боловсруулсан эсвэл багшийн гаргаж өгсөн зааврын дагуу засна. Ийм тохиолдолд ангийн сурагчид зөв, буруу бичсэнээ хянах, засварлах бүрэн чадвартай болсон байна. Энэ үед алдаатай ба алдаагүй эхийг харьцуулж харах, алдаатай бичсэнийг эрж олох, үгсийг бүлэглэх гэх мэт бүтээлч хэлбэрийн даалгавруудыг хийж болох юм. Хүлээгдэж буй үр дүнг үргэлж суралцагчдад ойлгомжтой байдлаар тодорхойлсон мэдээллийн хүснэгтийг багш ашиглаж болно. Эдгээр хүлээгдэж буй үр дүн/амжилтын шалгууруудыг багшаас гаргаж өгсөн, суралцагчид зохиосон эсвэл сургалтын хөтөлбөрөөс шууд авсан байж болох юм. Зөв бичгийн дүрмийн хувьд сурагчид олон дахин давтан үйлдлээр дадал хэвшил болж сурдагийг насанд хүрэгчид дүрэм бодож бичихгүйгээр алдаагүй бичиж чаддагаас харж болно.

Тиймээс ийм дүрэм бүхий үгсийг бүлэглэх, холбоо үг болон өгүүлбэрт оруулж бичих гэх мэт механик үйлдлүүд энэ чадварын хүрээнд зайлшгүй шаардагдана. Харин дүрэм цээжлүүлэх нь үр дүнгүй ажил болдгийг багш нар анхаарах нь зүйтэй. Тухайлбал: Гээгдэхгүй эгшигийн тохиолдлуудыг дараах байдлаар үгсийг бүлэглэх аргаар нүдлэн тогтоолгож болох ба үүнээс ургуулан төрөл бүрийн бүтээлч дасгал, даалгаврыг төлөвлөж болно.

Жишээ нь: Эдгээр үгсээс дурын 5 үгийг хувирган эвлүүлж утга төгс өгүүлбэрийг зөв бичгийн алдаагүй бүтээж бичих уралдаан зохион байгуулж болно.

Цэцэрлэг, өргөтгөл, боловсрол, чиглэл, самбар: **“Самбараас, боловсролын чиглэлээр цэцэрлэгийн өргөтгөлийг дуусгасан тухай уншив.”**

Өвгөн, тосгон, охин, бодогдоно, дайралдсан, сэтгэл: **“Тосгоны өвгөний сэтгэлээс охиныг аврах тухай бодол салсангүй.”** гэх мэт

1. Өргөтгөл, чадвар, өвгөн, эмгэн, боловсрол, цэцэрлэг, үлгэр, чиглэл, шинэчлэл, өргөн, зүтгэл, хэлбэр, алтлаг, мөнгөлөг, дээлэм, дөрвөн, гурван, арван, бяслаг, түргэн, сэтгэл, нөхөрлөл, салбар, самбар, бөмбөр, тасалбар, хуулбар, огтолбор, татвар, дэвсгэр, бэлтрэг, нүцгэр, явгар, болжмор, тэнгэр, дэргэд, өнгөц, холбоц, бүргэд, мэргэд, мэргэн г.м.
2. Үлэмжхэн, төгссөн, үндсэн, буцсан, нөхцөл, бахдал, түлхсэн, дайралдсан, бяцхан, хэрхсэн, хомсхон
3. Чанар, хувьсгал, мянган, үнэн, чанах, тосгон, санал, онол, хагас, загал, загас, хунар, хонгор, хоног, хөнөг, үнэг, үнэр, цэнэг, ханар, бөөгнөр, магад, сэтгэл

4. Сонин, солир, улир, хувир, суурин, давхих, тавил, зориг, охин, ноднин, авируул, тохируул, зохицоод
5. Янзага, хундага, чогчиг, богширго, эрдэнэ, хэдгэнэ, үзэгдэнэ, бодогдоно
6. Хөвсгөл, Байдраг, Мөрөн, Баатарын, Идэрийн, Улаанбаатар, Орхон
7. Мөөрөх, майлах, урамдах, үргэх, цочих, янцгаах, буйлах, орилох, донгодох, хуцах, улих, жиргэх, мяулах, сургах, байгуулах, дээшлүүлэх, мэдэх, шинжлэх, судлах, дэлгэрүүлэх, бүрэлдүүлэх, хөгжүүлэх, бичих, унших, тэмдэглэх, уламжлах, сайжруулах г.м

Эдгээрээс үлгэр жишээ зохиож бичсэн өгүүлбэрүүдийг шалгаруулах бөгөөд үүнийг ямар шалгуураар гаргаж ирснийг хүснэгтлэн жагсаасан шалгуур үзүүлэлтээс харж болох бөгөөд дараагийн удаа түүнийг сурагчид хэрхэн ашиглаж болохыг жишээгээр тайлбарлаж өгнө. Суралцагчид хэсэг өгүүлбэр зохиож бичсэний дараа өөрсдийн бичсэнийг үлгэр жишээ болсон өгүүлбэртэй харьцуулах ба тэдгээр нь юугаараа ижил, өөр байгааг тайлбарлана.

Амжилтын шалгуурыг хангасан өгүүлбэрүүдийг ангийн буланд байрлуулах нь

суралцагчдад өөрийн ахиц дэвшлийн талаар ерөнхий төсөөлөлтэй болоход тус болно.

Суралцагч өөрийнхөө явцын ахиц өөрчлөлтийг хэмжих чадварын ахицын үнэлгээний хүснэгтийг хүүхэд бүрийн гарт өгч тэд шалгуур бүрийн дараа ахиц дэвшилээ сүүдэрлүүлэн будаж, дараагийн алхмаа дугуйлж болно. Жишээ нь:

Миний зөв бичих чадвар

Өгүүлбэр эхэд догол мөрийг зөв гаргаж бичих	Өгүүлбэр ба эхийн хэсэгт цэг цэгэлэл гэх мэтийг зөв хэрэглэж бичих	Эхийн хэсгүүд, түүний дотроос харилцан ярианд цэг тэмдгийг зөв хэрэглэх	Төрөл бүрийн дүрслэлд цэг тэмдгийг хэрэглэж сурах	Товчилсон үгийг таних	Гадаад үгийг зөв бичих
Бодол санаагаа бичихдээ гээгдэх эгшигтэй үгсийг алдаагүй бичиж дадах	Бодол санаагаа бичихдээ гээгдэхгүй эгшигтэй үгсийг алдаагүй бичиж дадах	Танил бус хүндэвтэр эхийг сонсоод, уншаад утга санааг бичихдээ зөв бичгийн дүрмийн алдаагүй бичих	Гээгдэх эгшигийн дүрмээр үг бүлэглэх	Гээгдэхгүй эгшигийн дүрмээр үг бүлэглэх	Дуудлагын цээж бичгийг хүндэвтэр эх дээр алдаагүй бичиж сурах
Нэр ба үйл үгийн утгын ялгааг ажиглаж сурах	Үгсийг утгаар бүлэглэж сурах	Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгнээ үйл үг үүсгэх —л дагаврыг зөв бичиж сурах	Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд - л дагаврыг зөв бичих	Эгшгээр төгссөн үгэнд үйл үг үүсгэх - л дагаврыг зөв бичих	Дэлхийн зарим улсуудын нэрийг зөв бичих

Явцын үнэлгээнд өөрийн үнэлгээг тохируулан ашиглах нь сурах, сургах үйл ажиллагааг өөрчилдөг. Зөвхөн багш л үнэлгээ хийдэг гэсэн ойлголтыг авч хаяж, сурах үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлж, суралцагчдыг бие даан ажиллах сэдэл тэмүүллийг бий болгодог.

ЗОХИОН НАЙРУУЛЖ БИЧИХ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
5.2в. Эхийн үйл явдлын орчныг өөрчлөн богино өгүүллэг зохион бичих	Эхийн орчныг өөрчлөн бичихийн тулд: 1. Үлгэр, өгүүллэгийн утгыг ойлгож унших, ойлгосноо асуулт зохион ярилцах 2. Эхэд гарч буй дүр, дүрслэл, орчныг мэдэрч унших 3. Эхийн орчныг төсөөлөн бодох 4. Үлгэр, өгүүллэгийн аль хэсэгт ямар шинэ баатар, ямар шинэ орчин нэмэхээ төлөвлөх 5. Баатрынхаа гадаад төрх, зан чанарыг төсөөлөх, дүрслэн бичих 6. Сонгосон шинэ баатар бусад баатруудтай хэрхэн харилцахыг, юу ярихыг төлөвлөх 7. Төлөвлөсний дагуу ноороглох 8. Нооргоо засах - Найруулгын засвар хийх - Зөв бичгийн дүрмийн засвар хийх - Шинэ баатраа дүрсэлсэн эсэх - Зохиолын орчныг өөрчилсөн эсэх 9. Дахин сайжруулж бичих, хичээнгүй бичих Бүтээлч үйл ажиллагаа: 10. Хүншүүлэх аргаар шинэ баатар нэмэхээ төлөвлөх 11. Амьдралд байдаггүй уран сэтгэмжит баатар нэмэхээ төлөвлөх	- Дөрвөн улирал, төл мал, хүн зоны энгийн амьдралын тухай өгүүлсэн төрөл бүрийн эх - Зурагт үзүүлэн - Эхийн орчин, баатрыг дүрслэн харуулахад зориулсан цахим үзүүлэн

Багшийн анхаарах зүйл:

Эх зохиож бичихээс урьд, сурагч өөрийгөө үнэлэх үнэлгээний шалгуурыг гаргаж, тэдний гарт өгсөн байж болно. Тухайлбал: Эхэд шинэ орчныг өөрчлөн бичихдээ:

Ерөнхий үзүүлэлт	Дэд үзүүлэлт	Үнэлгээ
Санаагаа хэр зэрэг гаргасан	Үйл явдлыг сонирхолтойгоор ургуулан бодсон, бүтээлчээр шинэ орчныг дүрслэн төсөөлөн бодож гаргаж чадсан эсэх	
Дүр, дүрслэл хэр зэрэг болсон	Дүр дүрслэлийг хүний сэтгэлд буухуйцаар сонирхолтой дүрслэн бичиж илэрхийлсэн эсэх	
Зөв бичих зүйн хувьд	- Цэг цэглэл, догол мөр зэргийг зөв хэрэглэсэн эсэх - Гээгдэх ба гээгдэхгүй эгшигтэй үгийг алдаагүй зөв бичсэн эсэх	

Богино өгүүллэг хүүрнэн бичүүлэхдээ дараах асуулт, чиглүүлгийг хэрэглээрэй. Харин ямар дэмжлэгийг ямар үзүүлэнгээр өгөхөө багш та нар санаачлаарай.

1. Юуны тухай бичмээр байна вэ? Ямар асуудлыг хөндөж бичих вэ? Сайн найзын тухай, багшийнхаа тухай, нөхөрлөлийн тухай. Эхний асуултыг хэрэглэхдээ багш үйл явдал ургуулан гарахаар сэдэвт зураг хэрэглэвэл илүү дөхөм болно.
2. Уншигчдад чи юу хэлэхийг хүсэх вэ? Чиний зохиосон зохиолыг найз нар чинь уншаад юу ойлгоосой гэж хүсэж байна вэ? Хэлэлцээрэй. Бусдын саналыг сонсоорой.
3. Эхлэл хэсэгтээ хэний юу юуг яаж танилцуулах вэ? Ямар зан чанартай хүмүүс, эсвэл амьтад гарах вэ? Тэд хаана амьдардаг байж болох вэ? Орчныг нь тэмдэг нэрээр дэлгэрүүлж зохиогоорой. Энэ асуултыг тавих үедээ багш тэмдэг нэрийн цуглуулга нөөцтэй байвал сайн байна. Хүүхэд тохирох үгийг хэрэглэн зохиох боломжийг олгохыг санал болгож байна.
4. Гол хэсэгтээ баатруудад юу юу тохиолдсон бол? Тэдэнд ямар нэгэн бэрхшээл гарсан уу? Бэрхшээлээ яаж даван туулсан бол? зохиогоорой. Мөн баатруудад боломж гарсан болов уу? Боломжийг хэр ашигласан бол? Баатрууд хоорондоо юу юу ярьсан бол?
5. Төгсгөл хэсэгтээ уншигчдад, найз нөхдөдөө хэлэх гэсэн санаагааараа дүгнээрэй.
6. Гол хэсэгтээ 1-2 цогцолбороор үйл явдлыг өрнүүлж болно шүү.

7. 1-6 асуултад хариулж төлөвлөж дууссан бол ноороглож бичээрэй. 8. Ноороглосноо засаарай. Эхний ээлжинд найруулгын алдааг хараарай. 5 шалгуур хэрэглээд сурсан гэж үзнэ. Дараагийн ээлжинд зөв бичгийн дүрмийн алдааг хянаарай. Алдсан үгээ олсон бол зөв хувилбартай нь харьцуулан, үгийн бүтцийн дагуу зүй тогтлыг тайлбарлах дасгал ажиллаарай. Алдсан үгээ зөв болгосны дараа ахиж алдахгүйн тулд алдсан үгээ оролцуулж өөр шинэ өгүүлбэр зохиогоорой. 9. Нооргоо засаад, хичээнгүй бичээрэй. 10. Хэн нэгэнд уншин, зөвлөгөө аваарай. 11. Дахин сайжруулж бичиж болно.										
5.2г. Зохиолын санааг нэгтгэн дүгнэн, товчилж бичих	1. Эх зохиолын утгыг ойлгож унших 2. Эхийн агуулгатай холбоотой асуулт зохиож, харилцан ярилцах 3. Нэгтгэн дүгнэж бичихийн тулд цогцолбор бүрийн утгыг ярилцах, гол гол мэдээлэл бүхий санааг тодруулах 4. Гол гол санааг тодруулсан утгуудыг тэмдэглэн бичих 5. Тэмдэглэснээ хураангуйлан дүгнэн ярих, бичих 6. Ноороглох 7. Нооргоо засах Найруулгын засвар хийх Зөв бичгийн дүрмийн засвар хийх Гол санаагаа хураангуйлсан эсэх 8. Дахин сайжруулж бичих, хичээнгүй бичих 9. Бусдад уншин өгч, зөвлөгөө авах	- Сурах бичиг дэх уншсан эх зохиол								
Багшийн анхаарах зүйл: Эх зохиолын үйл явдлыг, утга агуулгыг ойлгосныг шалгах нэг арга бол гол гол үйл явдлыг нэгтгэн хураангуйлан бичих үйл байдаг. Зохиолын гол санааны тухай цөөн өгүүлбэрээр хураангуйлан бичихийг нэгтгэн дүгнэх \Summarizing\ гэнэ. Багш уншсан эхийн цогцолбор бүрд байх утга санааг задлан яриулсны дараа нэгтгэн дүгнэх үйлийг эхлүүлнэ. Сайн задлан уншуулъя гэвэл эхлээд сэргээн санах, дараа нь ойлгох, хэрэглэх, задлан шинжлэх түвшний асуулт зохиож, асуултын дагуу сурагчидтай ярилцсаны дараа нэгтгэн дүгнүүлэхэд анхаарна. Шууд энэ цогцолборт юуны тухай өгүүлж байна вэ гэсэн нэгтгэн дүгнэсэн асуулт асуухгүй гэсэн үг юм. Цогцолбор бүрд байх гол гол утга бүхий үг хэллэг, түлхүүр үгсийг оролцуулан нэгтгэн дүгнүүлээрэй. Энэхүү суралцахуйн зорилт нь 6 дугаар ангид үзэх агуулгын суурь чадвар болох юм. Дунд ангийн багш нар 5 дугаар анги төгссөн хүүхдээс энэ чадварыг эзэмшсэн эсэхийг шалгаж, гарааны үнэлгээ авах учиртай. Хүүхдүүдийн ялгаатай байдлыг харгалзан, 6 дугаар ангид үргэлжлүүлэн хөгжүүлэх үүргийг дунд ангийн багш нар хүлээж байгаа тул суурь чадварыг эзэмшүүлэхийг бага ангийн багш нар 5 дугаар ангид нь анхаарч ажиллахыг зөвлөмжилж байна.										
<table><tr><td>Уншсан эх зохиол</td><td>Нэгтгэн дүгнэсэн нь</td></tr><tr><td>Янзага ишигтэй зэрэгцэн, урд хоёр хөлөө нугалан бохирч, ховдоглон хөхнө. Турь муутай урт цүүцгэр хөл, дэлдгэр том чих, тугал хар нүд, шөмбөгөр хошуутай, бор цоохор толботой, содон сонин хөөрхөн нэгэн амьтан тэдний хонин дотор явдаг болсныг нутгийн хүмүүс шохоорхон өхөөрдөнө.</td><td>Эхээсээ төөрсөн, өлсөж цангасан нэгэн хөөрхөн янзага хонин сүрэг, нутгийн хүмүүстэй дассан боловч өсөж том болохын хэрээр нутаг ус, ижил сүрэгээ санан санасаар алга болсон тухай өгүүлнэ" гол санаа бүхий өгүүлбэрээр хураангуйлж бичсэн байвал сайн гэж үзнэ.</td></tr><tr><td>...Болд, Долгор хоёр түүнд Цоохондой гэж нэр өгөөд, дуудахад нь хүрч ирээд, том нүднээсээ нулимс унагахад тэр хоёрын зүрх шимширдэг байв. Цоохондой томрох тусмаа хониноос холдон ганцаараа явах нь олшироод, сүүл сүүлдээ модны зах руу орчихдог болов. Гэвч Цоохондой гэж дуудахад бөн бөн шогшоод ирдэг байжээ.</td><td></td></tr><tr><td>...Намар орой болж, өвсөн толгой ганхаж, тэнгэр бүрхэн, салхи сэвэлзэн шувууд хошууран ганганан буцаж байсан тэр нэгэн өдөр Цоохондой алга болов...</td><td></td></tr></table>			Уншсан эх зохиол	Нэгтгэн дүгнэсэн нь	Янзага ишигтэй зэрэгцэн, урд хоёр хөлөө нугалан бохирч, ховдоглон хөхнө. Турь муутай урт цүүцгэр хөл, дэлдгэр том чих, тугал хар нүд, шөмбөгөр хошуутай, бор цоохор толботой, содон сонин хөөрхөн нэгэн амьтан тэдний хонин дотор явдаг болсныг нутгийн хүмүүс шохоорхон өхөөрдөнө.	Эхээсээ төөрсөн, өлсөж цангасан нэгэн хөөрхөн янзага хонин сүрэг, нутгийн хүмүүстэй дассан боловч өсөж том болохын хэрээр нутаг ус, ижил сүрэгээ санан санасаар алга болсон тухай өгүүлнэ" гол санаа бүхий өгүүлбэрээр хураангуйлж бичсэн байвал сайн гэж үзнэ.	...Болд, Долгор хоёр түүнд Цоохондой гэж нэр өгөөд, дуудахад нь хүрч ирээд, том нүднээсээ нулимс унагахад тэр хоёрын зүрх шимширдэг байв. Цоохондой томрох тусмаа хониноос холдон ганцаараа явах нь олшироод, сүүл сүүлдээ модны зах руу орчихдог болов. Гэвч Цоохондой гэж дуудахад бөн бөн шогшоод ирдэг байжээ.		...Намар орой болж, өвсөн толгой ганхаж, тэнгэр бүрхэн, салхи сэвэлзэн шувууд хошууран ганганан буцаж байсан тэр нэгэн өдөр Цоохондой алга болов...	
Уншсан эх зохиол	Нэгтгэн дүгнэсэн нь									
Янзага ишигтэй зэрэгцэн, урд хоёр хөлөө нугалан бохирч, ховдоглон хөхнө. Турь муутай урт цүүцгэр хөл, дэлдгэр том чих, тугал хар нүд, шөмбөгөр хошуутай, бор цоохор толботой, содон сонин хөөрхөн нэгэн амьтан тэдний хонин дотор явдаг болсныг нутгийн хүмүүс шохоорхон өхөөрдөнө.	Эхээсээ төөрсөн, өлсөж цангасан нэгэн хөөрхөн янзага хонин сүрэг, нутгийн хүмүүстэй дассан боловч өсөж том болохын хэрээр нутаг ус, ижил сүрэгээ санан санасаар алга болсон тухай өгүүлнэ" гол санаа бүхий өгүүлбэрээр хураангуйлж бичсэн байвал сайн гэж үзнэ.									
...Болд, Долгор хоёр түүнд Цоохондой гэж нэр өгөөд, дуудахад нь хүрч ирээд, том нүднээсээ нулимс унагахад тэр хоёрын зүрх шимширдэг байв. Цоохондой томрох тусмаа хониноос холдон ганцаараа явах нь олшироод, сүүл сүүлдээ модны зах руу орчихдог болов. Гэвч Цоохондой гэж дуудахад бөн бөн шогшоод ирдэг байжээ.										
...Намар орой болж, өвсөн толгой ганхаж, тэнгэр бүрхэн, салхи сэвэлзэн шувууд хошууран ганганан буцаж байсан тэр нэгэн өдөр Цоохондой алга болов...										

5.2д. Бусдын үзэл бодлыг дэмжсэн, эсвэл эсэргүүцсэн утгатай захидал бичих	1. Ямар нэгэн асуудлын талаарх үзэл бодлыг бусдаас сонсох, эсвэл унших 2. Захидал бичихээсээ өмнө тухайн асуудлын \жишээ нь, гар утас ангид хэрэглэхгүй байх\ талаарх шийдвэрийг ярилцах, учир шалтгааныг тодруулан хэлэлцэх 3. Тухайн асуудлыг дэмжиж байгаагаа эсвэл эсэргүүцэж байгаагаа илэрхийлж бичихдээ нотолгоо, баримт цуглуулах 4. “Мэндчилгээ, миний үзэл бодол, захидал бичих болсон шалтгаан \шалтгаандаа цуглуулсан материалаа ашиглах\ талархлын үг, төгсгөлийн үг” гэсэн бүтцээр захидал бичихэд бэлдэх 5. Эхлэл хэсэгт ямар үг хэрэглэн мэндчилж болохоо төлөвлөх 6. Гол хэсэгт хэн? хэзээ? ямар зорилгоор? хэнд хандаж, ямар шалтгаанаар эсэргүүцсэнээ, эсвэл ямар шалтгаанаар дэмжсэнээ, юугаар нотолж, ямар өнгө аясаар (эсэргүүцсэн, дэмжсэн гэх мэт) бичихээ төлөвлөх 7. Төгсгөл хэсгээ төлөвлөх \баяр талархал, ерөөлийн үг, огноо, хэнээс\ 8. Төлөвлөсний дагуу ноороглон бичих 9. Нооргоо засах а. Найруулгын засвар хийх б. Зөв бичгийн дүрмийн засвар хийх в. Бүтцийн дагуу бичсэн эсэх г. Цогцолбороор санаагаа холбосон эсэх 10. Дахин сайжруулж бичих, хичээнгүй бичих 11. Бусдад уншин өгч, зөвлөгөө авах	- Дэмжсэн эсвэл эсэргүүцсэн утгатай захидлын хувилбарууд
Багшийн анхаарах зүйл: Энэхүү суралцахуйн зорилт нь өмнөх ангийн “Талархсан утгатай захидал бичих”\3 дугаар анги\, “Цогцолбороор холбон талархаж, бахархаж захидал бичих”\4 дүгээр анги\ гэсэн суралцахуйн зорилттой агуулгын уялдаа холбоотой юм. 3 дугаар ангид талархаж бичиж байгааг үнэлэх бол 4 дүгээр ангид талархаж, бахархаж бичихдээ цогцолбороор санаагаа холбож байгааг үнэлнэ. Харин 5 дугаар ангид дэмжсэн, эсэргүүцсэн утгатай захидал бичихдээ цогцолбороор санаагаа холбож байгаа эсэхийг үнэлнэ. Ямар нэгэн асуудлын талаарх үзэл бодол гэдгийг сурах бичгийн 13-16 дугаар хуудасны даалгаврыг ашиглаж болохоос гадна багш бүтээлчээр хандан ангидаа өнөө цагт тулгамдаж байгаа, эсвэл хүүхдэд өөрт нь тулгамдаж байгаа асуудлыг илрүүлж, ярилцсаны үндсэн дээр АСУУДЛАА олж ярилцахад анхаарна. Тухайн тулгамдсан олсон асуудлыг л сурагчид дэмжиж, эсвэл эсэргүүцэх юм. Асуудлаа олоогүй байж ийм төрлийн захидал бичихгүй юм. Мөн захидалдаа яагаад эсэргүүцсэнээ, яагаад дэмжсэнээ баримт цуглуулан, нотолгоо болгон бичих нь энэ хичээлийн зорилго, үр дүн болох учиртай.		
5.2е. Өдрийн тэмдэглэлээ бичихдээ сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэх. (өөрт тохиолдсон явдлаа)	1. Өдрийн тэмдэглэл уншиж, бүтэц, агуулга, үг сонголтын тухай ярилцах, дүгнэлт хийх 2. Уншсан өдрийн тэмдэглэлд өөртөө тохиолдсон явдал дээр мэдрэмжээ эсвэл сэтгэгдлээ илэрхийлж байгаа эсэх талаар ярилцах, яаж дуурайж бичихээ хэлэлцэх 3. Өдрийн тэмдэглэл бичихдээ: 4. Өөртөө тохиолдсон тэмдэглэлт юм уу, онцлогт үйл явдлаа бодох, ярих 5. Тэрхүү явдлаас төрсөн сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэн ярих, бичих 6. Өдрийн тэмдэглэлийг эхлэл, гол, төгсгөл гэсэн бүтцийн дагуу хэрхэн бичихээ төлөвлөх - Эхлэл хэсэгт он сар өдөр, тухайн өдрийн товч дүгнэлт - Гол хэсэгт онцлог юм уу тэмдэглэлт үйл явдал, түүнээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ бичих - Төгсгөл хэсэгт дүгнэлт, зорилго, төлөвлөгөөгөө бичих 7. Төлөвлөсний дагуу ноороглон бичих 8. Нооргоо засах А. Найруулгын засвар хийх Б. Зөв бичгийн дүрмийн засвар хийх В. Бүтцийн дагуу бичсэн эсэх	- Өдрийн тэмдэглэлийн загварууд

	Г. Онцлог үйл явдал, түүнээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлсэн эсэх 9. Дахин сайжруулж бичих, хичээнгүй бичих 10. Бусдад уншин өгч, зөвлөгөө авах	
Багшийн анхаарах зүйл: Сурагчийн бичсэн эх бичвэр дээр багш санал бичиж сурах нь маш чухал байдаг. Туршлагаас үзэхэд сурагчийн дэвтрийг шалгахад багш санал, зөвлөмж бичвэл, тухайн сурагчийг сайжрахад илүү нөлөөтэй аж. Зөвхөн дүн тавих нь сурагчид дүнгийн төлөө хөөцөлдөхийг чухалчлахаас бус хэрхэн сайжрах вэ? гэдгийг боддоггүй. Энэ аргыг хэрэглэснээр сурагчид өөрсдийн бичсэн эхэд ажиглалт хийж эхэлдэг бөгөөд өөрийн бичсэний аль хэсэг дээр юуг илүү ажиглаж засахаа мэддэг болно. Сурагчийн ажлыг шалгаж байхдаа багш тухайн ажлыг яавал илүү сайжруулж болох талаас нь зөвлөмж өгнө. Сурагч өөрийн шалгуулсан ажлыг буцааж аваад, зөвлөмжийн дагуу дараа дараагийн ажил хийхдээ хэрэглэж, сайжруулна. Сурагчдын ажлыг эерэг талаас нь харж, хөхүүлэн дэмжсэн зөвлөмж өгөх нь зүйтэй. ... сайн болсон байна. Гэхдээ ... –вэл илүү сайжирна гэх мэт. Жишээ нь: Дараах сурагчийн бичсэн өдрийн тэмдэглэл дээр багш ямар санал бичиж болохыг зөвлөе. 2019.04.20 5 дугаар ангийн сурагч Г.Цолмон Өдрийн тэмдэглэл За өнөөдөр бол манай ангийн тайлан болох өдөр. Өглөө босоол тайлангийнхаа бүх зүйлийг бэлдээл их завгүй байлаа. Тайлан болно гээд бараг хичээл ороогүй. Ихэнх хичээл цонхлоол. Тайландаа бэлдээл, хүүхдүүд ийшээ тийшээ бужигнаал, тэр ч <u>хааччав</u> гээл сандраал би ч мөн орох юмандаа <u>бэлдэж !!</u> ажилд тусалж байлаа. За тэгээд тайлан эхлэв. Би хамгийн эхний хөгжмийн дугуйлангийн <u>үзүүлбэрд</u> оролцсон. Хөгжмөө ч сайн <u>тоголож</u> амжилттай өнгөрлөө. Тэгээд тайзнаас буух завандаа эцэг эхчүүдийг <u>харсан чинь!!</u> аймаар цөөхөн хүмүүс ирсний, урд талд сууж байгаа захирал менежер гэх хүмүүсийг хартал их нүүрний баясгалантай <u>бахархасан</u> шинжтэй сууж байгааад нь би их баярлан гарч дараагийн орох зүйлдээ бэлдлээ. Тэр нь юу гэвэл, Цасангаа ба долоон одой гэх англи хэлний хичээлийн <u>жүжигчэлсэн</u> тоглолт. Энэ тоглолтонд би маш их сандарч айж байлаа. Нэг дотны найзтайгаа <u>нольд орон хувцасаа солилоо</u>. Тэгээд хартал би өөрийгөө ямар царай муутай юм бэ гэж бодлоо. Ха ха. Хүүхдүүд намайг хөөрхөн байна гэх юм. Би худлаа гэж бодоол байж байлаа. За тэгээд гарах ээлж боллоо. Маш их сандарсан ч гэлээ сайн <u>тоголхыг</u> хичээж байлаа. Аль болох чанга дуугарч хүмүүсийн анхаарлыг <u>татхыг</u> хүссэн боловч аавынхаа царайг хартал ямар тэнэг юм бэ? гэсэн байдалтай сууж байв. Би тэгэхэд үнэхээр л муу тоглоод байгаа юм байна даа гэж бодон тайзны цаана орлоо. Тэгээл тэр <u>жүжгийн!! нэг юм!!</u> арай ядан дуусгав. За тэгээд <u>нэг юм!!</u> тайлан тоглолт дуусан гэртээ ирж аав, ээждээ тэгсэн <u>цнэгсэн</u> гэж ярин өнөөдрийг өнгөрөөлөө. Маш их урт өдөр байлаа. Багш: Энэ сурагчийн бичсэн өдрийн тэмдэглэлийг эерэг талаас эхлээд дүгнэж сайшаагаад, цаашид сайжруулах зүйлийг санал болгож бичнэ. Үүнд: “Чиний бичсэн өдрийн тэмдэглэл маш сонирхолтой болжээ. Тэр өдөр танай ангийнхан болон бас чи их сандарч, тэвдэж бас бужигнаж өнгөрсөн байна. Чи өдрийн тэмдэглэл дотроо “босоол, бэлдээл, цонхлоол, сандраал, гээл” гэх мэт үгсэд байгаа “л” гэсэн бүтээврээр тэр өдрийн бужигнасан сандарсан байдлыг сайн гаргаж өгсөн байна. Бичиж байгаа зүйлдээ өгүүлэгч хүний сэтгэл санаа ямар байсан гэдгийг гаргаж чадаж байгаа нь хамгийн сайн зүйл юм. Чи цаашид маш сайн бичдэг болох ирээдүйтэй хүүхэд байна. Гэхдээ үүнээс хойш анхаарах зүйл бол энэ нь үйл үг бүтээх “-л” дагавар биш, хүний сэтгэлийн байдлыг илэрхийлж өмнөх үгээс нь тусдаа бичдэг “л” бүтээврээр учир босоод л, бэлдээд л, цонхлоод л, сандраад л, гээд л гэх мэтээр өмнөх үгээс салгаж бичдэгийг анхаараарай. Тэр байдлыг чи маш сонирхолтой дүрсэлсэн байна. Бас тэр өдөр болсон хамгийн онцлогтой зүйлүүдийг дарааллаар нь маш сайн бичсэн байна.” гэх мэт сайшааж бичгээр харилцах нь суралцахуйг дэмжихэд нь нөлөөтэй юм.		
5.2ж. Чухал, шинэ үйл явдлыг баримтаар нотлон, бүтцийн дагуу мэдээ бичих	1. Мэдээний онцлогийн талаар ярилцах 2. Тухайн цаг үед болсон чухал, шинэ үйл явдлын тухай бичих сэдвээ сонгох 3. Мэдээнд орох баримт, мэдээллээ цуглуулах 4. Мэдээний бүтцэд юу юу бичихээ төлөвлөх - Эхлэл хэсэгт хэн, юу, хэзээ, хаана, юу болсныг товч бичих - Гол хэсэгт эхлэл хэсгийн мэдээг учир шалтгаан, нөхцөл байдлыг тодруулан дэлгэрүүлж бичих - Төгсгөл хэсэгт мэдээ бичсэн хүний нэр 5. Төлөвлөсний дагуу ноороглон бичих	

	6. Нооргоо засах Найруулгын засвар хийх Зөв бичгийн дүрмийн засвар хийх Мэдээний онцлог шинж туссан эсэх Мэдээний бүтцийн дагуу бичсэн эсэх 7. Дахин сайжруулж бичих, хичээнгүй бичих 8. Бусдад уншин өгч, зөвлөгөө авах	
Багшийн анхаарах зүйл: <i>Мэдээ бичүүлэхээс өмнө сонины мэдээ уншуулж, ямар бүтцээр яаж бичсэнийг ажиглуулж, хэлэлцүүлэг хийх нь зүйтэй. Сурагчдаар сонины мэдээ олуулж, ямар ямар баримт ашигласныг ялгах дасгал хийлгэх, хэн, хэзээ, хаана, юу болов, хэрхэн гэх мэт асуух үгийг хэрэглэн мэдээний эхийг задлан шинжлүүлэх, даган дуурайх маягаар найруулж бичүүлэхэд анхаарна. Илүү бүтээлчээр сэтгэн ангидаа сонин гаргах, сургуулийнхаа, ангийнхаа, гэр бүлийнхээ, өөрийнхөө өдөр тутмын онцлог үйл явдлыг бичүүлж хэвшүүлэх нь чухал.</i>		
5.23. Бусдын анхаарлыг татгалзгаж бичих	1. Юуны тухай зар сурталчилгаа бичихээ сонгох, эргэцүүлэх, хэлэлцэхдээ өнөө цагийн хүмүүсийн буруу зуршил, үйлдлээс санаа авах - Эсвэл ямар нэг үйлдвэрийн, сургуулийн нэр хүндийг өсгөх, сурталчлах талаарх сэдэв бодох 2. Ятган итгүүлэх зар сурталчилгааныхаа агуулгыг ярилцах \хог, шүлсийг гудамжинд хаяхгүй байх, шүд эрүүл бол бие эрүүл гэх мэт\ 3. Анхаарал татсан үг хэллэг, эсвэл ямар өвөрмөц үг хэрэглэхээ төлөвлөх, бусдаас санаа авах, ярилцах 4. Зар сурталчилгаандаа хэрэглэх зураг, хэрэглэгдэхүүнээ бэлдэх 5. Зар сурталчилгаа бичих ноороглох 6. Нооргоо засах - Найруулгын хувьд засах - Зөв бичгийн дүрмийн алдааг засах - Анхаарал татсан, ятгах утгатай үг хэрэглэсэн эсэх - Зураг элдэв хэрэглэгдэхүүн нь сонирхолтой оновчтой эсэх 7. Дахин сайжруулж бичих, хичээнгүй хуулах 8. Бусдад унших	- Зар сурталчилгааны эхийн цуглуулга
Багшийн анхаарах зүйл: <i>Энэхүү суралцахуйн зорилт нь унших чадварын “Нэг сэдэвтэй хоёр эхийг харьцуулан дүгнэх” суралцахуйн зорилттой агуулгын хувьд холбоотой юм. Сурагчид унших явцдаа зар сурталчилгааны онцлог, ямар үг хэрэглэдгийг, ямар зураг, фото хэрэглэдгийг мэдсэн бол бичихдээ дуурайн бичих боломжтой. Хамгийн гол нь ятган итгүүлэхийн тулд, жишээ нь өнөөдөр гудамжинд хог их хаядаг нөхцөлд үнэхээр хог хаяхгүй болтол нь итгүүлэхийн тулд ямар арга хэрэглэж, ямар үгийг оновчтой сонгох вэ гэдгээ сурагчид эргэцүүлэх арга барилтай болбол хичээлийн үр дүн гарна. Сурагчид “Юуны тухай зар сурталчилгаа бичихээ сонгохдоо” өнөө цагийн хүмүүсийн буруу үйлдэл, буруу зуршлын тухай ярилцаж, хичээлийг амьдрал ахуйтай холбон багш зохион байгуулбал үр дүнтэй байх болно. Тухайлбал, гудамжинд хог шүлс хаяхгүй болтол нь ятгаж бичих, байгальд хог хаяхгүй болтол нь ятгаж бичих гэх мэт</i>		
5.2и. Жүжигт баатруудын харилцан яриаг нэмэн бичих	Жүжигт харилцан яриа нэмж бичихийн тулд: 1. Жүжгийн утгыг ойлгож унших 2. Эхэд гарч буй дүр, дүрслэл, орчныг мэдэрч унших 3. Эхийн орчныг төсөөлөн бодох 4. Жүжгийн аль хэсэгт баатрын харилцан яриа нэмэхээ төлөвлөх 5. Баатрынхаа гадаад төрх, зан чанарыг төсөөлөх, дүрслэн бичих 6. Сонгосон шинэ баатар бусад баатруудтай хэрхэн харилцахыг, юу ярихыг төлөвлөх	

	7. Төлөвлөсний дагуу ноороглох 8. Нооргоо засах - Найруулгын засвар хийх - Зөв бичгийн дүрмийн засвар хийх - Шинэ баатраа дүрсэлсэн эсэх - Зохиолын орчныг өөрчилсөн эсэх 9. Дахин сайжруулж бичих, хичээнгүй бичих	
Багшийн анхаарах зүйл: Багш ямар зорилгоор баатруудад харилцан яриа нэмж байгааг тодруулан асууна. Энэ нь сурагчид жүжгийнхээ утга агуулгыг хэрхэн мэдэж байгааг илрүүлэх зорилготой юм. Сурагчид ямар дүрийн яриаг нэмэхээ шийдэхээ эхлээд эргэцүүлэн тунгаах нь чухал. Тухайн нэмсэн ярианд сурагчийн өөрийн санаа бодол туссан байх тул багш чиглүүлэхдээ ямар учраас ийм яриа нэмснийг тодруулан ярилцах хэрэгтэй. Бичих үйл нь сурагчдыг өөрийн үзэл бодол, амьдралын туршлагатай болгоход сургахаас гадна бусдаар үнэлүүлэх бололцоо олгоно. Хүүхдийн гаднаас хүлээн авч буй мэдээлэл түүний оюун ухааны бүтцэд урьд нь эзэмшсэн мэдлэгийн тогтолцоонд тохирч байвал хүүхэд тэрхүү мэдээллийг хүлээн авч ойлгодог. Тиймээс бичих санаагаа олох, төлөвлөхийн тулд хүүхэд өөрийн урьд өмнө мэддэг зүйл, аль эсвэл өөрийн хувийн туршлагад тулгуурлахыг эрмэлздэг. Тиймээс бичих зүйлийн төлөвлөгөөг гаргахын тулд ямар нэгэн эхийн утга санааг сайтар ойлгож уншсан, эсвэл өөрт тохиолдсон үйл явдал, үзсэн харсан зүйлд тулгуурлахад анхаарна. Шууд дамжуулсан шинэ мэдээлэл, туршлага хүүхдийн одоо байгаа оюун ухааны бүтцийг төдийлөн өөрчилдөггүй байна.		
5.2к. Адил төстэй шинжийг харьцуулан утгыг далдлан оньсого зохион бичих	1. Юуны тухай оньсоголохоо сонгох, ном, үзэг гэх мэт 2. Оньсоголох гэж байгаа зүйл нь өөр ямар юмс үзэгдэлтэй төстэй байгааг ажиглах 3. Оньсоголох гэж байгаа зүйлээ далдлан зохиоход бэлдэх, ярилцах 4. Оньсогоо ноороглох 5. Нооргоо засах Найруулгын хувьд засах Зөв бичгийн дүрмийн алдааг засах Адил төстэй шинжээр нь далдлан зохиосон эсэхээ хянах 6. Дахин сайжруулж бичих, хичээнгүй хуулах 7. Бусдад унших	- Оньсоголох эд зүйлийн зураг
Багшийн анхаарах зүйл: Энэхүү суралцахуйн зорилт нь “Оньсогоын далд утгыг үндэслэлтэй таамаглах” чадвартай холбоотой нэгж хичээлээр эзэмших чадварууд юм. Багш сурагчдын харьцуулах, ажиглах, төсөөлөх чадварыг хөгжүүлэн үнэлнэ. Утгыг далдлуулахын тулд таалгах гэж байгаа зүйлийнхээ нэрлэж байгаа үгийг хэрэглэхгүй байхыг сануулна. Жишээ нь, Алтан өндөг агаараар өнхөрнө гэсэн оньсогоын таалгах зүйл нь нар юм. Нар гэдэг үгийг хэрэглээгүйдээ утгыг далдалсан гэж хэлж болно. Иймэрхүү төрлийн оньсогоыг нэлээн уншуулж, Юуг таалгах гэсэн бэ?, Таалгаж байгаа зүйл нь үгээр илэрсэн үү уг оньсогод? гэх мэтээр ярилцаад байвал, сурагч оньсого зохиоходоо утгыг далдлан сурах юм.		
5.2л. Баримт, зураг, график хэрэглэн баталгаа нотолгоо гарган санаагаа илэрхийлж бичих	График ашиглан санаагаа илэрхийлэхийн тулд: 1. Энгийн графикт юу байгааг ажиглаж харах 2. Энгийн графикийг ойлгож үгээр тайлбарлах 3. Ойлгосноо бүтэн өгүүлбэрээр тайлбарлаж бичих Зураг ашиглан санаагаа илэрхийлэхийн тулд: 1. Зар сурталчилгаа, ухуулгын зургийг ажиглан, зурагт дүрсэлсэн зүйлийн орчныг төсөөлөн бодох 2. Зургийг оновчтой нэрлэх 3. Санаа бодлоо цаасан дээр буулгаж, тухайн сэдвээр юу хэлэх гэснээ цэгцлэх 4. Мэдээллийн зураг (эх орон, энх тайван, ус хамгаалах, мод хамгаалах, байгаль дэлхийгээ хамгаалах гэх сэдвээр) зурж, зурсан зургаа хэн нэгэнд тайлбарлан ярьж зөвлөгөө авсан бол зурагтаа засвар хийнэ.	- График эх сурвалж бүхий эх - Зураг - Схем - Газрын зураг - Хүснэгт гэх мэт баримтад ашиглах мэдээлэл

	5. Засвар хийсэн зургаа ажиглаад зохион бичиж эхэлнэ. Баримт татан санаагаа илэрхийлэхийн тулд: 1. Төрөл бүрийн баримт, мэдээллийн эхээс өөрт хэрэгцээтэй мэдээллийг ялган тэмдэглэж унших 2. Сонгосон сэдэвтээ хамааралтай мэдээллийг эшлэл болгон ашиглахын тулд ялган тодруулж, тэмдэглэх 3. Сонгосон сэдвийн дагуу хамааралтай санааг илэрхийлэх үг, өгүүлбэр сонгон тэдгээрийг бүлэглэх 4. Бүлэглэсний дараа холбоо хамаарал бий болгох 5. Хамгийн сонирхолтой хамаарлаа сонгон тэмдэглэх 6. Ноороглон бичих 7. Найруулгын болон зөв бичгийн дүрмийн засвар хийх 8. Дахин сайжруулж бичих	
Багшийн анхаарах зүйл: Энэхүү суралцахуйн зорилт нь илтгэх чадварыг хөгжүүлэх хичээлтэй холбоотой юм. Илтгэж ярьж байхдаа баримт, зураг, график хэрэглэж сурах нь чухал. Баримт гэдэгт юу юуг оруулж болох вэ гэж сурагчдаар яриулсны дараа багш саналаа хэлж болно. Баримтад өөрт тохиолдсон явдал, уншсан, харсан үзсэн кино, номын баатруудын хэлсэн үг, зүйр цэцэн үг, хэлц үг зэрэг орж болно. Хамгийн гол нь сурагч ямар нэгэн зүйлийн талаар санаагаа илэрхийлж, илтгэх үедээ баримт, эсвэл график, эсвэл зураг зэргээс сонгон хэрэглэх нь энэ хичээлийн зорилго болно. Ингэхдээ баталгаа, нотолгоо гаргах нь чухал шалгуур юм. Баталгаа нотолгоо нь баримтаар байж болно, зургаар байж болно, графикаар байж болохыг багш сануулна.		
5.2м. Өгсөн бүтцийн дагуу үлгэр зохиох	1. Эхлэл, гол, төгсгөл хэсгээр заагласан үлгэрийг ажиглан унших 2. Уншсан үлгэрийн бүтэц шиг үлгэрээ зохион ярих дасгал ажиллах 3. Зураг харан юуны тухай бичиж болохоо эргэцүүлэх, харилцан ярилцах 4. Зохиох үлгэрээрээ уншигчдад юуг хэлэхийг хүсэж байгаагаа хэлэлцэх 5. Эхлэл хэсэгтээ дүр, орчноо танилцуулах, дүрийнхээ зан чанар, гадаад дүр байдлыг тодорхой дүрслэх, тэмдэг нэр хэрэглэн дүрслэх 6. Гол хэсэгтээ баатруудын хоорондох яриаг зохиох, баатруудад тохиолдсон адал явдал, бэрхшээл, боломжийн талаар бичиж турших 7. Төгсгөл хэсэгтээ уншигчдад хэлэх гэсэн санаагаа илэрхийлэх 8. Үлгэртээ хэлц үг, зүйр цэцэн үг, уншсан зохиолын баатрын хэлсэн үг, үзсэн киноны баатрын хэлсэн үг, мэддэг дуу, шүлгийн үг хэллэгийг хэрэглэж болно. 9. Бичиж төлөвлөсний дараа ноороглох 10. Нооргоо засах, зөв бичгийн дүрмийн болон найруулгын алдаагаа засах 11. Дахин сайжруулан хичээнгүй бичих 12. Бусдад уншин, зөвлөн ярилцах	- Эхлэл, гол, төгсгөл хэсэг нь заагтай харагдахуйц үлгэр - Дүрийн үйл хөдлөлийг заасан үйл үгийн цуглуулга - Дүрийг дүрслэн бичихэд дэмжлэг болох тэмдэг нэрийн цуглуулга
Багшийн анхаарах зүйл: Сурагчдаар үлгэр зохиолгохын тулд үлгэр сайн уншуулж, бүтэц, дүрийг дүрсэлсэн байдал, үг сонголт зэргийг ажиглуулан, задлан шинжлүүлбэл дуурайн зохион бичихэд нь дэмжлэг болно гэдгийг анхаарна уу.		

ГУРАВ. СОНСОХ-ЯРИХ ЧАДВАР

Нэгж хичээл бүрд эхийг уншаад ярих дасгалуудтай уялдуулан товч тодорхой ярих, ойлгомжтой ярих, цэгцтэй ярих, өөртөө итгэлтэй ярих, өгүүлбэрийн зөв бүтэцтэй ярих шаардлагыг багш тавина.

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
5.3а. Тодорхой сэдвийн хүрээнд (харсан сонссон) хэд хэдэн зүйлийг харьцуулж, дүгнэх	1. Нэг сэдэвтэй сонины мэдээ, телевизийн мэдээг унших 2. Мэдээллүүдийг хооронд нь ижил ба ялгаатай шинжээр нь харьцуулах 3. Харьцуулснаа дүгнэн бичихдээ “Мэдээллүүдийн ижил тал нь ...ийм ийм юмны тухай өгүүлснээрээ, ялгаатай нь үүгээрээ өөр юм” гэх зэргээр шүүн тунгааж дүгнэх 4. Харьцуулан дүгнэснээ бусдад танилцуулах Ярихдаа: - Ангийн найзууд руугаа харж ярих - Дууны өнгө, хурдаа тохируулан өөртөө итгэлтэй ярих - Сайн бэлтгэж, чөлөөтэй ярих Бусдын яриаг сонсохдоо: - Анхааралтай сонсож, тэмдэглэл хөтлөх - Тодруулах зүйлээ асуух Бүтээлч үйл ажиллагаа 1. Бусдын ярьсан нэг зохиолын үйл явдлыг өөрөө уншиж, хэрхэн ойлгож, ярьснаар нь ялгаатай болон ижил талыг тодруулж харьцуулах 2. Харьцуулснаа зөв бурууг шүүн тунгаан дүгнэж, бичих 3. Бичсэнээ бусдад унших	- Нэг сэдэвтэй холбоотой төрөл бүрийн эх сурвалжаас авсан мэдээллүүд Сурах бичгийн 62,63-р тал
Багшийн анхаарах зүйл: Энэхүү чадварыг эзэмшүүлэхдээ багш амьдралд ойр сэдэвтэй, сургуулийн болон гэр бүлийн амьдралд өдөр тутам хэрэглэгддэг мэдээллийг олж цуглуулан ашиглах хэрэгтэй. Тухайлбал, замын хөдөлгөөний соёлын тухай, цахим орчны тухай мэдээлэл сүүлийн үед ихэссэнтэй холбоотойгоор цахим орчноос юуг сонссон, эсвэл ТВ мэдээллээс юуг сонссон, эсвэл хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар юуг уншсанаа харьцуулах даалгавар өгч болно. Хамгийн гол нь уншсан сонссон мэдээлэл нь нэг сэдэвтэй байхаас гадна ижил сэдэвтэй мэдээллийг сурагчид хэрхэн ялгаж харьцуулж байгааг үнэлнэ. Ярихдаа тод чанга, бусдын өмнө ойлгомжтой ярьж байна уу, тодорхой, өөртөө итгэлтэй, бүтэн өгүүлбэрээр ярьж байгаа эсэхийг үнэлнэ. Үнэлэхийн тулд шалгуурыг хүүхдүүдэд нээлттэй тавих хэрэгтэй. Дүгнэж бичих чадварыг үнэлэхдээ “үүгээрээ өөр юм, жишээ нь энэ, үүгээрээ ялгаатай юм, жишээ нь энэ” гэсэн найруулгаар бичиж байна уу гэдгийг харгалзаарай. Багш та ийнхүү шалгуурт нийцүүлж бичиүүлж сургая гэвэл урьдчилан байдлаар шалгуурыг хүүхдэд танилцуулна биз ээ.		
5.3б. Хэлэлцэх, илтгэх үедээ сонссон зүйлийн голыг олж, зөв сонссон гэдгээ илэрхийлэх	1. Ямар нэгэн зүйлийн талаар хэлэлцэж эсвэл хэн нэгэн нь илтгэж байх үед багшийн болон ангийн найзуудын уншсан, ярьсан зүйлийг анхааралтай сонсох 2. Сонсохын өмнө сонсох зорилгоо тодорхойлох 3. Сонсох явцдаа гол санааг тулгуур бичиглэлээр, товч өгүүлбэрээр тэмдэглэх 4. Тулгуур бичиглэл юм уу тэмдэглэлээсээ сонсоод ойлгосон гэдгээ илэрхийлэхдээ: - Сонсож байх үедээ яригч руугаа харж ойлгож байгаагаа илэрхийлж толгой дохих - Ярианаас тодруулах зүйлтэй холбоотой асуулт тавих - Ярианы агуулгатай санал нийлж байгаа эсэх талаараа үзэл бодлоо илэрхийлэх	Хэлэлцэх сэдвүүд. Үүнд: 1. Уншсан зохиолын үйл явдал, баатруудын зан чанарын тухай хэлэлцэх 2. ХГҮА-ны цагтай холбоотой сэдвээр хэлэлцэх 3. Багаар ажиллаж болох хичээлүүдийн агуулгын хүрээнд
Багшийн анхаарах зүйл: Зөв сонссон гэдгээ илэрхийлэх гэдэг СОНСОХ чадвар нь өмнөх ангиудтай дараах байдлаар уялдаатай юм.		

1 дүгээр анги АНХААРАЛТАЙ СОНСОХ 2 дугаар анги АНХААРАЛТАЙ СОНСОХ 3 дугаар анги ИДЭВХТЭЙ СОНСОХ 4 дүгээр анги ХҮЛЭЭЦТЭЙ СОНСОХ. Эдгээр чадварыг эзэмшсэн эсэхийг хүүхэд бүрээр үнэлээд, хоцрогдолтой сурагч бүрт дараа дараагийн ангид нь эзэмшүүлэхийг зөвлөмжилж байна. 3 дугаар ангиас эхлээд 4 дүгээр ангид хэлэлцэж сурах чадварыг эзэмшүүлээд 5 дугаар ангид хэлэлцэх чадвараас гадна илтгэх чадварыг эзэмшүүлэхийг зорино. Хэлэлцүүлэг хийх нь бага ангийн хөтөлбөрт шинээр орж ирсэн чадвар. Тийм учраас багш хичээл орохоос өмнө хэлэлцүүлэгт сайн бэлтгэж сургах хэрэгтэй. Хэлэлцүүлэг, илтгэл гээд том нэр сонсогдож байгаа ч гэсэн тухайн ангийн хүүхдийн нас бие сэтгэхүүд тохирсон хүүхдийг амьд харилцаанд оруулж ном унших, юмны учрыг олох, юманд нухацтай хандах, батлах нотлох гэсэн эрмэлзэл бий болгоход чиглсэн чухал хичээл орж байна. Хэлэлцүүлэг хийхэд: 1. Хоёр талын санал зөрсөн байна. 2. Хэлэлцүүлэг нь эсрэг саналтай байсан ч хэлэлцүүлгийн төгсгөлд санал ойртох, санал нэгдэх үйл ажиллагаа явагддаг. 3. Саналаа хамгаалахдаа үнэмшилтэй, итгэлтэй жишээ татах 4. Хэлэлцүүлгийн дараалал, мөрдөх зүйлийг баримталж сурах Харилцааны хувьд: 1. Эелдэг харилцааг чухалчилна. 2. Бие биеэ хүндэтгэнэ. 3. Бусдын үгийг дуустал хүлээцтэй сонсоно. 4. Зөв зүйлд санал нийлж буулт хийнэ. 5. Хамтран шийд гаргадаг гол онцлогийг сурагчдад төлөвшүүлэх юм. Хэлэлцүүлгийн сэдвийг сонгоод хэлэлцүүлэгт бэлтгэхдээ багаар ажиллах нь тохиромжтой байдаг. Яавал хэлэлцүүлгээ итгэл үнэмшилтэй болгох вэ, хэлэлцүүлгийн материалыг хаанаас унших, ямар мэргэжилтний дэмжлэгийг авах талаар багш зөвлөгөө өгнө. Илтгэл, хэлэлцүүлгийн хичээлд сурагчид юм их уншиж материал цуглуулах, сонголт хийх боломж өргөн байдаг тул багш маш их бэлтгэлтэйгээр сурагчдыг удирдана. Хэлэлцүүлэг хийж болох санал зөрөлдөөтэй сэдэв олныг олж цуглуулах хэрэгтэй. Энэ нь сурагчдыг багаас нь юмыг өөр өөр өнцгөөс харж сурахад нөлөөлдөг. Хоцорч байгаа сурагчид юун дээр туслах чиглүүлэх вэ гэдгийг багш нарийн тооцож сурагчдыг хоцроохгүй өөрийн нь хэмжээнд хөгжүүлэх урамшуулах, магтан сайшаах аргыг хэрэглэж зөв буруу гэж дүгнэхээс илүүтэй тэднээр унших, ярих, сонсох үйлийг сайн хийлгэх хэрэгтэй.		
5.3в. Хэлэлцэх, илтгэх үедээ үзэл бодлоо баримт хэрэглэн товч тодорхой оновчтой илэрхийлэх	1. Ямар нэгэн зүйлийн талаар хэлэлцэж эсвэл хэн нэгэн нь илтгэж байх үед багшийн болон ангийн найзуудын уншсан, ярьсан зүйлийг анхааралтай сонсох 2. Хэлэлцүүлэгт оролцохдоо эсвэл илтгэхдээ өөрийн санаа бодлоо баримттай илэрхийлэх Баримтад орох зүйлээ бэлтгэх - Зураг - Бүдүүвч схем - Хүснэгтэн мэдээлэл - Өөрт болон бусдад тохиолдсон явдал - Уншсан, сонссон үзсэн зохиол, кино зохиолын баатруудын хэлсэн үг гэх мэт 3. Баримт хэрэглэн, үзэл бодлоо товч тодорхой илэрхийлж чадсан эсэхээ үнэлэх, үнэлүүлэх	- Маргаантай сэдвүүд - Уншсан зохиолын баатруудын
Багшийн анхаарах зүйл: Энэхүү суралцахуйн зорилтыг 5.2л гэсэн чадвартай холбоотойгээр нэгжийн түвшинд төлөвлөнө. Баримт хэрэглэн яриулж сургах нь өнөөгийн сургалтад маш чухал хэрэгцээтэй байгаа тул багш бүр анхаарч ажиллахыг хүсье. Тухайлбал, найзынхаа маш сайн гэдгийг илэрхийлэхдээ баримтууд татахад чиглүүлнэ. Баримт гэдэгт тохиолдол, зүйр цэцэн үг, хэлц үг, уншсан, үзсэн, сонссон кино эсвэл номынхоо баатрын хэлсэн үг, зарим жишээ, зураг зэргийг оруулж болох тул багш эдгээрийг баримтаар татаж ярихыг зөвлөөрэй. Багш дараах санамжийг хэрэглэж болно.		

Төлөвлөсний дагуу хэлэх зүйлээ эхнээс нь дуустал өөртөө ярьж үзэх. Энэ үедээ толь ашиглаж болох

1. Биеэ барих, яриа маань эвгүй болох вий гэж зовох зэрэг сэтгэл зовнил нь үлэмж саад болдог тул өөртөө итгэлтэй байх
2. Амьсгалаа зөв хуваарилах, дуу хоолойгоо хянах, уруулын хөдөлгөөнөө зохицуулах, зогсолт хийх, өргөлт- дууны өнгө, сэтгэлийн хөдөлгөөн, үгийн баялаг зэргийг анхаарах
3. Яриагаа чанга тод ойлгомжтой, давтсан нэгэн хэвийн өнгөөр биш, аль болох энгийн бөгөөд утга төгөлдөр байх
4. Дохио зангаа хөдөлгөөн нь яриаг амьдруулах ашигтай боловч түүнийг болгоомжтой хэрэглэх
5. Хэрэв ярьж эхлэхийн өмнө мэдэгдэхүйц шуугиан гарч сонсож байгаа сурагчдын санаа сэтгэл тогтворгүй байвал юуны өмнө тэр чимээг намдаах, анхаарлаа төвлөрүүлэхэд чиглэсэн өгүүлбэр хэлэх, хөдөлгөөн хийж болох.
6. Нэг хэвийн, өмнөх сурагчийн ярьсан зүйлийг давтан ярихаас зайлсхийх
7. Ярихдаа нэг үгийг ойр ойрхон хэрэглэхгүй байх
8. Гадаад үгийг зөв дуудах

Багш сурагчдыг бага ангийнх, нас нь бага гэх мэтээр амархан зүйл хийлгээд байвал сурагчдын бүтээлчээр сэтгэх чадвар нь хөгжихгүй. Багш нар сурагчдын өмнө бэрхшээлийг өндөрсгөх түвшний даалгавар хэрэглэвэл илүү амжилттай байх болно.

5.3г. Зохиолын баатрын хэл яриа, үйл хөдлөлийг дуурайн үзэл бодлыг нь илэрхийлэн жүжиглэх	Жүжгийн зохиолыг уншиж, дүрд тоглохын тулд: 1. Жүжгийн зохиолы хэсгээс сонгон чангаар дуудан уншиж, жүжгийн үйл явдлыг дүрслэн бодох 2. Жүжгийн зохиолоос өөрийн дүрд тоглох баатрыг сонгох - Сонгосон баатартай холбоотой хэсгүүдийг дахин уншиж, өөрийн жүжиглэж үзүүлэх хэсгээ сонгох - Сонгосон хэсгээ дахин дахин уншиж, утга санааг ойлгох - Бусдад ойлгомжтойгоор хэрхэн жүжиглэж үзүүлэхээ бэлтгэх - Дууны өнгөө тохируулан ярихын тулд жүжгийн хэсгийн цэг, таслал, үгийн утга өргөлт зэргийг тэмдэглэн давтан унших - Ярианы аль хэсэгт нүүрний хувирлаа ямар болгохоо толинд харан туршиж бэлтгэх, илэрхийлэх - Аль хэсэгт ямар биеийн хөдөлгөөн хийхээ төлөвлөж, бэлдэх 3. Анги хамт олноороо жүжгийн хэсгээс тоглож үзүүлэх 4. Хэрхэн жүжиглэн тоглосноо үнэлэх	- Монголын болон дэлхийн шилдэг хүүхдийн жүжгийн зохиолууд - Хүүхдийн жүжгийн бичлэгүүд - Монгол ардын жүжиг наадмын аман зохиол УБ., 1987
---	--	--

Багшийн анхаарах зүйл:

В ангийн сурагчийн унших зохиолын төрөл зүйл нь жүжгийн зохиолоор баяжиж байгаа. Жүжгийн зохиолыг уншиж, утга санааг нь ойлгож ярилцсаны дараа хүүхэд бүр өөрийн тоглож үзүүлэх дүрээ сонгоно. Бидний туршлагаар жүжигт гарч буй дүрүүдийг нэг нэг сурагчид оноон өгч, цөөн тооны сурагчид жүжгийг бүтнээр нь тоглож үзүүлдэг байсан. Энэ удаа бид бүрэн хэмжээний жүжгийн зохиолыг тоглож үзүүлэх гэхээсээ илүүтэй хүүхэд бүрийн дүрд тоглох чадварыг ахиулахыг зорьж байгаа учраас дараах байдлаар хичээлийн үйл ажиллагаагаа төлөвлөж болох юм. Хүүхэд өөрийн тоглохыг хүссэн дүрээ сонгоно. Тэр дүрийнхээ хийсэн үйл хөдлөл, хэлсэн үгтэй хэсгийг түүвэрлэн уншаад өөрийн жүжиглэж үзүүлэх хэсгээ сонгоно. Энэ нь хүүхэд бүрт хөгжих боломжийг нь олгож байгаагаараа давуу талтай. Сонгосон хэсгээ дүрээр илэрхийлэхдээ биеийн хөдөлгөөн, нүүрний хувирал, дуу хоолойны өнгөө тохируулна. Үүнийг багш болон ангийн бусад сурагчид үзэж, үнэлгээ өгнө. Сурагч тухайн дүрийнхээ баярласан, гунигласан, уйтгарласан, хөгжиж хөөрсөн, онгирсон, атаархсан, зэвүүцсэн байдлыг илэрхийлж чадаж байгаа эсэхэд нь үнэлгээ өгнө.

ДӨРӨВ. ХЭЛ ЗҮЙ, ҮГИЙН САН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
5.4а. Хашилт, хаалт, цэг тэмдгийг зөв хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох	Цэг, цуваа цэг, асуултын тэмдэг, анхаарлын тэмдэг, тодорхойлох цэг, таслал, цэгтэй таслал, дугуй ба дөрвөлжин хаалт, зураас, зэргийг зөв хэрэглэхийн тулд: - Уран зохиолын болон мэдээллийн эхийг хэрэглэсэн цэг тэмдгээс шалтгаалан аялга тохируулан унших - Жүжгийн зохиолд цэг тэмдгийг хэрхэн хэрэглэснийг ажиглах - Жүжгийн зохиолд ашигласан цэг тэмдгийг, үлгэр өгүүллэгт ашигласан цэг тэмдэгтэй харьцуулан ажиглах - Цэг тэмдэг бүрийн үүргийг ажиглаж, таних - Жүжигт шинэ үзэгдэл нэмж бичихдээ, цэг тэмдгийг зөв хэрэглэх - Төрөл бүрийн цэг тэмдгийг өгүүлбэр бичихдээ хэрэглэх - Төрөл бүрийн цэг тэмдгийг өгүүлбэр ба эхэд нөхөж бичих - Буруу хэрэглэсэн цэг тэмдгийг залруулах	- Хашилт, хаалт цэг тэмдгийг түгээмэл хэрэглэсэн төрөл бүрийн эхийн хэсэг, үлгэр ба өгүүллэгийн доторх харилцан яриа, зарим баримтын эхийн хэсэг
5.4б. Эх, өгүүлбэрт баталсан, дэмжсэн өнгө аясыг илтгэсэн үг, өгүүлбэрийг оновчтой хэрэглэх	Өгүүлбэрт сэтгэлийн хөдөлгөөн, өнгө аясыг илтгэх үг хэллэгийг аялга тохируулан хэрэглэх, зөв бичих (баталсан, дэмжсэн) ийн тулд: - Уран зохиолын болон мэдээллийн эхүүдийг чангаар уншихдаа дуу хоолойныхоо өнгийг тохируулах - Баталсан, дэмжсэн гэх мэт утгатай төрөл бүрийн өгүүлбэрийг эхээс ялгах, тайлбарлах (Тайлбартай дасгалын аргыг ашиглаж болно.) - Уран зохиолын эхийн харилцан ярианы хэсгийг дүрд тоглож унших - Ингэж унших явцдаа цэг тэмдгийг анзаарах - Эдгээр утгыг бичигт илэрхийлэхэд уран зохиолын болон мэдээллийн эхэд ялгаатай үг хэллэг ашигладгийг ойлгож хэрэглэх. Тухайлбал: “Булган дахаа өгье хө. Булган дахаа өгнө. Булган дахаа өгнө үү?” гэсэн өгүүлбэрийн утгын ялгаа, аялга, өгүүлбэрийн төгсгөлийн ялгаа нь “өгье хө, өгнө, өгнө үү?” гэсэн төгсгөлийн үгээс шалтгаалан өөрчлөгдөж байгааг мэдрэх. - Эх ба өгүүлбэрийг янз бүрийн зорилгоор бичихдээ уул бичиж буй зүйлийнхээ утгаас шалтгаалан үг ба өгүүлбэрт илрэх өгүүлэгчийн сэтгэлийн хөдөлгөөн, өнгө аяс өөрчлөгдөхийг мэдэрч тэдгээрийг зохиож буй зүйлдээ хэрэглэж сурах. Тухайлбал: “Эрдэм ухаан гэдэг ном зохиолоос гадна гарын эрдэм, үг хэлний эрдэм, хоолойн авьяас гээд ер нь хүний хийж сурсан бүхнийг хэлдэг.” гэхэд олон жишээ дурдсан бөгөөд “дэг” гэдэг бүтээврээр өгүүлбэрээ төгсгөсөн байгаа нь эрдэм ухааныг баталж нотолж, итгэж үнэмшүүлж бичихэд нөлөөлсөн байна.	- Эх ба өгүүлбэрийн утга нь дараах маягаар ялгарах жишээ, хэрэглэгдэхүүн байна. Тухайлбал: • Баталсан • Нотолсон • Мэдээлсэн • Тайлбарласан • Итгүүлэн, ятгасан гэх мэт төрөл бүрийн өнгө аяс бүхий эхийн хэсэг, өгүүлбэрийн жишээн дээр

	Үүнчлэн сурагчид өөрийн бичиж буй зүйлээ хэрхэн яаж бичих нь үг хэллэгийг зөв хэрэглэхээс шалтгаалдгийг мэдэж, хэрэглэж сурах юм.	
	Багшийн анхаарах зүйл: Эх ба өгүүлбэрийг зөв оновчтой найруулан бичихэд янз бүрийн өнгө аяс бүхий үг хэллэг, төрөл бүрийн холбоос, цэг тэмдгүүд чухал үүрэгтэй байдаг. 5 дугаар ангийн сурагчдын хувьд хамгийн түгээмэл хэрэглэдэг цөөн хэдэн холбоос үгийг сайтар хэрэглэж сурахад анхаарна. Үүнд: Гэтэл, гэвч, тэгээд, ингээд, ийм учраас, тийм учраас, тийнхүү, ийнхүү, яагаад гэвэл, өөрөөр хэлбэл, үүний үр дүнд гэх мэт Тухайлбал: Дараах эхэд “Муу санаа биеэ отох” гэсэн сургамжит санааг илэрхийлэхэд “Буудайн хоёр үр” – ийн харилцан яриа, тэдэнд тохиолдсон явдлыг ашиглажээ. Ингэхдээ эхлээд юу болсон, дараа нь юу болсон, эцэст нь хэрхэн төгссөн тухай үргэлжлүүлэн бичихэд “Эхний үр хэлсэн нь, удалгүй, хоёр дахь үр хэлсэн нь, харин, хэрвээ, мөн, ингээд” гэсэн холбоос өгүүлбэр болон холбоос үгийг ашиглажээ. Үүний дотроос нарийвчлан тайлбарлавал, “харин” гэдэг холбоосыг яагаад хэрэглэв? гэвэл буудайн хоёр үрийн бодол эсрэг байв. Нэг нь өөдрөг сайхныг бодож байхад, нөгөө нь муу муухайг бодож хэвтсээр тахианы хоол болж байна. Тиймээс энэ хоёр үр эсрэг тэсрэг зан чанартай тул хоёр үрийн бодлыг хооронд харьцуулан холбоход “харин” гэдэг холбоосыг хэрэглэсэн байна. Буудайн хоёр үр талбай дээр унажээ. Эхний үр хэлсэн нь: “Би ургахыг хүсэж байна. Би өөрийн үндсээ хөрсөн доороос ургуулж, соёогоо газрын гадарга дээр гарган нарны гэрлийг гаргаж навчин дээрээ шүүдрийн дусал буугаасай гэж хүсэж байна гэлээ. Удалгүй тэрээр хүссэнээрээ сайхан ургажээ. Харин, хоёр дахь үр хэлсэн нь: Би маш их айж байна. Хэрвээ би үндсээ хөрсөнд ургуулбал харанхуйд юу болж байгааг яаж мэдэх юм. Хэрвээ би газрын гадарга дээр соёогоо дэлгээд сайхан ишээ гэмтээчихвэл яана. Мөн сайхан дэлбээгээ дэлгэхэд өт идчихвэл яах яах юм бэ? Бүх зүйл аюулгүй болж сайн нөхцөл бүрдтэл зүгээр хэвтэж байсан нь дээр гэж хэлжээ. Ингээд тэр удаан хүлээв. Хаврын сайхан нартай өдөр нэгэн тахиа тариан талбай дээр гүйж яваад өнөөх ургаагүй үрийг олоод идчихжээ. (Шинэ ертөнц сэтгүүл) Ийм маягийн холбоос нь эхийн өгүүлбэрүүдийг утга санааны дарааллаар байрлуулахад чухал үүрэгтэй байдгийг сурагчид ойлгож, хэрэглэж сурах нь чухал юм. Тиймээс зарим сурагч томоохон эхийн хэмжээнд шууд тайлбарлахад нэлээд түвэг бэрхшээл учрах тул, хоёр өгүүлбэрийг холбох, цаашилаад гурав, дөрөв гэх мэтээр ахиулах замаар өгвөл үр дүнтэй болно. Тухайлбал: “Рэнжин орой болтол зургаа зураад нар жаргах үед л аяны бяцхан майхнаа элсний нөмөрт босгов. Хээрийн хоол хийж идэхэд амттай гэдэг тоймгүй. Тун ч таатай байлаа. Дараа нь хэсэгхэн дугхийгээд сар гармагц босож ажиглалтаа үргэлжлүүлэв...” гэхэд “дараа нь” гэсэн холбоосыг Рэнжингийн үйл хөдлөлийн дарааллыг гаргахын тул ашиглажээ. Ингэхлээр ямар нэг үйл хөдлөлийн нэгийг нөгөөтэй холбон нөхцөлдүүлэхэд холбоос үгийг хэрэглэдгийг сурагчид сайтар ойлгож хэрэглэж сурах нь чухал юм. Үлгэр ба өгүүллэгийг өрнүүлэн бичихэд эдгээр холбоосууд нэлээд чухал байдгийг сурагчид ойлгох нь чухал. Тухайлбал: “Үнэг уурлав. Тэр (Үнэгийг төлөөлсөн үг) уг нь долоо хоногийнхоо хоолыг иднэ гэж бодож ирсэн аж. Гэвч (Эсрэгцүүлэх холбоос) өлөн ходоодтойгоо гэр лүүгээ буцах болов. Тэр үеэс (Өмнөх үйл хөдлөлийг төлөөлсөн цаг хугацааны утгатай үг) хойш тогоруу үнэг хоёр нөхөрлөхөө больсон юмсанжээ. (“Үнэг тогоруу хоёр” үлгэрээс)” гэх мэт.	
5.4в. Эх, өгүүлбэр зохиохдоо ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэх	Ойролцоо ба эсрэг утгатай үг өгүүлбэрээр санаагаа илэрхийлэхийн тулд: - Ойролцоо ба эсрэг утгатай үг, өгүүлбэрийг ялгаж таних - Ойролцоо ба эсрэг утгатай хэлц үгсийн утгыг ойлгож цээжээр бичих - Эдгээр үг нь эх ба өгүүлбэрийн утгыг нэмэн дэлгэрүүлэх, ойлгоход хялбар болгодгийг мэдэх - Хэлц ба үгсийн утгыг тайлбарлах - Эсрэг ба ойролцоо утгатай хэлцийг хэрэглэж сурахад эсрэг ба ойролцоо утгатай эхийн хэсгүүд дээр ажиллана. Тухайлбал: Амралтаа таатай сайхан өнгөрөөсөн тухай, эсвэл таагүй өнгөрөөсөн тухай үе тэнгийн нөхөртөө ил захидал бичиж болох юм. Энэ үед ойролцоо ба эсрэг хэлцийг хэрхэн оновчтой хэрэглэж болох вэ?	- Төрөл бүрийн хүндэвтэр эхүүд - Төрөл бүрийн хэлц, зүйр цэцэн үгс - Ойролцоо ба эсрэг утгатай хэлц, зүйр цэцэн үгс

	- Ойролцоо ба эсрэг утгат хэлц бичиж буй зүйлийн утгыг илүү тодорхой, уран сайхан болгодгийг ойлгож хэрэглэж сурах	
5.4г. Эх, өгүүлбэр зохиохдоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэх	Хэлц үгийг хэрэглэж сурахын тулд: - Хэлц үг нь үгийн нөөцийг нэмэхэд нөлөөлдгийг ойлгох - Өгүүлбэрт хэрэглэсэн хэлц үгийг өгүүлбэрийн утгатай холбож ойлгох - Зарим энгийн хэлцээр өгүүлбэрийг дэлгэрүүлж бичих - Хэлц үгийн толь хөтлөх, толь ашиглаж хэлцийн утгыг тайлбарлах	- Хэлц үгийн толь - Түгээмэл хэрэглэдэг хэлц үгийн түүвэр - Хэлц үг орсон өгүүлбэр, эхийн жишээ

Багшийн анхаарах зүйл:

Ойролцоо ба эсрэг утгат үг өгүүлбэрээр санаагаа илэрхийлэх нь бодол санаагаа тод томруун хүргэх нэгэн арга юм. Юмс үзэгдлийн ижил төсөөтэй ба ялгаатай байдлыг хэлэхдээ харьцуулж, эсрэгцүүлж дүрсэлдэг. Тухайлбал: Монгол ардын зүйр цэцэн үг нь аливаа сургаалыг богино хэлбэрээр, хурдан түргэн, хурц тод хэлэх нь чухал байдаг тул ихэнхдээ ойролцоо юм уу эсрэг утгатай хоёр мөртөөс бүтсэн байдаг.

Жишээ нь:

Эсрэг утгатай	Ойролцоо утгатай
Бие нь хөгшин боловч сэтгэл нь залуу Сайн ах дүү мянга байсан ч арвидахгүй, муу ах дүү нэг байсан ч багадахгүй Ер хүн эвтэй бол төмөр хүрээ мэт бэх, хорин хүн эвгүй болбоос эвдэрхий хүрээ мэт хэврэг Гэрээсээ гарахдаа хийхээ бодож Гэртээ ирэхдээ хийснээ цэгнэ Авах хүнд нэг ч үг эрдэнэ Орхих хүнд мянган үг ч улиг	Өвсөнд ороовч үхэр идэхгүй Өөхөнд ороовч нохой шиншихгүй Бороотой боловч болзоондоо Хуртай боловч хугацаандаа Төмрийн сайн зэвэрдэггүй Төрлийн сайн мартагддаггүй Муу хүн сонжооч Мухар үхэр сэжээч

Ийнхүү уран зохиолд байгаль ба хүний тухай дүрсэлж буй зүйлээ сэтгэлд буутал дүрслэхэд эсрэг ба ойролцоо утгыг түгээмэл хэрэглэнэ.

Ойролцоо: Арван гурван наснаас тавин зургаан насыг хүртэл Улаанбаатар ба Шарын голын хооронд Дагвын өвс зөөж, Балдангийн түлээг тээсээр өдий хүрсэн тул зам дахь уул давааг андахгүй, энхэл донхлыг эндэхгүй, нүхнээс гарч хошгорох тарвагыг ч бараг таних бөгөөд нисэн өнгөрч одох шувууг ч төлөв мэднэ... (Д.Н)

1. Уул давааг андахгүй (маш сайн мэднэ).
2. Энхэл донхлыг эндэхгүй (ер нь мэднэ).
3. Нүхнээс гарч хошгорох тарвагыг ч бараг таних (багцаалан мэднэ).
4. Нисэн өнгөрч одох шувууг ч төлөв мэднэ (бараг мэдэж магадгүй).

Ойролцоо утгатай дөрвөн өгүүлбэрийн утгыг шатлан бууруулж, нүдэнд харагдаж, сэтгэлд буутал нь дүрсэлжээ.

Эсрэг: Хаврын хурц наранд өвлийн хунгарласан цас хайлж газрын хөрсийг чийгтүүлэн, өсөх төлжих ногоонд шимийг өх нь сайшаалтай боловч, тэрэгч Лувсангийн зуны халуунд хөлсөө урсгаж, өвлийн хүйтэнд хуруугаа хөлдөөж олсон муу гутлыг шавхайдан дүүргэх нь хайрлалтай. Хасаг тэрэгний хяхнах тутам Лувсангийн сэтгэл уйтгарлаж хүрэн шарыг хашигнах бүр түүний уур хүрнэ.

Лувсан эрт боссондоо гансартал эвшээж урт замд мацалхийлэн алхах нь хэдийгээр зүдүүртэй боловч, урьхан салхи өмнөөс нь зөөлнөөр үлээж, үдийн нар ууцруу төөнөхөд бас ч нэг жаргал шиг санагдана. (Д.Нацагдорж “Соёлыг гайхав”) Энд байгаль ба хүний байдлыг эсрэгцүүлэн уран сайхнаар дүрслэхдээ “боловч” гэдэг эсрэгцүүлэх холбоосыг ашигласан байна.

Юмсын ижил төсөөтэй байдлыг хэлэх үед бид харьцуулж байдаг бол юмсын ялгаатай байдлыг хэлэх үед бид эсрэгцүүлж байдаг. Түлхүүр үг нь гэвч, гэсэн ч, дуртай, дургүй гэх мэт ялгах ба харьцуулах дохио бүхий үгс байдаг.

